| **Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлага** | Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагын гурван давхар хамгаалалтын шугамыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд өөрийн удирдлагын тогтолцоо, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороогоор дамжуулан үйл ажиллагаандаа учирч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох, сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах талаар Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, журам болон холбогдох бусад заавар, журмын хүрээнд тодорхойлогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавин ажилладаг. | **2.9.1** |

**Түүхэн болон төлөвлөсөн санхүүгийн үзүүлэлт**

**2.7 болон 2.8.3**

## Орлогын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт, сая төгрөг | Аудит | | | Төлөвлөлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2021 | 2022 | 2023 III | 2024 | 2025 | 2026 | 2027 | 2028 |
| Борлуулалтын орлого /цэвэр/ | 3,995 | 7,396 | 6,464 | 34,768 | 40,237 | 47,559 | 54,348 | 61,234 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | (3,625) | (6,615) | (5,591) | (19,241) | (21,116) | (23,176) | (25,557) | (27,489) |
| **Нийт ашиг** | **370** | **781** | **874** | **15,528** | **19,120** | **24,383** | **28,791** | **33,745** |
| Хүүгийн орлого | - | - | 0.0 | 12 | 2,135 | 4,712 | 1,592 | 677 |
| Хүүгийн зардал | - | - | - | (2,229) | (4,975) | (5,650) | (3,317) | (402) |
| Борлуулалт маркетингийн зардал | - | (0) | - | (200) | (212) | (225) | (238) | (253) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | (166) | (727) | (1,066) | (4,232) | (3,332) | (3,911) | (4,218) | (4,528) |
| Бусад зардал | (1) | (0) | (3) | (5) | (5) | (6) | (6) | (6) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз (гарз) | - | (25) | (0) | (1,002) | (3,066) | (3,752) | (1,044) | (91) |
| Бусад ашиг /алдагдал) | - | - | (98) | (10) | (11) | (12) | (12) | (13) |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **203** | **29** | **(293)** | **7,861** | **9,655** | **15,541** | **21,547** | **29,128** |
| Орлогын татварын зардал | (21) | (3) | - | (1,322) | (1,771) | (3,242) | (4,744) | (6,639) |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **183** | **26** | **(293)** | **6,540** | **7,884** | **12,299** | **16,803** | **22,489** |

## Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт, сая төгрөг | Аудит | | | Төлөвлөлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2021 | 2022 | 2023 III | 2024 | 2025 | 2026 | 2027 | 2028 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 15 | 56 | 11 | 9,816 | 16,348 | 25,104 | 149 | 8,346 |
| Татвар, НДШ -ийн авлага | - | - | 140 | 3,901 | 4,008 | 3,699 | 2,979 | 1,520 |
| Бусад авлага | 119 | 631 | 607 | 5,719 | 7,816 | 9,676 | 8,431 | 10,720 |
| Бараа материал | 746 | 1,478 | 4,864 | 5,974 | 7,251 | 7,873 | 10,411 | 13,026 |
| Урьдчилж төлсөн зардал / тооцоо | 312 | 271 | 3,288 | 654 | 3,295 | 6,586 | 8,655 | 8,668 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **1,191** | **2,436** | **8,908** | **26,064** | **38,718** | **52,938** | **30,625** | **42,280** |
| Үндсэн хөрөнгө | 2,740 | 3,579 | 50,302 | 45,055 | 44,084 | 42,218 | 39,826 | 38,347 |
| Биет бус хөрөнгө | 220 | 227 | 2,006 | 2,004 | 2,004 | 2,004 | 2,004 | 2,004 |
| Дуусаагүй барилга | 102 | - | | - | - | - | - | - |
| Хөрөнгө оруулалт | - | - | - | 3,462 | 7,305 | 7,728 | - | 4,111 |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС
TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.07.05 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хойшлогдсон татварын хөрөнгө | - | 3 | 3 | 98 | 309 | 627 | 108 | - |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **3,062** | **3,808** | **52,310** | **50,619** | **53,702** | **52,578** | **41,937** | **44,462** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,253** | **6,244** | **61,218** | **76,683** | **92,419** | **105,515** | **72,563** | **86,742** |
| Дансны өглөг | 27 | 73 | 68 | 72 | 76 | 80 | 85 | 90 |
| Цалингийн өглөг | - | - | 107 | 102 | 110 | 146 | 189 | 170 |
| Хүүгийн өглөг | - | - | - | 750 | 244 | 258 | 267 | - |
| НӨАТ өглөг | - | - | - | - | - | 39 | 379 | 222 |
| Татвар, хураамж, НДШ-ийн өр төлбөр | 115 | 280 | 91 | 675 | 900 | 1,641 | 2,398 | 3,343 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 3,949 | 5,704 | 43,811 | 8,206 | 5,572 | 2,358 | 1,387 | 593 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **4,091** | **6,057** | **44,077** | **9,804** | **6,902** | **4,521** | **4,705** | **4,417** |
| Урт хугацаат өр төлбөр | - | - | - | 44,029 | 54,784 | 57,961 | 8,022 | - |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **-** | **-** | **44,029** | **54,784** | **57,961** | **8,022** | **-** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **4,091** | **6,057** | **44,077** | **53,833** | **61,685** | **62,483** | **12,727** | **4,417** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 |
| *Төрийн* | - | - | - | - | - | - | - | - |
| *Хувийн* | *10* | *10* | *10* | *10* | *10* | *10* | *10* | *10* |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | - | - | 17,247 | 17,247 | 17,247 | 17,247 | 17,247 | 17,247 |
| Хуримтлагдсан ашиг | 152 | 178 | (115) | 5,593 | 13,477 | 25,776 | 42,579 | 65,069 |
| **Эздийн өмчийн нийт дүн** | **162** | **188** | **17,142** | **22,850** | **30,734** | **43,033** | **59,836** | **82,325** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **4,253** | **6,244** | **61,218** | **76,683** | **92,419** | **105,515** | **72,563** | **86,742** |

## Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | Аудит | | | Төлөвлөлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2021 | 2022 | 2023 III | 2024 | 2025 | 2026 | 2027 | 2028 |
| **Хөрвөх чадварын харьцаа** | | | | | | | | |
| Эргэлтийн харьцаа | 0.29 | 0.4 | 0.2 | 2.66 | 5.61 | 11.71 | 6.51 | 9.57 |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 0.03 | 0.11 | 0.02 | 1.98 | 4.08 | 8.51 | 2.46 | 4.66 |
| Бэлэн мөнгөний харьцаа | 0.00 | 0.01 | 0.00 | 1.00 | 2.37 | 5.55 | 0.03 | 1.89 |
| **Төлбөрийн чадварын харьцаа** | | | | | | | | |
| Өрийн харьцаа | - | - | - | 57.4% | 59.3% | 54.9% | 11.1% | 0.0% |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өр эздийн өмчийн харьцаа | - | - | - | 1.93 | 1.78 | 1.35 | 0.18 | 0.00 |
| Санхүүгийн хөшүүрэг | 31.81 | 30.01 | 3.89 | 3.55 | 3.16 | 2.68 | 1.73 | 1.12 |
| Хүү төлөх чадварын харьцаа | - | - | - | 4.53 | 2.94 | 3.75 | 7.50 | 73.38 |
| **Үйл ажиллагааны харьцаа** | | | | | | | | |
| Бараа материалын эргэц (удаа) | 9.73 | 5.95 | 1.76 | 4.06 | 3.19 | 3.06 | 2.80 | 2.35 |
| Бараа материалын эргэц (өдөр) | 37.53 | 61.34 | 207.03 | 89.86 | 114.30 | 119.09 | 130.56 | 155.60 |
| Авлагын эргэц (удаа) | 67.28 | 19.73 | 10.44 | 7.60 | 5.95 | 5.44 | 6.00 | 6.39 |
| Авлагын эргэц (өдөр) | 5.43 | 18.5 | 34.95 | 48.03 | 61.39 | 67.12 | 60.80 | 57.08 |
| Өглөгийн эргэц (удаа) | 29.72 | 147.78 | 127.58 | 470.7 | 303.7 | 304.4 | 339.1 | 342.8 |
| Өглөгийн эргэц (өдөр) | 12.28 | 2.47 | 2.86 | 0.78 | 1.20 | 1.20 | 1.08 | 1.06 |
| **Ашигт ажиллагааны харьцаа** | | | | | | | | |
| Нийт ашгийн ахиуц | 9.3% | 10.6% | 13.5% | 44.7% | 47.5% | 51.3% | 53.0% | 55.1% |
| Цэвэр ашгийн ахиуц | 4.6% | 0.3% | -4.5% | 18.8% | 19.6% | 25.9% | 30.9% | 36.7% |
| Хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх ашгийн ахиуц (EBITDA margin) | 11.8% | 5.5% | 5.7% | 44.5% | 50.6% | 53.3% | 54.4% | 56.1% |
| Нийт хөрөнгийн өгөөж (ROA) | 8.1% | 0.5% | -0.9% | 31.9% | 38.7% | 42.6% | 44.8% | 47.3% |
| Нийт эздийн өмчийн өгөөж (ROE) | 258.1% | 14.8% | -3.4% | 9.4% | 9.3% | 12.4% | 18.9% | 28.2% |



# 02 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
2024. 07. 05
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

## 2.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮРТГЭЛ

### 2.1.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ

**Хүснэгт 1: Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл**

| Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл | |
|---|---|
| Компанийн нэр | ТЖТБ ХХК |
| Байгуулагдсан огноо* | 2007.06.18 |
| Улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо | 2007.06.18 |
| Улсын бүртгэлийн дугаар | 000262037 |
| Хувийн хэргийн дугаар | 9011105105 |
| Регистрийн дугаар | 5147204 |
| Хөрөнгийн биржид бүртгэлтэй эсэх | Үгүй |
| Үйл ажиллагааны үндсэн чиглэл | • Хог хаягдлаас хоёрдогч түүхий эд, материал гарган авах<br>• Хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл<br>• Аюулгүй хог хаягдлыг цуглуулах<br>• Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа |

*"ТЖТБ" ХХК нь анх 2007 онд гадаад худалдааны чиглэлээр үүсгэн байгуулагдаж, 2021 онд "Ти Эм Эл Трейд" ХХК-ийн харьяа компани болсон бөгөөд хуванцар хог хаягдал (PET - PolyEthylene Terephthalate)-ыг дахин боловсруулах чиглэлээр 2021 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.*

### 2.1.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН ЭРХ

**Хүснэгт 2: Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл болон эрх**

| № | Зөвшөөрлийн нэр | Зөвшөөрлийн дугаар, эрх бүхий этгээдийн тушаалын дугаар | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа | • Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 01/268 тоот албан бичиг | • Үнэт цаас гаргагч нь 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 01/268 тоот албан бичгээр энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хог хаягдлын мэдээллийн санд бүртгэгдсэн байна. |
| 2 | Худаг гаргах зөвшөөрөл | • Худаг гаргах зөвшөөрөл №506 | • Үнэт цаас гаргагч нь 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн байгаль орчны газраас 506 дугаар бүхий Худаг гаргах зөвшөөрлийг авсан байна. |
| 3 | Электрон тоолуур тавих зөвшөөрөл | • "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК, №0319119<br>• Стандартчилал, хэмжил зүйн газраас | • Үнэт цаас гаргагч нь 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК-аас АМ360 загварын, 3 фазын, 5320274 номерын электрон тоолуурыг тавих зөвшөөрлийг авсан байна. |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

027

| | | | |
|---|---|---|---|
| | | • цахилгаан тоолуурын анхдагч баталгаажуулалтыг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ | • Тус тоолуурыг Стандартчилал, хэмжил зүйн газраас цахилгаан тоолуурыг №ZPA лацаар битүүмжилж, 2027 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгосон байна. |
| 4 | Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл | • Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/719/189 дүгээр тушаалын хавсралт, Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл, №23/21 | • Үнэт цаас гаргагч нь 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газраас төвлөрсөн бохир усны шугамын коллекторт байршилтай хаягдал ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугамд жилд 19,986.0 мян.м$^3$ хаягдал усыг "Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015", "Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг 1 (нэг) жилийн хугацаатайгаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгах "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл"-ийг авчээ. |
| 5 | Ус ашиглах эрх | • Нийслэлийн Байгаль орчны газрын даргын А/121тоот тушаал | • Үнэт цаас гаргагч нь 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Нийслэлийн Байгаль орчны газрын даргын А/121 тоот тушаалаар үйлдвэрлэлийн зориулалтаар усыг 10 (арав) жилийн хугацаагаар авч ашиглах зөвшөөрлийг авсан байна. |

### 2.1.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАЯГ БАЙРШИЛ

**Хүснэгт 3: Үнэт цаас гаргагчийн хаяг байршил**

| Үнэт цаас гаргагчийн хаяг байршил | |
|---|---|
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо, Хотын шинэ төв /18720/ гудамж, 91 тоот |
| Утас | (976) 8600-8891, (976) 7709-5555 |
| Цахим шуудан | info@tjtb.mn |
| Веб хуудас | tmlplastic.mn |

СЗХ 2024.07.05 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 02
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES
5147204 ХАК0303 ТЖТБ УЛААНБААТАР ХОТ

### 2.1.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХӨРӨНГӨ

Үүсгэн байгуулагдсан цагаас хойш Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгөд аливаа өөрчлөлт орж байгаагүй бөгөөд 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн хөрөнгө дараах байдалтай байна.

**Хүснэгт 4: Үнэт цаас гаргагчийн хөрөнгө**

| Үнэт цаас гаргагчийн хөрөнгө, 2023.09.30-ны өдрийн байдлаар | |
|---|---|
| Зарласан хувьцааны тоо | 10,000 ширхэг |
| Гаргасан хувьцааны тоо | 10,000 ширхэг |
| Хувьцааны төрөл | Энгийн |
| Нэрлэсэн үнэ | 1,000.0 (мянга) төгрөг |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ | 10,000,000.0 (арван сая) төгрөг |
| Өөрийн хөрөнгийн хэмжээ | 17,141.7 сая төгрөг |
| Нийт хөрөнгийн хэмжээ | 61,218.3 сая төгрөг |

### 2.1.5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц нь үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

**Зураг 1: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц**




**"Ти Эм Эл Трейд" ХХК** нь анх 2013 онд автомашины худалдаа, автомашины түрээсийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2022 оноос хойш Компани нь төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа, моторт тээврийн хэрэгслийн түрээсийн үйл ажиллагааны чиглэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Өнөөдрийн байдлаар тус компани нь Беларусь, Вьетнам, Латви зэрэг улсуудтай хамтран ажиллаж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн импортлон, хэрэглэгчдэд хямд үнээр хүргэж байна.

## 2.1.6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАМААРАЛ БҮХИЙ НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэх бөгөөд үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь хараат компанигүй байна.

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт зааснаар Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэх бөгөөд үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК (РД: 6990916) гэх 1 охин компанитай байх ба тус компанийн гаргасан хувьцааны 100 хувийг дангаар эзэмшиж байна.

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх хэсэгт зааснаар толгой компани, түүнтэй тус хуулийн 6.1, 6.3, 6.8 дахь хэсгүүдэд заасан хамаарал бүхий компаниуд, нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг, эсхүл компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой компаниудыг компанийн нэгдэл гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.15 дахь хэсэгт зааснаар нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэргэлдээ компани гэж тус тус тодорхойлсон. Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь "Эм Жи Эл Акуа" ХХК, "МТЗҮК" ХХК, "Сээмета" ХХК, "Эс И Жи Вай Вай" ХХК, "Шидэтчандмань эрдэнэ" ХХК, "Скай Ти Ти Эс Эс" ХХК, "Ти Эм Эл констракшн" ХХК гэх 7 компанитай зэргэлдээ байх ба дараах компаниудтай нэгдмэл сонирхолтой байна.

**Хүснэгт 5: Үнэт цаас гаргагчийн нэгдмэл сонирхолтой этгээд**

| № | Компанийн нэр | Регистрийн дугаар | Хувьцаа эзэмшигч | Үйл ажиллагааны чиглэл |
|---|---|---|---|---|
| | | | **Зэргэлдээ компани** | |
| 1 | Эм Жи Эл Акуа ХХК | 2628333 | "Ти Эм Эл Трейд" ХХК (100%) | • Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа;<br>• Согтууруулах бус ундааны үйлдвэрлэл, савласан рашаан, бусад усны үйлдвэрлэл;<br>• Моторт тээврийн хэрэгслийн худалдаа;<br>• Хүнс, ундаа бөөний худалдаа. |
| 2 | МТЗҮК ХХК | 5647347 | "Ти Эм Эл Трейд" ХХК (100%) | • Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа;<br>• Геологийн тойм судалгаа хийх;<br>• Зар сурталчилгаа, самбар түрээс. |
| 3 | Сээмета ХХК | 6675824 | "Ти Эм Эл Трейд" ХХК (100%) | • Худалдааны зуучлал;<br>• Интерьер, экстрьер, дизайн хийх;<br>• Барилгын засвар хийх;<br>• Мэдээлэл технологийн үйл ажиллагаа;<br>• Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;<br>• Рашаан, ус, ундаа, цай үйлдвэрлэх үйл ажиллагаа;<br>• Рашаан, ус, ундаа, цай худалдах үйл ажиллагаа. |

СЗХ 2024.07.05 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Эс И Жи Вай Вай ХХК | 6503195 | "Ти Эм Эл Трейд" ХХК (100%) | • Автомашины сэлбэгийн худалдаа;<br>• Аялал жуучлал;<br>• Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа;<br>• Үндааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа. |
| 5 | Шидэтчандмань эрдэнэ ХХК | 5134749 | "Ти Эм Эл Трейд" ХХК (100%) | • Аялал жуулчлал;<br>• Рашаан, ус, ундаа, цай савлах, үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагаа;<br>• Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа. |
| 6 | Скай Ти Ти Эс Эс ХХК | 2685426 | "Ти Эм Эл Трейд" ХХК (100%) | • Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа;<br>• Моторт тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ;<br>• Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл. |
| 7 | Ти Эм Эл констракшн ХХК | 5510643 | "Ти Эм Эл Трейд" ХХК (100%) | • Барилгын засал чимэглэл;<br>• Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа. |
| | | **Бусад нэгдмэл сонирхолтой этгээд** | | |
| 1 | Эм Пластик ХХК | 6157769 | Монгол Улсын иргэн Х.Тэгшээ – (100%) | • Ундаа, усны бөглөө, таглаа үйлдвэрлэх;<br>• Гадаад худалдаа. |
| 2 | Ньюгор ХХК | 5525756 | Монгол Улсын иргэн Х.Тэгшээ – (100%) | • Барилга угсралтын ажил;<br>• Аялал жуулчлал;<br>• Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ;<br>• Хүнсний дэлгүүр;<br>• Барилгын засвар, засал чимэглэл;<br>• Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа.. Гадаад худалдаа. |
| 3 | Нью Шилэн Интернэшнл ХХК | 2074125 | Монгол Улсын иргэн Х.Тэгшээ (100%) | • Аялал жуулчлал;<br>• Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа. |
| 4 | Ти Эм Эл ГХОХХК | 5057299 | Монгол Улсын иргэн Х.Тэгшээ (50%) | • Гадаад худалдаа. |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES



УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

## 2.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### 2.2.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь дараах бүтэц, зохион байгууллалттайгаар үйл ажиллагаагаа эрхэлж байна.

**Зураг 2: Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт**




**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн алба*

### 2.2.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт зааснаар компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулдаг ба Компанийн дүрэмд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 (тав) хоногийн дотор Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсэгт зааснаар дор дурдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхтэй байна. Үүнд:

- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
- Компанийн хэлбэрийг өөрчлөх, компанийг өөрчлөн байгуулах;
- Компанийн татан буулгах;
- Охин, хараат компани шилжүүлэх, шилжүүлэн авах;
- Салбар төлөөлөгчийн газар байгуулах;
- Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтооход санал өгөх;
- Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг тогтооход санал өгөх;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилж, чөлөөлөх;

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

УЛААНБААТАР ХОТ

- Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэртэй танилцах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрлэж чадаагүй, хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулсан асуудлыг шийдвэрлэх;
- Компанийн хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах асуудлыг шийдвэрлэх;
- Үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтооход санал оруулах;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрэмд заасан хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх бусад асуудал.

## 2.2.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

### Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна гэж заасан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл нь тус хуулийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг эдэлнэ.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт зааснаар доор дурдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхтэй байна. Үүнд:

- Хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах;
- Компанийн тухай хууль болон хувь нийлүүлэгчдийн хурлаас эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх;
- Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох, хязгаарлах;
- Компанийн хувьцаа болон хувьцаанд хөрвөх үнэт цааснаас бусад үнэт цаас гаргах, буцаан дуудах, түүний нөхцөлийг батлах;
- Компанийн засаглалын зарим баримт бичгийг батлах;
- Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- Компанийн холбогдох баримт бичгийг батлах;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрэмд заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэх бусад асуудал.

### ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/05 тоот тогтоолоор батлагдсан "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-аар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлага, бүрэн эрхийн хугацаа, ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, томилох, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, чөлөөлөх болон ТУЗ-ийн үйл ажиллагаа, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа, тэдгээрийн бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

### Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл 7 хүртэлх гишүүнтэй байх ба гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна." гэж заасны дагуу Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/02 тоот тогтоолоор Компанийн ТУЗ-ийн 4 гишүүнийг тус тус томилсон байна. Ингээд 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр ТУЗ хуралдаж, 24/04 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргыг сонгосон байна.

### Хүснэгт 6: Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд

| № | ТУЗ-ийн гишүүдийн нэр | Албан тушаал | ТУЗ-ийн гишүүнийг томилсон шийдвэр | Засаглалын гэрчилгээ авсан огноо, гэрчилгээний дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | Х.Сэргэлэн /Hu Siriguleng/ | ТУЗ-ийн дарга, гишүүн | Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/02 тоот шийдвэр; Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/04 тоот тогтоол | 2023.09.10 1030190 |
| 2 | Х.Тэгшээ | ТУЗ-ийн гишүүн | Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/02 тоот шийдвэр | 2023.06.23 1030179 |
| 3 | Ч.Агиймаа | ТУЗ-ийн гишүүн | Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/02 тоот шийдвэр | 2023.09.10 1030184 |
| 4 | Г.Намхайдорж | ТУЗ-ийн гишүүн | Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/02 тоот шийдвэр | 2023.09.10 1030182 |
| 5 | Э.Билгүүн | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/04 тоот тогтоол | 2024.04.16 0431221 |

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга



**Х.Сэргэлэн /Hu Siriguleng/**
ТУЗ-ийн дарга
**13+** жилийн туршлага

**Боловсрол**

- БНХАУ, Өвөр Монголын Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Маркетинг.

**Туршлага**

- 2011 – 2015 онд Ти Эм Эл ГХОХХК, Менежер;
- 2021 оноос одоог хүртэл Ти Эм Эл ГХОХХК, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч;
- 2024 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, ТУЗ-ийн дарга, Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүн.



**Х.Тэгшээ**
ТУЗ-ийн ердийн гишүүн
**20+** жилийн туршлага

**Боловсрол**

- БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль, Химич.

**Туршлага**

- 2006 оноос одоог хүртэл Ти Эм Эл ГХОХХК, Ерөнхий захирал;
- 2014 оноос одоог хүртэл Ти Эм Эл Трейд ХХК, Ерөнхий захирал;
- 2014 оноос одоог хүртэл Эм Жи Эл Акуа ХХК, Ерөнхий захирал;
- 2017 оноос одоог хүртэл Ньюгор ХХК, Ерөнхий захирал;
- 2017 оноос одоог хүртэл Эм Пластик ХХК, Ерөнхий захирал;
- 2018 оноос одоог хүртэл Ньюшилэн Интернэшнл ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2021 оноос одоог хүртэл Шидэт Чандмань Эрдэнэ ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2021 оноос одоог хүртэл Ти Эм Эл Констракшн ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2021-2023 онд ТЖТБ ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2022 оноос одоог хүртэл Эс И Жи Вай Вай ХХК, Гүйцэтгэх захирал;

СЗХ
2024 .07 сар 05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2024 -06- 03
БҮРТГЭВ-02

- 2023 оноос одоог хүртэл Эс И Эс Эл Смарт Солюшн ХХК, Ерөнхий захирал;
- 2024 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны дарга, Аудитын хорооны гишүүн.



**Ч.Агиймаа**
**ТУЗ-ийн ердийн гишүүн**
**12+ жилийн туршлага**

**Боловсрол**

- БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль, Менежмент;
- БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль, Англи хэл;
- МУИС, Хууль зүйн сургууль, Эрх зүй.

**Туршлага**

- 2012 – 2020 онд Магнай Трейд ХХК, Гадаад худалдааны менежер;
- 2017 – 2018 онд Жимобайл ХХК, Гадаад худалдааны менежер;
- 2020 – 2021 онд Магнай Трейд ХХК, Гадаад худалдааны ахлах менежер;
- 2021 – 2023 онд Ти Эм Эл ГХОХХК, Захирлын туслах;
- 2023 оноос одоог хүртэл Эс И Эс Эл Смарт Солюшн ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2023 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2024 оноос одоог хүртэл ТЖТЖ ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн, Ногоон санхүүжилтийн хорооны дарга.



**Г.Намхайдорж**
**ТУЗ-ийн ердийн гишүүн**
**10+ жилийн туршлага**

**Боловсрол**

- Төмөр замын коллеж, Машинист;
- Нийгмийн ухааны дээд сургууль, Нийгмийн ажилтан;
- Тайвань, Үндэсний Донг Хуа Их сургууль, Бизнесийн удирдлагын магистр.

**Туршлага**

- 2008 – 2010 онд Олон улсын хүүхдийн найрамдал төв, Бүлгийн багш;
- 2010 – 2011 онд Ногоон цэм ТББ, Төслийн мэргэжилтэн;
- 2012 – 2013 онд Чойсамбуу ХХК, Менежер;
- 2013 – 2024 онд Нум Өргөө констракшн ХХК, Менежер;
- 2018 – 2020 онд БиДиСек ҮЦК ХК, Хөрөнгө оруулалтын шинжээч;
- 2021 – 2023 онд Блюскай Секьюритиз ҮЦК ХК, Менежер;
- 2023 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, Эдийн засагч;
- 2024 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүн, Аудитын хорооны гишүүн, Ногоон санхүүжилтийн хорооны гишүүн.



**Э.Билгүүн**
**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга**
**3+ жилийн туршлага**

**Боловсрол**

- Монгол Улсын Их Сургууль, Бизнесийн сургууль, Санхүү эдийн засаг.

**Туршлага**

- 2021 – 2022 онд Апекс Капитал ҮЦК ХХК, Брокер;
- 2022 – 2023 онд Апекс Капитал ҮЦК ХХК, Санхүүгийн шинжээч;
- 2023 оноос одоог хүртэл Ти Эм Эл ГХОХХК, Санхүүгийн шинжээч;
- 2024 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



УЛААНБААТАР ХОТ

## 2.2.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

### ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь дараах байнгын болон түр хороодуудтай байна. Үүнд:

- Аудитын хороо;
- Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо;
- Ногоон санхүүжилтийн түр хороо.

### Аудитын хороо

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/06 тоот тогтоолоор "Аудитын хорооны үйл ажиллагааны журам"-ыг баталсан ба уг журмаар ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны бүтэц, хороодын гишүүдийн эрх, үүрэг, тэдгээрийг сонгох, чөлөөлөх, хурлыг зохион байгуулах, хороодын гишүүдийн цалин хөлсийг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байна.

Мөн Үнэт цаас гаргагчийн Аудитын хороо нь 3 (гурав)-аас доошгүй тооны гишүүнтэй байх ба ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар хорооны гишүүдийг сонгоно. Аудитын хорооны дарга болон нарийн бичгийн даргыг хорооны гишүүд сонгох ба хорооны нарийн бичгийн даргад хорооны аль нэг гишүүнийг сонгох эсхүл тус үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

1. **Аудитын хороо нь Компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагатай холбоотой үйл ажиллагаанд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:**

   - Компанийн үйл ажиллагаа, санхүү, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлон хянах ба Компанийн удирдлагын зүгээс эрсдэлийг тодорхойлох, үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах, тодорхой хугацаанд хянах явцад баримтлах удирдамж, бодлогыг тодорхойлох;
   - Компанийн хяналтын үйл ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгох, цар хүрээг өргөжүүлэх асуудлаар зөвлөмж боловсруулах;
   - Дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын үр дүнгийн ерөнхий байдалд үнэлгээ хийх бөгөөд Компанийн гүйцэтгэх удирдлага, төсөв, боловсон хүчний асуудал, түүнчлэн дотоод хяналт болон хөндлөнгийн аудитаас гаргасан зөвлөмжийг Компаниас хэрхэн хэрэгжүүлж байгаа зэргийг хянах;
   - Компьютерын системийн аюулгүй байдлыг хангах, ашиглах болон компьютерын системд саатал эсвэл эвдрэл гарах тохиолдолд санхүүгийн мэдээллийг боловсруулах, түүнд Компанийн мэдээлэл технологийн ажилтнуудын үүрэг хариуцлагыг тусгасан тусгай төлөвлөгөө боловсруулах, менежментийн боловсруулсан төлөвлөгөө, энэ талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

2. **Аудитын хороо нь Компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлантай холбоотой үйл ажиллагаанд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:**

   - Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн, бодит байдалд хяналт тавьж ажиллах;
   - Компанийн санхүүгийн тайлан болон дансны тэнцэл тооцоо гаргах ажлыг зохион байгуулах, бэлтгэлийг хангах ажилд туслалцаа үзүүлэх, Компанийн санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдал, ил тод байдал, бүрэн бүтэн байдлыг хангах;
   - Нягтлан бодох бүртгэлийн болон тайлагналтай холбоотой асуудлуудыг тодорхойлж, хянах;
   - Гүйцэтгэх удирдлагын зүгээс улирал, жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэх явцад хяналт тавих;
   - Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой зөвлөмжийг гаргаж ТУЗ-д хүргүүлэх ба Компанийн санхүүгийн тайлан болон үнэлгээнд хийсэн дүн шинжилгээний зөвлөмж болон аудитын хийгдсэн ажлын үр дүнгийн талаар зөвлөмж гаргаж танилцуулах;
   - Компанийн жилийн ажлын тайланг батлахын өмнө ТУЗ-д зөвлөмж бэлтгэн хүргүүлэх;



2024.07.05 өдөр № 01
2024-06-03 БҮРТГЭВ-02
TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

- Компанийн хийх их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах.

**3. Аудитын хороо нь Компанийн хөндлөнгийн аудитортай хамтран ажиллахтай холбоотой үйл ажиллагаанд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:**

- Хөндлөнгийн аудитораас Компанид үзүүлж болох хуулиар тогтоосноос бусад үйлчилгээг Аудитын хороо баталж, хяналт тавьж ажиллах;
- Хөндлөнгийн аудитор сонгох талаар зөвлөмж гаргах ба үүнд аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдал, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлийн асуудал, аудиторын хөлс зэргийг хамруулах;
- Хөндлөнгийн аудиторын ажлыг жилийн эцэст үнэлж дүгнэх, хөндлөнгийн аудиторын томилгоо, дахин томилох, эсвэл гэрээг цуцлах асуудлаар мэдээлэл зөвлөмж бэлтгэх ба хөндлөнгийн аудитын томилгоотой холбогдуулан хөндлөнгийн аудитыг дүгнэсэн, сонгон шалгаруулсан байдлыг хувьцаа эзэмшигчид танилцуулах;
- Хөндлөнгийн аудитортай хамтран тухайн жилийн аудитын ажлын хүрээ, төлөвлөгөө, аудитын дагаж мөрдөх дотоод дүрмийг батлах бөгөөд ингэхдээ Компанийн тухайн үеийн нөхцөл байдал, хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг болон тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг харгалзан үзэх ба мөн хөндлөнгийн аудитортай байгуулах гэрээний төслийг боловсруулах;
- Аудиторын хэвийн үйл ажиллагаанд саад бэрхшээл гарахад түүнийг шийдвэрлэх;
- Хөндлөнгийн аудиторын шалгалтын явцад илэрсэн зөрчил, түүний гаргасан зөвлөмж болон гүйцэтгэх удирдлагын зүгээс тухайн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаар хэлэлцэх;
- Компанийн санхүүгийн тайланг Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, практикийн дагуу бэлтгэх нөхцөлийг хангах;
- Хороо эсвэл хөндлөнгийн аудитор тухайн асуудлыг итгэмжилсэн байдлаар хэлэлцэх шаардлагатай гэж үзвэл аудиторыг Хорооны даргатай чөлөөтэй уулзах боломжоор хангах;
- Хөндлөнгийн аудитын Компани болон бусад Компанид зөвлөх үүрэг гүйцэтгэж байсан этгээд уг ажлаасаа гарч компанид ажилд орохыг хүссэн тохиолдолд Компанийн зүгээс баримтлах бодлого, журмыг боловсруулна.
- Хөндлөнгийн аудиторууд, түүн дотор Компанитай тэргүүн ээлжид ажилладаг аудитын Компанийн үйл ажиллагааг хязгаарлах, аудитын байгууллагыг заавал сольдог байх Компанийн бодлогыг боловсруулах, энэхүү бодлого нь дотоодын хууль тогтоомжийн хүрээнд боловсруулагдсан байх нөхцөлийг хангах.

**4. Аудитын хороо нь Компанийн дотоод хяналттай холбоотой үйл ажиллагаанд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:**

- Дотоод хяналт шалгалтын асуудал хариуцсан дотоод аудитын албаны боловсон хүчний болон төсвийн асуудал, түүний хараат бус байдлыг хангах асуудлаар зөвлөмж гаргах;
- Дотоод аудитын албатай уулзалт зохион байгуулах ба Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хамтарсан зөвлөмж боловсруулан гаргах түүнчлэн шаардлагатай тохиолдолд дотоод аудит алба хороотой чөлөөтэй харилцах нөхцөлөөр хангах;
- Дотоод аудитын албаны үйл ажиллагаанд үнэлгээ өгөх;
- Дотоодын аудитын ажлын тайланг хянаж, дотоод аудитын цаашид хийх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын ажилд зөвлөмж өгөх.

**5. Аудитын хороо нь Компанийн хууль, журмыг мөрдөхтэй холбоотой үйл ажиллагаанд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:**

- Дотоод хяналт шалгалтын явц, санхүүгийн нягтлан бодох бүртгэл болон тайлан, эсвэл хөндлөнгийн аудиттай холбоотой асуудлаар Компанийн хүлээн авсан гомдол, саналыг хянах журмыг боловсруулан мөрдөх;
- Ажилгасад нэргүй санал, гомдол гаргах нөхцөлөөр хангах ба тэдгээр гомдол, түүн дотор дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаанд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг гүйцэтгэх удирдлага болон бусад менежер, ажилтантай холбоотой залилан, хууль бус, ёс суртахуунд нийцээгүй үйлдэл, эс үйлдлийн талаар ирүүлсэн мэдээллийг хянаж шалгах.

СЗХ 2024.07.05 БҮРТГЭВ № 01
2024-06-03 БҮРТГЭВ-02
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

**Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо**

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/06 тоот тогтоолоор "Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам"-ыг баталсан ба уг журмаар ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах, томилох, эрх бүхий албан тушаалтнуудад олгох цалин урамшууллын дээд хэмжээг тогтоохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байна.

Тус хороо нь ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, Компанид ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд мэдлэг, ур чадвартай удирдах ажилтныг олж тогтоож, улмаар Компанийн бизнесийн зорилтдоо хүрэх, бизнесээ тогтвортой хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Хороо нь 3 гишүүнтэй байх ба гишүүдийг ТУЗ-ийн олонхын саналаар сонгоно.

1. **Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь нэр дэвшүүлэх хүрээнд дараах чиг үүрэгтэйгээр ажиллана. Үүнд:**

- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн ёс зүй, зан суртахуун, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, боловсрол, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгаж, ТУЗ-ийн хуралд танилцуулах;
- Компанийн залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулан ТУЗ-өөр батлуулах;
- Компанийн эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлага нь тухайн ажлын байрны шаардлагыг хангаж байгаа эсэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн бие даасан хараат бус байдал зэргийг тогтоох, тэдгээрийг сургах, мэргэшүүлэх ажлыг хариуцах;
- ТУЗ-ийн гишүүнийг улируулан томилох асуудлыг Хувьцаа эзэмшигчээр шийдвэрлүүлэхдээ гишүүнээр ажилласан нийт хугацаа, өмнөх бүрэн эрхийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, ТУЗ-ийн гишүүний үнэлгээ зэрэг мэдээллийг танилцуулах;
- ТУЗ-ийн хараат бус гишүүнээр нэр дэвшиж буй этгээдийн хараат бус байдлыг хэрхэн тодорхойлсон, бусад Компанийн эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг эсэх талаар Хувьцаа эзэмшигчид танилцуулах;
- ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгана;
- Шинээр томилогдож буй ТУЗ-ийн гишүүн бүрд цалин урамшуулал, хариуцлагын даатгалын хэмжээг тогтоох;
- Хараат бус гишүүний хувьд хараат бус байдал алдагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх болон Компанийн мэдээлэлтэй харьцах дэг журам, нууцлалын үүргийг хариуцах;
- ТУЗ-ийн гишүүд Компанийн ёс зүйн дүрэм, авлига, албан тушаалын гэмт хэргээс сэргийлэх, дотоод мэдээлэл эзэмшигчид хориглох үйл ажиллагааг дотооддоо баталж мөрдүүлэх;
- ТУЗ-ийн гишүүн, ерөнхий захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн болон хэлтэс, албадын даргын албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулахад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тогтооход ТУЗ-д туслах бөгөөд холбогдох зөвлөмжийг боловсруулах;
- ТУЗ-ийн гишүүн, ерөнхий захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн болон Компанийн бусад хэсэг, нэгжүүдийн хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшигчдэд урьдчилсан үнэлгээ өгөх;
- ТУЗ-ийн гишүүний хараат бус байдлыг тодорхойлох шалгууруудыг боловсруулах;
- Шинээр сонгогдсон хараат бус ТУЗ-ийн гишүүдэд гишүүний үүрэг хариуцлагыг тодорхой заасан удирдамж, зааварчилгаагаар хангах;
- Шаардлагатай гэж үзвэл ТУЗ болон түүний дэргэдэх хороод, гишүүдийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлэх;
- ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигт туссан зорилтын биелэлтийг жил бүр дүгнэж, Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оруулах.

**2. Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь цалин урамшууллын хүрээнд дараах чиг үүрэгтэйгээр ажиллана. Үүнд:**

- Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг ТУЗ-өөр батлуулж, хяналт тавих, холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах;
- Холбогдох хууль тогтоомж болон ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудлын хүрээнд тогтмол цалин, урамшуулалт цалин, үйл ажиллагааны чиглэл болон бусад нөхцөл байдлаас шалтгаалсан бусад хэлбэрийн урамшууллын зохистой хэмжээг тогтоох;
- ТУЗ, удирдах ажилтан болон бусад эрх бүхий ажилтанд олгох цалин хөлс болон урамшууллын бодлогыг тухайн ажилтны Компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, стратегийн зорилтыг биелүүлэхэд чиглэсэн үйлдэл, оруулсан хувь нэмэр болон ТУЗ-өөс баталсан зорилго, зорилтыг хэрхэн биелүүлсэн байдлыг харгалзах зарчмыг баримтлан боловсруулж, түүнд хяналт тавих;
- Компанийн ажилтны цалин, урамшуулалтай холбоотой дотоод дүрэм, журам, системийн үр дүнг үнэлж, холбогдох хууль тогтоомжид нийцэж буй байдалд хяналт тавих, Компанийн цалингийн бодлого, түвшин, бүтэц, цалин тогтоох журамд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-д тайлагнаж, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэх;
- ТУЗ-ийн дарга, хорооны гишүүн болон бусад зөвлөлийн гишүүдэд Компаниас олгох цалин урамшууллын шалгуурыг гишүүдийн хараат бус байдал нөлөөлөхгүй, өрсөлдөх чадвартай байлгахаар боловсруулах;
- Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн болон бусад удирдах албан тушаалтан, Компанийн эрх бүхий албан тушаалтны жилийн үндсэн цалингийн дээд хэмжээ, санхүүгийн болон бусад ажлын гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтэд суурилсан жилийн хувьсах урамшууллын систем, менежерүүдийн ашиг сонирхлыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолтой нийцүүлэх урт хугацааны урамшууллын систем мөн тэтгэвэр, тэтгэмж болон бусад нэмэлт орлогыг тогтоож, тогтмол хянах;
- Компанийн цалин урамшууллын шалгуурыг Компанийн хөгжлийн стратеги, санхүүгийн нөхцөл байдал болон хөдөлмөрийн зах зээлийн давамгай хандлага зэрэгт үндэслэн тохиромжтой эсэхийг тогтмол хянах;
- Хувьцаа эзэмшигчийн шийдвэрлэсэн гүйцэтгэх захирал, удирдах албан тушаалтны цалин урамшуулалтай холбоотой шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, түүнчлэн, захирлуудын цалин урамшууллын талаарх мэдээлэл, хэрэгжилтийг хянах;
- Бүх ажилчдын цалин урамшууллын бодлого боловсруулах чиглэлээр Компанийн удирдлага болон хүний нөөцийн боловсруулсан төсөлд саналаа оруулах.

### Ногоон санхүүжилтийн хороо

Үнэт цаас гаргагч нь ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/06 тоот тогтоолоор ногоон төслүүдийг сонгох болон үнэлэх, хяналт тавих ажлын хүрээнд Ногоон санхүүжилтийн түр хороог байгуулсан билээ.

Ногоон санхүүжилтийн хороо нь ногоон бонд гаргаснаас татан төвлөрүүлэх хөрөнгийг санхүүжүүлэхэд тохиромжтой төслүүдэд байршуулсан эсэх, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хуваарилалтын[1] болон нөлөөллийн[2] үнэлгээний тайланг төсөл тус бүрээр жил бүр хөрөнгө оруулагчдад өөрийн веб хуудсаар дамжуулан тайлагнах, мөн жил бүр хөндлөнгийн аудит томилж татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын болон хуваарилалтыг баталгаажуулсан тайланг[3] хөрөнгө оруулагчдад тайлагнах үндсэн чиг үүргийн хүрээнд ажиллана. Ногоон санхүүжилтийн хорооны зорилго нь ногоон бонд гарсны дараагаар эрх бүхий байгууллага болон олон нийтэд Компанийн талаарх үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэх, тайлагнах зэрэг харилцааг зохицуулан ажиллана.

**Ногоон санхүүжилтийн хороо нь дараах чиг үүрэгтэй ажиллана. Үүнд:**

[1] Хуваарилалтын тайлан – Ногоон бонд гаргаж татан төвлөрүүлсэн хөрөнгийн хуваарилалтын талаарх мэдээллийг агуулсан тайлан.

[2] Нөлөөллийн тайлан – Ногоон бонд гаргаж татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлсэн төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тоо болон чанарын үзүүлэлтээр үнэлсэн тайлан.

[3] Баталгаажуулах тайлан (Assurance report) – Ногоон бонд гаргаснаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт нь Үнэт цаас гаргагчийн Ногоон бондын хүрээ (Green bond framework)-д тусгагдсан төслүүдэд зарцуулагдсан эсэх, мөн санхүүжилт хийгдсэн төслүүд нь"Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ICMA)-ны Ногоон бондын зарчим (GBP)-д нийцэж буй эсэхийг баталгаажуулсан тайлан.

- Татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх тохиромжтой төслүүдийг сонгон шалгаруулах;
- Ногоон бондын хугацаа дуусах хүртэл төслүүдийг "Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо" (International Capital Market Association, ICMA)-ны Ногоон бондын зарчмууд (Green bond principles, GBP) болон Үнэт цаас гаргагчийн Ногоон бондын хүрээ (Greenbond Framework)-д тодорхойлсон шаардлагуудыг хангаж буй эсэхэд тогтмол хяналт тавих;
- Ногоон бондын татан төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулж буй эсэхэд хяналт тавих;
- Ногоон бондоор татан төвлөрүүлсэн хөрөнгийг шаардлага хангасан төслүүдэд хуваарилсан эсэхийг шалгах;
- Жил бүр эсхүл тухай бүр ногоон бондын татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт болон төслүүдийн нөлөөллийн тайланг хөрөнгө оруулагчдад өөрийн вэбсайтаар дамжуулан хүргэх;
- Хараат бус аудиторыг томилж, баталгаажуулах тайланг жил бүр гаргуулах.

**Ногоон санхүүжилтийн хороо нь татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх тохиромжтой төслүүдийг доорх шалгуур үзүүлэлтүүд болон алхмуудаар үнэлнэ. Үүнд:**

- Татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх тохиромжтой төслүүдийг "Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо" (ICMA)-ын Ногоон төслийн ангилалтай зэрэгцүүлэн үнэлэх;
- Татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх тохиромжтой төслүүдийг Үнэт цаас гаргагчийн Тогтвортой хөгжлийн бодлогод нийцэж байгаа эсэхийг үнэлэх;
- Татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх тохиромжтой төслүүдийг Монгол Улсын Ногоон таксономийн шалгуур үзүүлэлт болон Европын холбооны Ногоон таксономийн шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг үнэлэх;
- Татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх тохиромжтой төсөл тус бүр дээр нийгмийн болон байгаль орчны эрсдэлийг үнэлэх;
- Татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх тохиромжтой төслүүдийг Үнэт цаас гаргагчийн Ногоон бондын хүрээнд тодорхойлсон тохирох ногоон төслийн ангиллын шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг үнэлэх;
- Дээрх шалгууруудыг хангасан төслүүдийг татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх шийдвэрийг гаргах.

**Ногоон бонд гаргаснаар татан төвлөрүүлэх хөрөнгийг дараах чиглэлийн төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулахгүй. Үүнд:**

- Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ICMA)-ын Ногоон бондын зарчимд үл нийцэх төсөл;
- Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах төсөл;
- Химийн хорт болон аюултай бодисын хог хаягдал, түүнийг цуглуулах, дахин боловсруулах төсөл;
- Автомашины эд анги, сэлбэг хэрэгсэл болон цахилгаан барааны хог хаягдал, батарей цуглуулах, дахин боловсруулах төсөл;
- Барилгын хог хаягдал цуглуулах, дахин боловсруулах төсөл.

СЭХ
2024 .07 сар 05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд**

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/06 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг баталсан ба үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороод нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

**Хүснэгт 7: Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд**

| № | Хорооны нэр | Гишүүдийн тоо | Албан тушаал | Гишүүдийн нэрс | Төлөөлөн удирдах зөвлөл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Аудитын хороо | 3 | Дарга | Х.Сэргэлэн | ТУЗ-ийн дарга |
| | | | Гишүүн | Г.Намхайдорж | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| | | | Гишүүн | Х.Тэгшээ | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| 2 | Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо | 3 | Дарга | Х.Тэгшээ | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| | | | Гишүүн | Х.Сэргэлэн | ТУЗ-ийн дарга |
| | | | Гишүүн | Г.Намхайдорж | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| 3 | Ногоон санхүүжилтийн түр хороо | 3 | Дарга | Ч.Агиймаа | ТУЗ-ийн ердийн гишүүн, Гүйцэтгэх захирал |
| | | | Гишүүн | Г.Намхайдорж | ТУЗ-ийн ердийн гишүүн, Комплайнс, Эрсдэлийн эксперт |
| | | | Гишүүн | О.Өнөржаргал | БОНЗ менежер |
| | | | Гишүүн | Н.Жавхланчимэг | Ахлах нягтлан бодогч |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES

ХАК0303
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.07.05 өдөр
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

### 2.2.5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГЫН БАГ

#### Гүйцэтгэх удирдлага

Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс сонгосон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал Ч.Агиймаа нь Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 5/11 тоот шийдвэрээр томилогдсон байх ба холбогдох гэрээг байгуулан 2023 оноос хойш Компанийн Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байна.

**Хүснэгт 8: Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх удирдлагын танилцуулга**



**Ч.Агиймаа**
Гүйцэтгэх захирал
**12+** жилийн туршлага

**Боловсрол**
- БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль, Менежмент;
- БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль, Англи хэл;
- МУИС, Хууль зүйн сургууль, Эрх зүйч.

**Туршлага**
- 2012 – 2020 онд Магнай Трейд ХХК, Гадаад худалдааны менежер;
- 2017 – 2018 онд Жимобайл ХХК, Гадаад худалдааны менежер;
- 2020 – 2021 онд Магнай Трейд ХХК, Гадаад худалдааны ахлах менежер;
- 2021 – 2023 онд Ти Эм Эл ГХОХХК, Захирлын туслах;
- 2023 оноос одоог хүртэл Эс И Эс Эл Смарт Солюшн ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2023 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2024 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн, Ногоон санхүүжилтийн хорооны дарга.

#### Эрх бүхий албан тушаалтан

Үнэт цаас гаргагч нь Компанийн дүрэмдээ эрх бүхий албан тушаалтныг нарийвчлан заагаагүй тул Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт заасан компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог албан тушаалтнуудыг эрх бүхий албан тушаалтанд тооцно.

Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/09 тоот "Эрх бүхий албан тушаалтан томилох тухай" тушаалаар ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас бусад эрх бүхий албан тушаалтанг томилсон байх ба үүнд Компанийн Гүйцэтгэх захирал, Захиргаа, хүний нөөцийн албаны дарга, Ерөнхий менежер, Ахлах нягтлан бодогч нарыг эрх бүхий албан тушаалтанд тооцжээ.

Хуулийн дүгнэлтэд тусгаснаар Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан "Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-д заасан шаардлагыг хангасан байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES



УЛААНБААТАР ХОТ

2024.07.05
он сар өдөр
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Хүснэгт 9: Үнэт цаас гаргагчийн ТУЗ гишүүд ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас бусад эрх бүхий албан тушаалтан**



**Ч.Агиймаа**
Гүйцэтгэх захирал
**12+** жилийн туршлага

**Боловсрол**

- БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль, Менежмент;
- БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль, Англи хэл;
- МУИС, Хууль зүйн сургууль, Эрх зүйч.

**Туршлага**

- 2012 – 2020 онд Магнай Трейд ХХК, Гадаад худалдааны менежер;
- 2017 – 2018 онд Жимобайл ХХК, Гадаад худалдааны менежер;
- 2020 – 2021 онд Магнай Трейд ХХК, Гадаад худалдааны ахлах менежер;
- 2021 – 2023 онд Ти Эм Эл ГХОХХК, Захирлын туслах;
- 2023 оноос одоог хүртэл Эс И Эс Эл Смарт Солюшн ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2023 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2024 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн, Ногоон санхүүжилтийн хорооны дарга.



**И.Туул**
Захиргаа, хүний нөөцийн албаны дарга
**10+** жилийн ажлын туршлага

**Боловсрол**

- МУИС, Олон Улсын харилцааны сургууль, Олон улсын эдийн засгийн харилцаа;
- БНСУ, Kumoh National Institute of Korea, Бизнесийн удирдлага.

**Туршлага**

- 2014 онд Магнай Трейд ХХК, Захирлын туслах, менежер;
- 2016 онд Хөдөлмөрийн яам, Нэгдсэн төсөл хариуцсан мэргэжилтэн;
- 2017 онд Жимобайл ХХК, Байгууллага хариуцсан менежер;
- 2018 онд Магнай Трейд ХХК, Үйл ажиллагаа хариуцсан менежер;
- 2021 онд Ти Эм Эл ГХОХХК, Хүний нөөцийн менежер;
- 2022 онд Ти Эм Эл ГХОХХК, Төсөл хариуцсан захирал;
- 2024 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, Захиргаа, хүний нөөцийн албаны дарга.



**Н.Жавхланчимэг**
Ерөнхий нягтлан бодогч
**15+** жилийн туршлага

**Боловсрол**

- Олон Улсын эдийн засаг бизнесийн их сургууль, Банк, санхүүгийн нягтлан бодогчийн магистр;
- Санхүү Эдийн засгийн Их Сургууль, Санхүүгийн менежмент.

**Туршлага**

- 2008 – 2012 онд Капитал банк ХХК, Теллер, Ахлах теллер;
- 2013 – 2016 онд Номин Холдинг ХХК, Тооцооны нягтлан бодогч;
- 2016 – 2019 онд Атар-Өргөө ХК, Ахлах нягтлан бодогч;
- 2019 – 2022 онд МАК ХХК, Ерөнхий нягтлан бодогч;
- 2022 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, Ерөнхий нягтлан бодогч;
- 2024 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, Ногоон санхүүжилтийн түр хорооны гишүүн.



**Ц.Дайчин /Dai Qin/**
Ерөнхий менежер
**5+** жилийн туршлага

**Боловсрол**

- БНХАУ, Өвөр Монголын Эдийн засаг, Аж ахуйн Их Сургууль, Аялал жуулчлалын менежмент.

**Туршлага**

- 2019 онд Ньюгор ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2019 онд ТЖТБ ХХК, Үйлдвэрийн дарга;
- 2023 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, Ерөнхий менежер.

TDB SECURITIES
ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ 2024.07.06 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны алба**

Үнэт цаас гаргагч нь Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын алба, Захиргаа, хүний нөөцийн алба, Маркетинг, борлуулалтын алба, Үйлдвэрлэлийн алба, Чанар хяналтын алба, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн алба гэх 6 албуудаар дамжуулан өдөр тутмын үйл ажиллагаагаа тогтвортой явуулан ажиллаж байна.

**Хүснэгт 10: Үнэт цаас гаргагчийн албууд**

| № | Үйл ажиллагааны албууд | Үйл ажиллагааны албуудын чиг үүрэг |
|---|---|---|
| 1 | **Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын алба** | Компанийн санхүүгийн зорилт, төлөвлөгөө, төсвийг тодорхойлон боловсруулах, гүйцэтгэлийг хянах, үйл ажиллагаанд баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх, санхүү, аж ахуйн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн асуудалд хяналт тавих, тэдгээрийг жишиг стандартын дагуу хөтлөх, санхүүгийн гүйлгээнүүд буюу орлого, зарлагын бүртгэл хийх, хяналт тавих, хөрөнгө, хангамжийн ашиглалт, зарцуулалт, мөнгөн хөрөнгийн урсгалыг удирдах, хянах, санхүүгийн тайлан, холбогдох тодруулга мэдээллүүдийг боловсруулж тайлагнах, татварын тайлан, бүртгэл, нийгмийн даатгал, бусад тооцоонуудыг бэлтгэн боловсруулж холбогдох этгээдэд тайлагнах, Компанийн бүтээгдэхүүн үйлчилгээ, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцоолж эрх бүхий этгээдэд тайлагнах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. |
| 2 | **Захиргаа, хүний нөөцийн алба** | Компанийн урт болон дунд хугацааны стратеги зорилт, бизнес төлөвлөгөөний хүрээнд хүний нөөцийн нэгдсэн удирдлага, бодлого, стратеги, менежмент, ажилтнуудын сургалт хөгжлийг дэмжих, сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, ажилтнуудын хөдөлмөр эрхлэлтийн харилцааны хэвийн байдлыг хангах, хөдөлмөрлөх таатай нөхцөлийг бүрдүүлэх, бусад албаны хэвийн тасралтгүй үйл ажиллагаа явуулахтай холбоотой асуудалд дэмжлэг туслалцаа үзүүлэх болон байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад чиглэсэн алба юм. Мөн хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжил, хөдөлмөрийн харилцааны зохицуулалт зэрэг үйл ажиллагааг удирдлагаар хангахын зэрэгцээ оффисын болон үйлдвэрийн байрны өдөр тутмын үйл ажиллагааны зохицуулалт, үйлчилгээг удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. |
| 3 | **Маркетинг, борлуулалтын алба** | Компанийн зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, экспорт болон борлуулалтын хувь хэмжээг тогтмол нэмэгдүүлэх борлуулалтын төлөвлөгөө, тоон зорилтыг баталж хэрэгжүүлэхэд чиглэсэн алба юм.<br><br>Маркетинг, борлуулалтын алба нь боломжит гадаадын болон дотоодын худалдан авагчдыг тодорхойлох, тэднийг татах арга замыг эрэлхийлж, урт хугацаанд тогтвортой хамтран ажиллах, худалдан авагчдад мэдлэг, мэдээлэл түгээх, харилцагчдын сэтгэл ханамжийг судалж улмаар бүтээгдэхүүнийг илүү хэрэглэгчдэд ойр, хэрэгцээтэй болгон хөгжүүлэх боломжийг эрэлхийлэн ажилладаг байна. Мөн бэлэн бүтээгдэхүүнийг гадаад болон дотоодын харилцагч худалдан авагчдын гарт хамгийн түргэн шуурхайгаар тээвэрлэж, захиалгын дагуу хурдан, шуурхай, хадгалалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байдлаар чанарт өөрчлөлт оруулахгүйгээр борлуулан түгээх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

2024.07.05
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 02

| | | |
|---|---|---|
| 4 | **Үйлдвэрлэлийн алба** | Үйлдвэрлэлийн алба нь батлагдсан технологи, горимын дагуу шингэн хүнсний хуванцар хаягдлыг боловсруулж, олон улсын чанарын стандартууд болох (FSSC -22000, GRS, ISO 14001:2015, ISO 9001:2015, FDA, EFSA)-д нийцсэн мөхлөг болох rPET буюу эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг зохион байгуулан ажиллах бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан, орчин, барилга байгууламж, ажлын байранд зориулалтын багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг ашиглан, чанар, аюулгүй байдлын үзүүлэлтүүдийн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг өдөр тутмын тасралтгүй үйл ажиллагааг хангах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. |
| 5 | **Чанар хяналтын алба** | Чанарын иж бүрэн удирдлагын тогтолцоо болон бүтээгдэхүүний орц, гарцын хяналтыг сайжруулах, сорилт шинжилгээ хийх, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор стандартыг хэрэгжүүлж, дэлхийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсын стандартад нийцсэн эцсийн бүтээгдэхүүн болон гаднаас нийлүүлэгдэж буй технологийн материал, тоног төхөөрөмжийн хяналтад хамтран ажиллах, гологдол, ашиггүй үлдэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хэмжлийн нэгдмэл байдал, чанарын менежментийн тогтолцоо, олон улсын чанарын стандартад нийцсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хяналт тавих, стандартын талаарх асуудлыг хариуцах үндсэн чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.<br><br>Чанарын алба нь түүхий эдээс бэлэн бүтээгдэхүүн гарах хүртэлх бүхий л үе шатанд дотоодын лабораторийн хяналтыг 1 цаг тутамд тогтмол тавьж ажилладаг бөгөөд хяналтын үед илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр залруулж, чанарын тогтолцоог сайжруулах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлдэг байна. |
| 6 | **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн алба** | ХАБЭА алба нь байгууллагын хэмжээнд ажилтан албан хаагчдын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсэн чиглэлд суурь зарчмыг баримтлан ХАБЭА-н хууль, холбогдох стандартад нийцүүлэн ХАБЭА-н бодлого, удирдлагын тогтолцооны журам, дүрэм, заавар, стандартыг боловсруулах, хяналт тавих, хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлсийн хэмжилт, шинжилгээ хийх, аюулгүй ажиллах арга барилд сургах, мэдлэг олгох, осол эндэгдэл гарахаас урьдчилан сэргийлэх, Хүнсний аюулгүй байдлыг хангаж ажилчдыг эрүүл хоол хүнсээр хангах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, тайлагнах үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES



ХХК
УЛААНБААТАР ХОТ

## 2.2.6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХҮНИЙ НӨӨЦ



**Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн бодлого**

Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн бодлогын гол зорилго нь тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгож, байгууллагын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн хүний нөөцийн удирдлагыг цогцоор нь хэрэгжүүлэхэд оршино.

Үнэт цаас гаргагч нь бизнесийн үйл ажиллагааг тогтвортой байлгахын тулд компанид шаардлагатай ур чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлж, ажилчдын ур чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, чадавхжуулах, ажилтанд ээлтэй ажиллах орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн хөдөлмөрийн зах зээлд ажлын байрыг нэмэгдүүлэх болон ажилтны бүтээмжийг дээшлүүлэх, ажиллах таатай орчныг бүрдүүлэх бодлогыг баримталдаг.

Үнэт цаас гаргагч нь хөдөлмөрийн харилцааг "Хөдөлмөрийн дотоод журам", "Хүний нөөцийн бодлого", "Бүрдүүлэлт сонгон шалгаруулалт, чиглүүлгийн журам", "Шагнал урамшууллын журам", "Цалин хөлсний журам", "Сургалтын журам" "Ёс зүйн дүрэм" зэрэг бодлого, журмуудаар зохицуулж байна.

Мөн үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн тогтвортой байдал, ажилтнуудын ажлын байрны найдвартай байдлыг чухалчлан үздэг бөгөөд цар тахлын нийгэм эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд бүтэц орон тоонд өөрчлөлт оруулалгүй цалин хөлсийг олгож ажлын байрыг хадгалж үлдэх зарчмыг баримтлан хэрэгжүүлсэн.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт 148 ажилтантай байх бөгөөд үүний 55 хувийг эрэгтэй ажилчид, үлдсэн 45 хувийг эмэгтэй ажилчид тус тус бүрдүүлж байна. Мөн ажилтнуудын 22 хувь нь дээд боловсролтой, 52 хувь нь бүрэн дунд боловсролтой, 16 хувь нь тусгай дунд боловсролтой, 10 хувь нь бүрэн бус дунд боловсролтой байна. Насжилтын хувьд 20 хувийг 19-25 насны залуучууд эзэлж байгаа бол 30 хувийг 26-35 настай ажилчид, 30 хувийг 36-45 настай ажилчид, үлдсэн 20 хувийг 46-аас дээш настай ажилчид бүрдүүлж байна.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

2024.07.05 СЗХ БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ

**Хүснэгт 11: Үнэт цаас гаргагчийн хүний нөөцөд чиглэсэн үйл ажиллагаа**

| | |
|---|---|
| **Эрүүл мэндэд чиглэсэн** | • **Эрүүл ажилтан бидний бахархал:** Үнэт цаас гаргагч нь ажилтан бүрийг эрүүл мэндийн үзлэг буюу урьдчилан сэргийлэх шинжилгээнд жил бүр хамруулдаг ба энэ нь ажилтан бүрд эрүүл мэндийн шалтгаанаар үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлдэг.<br>• **Спортлог эрүүл чийрэг ажилтан:** Үнэт цаас гаргагч нь ажилтнуудынхаа чөлөөт цагийг зөв зохистой, идэвхтэй өнгөрүүлэх зорилгоор сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис зэрэг спортын төрлүүдээр хичээллэх боломж бүхий спорт заал болон чийрэгжүүлэх төвүүдтэй хамтран ажилладаг. |
| **Боловсрол, хувь хүний хөгжилд чиглэсэн** | • **Сургалт хөгжил:** Үнэт цаас гаргагч нь ажилтнуудынхаа ур чадварыг тодорхойлон, ур чадвар дээр суурилан сургалтын хэрэгцээг нь тодорхойлсны дагуу гадаад болон дотоод эх үүсвэрээс ерөнхий ур чадварын сургалт, мэргэшүүлэх сургалт болон техникийн ур чадварын сургалтуудад ажилчдадаа тогтмол хамруулж байна.<br>• **Идэвхжүүлэлт:** Ажилчдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, өөрийгөө нээн харуулах боломж олгох, багаар ажиллах, хамт олонч уур амьсгал бүрдүүлэх зорилгоор Компани нь "Сургалтын журам"-ынхаа хэрэгжилтийг хангаж, олон сонирхолтой тэмцээн, уралдааныг тогтмол зохион байгуулж байна. Мөн жил бүр намрын улиралд нийт ажилтнуудыг хамруулсан амралт, зугаалга, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг. |
| **Нийгмийн хангамжид чиглэсэн** | • **Даатгал:** Үнэт цаас гаргагч нь ажилтнуудаа ажлын байрны онцлогоос шалтгаалан гэнэтийн ослын даатгалд хамруулдаг байна.<br>• **Шагнал урамшуулал:** Үнэт цаас гаргагч нь ажилтнуудын гүйцэтгэлийн үр дүн, компанийн үйл ажиллагааны үр ашигт байдлыг нэмэгдүүлэхийн тулд ажил үйлсээрээ манлайлсан, урт хугацаанд тогтвор суурьшилтай ажилласан ажилтнуудыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх бодлогыг баримталдаг. Энэхүү бодлогын хүрээнд ажилтнуудын тэтгэмж, хөнгөлөлт тусламж, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдгээс гадна урлаг, спортын гэх мэт олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг. Түүнчлэн дотооддоо ажлын байр бүрээр амжилт бүтээл, ажлын гүйцэтгэлийг үнэлж өндөр гүйцэтгэлтэй ажилласан манлайлагч ажилтнуудыг шалгаруулан жил бүр гадаад улс руу аялах эрхийн бичгээр шагнаж, тэргүүний ажилтнуудыг мөнгөн шагнал, өргөмжлөл үнэ бүхий зүйлээр урамшуулдаг. Шагнал урамшууллаттай холбоотой төсвийн санхүүжилтийг санхүүгийн төлөвлөгөөндөө жил бүр тусгаж, хэрэгжүүлдэг.<br>• **Хөнгөлөлт:** Ажиллагсдадаа сайн чанарын хоол хүнсээр тогтмол үйлчилдэг, гар утасны ярианы төлбөрийн хөнгөлөлт үзүүлэхээс гадна албан хэрэгцээнд ашиглах автомашины бензиний хөнгөлөлтийг журмын дагуу олгодог байна. |

### Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн менежментийн стратеги

Үнэт цаас гаргагч нь чадварлаг хүний нөөцийг байгууллагадаа татах шилдэг ажил олгогч буюу хөдөлмөрийн зах зээл дэх өрсөлдөгч байхын тулд дараах стратегийг хүний нөөцийн бодлогодоо хэрэгжүүлдэг. Үүнд:

- **Санхүү борлуулалт**: Хүний нөөцийн зардлын санг ажил олгогч болон ажилтан аль алинд нь ээлтэй байхаар тооцож, гүйцэтгэлийн хяналтыг тогтмол сайжруулах.
- **Бүтээгдэхүүн, чанар стандарт**: Үйлдвэрлэлийн шугамын эцсийн бүтээгдэхүүнд шинжилгээ хийхээс гадна түүхий эдийн шинж чанар, үйлдвэрлэлийн процесст хяналт тавьдаг. Хүн төвтэй байгууллагын эрүүл зөв соёлыг төлөвшүүлж бэхжүүлэх.
- **Процессын сайжруулалт**: Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дэмжих замаар хүний нөөцийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах.

TDB SECURITIES

**Сургалт, хөгжил:** Нийт ажилтнуудын мэдлэг ур чадварыг хөгжүүлэх, байгууллагын сургалт хөгжлийн тогтолцоог тасралтгүй сайжруулах.

Үнэт цаас гаргагч нь шилдэг ажил олгогч бөгөөд сайн хамтрагч байх стратегийн хүрээнд дараах 6 **"CHOICE зарчим"**-ыг баримталдаг байна. Үүнд:

**C**aring about people */Ажилтнуудаа анхаардаг, хүндэлдэг байх/*
**H**onesty and fairness */Үнэнч, шударга байх/*
**O**pen communication */Нээлттэй харилцаа, холбоотой байх/*
**I**nvolvement */Ажилтнуудын оролцоог дэмжих/*
**C**oaching and assisting */Зааварчлах, туслан дэмжих/*
**E**thical practice */Ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх/*

СЭХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

## 2.2.7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БАЙГУУЛСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

### 2.2.7.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт зааснаар "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)", мөн "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцно.

Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг ТУЗ тогтоох бөгөөд ТУЗ нь их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшны уналтын түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болдог.

Их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ нь Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэгт заасны дагуу санал нэгтэйгээр гаргах ёстой бөгөөд шийдвэрийг санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь их хэмжээний хэлцэл хийх асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэдэг.

Хуулийн дүгнэлтэд тусгагдсанаар Компанийн үйл ажиллагаа, бичиг баримт, гэрээ хэлцэлд хийсэн хуулийн дүн шинжилгээнийхээ үр дүнд "ТЖТБ" ХХК нь сүүлийн гурван жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт тодорхойлсон 5 их хэмжээний хэлцэл байгуулсан байна.

**Хүснэгт 12: Үнэт цаас гаргагчийн байгуулсан их хэмжээний гэрээ, хэлцэл**

| № | Гэрээний огноо | Гэрээний дугаар | Гэрээний утга | Гэрээ байгуулсан тал |
|---|---|---|---|---|
| 1 | 2021.11.04 | ЗБ/СС211101019-10-68 | Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээ | Худалдаа, хөгжлийн банк ХК |
| 2 | 2021.12.23 | ЗГ5004849212 | Зээлийн шугамын гэрээ | ХасБанк ХК |
| 3 | 2023.02.07 | ЗГ1540083030 | Бизнесийн зээлийн гэрээ | ХасБанк ХК |
| 4 | 2023.03.06 | ЗГ5005614061 | Зээлийн шугамын эрх нээх гэрээ | ХасБанк ХК |
| 5 | 2023.04.05 | ЗБ/СС230405029-10-51 | Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээ | Худалдаа, хөгжлийн банк ХК |

### 2.2.7.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д зааснаар сонирхлын зөрчил бүхий этгээд гэдэг нь компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай хуульд заасан харилцаанд орсон бол компанитай, эсвэл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэдэг сонирхлын зөрчил бүхий этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж байгаа хэлцлийг хэлнэ. Хэлцлийг хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар гаргах бөгөөд ТУЗ нь сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан



TDB SECURITIES

авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг тогтооно.

Хуулийн дүгнэлтэд тусгагдсанаар Компанийн үйл ажиллагаа, бичиг баримт, гэрээ хэлцэлд хийсэн хуулийн дүн шинжилгээнийхээ үр дүнд "ТЖТБ" ХХК нь сүүлийн гурван жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй 8 хэлцэл байгуулсан байна.

**Хүснэгт 13: Үнэт цаас гаргагчийн байгуулсан сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл**

| № | Гэрээний огноо | Гэрээний дугаар | Гэрээний утга | Гэрээ байгуулсан тал | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2021.07.01 | - | Хоёрдогч түүхий эд /PET/ хуванцар сав нийлүүлэх гэрээ | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |
| 2 | 2023.06.30 | ХХАГ-240602 | Хоёрдогч түүхий эд /PET/ хуванцар сав нийлүүлэх гэрээний нэмэлт гэрээ | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |
| 3 | 2021.08.02 | TML/НГ-2108 | Түүхий эд, сэлбэг хэрэгсэл, хангамжийн материал нийлүүлэх гэрээ | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |
| 4 | 2021.09.01 | - | Түүхий эд, материал нийлүүлэх гэрээ | Эм жи эл акуа ХХК | Хэрэгжиж байгаа |
| 5 | 2023.04.06 | MP-23040 | Түүхий эд, материал бэлтгэн нийлүүлэх гэрээ | Эм пластик ХХК | Хэрэгжиж байгаа |
| 6 | 2023.09.30 | - | Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний дагалдах баримт бичиг | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |
| 7 | 2024.03.01 | - | Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний дагалдах баримт бичгийн нэмэлт өөрчлөлт | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |
| 8 | 2024.03.01 | - | Төлбөр харилцан тооцох гэрээ | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |

### 2.2.8. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАВ БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВЬТАЙ ТЭНЦЭХ ХЭМЖЭЭНИЙ ҮНИЙН ДҮН БҮХИЙ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ГЭРЭЭ, ХЭЛЦЭЛ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.7 дахь заалт, Биржийн баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 4.3.7 дахь заалт заасны дагуу Хуулийн дүгнэлтэд тусгагдсанаар Компанийн сүүлийн нэг жилийн хугацаанд байгуулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар нийт 32 байна. Үүнд:

**Хүснэгт 14: Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл**

| № | Гэрээний огноо | Гэрээний дугаар | Гэрээний утга | Гэрээ байгуулсан тал | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2021.07.01 | - | Хоёрдогч түүхий эд /PET/ хуванцар сав нийлүүлэх гэрээ, түүний Нэмэлт гэрээ | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |
| 2 | 2021.08.02 | TML/НГ-2108 | Түүхий эд, сэлбэг хэрэгсэл, хангамжийн материал нийлүүлэх гэрээ | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |
| 3 | 2021.11.04 | ЗБ/CC211101019-10-68 | Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээ | Худалдаа, хөгжлийн банк ХК | Хэрэгжиж байгаа |
| 4 | 2021.09.01 | - | Түүхий эд, материал нийлүүлэх гэрээ | Эм жи эл акуа ХХК | Хэрэгжиж байгаа |
| 5 | 2021.12.23 | ЗГ5004849212 | Зээлийн шугамын гэрээ | ХасБанк ХК | Хэрэгжиж байгаа |
| 6 | 2022.05.01 | - | Ариутгал халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээ | Ариун сан нар ХХК | Хэрэгжиж байгаа |
| 7 | 2023.02.07 | ЗГ1540083030 | Бизнесийн зээлийн гэрээ | ХасБанк ХК | Хэрэгжиж байгаа |
| 8 | 2023.03.06 | ЗГ5005614061 | Зээлийн шугамын эрх нээх гэрээ | ХасБанк ХК | Хэрэгжиж байгаа |
| 9 | 2023.04.05 | ЗБ/CC230405029-10-51 | Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээ | Худалдаа, хөгжлийн банк ХК | Хэрэгжиж байгаа |
| 10 | 2023.04.06 | MP-23040 | Түүхий эд, материал бэлтгэн нийлүүлэх гэрээ | Эм пластик ХХК | Хэрэгжиж байгаа |
| 11 | 2023.05.25 | ХХГ230525-1 | Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ | Масс солюшн ХХК | Хэрэгжиж байгаа |
| 12 | 2023.05.25 | ХХГ230525-2 | Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх гэрээ | Масс солюшн ХХК | Хэрэгжиж байгаа |
| 13 | 2023.06.30 | ХХАГ-240602 | Хоёрдогч түүхий эд /PET/ хуванцар сав нийлүүлэх гэрээний нэмэлт гэрээ | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |
| 14 | 2023.07.19 | 19923070012 | Даатгалын ерөнхий гэрээ | Тэнгэр Даатгал ХХК | Хэрэгжиж байгаа |
| 15 | 2023.07.25 | 619923011341 | Бараа материалын даатгалын дэд гэрээ | Тэнгэр Даатгал ХХК | Хэрэгжиж байгаа |
| 16 | 2023.07.25 | 619923011200 | Тоног төхөөрөмжийн даатгалын дэд гэрээ | Тэнгэр Даатгал ХХК | Хэрэгжиж байгаа |
| 17 | 2023.08.07 | S-50/23 | Хууль зүйн үйлчилгээний гэрээ | Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН | Хэрэгжиж байгаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18 | 2023.08.31 | Ш-23/099 | Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ | Цэцүүх Трейд ХХК | Хэрэгжиж байгаа |
| 19 | 2023.09.01 | №T-23 | Аюултай хог хаягдал тээвэрлэлтийн гэрээ | Цэцүүх Трейд ХХК | Хэрэгжиж байгаа |
| 20 | 2023.12.01 | 2023/36 | Ус ашиглах гэрээ | Нийслэлийн байгаль орчны газар | Хэрэгжиж байгаа |
| 21 | 2023.09.12 | 18 | Аудитын үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ | Пи Кэй Эф Монголиа Аудит ХХК | Хэрэгжиж дууссан |
| 22 | 2023.09.27 | GB-230901 | Хөрөнгийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ | Гэрэгэ Эстимэйт ХХК* | Хэрэгжиж байгаа |
| 23 | 2023.09.30 | - | Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний дагалдах баримт бичиг | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |
| 24 | 2023.10.11 | ЗГ1540083107 | Бизнесийн зээлийн гэрээ | Хас Банк ХК | Хэрэгжиж байгаа |
| 25 | 2023.11.15 | 231115-01 | Худалдах худалдан авах гэрээ | Inner Mongolia Temonte Industry and Trade Co., LTD | Хэрэгжиж байгаа |
| 26 | 2023.12.18 | 00158705.0 | SPO Гэрээ | Sustainable Fitch | Хэрэгжиж байгаа |
| 27 | 2021.12.01<br>2023.12.28 | ES_SD_C21104<br>ES_SD_C21104 | Цахилгаан эрчим хүчээр хангах, ашиглалт үйлчилгээний гэрээ, түүний нэмэлт | "Эрчим сүлжээ" ХХК | Хэрэгжиж байгаа |
| 28 | 2023.12.22<br>2024.04.15 | TDBS-575/2023<br>TDBS-618/2024 | Андеррайтер - Зөвлөх үйлчилгээний гэрээ, түүний нэмэлт | Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК | Хэрэгжиж байгаа |
| 29 | 2024.01.16 | ЗГ1540083134 | Бизнесийн зээлийн гэрээ | Хас Банк ХК (Зээлдүүлэгч) Ти Эм Эл ГХОХХК (Зээлдэгч) ТЖТБ ХХК (хамтран үүрэг гүйцэтгэгч) | Хэрэгжиж байгаа |
| 30 | 2024.02.01 | 90C2420001208 | Даатгалын гэрээ | Монгол Даатгал ХХК | Хэрэгжиж байгаа |
| 31 | 2024.03.01 | - | Төлбөр харилцан тооцох гэрээ | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |
| 32 | 2024.03.01 | - | Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний дагалдах баримт бичгийн нэмэлт өөрчлөлт | Ти Эм Эл ГХОХХК | Хэрэгжиж байгаа |

***2024 онд хуулийн этгээдийн нэр өөрчлөгдөж Гэрэгэ-Эстимэйт Үнэлгээ ХХК болсон.**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -06- 03
БҮРТГЭВ-02

## 2.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.3.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"ТЖТБ" ХХК нь анх 2007 онд гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан. Компани нь Монгол Улсын байгаль орчны бохирдлыг бууруулах зорилгоор өдөр тутам үүсэж буй шингэн хүнсний **хуванцар хог хаягдал (PET-PolyEthylene Terephthalate)-ыг дахин боловсруулах** үйлдвэрийн төслийг санаачлан, 2018 оноос хойш үйлдвэрийн бэлтгэл ажлыг хангаң PET хог хаягдлыг цуглуулж эхэлсэн ба Монгол Улсдаа анхдагч томоохон дахин боловсруулах үйлдвэр болох **Ти Эм Эл Пластик** үйлдвэрээ 2019 онд байгуулсан. Улмаар 2021 онд албан ёсоор үйлдвэрлэлээ эхлүүлж, "Ти Эм Эл Трейд" ХХК-ийн харьяа компани болсон. Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын шингэн хүнсний үйлдвэрлэлийн салбарт дахин боловсруулсан түүхий эдийн тухай ойлголтыг анх нэвтрүүлэн, "Савнаас Сав" үйлдвэрлэх түүхий эдийг үйлдвэрлэж, олон улсын стандартад нийцсэн мөхлөг буюу rPET-г 3 дахь жилдээ дотоодын зах зээлд төдийгүй гадаад зах зээлд нийлүүлж байна.

Үнэт цаас гаргагч нь байгаль орчинд ээлтэй тус үйл ажиллагаагаараа дамжуулан хүлэмжийн хийн ялгарлыг багасгаж, орчны бохирдлыг бууруулах замаар ээлтэй хот, иргэдийн оролцоо, хариуцлагатай хэрэглээг дэмжин, урт хугацаанд тогтвортой ногоон хөгжлийн бодлогыг баримтлан ажиллаж байна.

Түүнчлэн "ТЖТБ" ХХК нь байгаль орчинд ээлтэй, хаягдал багатай, үр ашигтай дахин боловсруулах үйлдвэрлэлээрээ дамжуулан хөгжлийн өнөөгийн чиг хандлагыг өөрчилж, байгалийн шавхагдах нөөц баялаг, экосистемийн үнэ цэнийг хадгалан, хог хаягдлын менежментийг сайжруулан эдийн засгийн эргэлтэд оруулахаар зорин ажиллаж байна. Мөн үйлдвэрлэлээрээ дамжуулан төслийн бүх оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг бий болгож, Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ)-ын Тогтвортой хөгжлийн зорилт болон Монгол Улсын хөгжлийн зорилтуудад хувь нэмрээ оруулж байна.

**Зураг 3: Үнэт цаас гаргагчийн алсын хараа, эрхэм зорилго, уриа үг**

**Алсын хараа**
Дэлхийд тэргүүлэх технологиор хуванцар хог хаягдлыг дахин боловсруулж, номин ногоон ирээдүйд хувь нэмрээ оруулна.

**Эрхэм зорилго**
Хог хаягдлын тогтвортой менежментийг бий болгож, уусдаггүй хог хаягдлыг байгальд ээлтэй технологиор дахин боловсруулна

**Уриа үг**
Ухаалаг хэвшил – Ногоон ирээдүй

**Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

**Хүснэгт 15: Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

| | |
|---|---|
| **Тогтвортой ногоон бизнес** | • "ТЖТБ" ХХК нь Ти Эм Эл Пластик үйлдвэрээрээ дамжуулан Монгол Улсад өдөр тутам үүсэж буй ус, ундааны хуванцар хог хаягдлыг (PET буюу PolyEthylene Terephthalate) дахин боловсруулж хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулан, байгалийн шавхагдах нөөцийг хэмнэн, эдийн засгийн эргэлтэд оруулж тогтвортой ирээдүйд хувь нэмрээ оруулах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.<br>• Үнэт цаас гаргагч нь жилд 27,000 тонн PET хуванцар хаягдал дахин боловсруулах хүчин чадалтай Ти Эм Эл Пластик үйлдвэрээрээ дамжуулан хүнсний зориулалттай сав баглаа боодлын дахин боловсруулсан түүхий эд болох rPET мөхлөгийг үйлдвэрлэдэг.<br>• Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэж буй rPET мөхлөг нь АНУ-ын Хүнс ба Эмийн чанарын хяналтын газар (FDA - Food and Drug Administration)-аар хүлээн зөвшөөрөгдсөн, мөн GRS (Global recycled standard) стандарт, чанарын |

TDB SECURITIES

СЭХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

удирдлагын ISO 9001:2015 стандарт, байгаль орчны менежментийн ISO 14001:2015 стандарт, хүнсний аюулгүй байдлын FSSC 22000 стандарт болон Европын хүнсний аюулгүй байдлын EFSA стандартуудыг тус тус хангасан.

- Үнэт цаас гаргагч нь 2021-2023 оны гүйцэтгэлээр нийт 16,144 тонн хуванцар хаягдлыг дахин боловсруулж, 9,821 тонн эцсийн бүтээгдэхүүнийг (rPET мөхлөг) үйлдвэрлэж, 63.2 мянган тонн нүүрсхүчлийн хий ялгарахаас сэргийлж, 46,522 м.куб талбайд хог хаягдал үүсэхээс сэргийлж, 8.8 сая тонн усны нөөцийг хэмнэж, 139.9 ГВт эрчим хүчийг хэмнэсэн байна.
- Түүнчлэн Компани нь импортыг орлон, экспортыг нэмэгдүүлж, улс эх орны тойрог эдийн засгийн засгийн шилжилтэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

**Тогтвортой ногоон түншлэл**

- “ТЖТБ” ХХК нь өөрийн охин компани болох “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК-аар дамжуулан үйлдвэрийн түүхий эд болох хуванцар хаягдлыг цуглуулах, өөрийн бэлтгэн нийлүүлэх цэгүүд дээр ангилан ялгадаг. Түүнчлэн олон нийтэд хог хаягдлыг ангилан ялгах ач холбогдлыг сурталчлах, сургалт, мэдээллээр тогтмол хангаж байна.
- “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК нь нийслэлийн 1,400, орон нутгийн 13 гэрээт харилцагчтай хамтран ажиллаж 3,000 гаруй шууд бус ажлын байрыг бий болгосон. Олон нийтийг хамарсан үйл ажилагаандарга хэмжээнд тогтмолоролцож, 1,500 гаруй хүнийг хамарсан 40 гаруй удаагийн сургалтыг зохион байгуулсан байна.
- Мөн Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлийн үндсэн болон туслах материалын нийлүүлэлтийг олон улсын стандарт хангасан, тогтвортой хөгжлийн зорилтыг (SDG) хэрэгжүүлэгч үйлдвэрлэгчтэй хийхийг эрмэлздэг. Компани нь өөрийн худалдан авалтын бодлогодоо уг зарчмыг тусгасан.

**Тогтвортой ногоон технологи**

- Үнэт цаас гаргагч нь байгальд ээлтэй ногоон үйлдвэрийг бий болгох зорилгоор орчин үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Компанийн үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж нь Европын холбооны чанарын шаардлага хангасан бүрэн автомат хуванцар хаягдлыг ангилах, хэрчих, угаах, хатаах шугам бүхий Итали улсын Сорема (Sorema) тоног төхөөрөмж, мөн хайлуулах, талстжуулж хөргөх технологи болон АНУ-ын Хүнс ба Эмийн чанарын хяналтын газар, эрүүл мэндийн яамны холбоо болох FDA (Food and Drug Administration) болон Европын хүнсний аюулгүй байдлын газар (EFSA)-аас хүлээн зөвшөөрөгдсөн Австри улсын Эрема (Erema) брэндийн үйлдвэрлэлийн шугамуудыг нэвтрүүлсэн. Эдгээр нь байгаль орчинд ээлтэй зах зээлд тэргүүлэгч технологиор савнаас сав үйлдвэрлэх хүнсний стандартад нийцсэн дахин боловсруулсан хуванцрын мөхлөгийг (rPET) үйлдвэрлэдэг.
- Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлдээ чанар хяналтын тогтолцоог бий болгон эцсийн бүтээгдэхүүний шинж чанарыг илэрхийлэх хайлах температур, чийгшил, дотоод зуурамтгай буюу Intrinsic viscosity, органик үлдэгдэл, өнгөний координат, ацетальдегидийн агууламж зэрэг нийт 18 төрлийн шинжилгээг 1 цаг тутамд 24 цагийн турш тасралтгүй гүйцэтгэдэг байна. Үүнээс гадна угаалгад ашиглагдаж буй химийн бодисыг хянах, шахан багласан түүхий эдийн ашигтай материалын хэмжээг тодорхойлох, Сорема үйлдвэрлэлийн шугамын ялгалт чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг хянах зэрэг үйлдвэрлэлийн процессын бүхий л үе шатанд чанарт нөлөөлөх боломжтой бүх параметрүүдийг хянан ажилладаг.
- Компани усны нөөцийг хэмнэхээр усыг 96% хүртэл цэвэршүүлэн дахин ашиглах хүчинтэй чадалтай хаягдал ус цэвэрлэшүүлэх байгууламжийг байгуулсан. Мөн Үнэт цаас гаргагч нь агаарын бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлж утааг 90% хүртэл цэвэршүүлэх уурын зуухыг суурилуулсан.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



5147204 ХАК0303
ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

2024.07.05
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

## 2.3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТҮҮХЭН ЦАГАЛБАР, ОЛОЛТ АМЖИЛТ

**2007**

- "ТЖТБ" ХХК нь үүсгэн байгуулагдав.

**2018**

- Түүхий эд болох хуванцар хаягдлыг татан авч цуглуулж эхлэв.
- Ти Эм Эл Пластик үйлдвэрийн барилгын ажил эхлэв.

**2019**

- Ти Эм Эл Пластик үйлдвэрийн барилга ашиглалтад орж, үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжүүдийн суурилуулалт хийгдэв.

**2021**

- Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн бүрэн тохируулгын ажил амжилттай хийгдэв.
- "Ти Эм Эл Трейд" ХХК-ийн охин компани болов.
- Хоёрдогч түүхий эд материал болох rPET мөхлөгийг үйлдвэрлэж эхлэв.

**2022**

- Олон улсын GRS стандартыг нэвтрүүлэв.

**2023**

- Олон улсын FSSC 22000, FDA, ISO 14001, ISO 9001:2015, болон EFSA стандартуудыг нэвтрүүлэв.
- Бүтээгдэхүүний зуурамтгай чанарыг нэмэгдүүлэх зориулалттай нэмэлт тоног төхөөрөмжийг үйлдвэрт суурилуулж, хүнсний зориулалтын түүхий эдийг үйлдвэрлэж эхлэв.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ТЖТБ
УЛААНБААТАР ХОТ

2024.07.05 БҮРТГЭВ № 01

### 2.3.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН СТАНДАРТУУД

2024-06-03 БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагч нь батлагдсан технологи горимын дагуу шингэн хүнсний хуванцар хаягдлыг боловсруулж, чанарын иж бүрэн удирдлагын тогтолцоо болон бүтээгдэхүүний орц, гарцын хяналтыг сайжруулах, сорилт шинжилгээ хийх, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор олон улсын дараах стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, дэлхийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсын стандартад нийцсэн rPET мөхлөгийг үйлдвэрлэж байна.

**Хүснэгт 16: Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн стандартууд**

| | |
|---|---|
| FSSC 22000<br>**FSSC 22000 стандарт** | • FSSC 22000 стандарт нь Хүнсний аюулгүй байдлын дэлхийн санаачилга (Global Food Safety Initiative)-с батлагдсан, дэлхий даяар хүлээн зөвшөөрөгдсөн, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын аудит, хяналт, баталгаажуулалтын стандарт юм. Тус стандарт нь амьтны гаралтай бүтээгдэхүүн, хурдан мууддаг ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хадгалах хугацаа удаан бүтээгдэхүүн болон нэмэлт орц, бодис агуулсан бүтээгдэхүүн зэрэг хүнсний болон орц найрлагын үйлдвэрлэл, хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл, бүтээгдэхүүний хадгалалт, түгээлтийн аюулгүй байдлын системийг баталгаажуулдаг. Мөн FSSC22000 стандарт нь хүнсний аюулгүй байдлаас гадна хүнсний чанар, хүнсний хамгаалалт, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх ажиллагааг хамарсан иж бүрэн удирдлагын тогтолцоо бөгөөд ISO 22000:2005 хүнсний аюулгүй байдлын стандарт дээр суурилдаг.<br>• Энэхүү стандарт нь хүнсний үйлдвэрлэгчдэд хүнсний аюулгүй байдлыг алдагдуулж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, улмаар эрсдэлийг арилгах эсвэл багасгах боломжийг олгодог байна.<br>• FSSC 22000 стандартын дагуу үйлдвэрлэгдсэн бүх төрлийн бүтээгдэхүүн нь хүнсний үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чанарын шаардлагыг хангасан байдаг.<br>• Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэл, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь FSSC 22000 стандартын Хүнсний сав баглаа боодлын материалын үйлдвэрлэл төрөлд чанарын шаардлага хангасан тул 2023 оны 8 дугаар сарын 19-ний өдөр FSSC 22000 гэрчилгээг авсан байна. Тус гэрчилгээ нь 2026 оны 8 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл хүчинтэй байх ба ахин баталгаажуулалт хийлгэсэн тохиолдолд хүчинтэй хэвээр байна. |
| ISO 9001:2015<br>**ISO 9001:2015 стандарт** | • ISO 9001:2015 стандарт нь олон улсын чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандарт бөгөөд тус стандарт нь байгууллагын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх процесст тавих хяналтын тогтолцоог бий болгодог байна. Тус стандарт нь дэлхийн 178 орны 1,064,000 гаруй байгууллагад хэрэгжсэн, дэлхийн хамгийн түгээмэл чанарын удирдлагын тогтолцооны нэг юм.<br>• Мөн тус стандарт нь өөрийн үйл ажиллагааг харилцагч, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг системтэйгээр хянах тогтолцоог бий болгодог бөгөөд дэлхийн хаана ч, ямар ч процессоор хийгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирохоор боловсруулагдсан байдаг.<br>• Bureau Veritas Certification Holding SAS-н Их Британи дахь салбар төлөөлөгчийн газраас Үнэт цаас гаргагчийн PET хаягдлыг дахин боловсруулж, rPET мөхлөгийг үйлдвэрлэж буй удирдлагын тогтолцоог хянан, стандартад нийцэж байгааг баталгаажуулан ISO 9001:2015 стандартын гэрчилгээг 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр олгосон байна. Тус стандартын гэрчилгээ нь 2026 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл 3 жилийн хугацаанд хүчинтэй байна. |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES



УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**ISO 14001:2015 стандарт**

- ISO 14001:2015 стандарт нь байгаль орчны удирдлагын тогтолцооны стандарт бөгөөд байгалийн нөөцийн ашиглалтыг багасгах, хөрс, ус, агаарт учирч болзошгүй хохирлыг бууруулах зорилготой эрсдэлийн шинжилгээнд үндэслэсэн менежментийн загвар юм.
- Энэ стандарт нь олон улсын стандартын байгууллагаас гаргасан цуврал стандарт бөгөөд үүнд түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн хүртэлх байгаль орчинд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох, хэрэглэгчдэд танилцуулах, эдгээр хүчин зүйлийг шаардлагатай шалгалт, арга хэмжээгээр хянаснаар байгаль орчны хохирлыг багасгана.
- Bureau Veritas Certification Holding SAS-н Их Британи дахь салбар төлөөлөгчийн газраас Үнэт цаас гаргагчийн хуванцар савыг дахин боловсруулах үйл ажиллагааг хянан, баталгаажуулж, ISO 14001:2015 стандартын гэрчилгээг 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр олгосон байна. Тус стандартын гэрчилгээ нь 2026 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл 3 жилийн хугацаанд хүчинтэй байна.

**GRS 4.0 стандарт**

- GRS (Global Recycled Standard) нь дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг гуравдагч этгээдээр баталгаажуулахад тавигдах шаардлагыг тогтоосон стандарт бөгөөд тус стандартын гол зорилго нь дахин боловсруулсан материалын хэрэглээг нэмэгдүүлэхэд оршино.
- Үнэт цаас гаргагч нь GRS стандартыг анх 2022 онд нэвтрүүлсэн бөгөөд жил бүр стандартын шаардлагуудын дагуу өөрийн үйл ажиллагааг баталгаажуулсан тохиолдолд нэг жилийн хугацаанд сунгагддаг байна. Компани нь 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр өөрийн үйл ажиллагааг тус стандартын шаардлагуудын дагуу ахин баталгаажуулсан тул тус гэрчилгээ нь 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хүчинтэй байна.

**АНУ-ын Хүнс ба эмийн зохицуулагч агенлаг (FDA)-ийн гэрчилгээ**

- АНУ-ын хүнс ба эмийн захиргаа, эрүүл мэндийн яамны холбооны агентлаг болох FDA (Food Drug Administration) нь хүнсний аюулгүй байдал, гоо сайхан, амьтны гаралтай хоол хүнс, хоолны нэмэлт тэжээл, жороор олгодог эм, вакцин, био эм, цус сэлбэх, эмнэлгийн хэрэгсэл зэрэг эрүүл мэндтэй холбоотой бүхий л төрлийн бүтээгдэхүүнийг хянан баталгаажуулж, экспорт хийхийг зөвшөөрч, гэрчилгээ олгодог байгууллага юм. Хуванцар материалын химийн бохирдол нь дахин боловсруулсан бүтээгдэхүүнд үлдэх эрсдэлтэй байдаг бөгөөд үүнийг дахин боловсруулж хэрэглээнд ашиглах нь хүнс болон эрүүл мэндийн хувьд аюулгүй байдлыг зайлшгүй хангах шаардлагатай. Иймд Үнэт цаас гаргагч нь FDA гэрчилгээг Эрема тоног төхөөрөмжийн үйл ажиллагаагаар баталгаажуулан 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр авсан байна.

**Европын хүнсний аюулгүй байдлын байгууллага (EFSA)-ын шаардлага**

- Европын Хүнсний Аюулгүй Байдлын Газар (EFSA) нь хүнсний болон тэжээлийн аюулгүй байдалд шууд болон шууд бусаар нөлөөлдөг бүх салбарт шинжлэх ухааны зөвлөгөө, техникийн дэмжлэг үзүүлдэг олон нийтийн байгууллага юм. Тус байгууллага нь хувиргасан амьд организм, пестицид болон хүнсний бүтээгдэхүүнтэй хүрэлцэх материал зэргийг хянан баталгаажуулдаг.
- Европын Хүнсний Аюулгүй Байдлын Газарт Хүнстэй холбоотой дахин боловсруулсан хуванцар материалын бүтээгдэхүүн болон өөрчлөлт хийгдсэн тухай зохицуулалтын дугаар: 2023/2006 гэх шаардлага байдаг бөгөөд энэхүү шаардлагыг Үнэт цаас гаргагч нь Эрема тоног төхөөрөмжийн үйл ажиллагаагаар баталгаажуулан авсан байдаг.

TDB SECURITIES



УЛААНБААТАР ХОТ

## 2.3.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Үнэт цаас гаргагч нь хог хаягдлаас хоёрдогч түүхий эд, материал гарган авах, хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр 2021 оноос тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж, дахин боловсруулагдсан полиэтилен терефталат мөхлөг (rPET)-ийг олон улсын чанар, стандартын шаардлагын дагуу үйлдвэрлэж зах зээлд бэлтгэн нийлүүлж байна.

### 2.3.4.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ




Үнэт цаас гаргагч нь Сонгинохайрхан дүүргийн 32-р хороонд байрлах үйлдвэрлэлийн зориулалттай эзэмших болон ашиглах эрхтэй 19,985 га талбай бүхий газар дээр 6,000 м.кв талбай бүхий Ти Эм Эл Пластик үйлдвэрээ байгуулсан бөгөөд тус үйлдвэр нь жилд 27,000 тонн ус ундааны хуванцар хог хаягдлыг дахин боловсруулж, 16,450 тонн сав баглаа боодлын түүхий эд болох (rPET) мөхлөгийг үйлдвэрлэх хүчин чадалтай.

**Хүснэгт 17: Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэлийн хүчин чадал**

| Үйлдвэрлэлийн хүчин чадал | Хэмжих нэгж | Цагт үйлдвэрлэх хүчин чадал | Хоногт үйлдвэрлэх хүчин чадал | Сард үйлдвэрлэх хүчин чадал | Жилд үйлдвэрлэх хүчин чадал |
|---|---|---|---|---|---|
| Орц | Тонн | 3.1 | 75.0 | 2,250.0 | 27,000.0 |
| Бүтээгдэхүүний цэвэр гарц | Тонн | 1.9 | 45.7 | 1,370.2 | 16,450.0 |

Үнэт цаас гаргагч нь өөрийн охин компани болох "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК-аар дамжуулан хуванцар хог хаягдал (PET)-ыг цуглуулан үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ашигладаг ба 2021 оноос 2023 оны 3 дугаар улирал хүртэл Компани нь нийт 14,784 орчим тонн хуванцар хаягдлыг дахин боловсруулж, 7,901 орчим тонн rPET мөхлөгийг үйлдвэрлэсэн байна.

**Зураг 4: Үнэт цаас гаргагчийн боловсруулсан хог хаягдал болон үйлдвэрлэсэн rPET мөхлөгийн хэмжээ, 2021-2023.III**







Үнэт цаас гаргагч нь 2023 оны 3 дугаар улиралд нийт 7.0 мянган тонн ус, ундааны хуванцар савны хаягдлыг боловсруулж, 4.3 мянган тонн хагас боловсруулсан бүтээгдэхүүн, 2.8 мянган тонн rPET мөхлөгийг үйлдвэрлэсэн нь Компанийн хог хаягдал боловсруулах нийт үйлдвэрлэлийн хүчин чадлын 26.1 хувийг, rPET мөхлөг үйлдвэрлэх хүчин чадлын 17.1 хувийг тус тус ашиглажээ. Тус оны 3 дугаар улиралд Үнэт цаас гаргагчийн rPET мөхлөг үйлдвэрлэх үндсэн тоног төхөөрөмж болох Эрема үйлдвэрлэлийн шугамд нэмэлт тоног төхөөрөмж суурилуулсан ба тус хугацаанд Эрема тоног төхөөрөмж ажиллаагүй. Иймд 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Компанийн rPET мөхлөг үйлдвэрлэлийн гарц бага байсан байна.

Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа ба 2024-2028 онд Компани нь нийт боловсруулах хуванцар хог хаягдлын үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын хэмжээг 43-55 хувьд, үйлдвэрлэсэн rPET мөхлөгийн үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын хэмжээг 50-67 хувьд тус тус хүргэхээр зорин ажиллаж байна.

### 2.3.4.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Үнэт цаас гаргагч нь ус, ундааны хуванцар хог хаягдал (PET)-ыг дахин боловсруулж, савнаас сав үйлдвэрлэх технологиор түүхий эдийн үндсэн өнгөний дагуу сав баглаа боодлын түүхий эд болох rPET мөхлөгийг үйлдвэрлэдэг бөгөөд Компанийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь дараах нэр төрөлтэй байна.

**Хүснэгт 18: Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний төрөл**

| № | Бүтээгдэхүүн код | Бүтээгдэхүүн төрөл | Зураг |
|---|---|---|---|
| 1 | TML-101 | Цагаан |  |
| 2 | TML-102 | Ногоон |  |
| 3 | TML-103 | Бор |  |
| 4 | TML-104 | Цэнхэр |  |
| 5 | TML-105 | Цэнхэр цагаан холимог | |
| 6 | TML-106 | Цагаан холимог | |
| 7 | TML-107 | Цэнхэр холимог | |
| 8 | TML-108 | Шаргал энгийн холимог | |
| 9 | TML-109 | Шаргал энгийн холимог | |
| 10 | TML-110 | Ногоон бор холимог | |
| 11 | TML-111 | Бор цагаан холимог | |

Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэж буй rPET мөхлөг нь АНУ-ын хүнсний аюулгүй байдлын FDA стандарт, олон улсын дахин боловсруулалтын GRS стандарт, чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандарт, Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандарт, хүнсний аюулгүй байдлын удирдлагын систем FSSC 22000 болон Европын хүнсний аюулгүй байдлын EFSA чанарын стандартуудын дагуу хүний эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, бүтээгдэхүүний чанарыг дээд зэргээр хангадаг байна.

## 2.3.4.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа Европын холбооны чанарын шаардлага хангасан Итали улсын Сорема (Sorema) брэндийн тоног төхөөрөмж бүхий хэрчдэс үйлдвэрлэх шугам, Америкийн нэгдсэн улсын Хүнс ба Эмийн чанарын хяналтын газар болон Европын хүнсний аюулгүй байдлын газраас хүлээн зөвшөөрөгдсөн Австри улсад үйлдвэрлэгдсэн Эрема (Erema) брэндийн тоног төхөөрөмж бүхий хүнсний зориулалттай мөхлөг үйлдвэрлэх үндсэн 14 дамжлагаар ажиллах технологи юм. Тус технологи нь жилд 27,000 тонн ус ундааны хуванцар хаягдал дахин боловсруулах хүчин чадалтай ба байгаль орчинд ээлтэй зах зээлд тэргүүлэгч технологиор савнаас сав үйлдвэрлэх хүнсний зориулалтын өндөр зэрэглэлийн rPET мөхлөгийг үйлдвэрлэдэг.

### Сорема (Sorema) үйлдвэрлэлийн шугам



Хуванцрын хэрчдэс буюу хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалт бүхий Сорема брэндийн тоног төхөөрөмжийг анх 1974 онд Previero N.srl гэх компани зохион бүтээжээ. Тус компани нь 1922 оноос хойш хуванцар болон резинэн материалын хэмжээг багасгах зориулалт бүхий тоног төхөөрөмжийн инженерчлэлийн болон суурилуулалтын үйл ажиллагаа эрхэлсээр ирсэн бөгөөд 1974 онд хуванцрыг угаах, дахин боловсруулах үйлдвэрлэлийн шугамыг зохион бүтээх зорилго дор энэхүү Сорема брэндийн тоног төхөөрөмжийг зохион бүтээж, үйл ажиллагаагаа тэлж, хуванцар материал дахин боловсруулах үйлдвэрүүдийн дизайн, үйлдвэрлэл, суурилуулалтаар тэргүүлэгч компани болсон юм. Өдгөө 50 жилийн түүхтэй уг тоног төхөөрөмж нь хамгийн шинэлэг шийдлээрээ дэлхийд алдартай бөгөөд төрөл бүрийн хуванцрыг цагт 500-10,000 килограмм хүчин чадалтайгаар дахин боловсруулж, стандарт, шаардлага хангасан хэрчдэс үйлдвэрлэдэг байна.

Сорема тоног төхөөрөмжийн савнаас сав үйлдвэрлэх процесс (PET bottles to Bottles process)-ийн шийдэл бүхий тус тоног төхөөрөмж нь ус, ундааны хуванцар савыг бохирдол, шошго, бөглөө болон бусад метал, жижиг хаягдлаас нь салгах, угаах, өнгө материалаар нь ялгах, хэрчдэс болгох, хатаах, жижиг тоосонцруудыг ялгах зэрэг үйл ажиллагаагаар дахин боловсруулж, хэрчдэс бий болгодог.

Previero N.srl компани нь Сорема өөрийн харилцагч компаниуддаа үйл ажиллагааны үр ашигтай байдлын судалгаа, шинжилгээ, үйлдвэрлэлийн загварчлал, тоног төхөөрөмжийн тохиргооны хяналт, мэргэжлийн заавар, сургалт, сэлбэг хэрэгслийн нийлүүлэлт гэх мэт харилцагчийн үйлчилгээг тогтмол үзүүлж урт хугацааны хамтын ажиллагааг явуулдаг байна.

### Эрема (Erema) үйлдвэрлэлийн шугам




Эрема (Erema) нь дэлхийд тэргүүлэх хуванцар дахин боловсруулах бүрэн автомат технологи бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь олон улсын хүнсний аюулгүй байдлын шаардлагыг өндөр түвшинд хангадаг.Тус систем нь инженерийн шинэлэг шийдлүүдийг шингээсэн ухаалаг, байгальд ээлтэй, үр ашигт үйлдвэрлэлийн хэмжээ өндөр дэвшилтэт тоног төхөөрөмж юм.

Байгаль орчинд ээлтэй, тогтвортой ногоон хөгжлийн бодлого бүхий хуванцар сав баглаа боодлын шийдлүүд нь олон улсад эрчимжиж байна. Хэрэглэгчид ч мөн адил байгаль орчинд ээлтэйг илүү ухамсаран хэрэглээндээ анхаарч, дахин боловсруулах боломжтой, дахин боловсруулсан материалаар хийсэн бүтээгдэхүүнийг сонгохыг илүүд үзэх болжээ. Үүнийг даган олон улсад Засгийн газрууд тойрог эдийн засгийг дэмжих шийдвэрүүд ихээр гаргаж байгаа ба тухайлбал үйлдвэрлэгчдэд сав баглаа боодолдоо дахин боловсруулсан түүхий эд ашиглах, мөн анхдагч PET-ны агууламжийг хамгийн бага түвшинд хүргэх зорилтууд тавьсаар байна. Эдгээр зохицуулалтыг томоохон бизнес эрхлэгчид ихээхэн дэмжиж дунд хугацааны зорилтууддаа оруулсаар байгааг дурдах нь зүйтэй.

Эрема нь Сорема тоног төхөөрөмжөөс үйлдвэрлэгдэн гарсан хэрчдэсийг вакум орчинд оруулан ариутган, чийгшлийг арилгаж, зохих температурт хайлуулж, үл хайлах биетийг шүүж, хайлмагийг хэрчин, талстжуулж, төхөөрөмжид оруулсан хэрчдэсийн шинж чанарын ялгаатай байдлыг үл харгалзан ижил түвшний зуурамтгай чанар бүхий өндөр зэрэглэлийн rPET мөхлөгийг үйлдвэрлэдэг. Мөн үйлдвэрлэгдэн гарч буй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн бүхий л үйл явцад зуурамтгай чанарын түвшинг хянах боломжтой бүрэн автоматжуулсан системтэй байдаг. Эрема тоног төхөөрөмж нь маш нарийн шүүлтүүртэй байдаг тул бичил хэмжээний хөнгөн цагаан, ган болон бусад метал биетийг шүүх чадвартай ба маш өндөр түвшинд хуванцрын хайлмагийг талстжуулдаг. Үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнийг шууд хүнсний зориулалтын сав үйлдвэрлэхэд ашиглах боломжтойгоор загварчилсан байдаг бөгөөд чанартай, найдвартай, аюулгүй бүтээгдэхүүний гарцыг баталгаажуулдаг байна.

## Лабораторийн тоног төхөөрөмжүүд

Үнэт цаас гаргагч нь өөрийн лабораторид нийт 30 нэр төрлийн олон улсын стандартад хүлээн зөвшөөрөгдсөн тоног төхөөрөмжтэй бөгөөд жил бүр Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шалгалт сорилт, тохируулгад хамруулан баталгаажуулж, лабораторийн үйл ажиллагаандаа дараах 30 нэр төрлийн тоног төхөөрөмжүүдийг эцсийн бүтээгдэхүүний чанар стандартыг шалгах зориулалтаар ашиглаж байна.

**Хүснэгт 19: Үнэт цаас гаргагчийн лабораторийн шинжилгээнд ашиглагддаг тоног төхөөрөмжүүд**

| № | Нэр | Зориулалт |
|---|---|---|
| 1 | Электрон жин | Хамгийн ихдээ 2,200 грамм хүртэлх хэмжээгээр дээжийг жинлэх |
| 2 | Электрон жин | Хамгийн ихдээ 220 грамм хүртэлх хэмжээгээр дээжийг жинлэх |
| 3 | Хатаах шүүгээ | Хагас боловсруулсан бүтээгдэхүүний бохирдлыг тодорхойлох болон химийн бодис хайлуулах, шил сав хатаах |
| 4 | Чичиргээт шигшүүрийн машин-retsch | Хагас боловсруулсан бүтээгдэхүүн болон бэлэн бүтээгдэхүүний хэмжээг тодорхойлох |
| 5 | COD-термостат | Химийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох, хагас боловсруулсан бүтээгдэхүүн болон бохир усны дээжийн шинжилгээнд урвалжийг халаах |
| 6 | Спектрофотометр | Химийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох, хагас боловсруулсан бүтээгдэхүүн болон бохир усны дээжийн шинжилгээнд үр дүнг уншуулах |
| 7 | Colorlite-зөөврийн фотометр | Хагас боловсруулсан бүтээгдэхүүн болон бэлэн бүтээгдэхүүний өнгөний үзүүлэлтийг тодорхойлох |
| 8 | Автомат электрон нягтрал хэмжигч | Бэлэн бүтээгдэхүүний нягтыг тодорхойлох |
| 9 | Автомат удирдлагатай цахилгаан ус нэрлэгийн төхөөрөмж | Нэрмэл ус нэрэх |
| 10 | Олон параметрийн анализатор | Хагас боловсруулсан бүтээгдэхүүн болон бохир усны pH тодорхойлох |
| 11 | Бутлагч | Дээжийг бутлах |
| 12 | Чийгшил хэмжигч | Хагас боловсруулсан бүтээгдэхүүний чийгшлийг тодорхойлох |
| 13 | Aquatrac-v | Бэлэн бүтээгдэхүүний чийгшлийг тодорхойлох |
| 14 | Холигч | Хагас боловсруулсан бүтээгдэхүүний pH тодорхойлох холигч |
| 15 | DSC-Хайлах цэг тодорхойлогч | Бэлэн бүтээгдэхүүний хайлах цэгийг тодорхойлох |
| 16 | Intelligent Viscosity Measurement System | Дээжийн дотоод зуурамтгай чанар (IV) тодорхойлох |
| 17 | Соронзон холигч | pH тодорхойлох шинжилгээнд ашигладаг соронзон холигч |
| 18 | Analytic balance | Хамгийн ихдээ 220 грамм хүртэлх хэмжээгээр дээжийг жинлэх |
| 19 | Электрон Жин 150кг | 50 килограмм түүхий эдэд шинжилгээ хийх |
| 20 | Autoextractor | Органик бохирдлыг тодорхойлох |
| 21 | Соронзон холигч | pH тодорхойлох шинжилгээнд нэрмэл ус халаах |
| 22 | Gas chromatography | Химийн хортой нэгдлүүдийг тодорхойлох |
| 23 | Spectrum two | Бүтээгдэхүүний дээжийн чанарыг хэмжих |
| 24 | Centrifuge-V | Шингэнийг нягтралаар нь ялгах |



БҮРТГЭВ-02
TDB SECURITIES
ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.07.05 он сар өдөр БҮРТГЭВ №01

2024-06-03 БҮРТГЭВ-02

| | | |
|---|---|---|
| 25 | Vacuum drying | Хатаах |
| 26 | Экстрактор | Дээжийг хандлах |
| 27 | Микроскоп | Дээжийг микроскопоор өсгөж харах |
| 28 | Үйлдвэрлэлийн электрон микроскоп | Нүдэнд үл харагдах биетийг томруулж, шинжилгээ хийх |
| 29 | Нунтаг бутлуур | Дээжийг нунтаглан бутлах |
| 30 | Шатаах зуух | Дээжийг шатаах |

### 2.3.4.4. ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### Хуванцар сав (PET) бэлтгэн нийлүүлэлтийн үйл ажиллагаа

Түүхий эдийг анх 2018 оноос Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани "Ти Эм Эл" ГХОХХК нь өөрийн хаягдал хуванцар цуглуулах цэгүүдээр дамжуулан, хоёрдогч түүхий эдийн үй ажиллагаа явуулдаг ААН, иргэдээс худалдан авч 2023 он хүртэл цуглуулан, бэлтгэж байсан ба Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "Ти Эм Эл Трейд" ХХК нь "ТЖТБ" ХХК-ийн үйлдвэрлэлийн түүхий эд материалын тасралтгүй байдлыг хангах, анхны эх үүсвэр дээрх дахиврыг ангилах, ялгах хэвшлийг бий болгох томоохон зорилт тавин ажиллаж байна. Түүнчлэн "Ти Эм Эл Трейд" ХХК нь Монгол Улсад хог хаягдлын менежментийг хөгжүүлэх зорилгоор "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК-г 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр байгуулахаар шийдвэрлэж, тус компани нь 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлд доорх чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн байна. Үүнд:

- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа;
- Аюулгүй хог хаягдал цуглуулах,
- Хог хаягдлаас хоёрдогч түүхий эд гарган авах.

Өдгөө "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК нь 68 ажилчидтайгаар үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.

**Хүснэгт 20: Үнэт цаас гаргагчийн охин компани болох "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК-ийн хуулийн этгээдийн бүртгэл**

| "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК-ийн хуулийн этгээдийн бүртгэл | |
|---|---|
| Компанийн нэр | "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК |
| Байгуулагдсан огноо | 2023.01.30 |
| Улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо | 2023.02.07 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011848613 |
| Регистрийн дугаар | 6990916 |
| Үйл ажиллагааны үндсэн чиглэл | • Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа<br>• Аюулгүй хог хаягдлыг цуглуулах<br>• Хог хаягдлаас хоёрдогч түүхий эд, материал гарган авах |

"Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш "ТЖТБ" ХХК-ийн хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг тасралтгүй түүхий эдээр хангах зорилгоор хуванцар хог хаягдлыг цуглуулан, бэлтгэн нийлүүлэн ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 23/329 тоот шийдвэрээр "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК-

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES

ийн нэг бүр нь 2,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10 ширхэг энгийн хувьцааг худалдан авч, 100 хувь өөрийн охин компани болгон эзэмшиж байна.

"Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК нь Улаанбаатар хотод 3, Дархан-Уул аймагт байрлах 1 хуванцар хаягдал цуглуулах цэгүүдээрээ дамжуулан хоёрдогч түүхий эдийн үйл ажиллагаа явуулдаг ААН, иргэдээс худалдан авахаас гадна нийслэлийн 1,400 харилцагчаас анхдагч эх үүсвэрээс ангилан ялгасан дахиврыг өөрсдийн тээврээр татан авч байна. Мөн орон нутгийн хувьд 13 гэрээт харилцагчдаас ангилсан хуванцар хаягдлыг "ТЖТБ" ХХК-ийн үйлдвэрт хүлээн авч байна.







**Зураг 5: Үнэт цаас гаргагчийн охин компани болох "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК-ийн бэлтгэн нийлүүлэлтийн цэг**



**Хуванцар сав (PET) бэлтгэн нийлүүлэлтийн суваг**

"Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК нь үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар нийслэл, орон нутаг, хоёрдогч түүхий эдийн үйл ажиллагаа явуулдаг ААН, иргэдийн 3 сувгийг хөгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд тус сувгуудаар дамжуулан компани нь 2023 онд нийслэлийн 1,400, орон нутгийн 13, хоёрдогч түүхий эдийн үйл ажиллагаа явуулдаг 87 харилцагч нараас нийт 3,342 тонн хуванцар хаягдлыг худалдан авч цуглуулжээ.

СЭХ
2024.07.05 өдөр
БҮРТГ
№ 01

EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

➔ **Нийслэл суваг**

Нийслэл суваг нь Улаанбаатар хотод байрлах СӨХ, бүх шатны боловсролын байгууллага, үзвэр үйлчилгээний төвүүд, ААН, барилга байгууламж гэх мэт 400 орчим харилцагчдаас анхны эх үүсвэр дээр ангилсан хуванцар хог хаягдлыг дуудлагаар тээвэрлэн авч, цуглуулж байна. Худалдааны төлөөлөгч бүр хариуцсан бүсийн харилцагч нартай уулзаж, сургалт мэдээлэл өгч, хамтын ажиллагааг эхлүүлэн гэрээ байгуулан ажиллаж байна.

➔ **Орон нутгийн суваг**

"Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК нь Дархан-Уул аймагт 1 бэлтгэн нийлүүлэх цэгтэй бөгөөд тус цэг нь 2022 оны 7 дугаар сараас хойш 50 гаруй харилцагчтай болсон ба 2.8 га бүхий талбай газарт үйл ажиллагаа явуулж байна. Бусад аймаг, орон нутгийн 13 гэрээт харилцагчдаас хуванцар хог хаягдлыг Улаанбаатар хот руу шууд цуглуулан тээвэрлэж, бэлтгэн нийлүүлэх цэгүүдэд хүргэж байна. Мөн Компани нь орон нутгийн сувгийг цаашид хөгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд бусад аймагт бэлтгэн нийлүүлэх цэг байгуулах, тэдгээрт худалдааны төлөөлөгч ажиллуулж, түүхий эдийн худалдан авалтыг илүү нэмэгдүүлэх, уул уурхайн компаниудтай илүү өргөн хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр ажиллаж байна.

➔ **Цэгийн худалдан авалтын суваг**

"Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК нь Улаанбаатар хотын 3 байршилд түүхий эд худалдан авч, Ти Эм Пластик үйлдвэрт бэлтгэн нийлүүлж байна. Үүнд:

1. Цэг 1 – Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 10 хороо, Амгалан гудамж, 87/18 тоот хаягт үйл ажиллагаагаа явуулж байна.
- Цэг 2 – 2019 оны 6 дугаар сараас Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 26 хороо, Их наран, Мандал овоо, 2-ийн задгай хаягт үйл ажиллагаагаа явуулж байна.
- Цэг 3 – 2023 оны 3 дугаар сараас эхлэн Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо, Хотын шинэ төв /18270/ гудамж, 91 тоот хаягт үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

## Химийн бодис бэлтгэн нийлүүлэлтийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигладаг химийн бодисыг Компанийн нэгдэлд хамаарах химийн бодис импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл бүхий "Ти Эм Эл" ГХОХХК-тай байгуулсан 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн TML/НГ-2108 тоот "Түүхий эд, сэлбэг хэрэгсэл, хангамжийн материал нийлүүлэх гэрээ"-ний хүрээнд "Ти Эм Эл" ГХОХХК-с худалдан авч, үйл ажиллагаандаа ашигладаг. "Ти Эм Эл" ГХОХХК нь өөрийн худалдан авалтын бодлогодоо тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэгч үйлдвэрлэгчтэй хамтран ажиллахыг тусгасан байх бөгөөд үйлдвэрлэлд хэрэглэгдэж байгаа химийн бодисыг Европын компаниудтай гэрээ байгуулан, нийлүүлэлтийн үйл ажиллагааг тогтвортой хангадаг байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES



ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

**Хүснэгт 21: Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд ашиглаж буй химийн бодис**

| Ашиглаж буй байршил | Монгол нэр | Олон улсын нэршил | Томъёо |
|---|---|---|---|
| Лаборатори | Фенол | Phenol | $C_6H_6O$ |
| | 1,1,2,2 Тетрахлорэтан | 1,1,2,2 Tetrachlorethane | $C_2H_2Cl_4$ |
| | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч | COD | |
| | Гексан | Hexane | $C_6H14$ |
| Үйлдвэрийн процесс | Цэвэрлэгээний нэмэлт | Cleaning additive skip /Tubiwash SKP/ | - |
| | Хөөс задлагч | Defoamer ke 100 /Tubifoam KE 100/ | - |
| | Агааргүйжүүлэгч | Deareater /Tubifoam PNF/ | - |
| | Натрийн шүлт | Sodium hydroxide | NaOH |
| Ус цэвэршүүлэх байгууламж | Натрийн гипохлорит | Sodium hypochlorite solution, Sodium hypochlorite | NaClO |
| | Давсны хүчил | Hydrochloric acid 30% | HCL |
| | Полиалюминум хлорид | PAC (poly aliminum chloride) | Al2Cl(OH)5 |
| | Катионик полиакриламид | CPAM (Cationic polyacrylamide) | (C3H4No)n |

➔ **Үйлдвэрийн процесст ашиглаж буй химийн бодисын тухай**

***1. Цэвэрлэгээний нэмэлт***

Үнэт цаас гаргагч нь хуванцрын хог хаягдлыг бохирдлоос нь салгахын тулд цэвэрлэгээний нэмэлт гадаргуугийн идэвхтэй бодисуудыг үйл ажиллагаандаа ашигладаг. Цэвэрлэгээний нэмэлт химийн бодис нь хуванцрын хэрчдэсийг өндөр үр ашигтайгаар цэвэрлэх цэвэрлэгээний нэмэлт бүтээгдэхүүн бөгөөд натрийн шүлтийн үйлчилгээг дэмждэг тул наалдамхай бодис болон бусад хольцыг бага хэмжээгээр хэрэглэсэн хэдий ч бохирдлыг нь маш сайн цэвэрлэдэг байна. Энэхүү бодис нь FDA-ийн "177.1630 Полиэтилен фталат полимер"-ийн шаардлагад нийцсэн, PET хаягдлыг дахин боловсруулахад тохиромжтой бөгөөд шошго, наалдамхай бодисыг маш сайн арилгадаг байна.

***2. Хөөс задлагч***

Бутлагдсан бөглөөний материал болох HDPE болон шошго зэрэг бохирдлууд нь нягтын хувьд ялгаатай учир хөвүүлэн живүүлэх аргаар ялгаж авдаг. Тухайлбал Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэлийн үндсэн материал болох PET нь хөвүүлэхэд живж, бусад материалууд хөвөн үлддэг. Энэ үед ялгагч танканд материал өндөр даралттай орж ирдэг. Ингэснээр материалууд сайн холилддог хэдий ч агаарын бөмбөлөг үүсдэг. Агаарын бөмбөлөг үүссэнээр живэх ёстой материалын доод гадаргууд наалдсанаар тухайн материалыг хөвүүлдэг учир агаарын бөмбөлгийг задалдаг болон гадаргуу дээр тогтсон хөөсийг задалдаг химийн бодисыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ашигладаг. Тус бодис нь FDA-ийн шаардлагад нийцдэг ба ашигт малтмалын тос агуулаагүй, маш сайн агаар тайлах болон хөөс задлах үйлчилгээтэй тул хуванцар хаягдлыг дахин боловсруулахад түгээмэл хэрэглэгддэг байна.

***3. Агааргүйжүүлэгч болон Натрийн шүлт Sodium hydroxide***

Агааргүйжүүлэгч бодис нь янз бүрийн материалыг илүү сайн салгах үйлчилгээтэй ба тухайлбал HDPE, PET материалыг хооронд нь ялгаж салгахад чухал нөлөөтэй байдаг.

Мөн Үнэт цаас гаргагч нь хуванцрын хэрчдэсийг бохирдлоос ялгаж, салгахын тулд гадаргуугийн идэвхтэй бодис болох натрийн шүлтийг ашигладаг.

### 2.3.4.5. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### 2.3.4.5.1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024-06-03
БҮРТГЭВ-02

**Зураг 6: Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэлийн ерөнхий процесс**




Хуванцар савыг дахин боловсруулж, rPET мөхлөг үйлдвэрлэх хүртэл нийт 14 шат дамжлагыг дамжин өнгөрч, өндөр зэрэглэлийн чанартай rPET мөхлөг үйлдвэрлэгчдийн гарт хүрдэг байна. Дээрх зурагт харуулсан үйлдвэрлэлийн ерөнхий процессын 4-6 дахь үйл ажиллагааг Үнэт цаас гаргагчийн охин компани болох “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК хийж гүйцэтгэдэг бол “ТЖТБ” ХХК нь 7-13 хүртэлх үйл ажиллагаагаар Сорема тоног төхөөрөмжийнхөө тусламжтайгаар хэрчдэс бэлтгэж, 14-17 хүртэлх үйл ажиллагаагаараа Эрема тоног төхөөрөмжийнхөө тусламжтайгаар эцсийн бүтээгдэхүүн болох rPET мөхлөг үйлдвэрлэж байна.

#### 2.3.4.5.2. ХАГАС БОЛОВСРУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



TDB SECURITIES

**Зураг 7: Хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа**




Тайлбар:

1. Үнэт цаас гаргагчийн охин компани болох "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК-аас ус, ундааны хуванцар савны хаягдлыг өнгөөр ялган, прессдэн Ти Эм Эл Пластик үйлдвэр рүү тээвэрлэнэ. Нэг пресс түүхий эд нь ойролцоогоор 400-450 килограмм орчим орчим жинтэй байдаг байна.
2. Түүхий эдийг ачаалах хэсэг рүү оруулна.
3. Пресс задлагч тоног төхөөрөмжөөр прессэлсэн түүхий эдийг задална.
4. Соронзон конвейрт металл илрүүлэгчээр дамжин металлуудыг ялгана.
5. Сорема тоног төхөөрөмжийн хуурай тээрэм буюу хэвтээ байрласан шүүрээр дамжин жижиг хэмжээтэй элс, шороо гэх мэт материалуудыг салгана.
6. Эхний угаалга явагдахад шошго салгагдан, ангилан ялгах дамжлагад шилжинэ.
7. Хуванцар савыг өнгө болон материалаар нь ялгана.
8. Бусад энгийн сав болон металлыг гараар ангилан ялгана.
9. Нойтон бутлуурт хуванцар савууд жижиг хэрчдэс болох ба хоорондоо үрэгдэн угаагдана.
10. Хэрчдэсийг нойтон бутлуураас угаалгын танк руу ороход гадаргуугийн идэвхтэй угаалгын бодис болон эмульс үүсгэгч зэрэг химийн бодисуудыг ашиглан цэвэрлэнэ.
11. Хэрчдэсээс бутлагдсан бөглөөний материал болох HDPE-г ялгахын тулд усанд хөвүүлэн живүүлэх аргаар үндсэн PET материалаас ялгана.
12. Усаар угаагдсан хэрчдэсийг хатаана.
13. Хэрчдэс хадгалах, холих силод оруулна.
14. Элиутриатор (Elutriator) ашиглан бичил хэмжээтэй тоосонцрыг ялгана.
15. Өнгө мэдрэгч диодын байршлыг тогтоон өндөр даралтаар үлээн өнгөөр ангилна
16. Сорема шугамын эцсийн бүтээгдэхүүн болох хагас боловсруулсан хэрчдэсийг савлана.

## 2.3.4.5.3. ЭЦСИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Сорема үйлдвэрлэлийн шугамаас боловсруулагдан гарсан хуванцрын хэрчдэсийг өндөр температур, үйлдвэрлэлийн процессын дагуу боловсруулж, хүнс, нэхмэлийн утас болон бусад сав баглаа боодлын түүхий эд болох rPET мөхлөгийг үйлдвэрлэх үйл ажиллагааг Эрема үйлдвэрлэлийн шугамаар дамжуулан гүйцэтгэдэг.

**Зураг 8: Эцсийн бүтээгдэхүүн болох rPET (recycled PolyEthylene Terephthalate) үйлдвэрлэх үйл ажиллагаа**




Тайлбар:

1. Сорема үйлдвэрлэлийн шугамаас боловсруулагдан гарсан хагас боловсруулагдсан бүтээгдэхүүн буюу хэрчдэсийг хуванцрын Эрема үйлдвэрлэлийн шугам руу оруулан эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ.
2. Хэрчдэсийг Эрема тоног төхөөрөмжийн цуглуулах танк руу оруулна.
3. Хэрчдэс нь металлуудыг ялган илрүүлдэг хоолойгоор дамжин вакум холигч руу орж, үрэлтийн даралтаар 280 градус хүртэл температурт хайлна.
4. Хайлмаг нь 8 ширхэг фильтерээр дамжиж хайлмагаас үл хайлах бохирдол шүүгдэнэ.
5. Шүүгдсэн хайлмаг нь тунгалаг, хуванцар, утсан хэлбэртэйгээр урсан гарч ус руу орж бэхжин, хэрчигдсэнээр аморф хэлбэртэй болно.

СЭХ
2024 он 07 сар 05 өдөр
БҮРТГЭВ
№ 0

2024-06-03
БҮРТГЭВ-02

6. Аморф холбоотой мөхлөг нь өөртөө ус чигийг их хэмжээгээр татдаг тул усгүй болж талстжих танкаар дамжин талстжина.
7. Мөхлөгийг дахин талстжуулах болон хэргэх хоолой руу оруулж дахин талстжуулна.
8. Талстажсан мөхлөгөөс жигд хэмжээтэй мөхлөгийг шигшиж ялгана.
9. Полимерийн холбоонууд параллель байрлалд шилжин мөхлөгүүд савлагдана.

**rPET мөхлөгийн борлуулалтын орлого**

Үнэт цаас гаргагч нь эцсийн бүтээгдэхүүн болох rPET мөхлөгийг 2021 оны 11 сараас БНХАУ болон Узбекистан улсууд руу өөрийн нэгдлийн компани "Ти Эм Эл" ГХОХХК-иар дамжуулан экспортолж эхэлсэн. 2023 оны 11 дүгээр сараас эхлэн Үнэт цаас гаргагч нь БНХАУ руу шууд экспорт хийж эхэлсэн байна.

**Бүтээгдэхүүний чанар сайжрав:**

2023 оны 3 дугаар улирлад Үнэт цаас гаргагч нь үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж болох Эрема үйлдвэрлэлийн шугамд нэмэлт төхөөрөмж суурилуулсан ба энэ нь хүнсний зориулалтын шаардлага стандартыг хангасан зуурамтгай чанар бүхий эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болов.

**Зураг 9: Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэсэн rPET мөхлөгийн хэмжээ болон борлуулалтын орлого**










**Үнэт цаас гаргагчийн 2023 оны урьдчилсан санхүүгийн гүйцэтгэл*

Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэсэн rPET мөхлөгийн хэмжээ 2021 оноос 2023 оны 3 дугаар улирал хүртэл 1.4 дахин өсөж, 2.8 мянган тоннд, борлуулсан rPET мөхлөгийн хэмжээ 1.5 дахин өсөж, 2.9 мянган тоннд хүрсэн үзүүлэлттэй байна. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагч нь өмнөх бараа материалын үлдэгдлээс нэмж борлуулсан тул борлуулсан rPET мөхлөгийн хэмжээ үйлдвэрлэсэн rPET мөхлөгийн хэмжээнээс их байна.

TDB SECURITIES



УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагчийн rPET мөхлөгийн борлуулалтын орлого 2021 оноос 2023 оны 3 дугаар улирал хүртэл 1.6 дахин өсөж, 6.4 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт борлуулалтын орлогын 99.5 хувийг бүрдүүлж байна. Компани нь үйлдвэрлэсэн rPET мөхлөгөө 2021-2022 онуудад "Ти Эм Эл" ГХОХХК-аар дамжуулан экспортод гаргадаг байсан бол 2023 оны 11 дүгээр сараас хойш "ТЖТБ" ХХК нь бүтээгдэхүүнээ БНХАУ руу шууд экспортолж эхэлсэнтэй холбогдуулан 2023 оны урьдчилсан санхүүгийн гүйцэтгэлээр Компанийн нийт борлуулалтын орлогын 76.9 хувь буюу 8.0 тэрбум төгрөгийг дотоодын борлуулалт, 23.1 хувь буюу 2.4 тэрбум төгрөгийг БНХАУ руу экспортлон гаргасны борлуулалт тус тус бүрдүүлж, Компанийн нийт борлуулалтын орлого 10.4 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Цаашид Үнэт цаас гаргагч нь хүнсний болон хэрэглээний зориулалттай rPET мөхлөгийг Европын орнууд руу экспортлох, мөн олон улсын томоохон шингэн хүнсний үйлдвэрлэгчид нийлүүлэхээр төлөвлөж байна.

## Борлуулсан rPET мөхлөгийн өртөг

**Зураг 10: Үнэт цаас гаргагчийн борлуулсан rPET мөхлөгийн өртөг, 2021-2023.III**




Үнэт цаас гаргагчийн борлуулсан мөхлөгийн өртөг нь 2021 оноос 2023 оны 3 дугаар улирал хүртэл 1.6 дахин нэмэгдэж, 5.6 тэрбум төгрөгт хүрсэн байх ба тус хугацаанд борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон борлуулалтын орлогын харьцаа дунджаар 89.0 хувьтай тэнцэж байна. Мөн борлуулсан rPET мөхлөгийн өртгийг борлуулсан тоон хэмжээтэй харьцуулсан нэг тонн rPET мөхлөгийн өртөг 2021 оноос 2023 оны 3 дугаар улирал хүртэл 1.1 дахин нэмэгдэж, 1.9 сая төгрөгт хүрсэн байна. Харин нэг тонн rPET мөхлөгийг борлуулж буй дундаж үнэ нь 2021 оноос 2023 оны 3 дугаар улирал хүртэл 1.1 дахин өсөж, 2.2 сая төгрөгт хүрчээ. Ингэснээр rPET мөхлөгийг борлуулалтаас олж буй ашгийн ахиуц нь 2023 оны 3 дугаар улиралд 13.3 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн rPET мөхлөгийн эргэц 50.3, өдрөөр тооцсон эргэц 7.2 өдөр байгаа нь бараа материалын үлдэгдлийн хөрвөх чадвар сайн байгааг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл rPET мөхлөг жилд 50.3 удаа буюу 7 өдөрт нэг эргэж байгаа нь өмнөх оны мөн үеэс удааширсан хэдий ч Үнэт цаас гаргагч нь бараа материалын хөрвөх чадварыг сайн хангаж ажиллаж байна.

## rPET мөхлөгийн хэрэглээ

Эцсийн бүтээгдэхүүн болох rPET (Recycled Polyethylene Terephthalate) мөхлөгийг дэлхий дахинд ус, ундааны сав, нэхмэлийн утас, бусад хүнсний сав баглаа боодол, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн зэргийн үйлдвэрлэлд түүхий эд болгон өргөнөөр ашиглаж байна.

СЭХ
2024.07.05 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2024-06-03
БҮРТГЭВ-02

**Хүснэгт 22: rPET мөхлөгийн хэрэглээ**

| | |
|---|---|
| **Сав, баглаа боодлын үйлдвэрлэл** | • **Хуванцар савны үйлдвэрлэл:** rPET мөхлөгийн хамгийн түгээмэл хэрэглээний нэг бол ус, ундааны хуванцар сав үйлдвэрлэхэд өргөнөөр ашигладаг.<br>• **Хүнсний сав, сав баглаа боодол:** rPET мөхлөгийг янз бүрийн хэлбэрт оруулж, хүнсний зориулалттай сав, баглаа боодлыг үйлдвэрлэдэг бөгөөд хэрэглээний дараа үүнийг дахин боловсруулах боломжтой байдаг. |
| **Утас үйлдвэрлэл** | • **Утас үйлдвэрлэл:** rPET мөхлөгийг хайлуулж, утас болгон ээрүүлж, полиэфир даавуу үйлдвэрлэж, хувцас, бүрээс, хивс, нэхмэл эдлэлийн үйлдвэрлэлд ашигладаг. rPET мөхлөгийг даавуу болгон хувиргах үйл явц нь химийн найрлагатай полиэстер материал үйлдвэрлэхээс ч бага ус, эрчим хүч зарцуулдаг тул байгальд ээлтэй хандлагыг илүүд үздэг хувцас үйлдвэрлэгчдийн томоохон сонголт болоод байна.<br>• **Дүүргэгч материал:** rPET мөхлөгийг нь дэр, хөнжил, гадуур хувцас зэргийг дүүргэх материал болгон хувиргаж ашиглах боломжтой байна. |
| **Автомашины эд анги** | • **Автомашины дотор болон гадна эд анги**: rPET мөхлөгийг автомашины үйлдвэрлэлд ашиглахад бат бөх, элэгдэлд тэсвэртэй байдаг тул автомашины доторлогоо, дэвсгэр, тусгаарлагч зэрэг эд анги үйлдвэрлэхэд өргөнөөр ашигладаг. |
| **Барилгын материалын үйлдвэрлэл** | • **Дуу чимээ тусгаарлагч:** rPET мөхлөгийг боловсруулж барилгын дулаалга, дуу чимээ тусгаарлагч материал болгон ашигладаг ба rPET мөхлөгөөр хийгдсэн барилгын материал нь уламжлалт материалтай төстэй дулаан тусгаарлах шинж чанартай боловч байгаль орчинд ээлтэй байдгаараа илүү давуу талтай.<br>• **Геонэхмэл материал:** rPET мөхлөгийг хөрс тогтворжуулах, элэгдлээс хамгаалах, ус зайлуулах зэрэгт ашиглагддаг туслах материал болгон ашигладаг. |
| **Үйлдвэрлэлийн хэрэглээ** | • **Татлага болон бусад материал**: rPET мөхлөгийг ачаа тээвэрлэлт болон сав баглаа боодолд ашиглагддаг татлага хийхэд ашигладаг ба бусад үйлдвэрлэлийн зориулалтаар янз бүрийн хэлбэрт оруулан хувирган ашиглах боломжтой байна. |
| **Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл** | • **Гэр ахуйн хэрэгсэл, тавилга:** rPET мөхлөгийг гал тогооны хэрэгсэл, гаднах орчны тавилга, хадгалах сав зэрэг олон төрлийн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашигладаг. |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES



5147204 ХАК0303
ТЖТБ
УЛААНБААТАР ХОТ

**Тогтвортой хөгжлийн ашиг тус**

rPET мөхлөгийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй нь байгаль орчинд ихээхэн хувь нэмрийг оруулж байна. Тухайлбал:

- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах
- Газрын тосны хэрэглээг бууруулах
- Хог хаягдлыг багасгах
- Ус, эрчим хүчийг хэмнэх
- Хөрсний бохирдлыг бууруулах
- Хуванцрын бохирдлыг бууруулах, дахин боловсруулалтыг дэмжих дэлхийн чиг хандлагыг дагаж үйлдвэрлэлийн салбарт байгальд ээлтэй материалын талаарх мэдлэг, мөн эрэлт хэрэгцээ ихсэж байгааг rPET мөхлөгийн өсөн нэмэгдэж буй хэрэглээ харуулж байна.

### 2.3.4.6. ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО



Үнэт цаас гаргагчийн Чанар хяналтын алба нь Чанарын менежер, Чанар шалгагч гэсэн нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйлдвэрлэлийн шугамуудаас гарч буй бүтээгдэхүүний чанарыг хянах, сайжруулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн хяналтын тогтолцооны хүрээнд үйлдвэрлэлийн

САХ 2024.07.05 БҮРТГЭВ
2024-06-03 БҮРТГЭВ-02

шугамуудын эцсийн бүтээгдэхүүнүүдэд цаг тутамд шинжилгээ хийхээс гадна түүхий эдийн шинж чанар болон үйлдвэрлэлийн процесст тогтмол хяналт тавин ажилладаг.

Чанар хяналтын алба нь эцсийн бүтээгдэхүүний шинж чанарыг илэрхийлэхэд дараах үзүүлэлтүүдээр стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг нийт 18 төрлийн шинжилгээний хүрээнд, 24 цагийн турш цаг тутамд тасралтгүй гүйцэтгэж тодорхойлдог байна. Үүнд:

- Хайлах температур;
- Чийгшил;
- Дотоод зууралдлага буюу Intrinsic viscosity;
- Өөрийн нягт;
- Овор хэмжээний нягт;
- Органик үлдэгдэл;
- Өнгөний координат;
- Бохирдлын хэмжээ;
- Ширхэглэгийн хэмжээ;
- Ацетальдегидийн агууламж;
- Химийн хэрэгцээт хүчилтөрөгч;
- pH;
- Бусад.

Түүнчлэн Компанийн Чанар хяналтын алба нь лабораторийн тоног төхөөрөмжийг зааврын дагуу ажиллуулж, цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол хийж, техник ашиглалтын паспортыг тогтмол хөтлөх, шинжилгээний тоон мэдээ тайлан гаргах, батлагдсан журмын дагуу холбогдох цэгүүдээс дээж авах, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлүүлэхэд хяналт тавих, лабораторийн дотоод журмын дагуу бүртгэлүүдийг үнэн зөв бөглөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэдэг байна. Үүнээс гадна хэрчдэс, мөхлөгийн угаалгад ашиглагдаж буй химийн бодисыг хянах, шахан багласан түүхий эдийн ашигтай материалын хэмжээг тодорхойлох, Сорема үйлдвэрлэлийн шугамын гараар ялгалт хийх үед чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг хянах зэрэг үйлдвэрлэлийн процессын бүхий л үе шатанд чанарт нөлөөлөх боломжтой бүх параметрүүдийг хянан ажилладаг.

**Схем 1: Үнэт цаас гаргагчийн чанарын баталгаажуулалтын үйл явц**




Хуванцрын боловсруулалтын үйл ажиллагааны түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн хүртэлх үе шат бүрд чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг Чанар хяналтын албаны лабораторийн баг ажиллаж, хими болон физикийн шинжилгээг гүйцэтгэж, үнэлгээ дүгнэлтийг тогтмол гарган ажиллаж байна. Тус шинжилгээний дүгнэлт дээр үндэслэн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүний шошгыг хийдэг бөгөөд мөн ус цэвэршүүлэх байгууламжийн бохир усны дээжид Компанийн Чанарын хяналтын алба лабораторийн шинжилгээг хийхийн зэрэгцээ хоёрдогч лабораторид шинжилгээ хийлгүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн хуванцар савыг дахин боловсруулах үйлдвэрт дотоод хяналтын лабораторид тогтоосон чанарын үзүүлэлтүүд, хуванцрыг дахин боловсруулах FDA, EFSA, GRS-ийн олон улсын стандарт шаардлага, мөн эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын ISO 9001:2015, ISO 14001:2015, FSSC 22000 стандартыг мөрдөн, шаардлага хангасан rPET мөхлөгийг үйлдвэрлэж байна.

2024.07.05 он сар өдөр БҮРТГЭВ № 01

**Схем 2: Хагас боловсруулсан бүтээгдэхүүн ба эцсийн бүтээгдэхүүний үзүүлэлтүүдийн төрөл**

2024-06-03 БҮРТГЭВ-02




Хагас боловсруулсан бүтээгдэхүүн болон эцсийн бүтээгдэхүүн нь дээрх схемд үзүүлсэн чанарын шаардлагын үзүүлэлтүүдийг бүрэн хангасан байдаг ба чанарын шинжилгээг Компанийн Чанар хяналтын алба болон олон улсын хараат бус лабораториудаар хийлгэн баталгаажуулдаг.

### Хагас боловсруулсан бүтээгдэхүүний чанарын шаардлага

Сорема шугамын эцсийн бүтээгдэхүүн болох хагас боловсруулсан бүтээгдэхүүний чанар нь мэдрэхүйн буюу физикийн болон химийн гэсэн 2 төрлийн үзүүлэлт бүхий шаардлагуудыг хангасан байдаг. Үүнд:

**Хүснэгт 23: Хагас боловсруулсан бүтээгдэхүүний чанарын шаардлагууд**

| **Физикийн үзүүлэлтүүд** | | |
|---|---|---|
| Үзүүлэлтүүд | Стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Утга |
| Чийгшил | • <0.7% | • 0.42% |
| Нягт | • 250-500 кг/м³ | • 283.34 кг/м³ |
| Дотоод зуурамтгай чанар | • 0.72-0.76 дл/г | • 0.74 дл/г |
| Өнгө | • Захиалагчийн хүсэлтээр | • Захиалагчийн хүсэлтээр |
| pH өсөлт | • 0.5 | • 0.32 |

| **Химийн үзүүлэлтүүд** | | |
|---|---|---|
| Үзүүлэлтүүд | Стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Утга |
| Поливинилхлорид | • < 5 ppm | • < 2 ppm |
| Метал | • < 5 ppm | • < 0 ppm |
| Полиолефин | • Хамгийн ихдээ 50 ppm | • < 0 ppm |
| Лимонен | • Захиалагчийн хүсэлтээр | • Захиалагчийн хүсэлтээр |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES TDB SECURITIES



ТЖТБ УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.07.05 өдөр
№ 01

2024-06-03
БҮРТГЭВ-02

### Эцсийн бүтээгдэхүүн болох rPET мөхлөгийн чанарын шаардлага

Эцсийн бүтээгдэхүүний чанар нь мэдрэхүйн буюу физикийн, химийн, хүнд металлын болон нян судлалын гэсэн 4 төрлийн үзүүлэлт бүхий шаардлагуудыг хангасан байдаг. Үүнд:

**Хүснэгт 24. Эцсийн бүтээгдэхүүний чанарын шаардлагууд**

| Физикийн үзүүлэлтүүд | | |
|---|---|---|
| Үзүүлэлтүүд | Стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Утга |
| Чийгшил | • <0.7% | • 0.42% |
| Их хэмжээний нягтшил | • 800-900 кг/м³ | • 802.30 кг/м³ |
| Дотоод зуурамтгай чанар | • 0.80-0.84 дл/г | • 0.82 дл/г |
| Нягт | • 1.35-1.45 г/см³ | • 1.36 г/см³ |
| 1 грамм бүтээгдэхүүн дэх ширхгийн тоо | • 45-65ш | • 57ш |
| Хайлах цэг | • 255-260°C | • 256.6°C |
| Ширхэглэгийн хэмжээ | • 100ppm | • 0 ppm |
| 100 ширхэг бүтээгдэхүүн дэх массын хэмжээ | • - | • 1.76г |

| Химийн үзүүлэлтүүд | | |
|---|---|---|
| Үзүүлэлтүүд | Стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Утга |
| Ацетальдегид | • < 1 ppm | • < 0.8 ppm |
| Лимонен | • Захиалагчийн хүсэлтээр | • Захиалагчийн хүсэлтээр |

| Хүнд металлын үзүүлэлтүүд | | | |
|---|---|---|---|
| Үзүүлэлтүүд | | Стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | Утга |
| Хүнд металлын үлдэгдэл, мг/л | Кадми | • 0.01 | • 0.01 |
| | Хар тугалга | • 0.0 | • 0.03 |

| Нян судлалын үзүүлэлтүүд | | | |
|---|---|---|---|
| Үзүүлэлтүүд | Стандартын дагуу зөвшөөрөгдөх хэмжээ | | Утга |
| Нян судлал | • Салмонел, 25 г-д | • Илрэхгүй | • Илрэхгүй |
| | • Эмгэг төрөгч E.coli, 25 г-д | • Илрэхгүй | • Илрэхгүй |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

5147204 ХАК0303
ТЖТБ ХХК

### 2.3.4.7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

"ТЖТБ" ХХК нь хог хаягдал цуглуулах, ялган ангилах, дахин боловсруулах үйл ажиллагаагаараа дамжуулан Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ)-ын Тогтвортой хөгжлийн доорх зорилтуудад шууд болон шууд бусаар хувь нэмрээ оруулж байна. Үүнд:




2021 оноос 2023 оны урьдчилсан гүйцэтгэлийн үзүүлэлтээр Үнэт цаас гаргагч нь нийт 16,144 тонн хог хаягдлыг дахин боловсруулж, 9,821 тонн rPET мөхлөг үйлдвэрлэсэн нь байгаль орчинд дараах эерэг нөлөөллийг үзүүлж байна. Үүнд:

- Хүлэмжийн хийн ялгарлыг **63.2 мянган тонноор** бууруулсан.
- **139.9 ГВт** цахилгаан эрчим хүчийн хэмнэсэн.
- **8.8 сая тонн** усны хэрэглээг хэмнэсэн.
- **46.5 мянган м.куб** хөрсний бохирдол үүсэхээс сэргийлсэн.

Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь үйлдвэрийн саарал усыг дахин боловсруулах байгууламжтай бөгөөд тус байгууламж нь өдөрт 96м$^3$ хаягдал усыг 96 хувь шүүн, цэвэршүүлэх хүчин чадалтай байна. Тус байгууламж нь одоогийн байдлаар бүрэн ашиглалтад ороогүй буюу туршилтын шатандаа явагдаж байна. Polyacrylamide-аар хаягдал усыг дахин боловсруулах тус байгууламж нь Ти Эм Эл Пластик үйлдвэрээс гарсан бохир усыг цэвэрлэж, 70 орчим хувийг үйлдвэрт дахин ашиглахаар төлөвлөж байна. Ингэснээр ижил төстэй үйлдвэрүүдээс 6-7 дахин бага ус зарцуулах боломжтой юм.

Мөн Үнэт цаас гаргагч нь rPET мөхлөг үйлдвэрлэж буй үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаараа дамжуулан 2021 оноос хойш 63,171 тонн хүлэмийн хий ялгарахаас сэргийлэн ажилласан байна.

**Хүснэгт 25: Үнэт цаас гаргагчийн ус цэвэршүүлэх төхөөрөмжийн үзүүлэлт**

| № | Цэвэршүүлэх төхөөрөмж | Үзүүлэлт |
|---|---|---|
| 1 | Цэвэршүүлэх үзүүлэлт | 4 м$^3$/ц |
| 2 | Олон улсын ялгаралтын стандарт | "Ариутгах татуургын бохирдлын нэгдсэн стандарт" А түвшний стандарт /GB8978-1996/ |
| 3 | Цэвэршүүлэх хүчин чадал | 96м$^3$/хоног |
| 4 | Цэвэршүүлэлтийн хувь | 96.8% |

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 298 дугаар тогтоолоор баталсан "Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийн 2 дугаар зүйлийн 2.2.2 дахь заалтад "Үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, хэмнэх замаар хог хаягдлыг бууруулах болон хаягдалгүй дэвшилтэт технологийг дэмжих, үйлдвэрлэлийн хог хаягдлын зохистой менежмент, хяналтын тогтолцоог бүрдүүлэх" гэх зорилтыг тусгасан байдаг.

Үнэт цаас гаргагч нь Ти Эм Эл Пластик үйлдвэрээрээ дамжуулан тус зорилтыг хангахад бүрэн чиглэн ажиллаж байгаа бөгөөд ус, ундааны хуванцар савны хог хаягдлыг цуглуулан, дахин боловсруулж Монгол Улсад анх удаа савнаас сав үйлдвэрлэх хүнсний дээд зэргийн дахин боловсруулсан хуванцрын мөхлөг (rPET) буюу нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж байна. Үүний зэрэгцээ Компани нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хүрээлэн буй орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хэмнэх зорилгоор технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламжаар цэвэршүүлэн дахин ашиглах, уурын зууханд хэрэглэгдэж байгаа нүүрсэнд тохирсон утаа цэвэршүүлэх яндангийн шүүлтүүр суурилуулан хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох зэрэг Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцсэн зорилтуудыг хэрэгжүүлнэ гэдгээрээ олон давуу талтай.

Цаашид Үнэт цаас гаргагч нь ногоон технологийг тасралтгүй нэвтрүүлэхээр төлөвлөж дотоод үйл ажиллагаанаас үүсэх органик хог хаягдлыг боловсруулж компост бордоо үүсгэх төхөөрөмж, үйлдвэрийн зарим байгууламжийг нарны эрчим хүчээр үүсгэх төхөөрөмжийг суурилуулан цаашид сэргээгдэх эрчим хүчийг үйлдвэрлэлд үе шаттайгаар нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

## 2.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ОРЧИН

### 2.4.1. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

СЗХ
2024.07.
БҮРТГЭВ
№
2024-06-03
БҮРТГЭВ-02

#### Дотоодын нийт бүтээгдэхүүн

Дэлхий дахинд нүүрлэсэн цар тахлын улмаас дэлхийн эдийн засаг 2020 онд 2.8 хувиар агшиж байсан бол 2021 онд 6.3 хувийн өсөлтийг үзүүлж, дэлхийн түүхэнд тохиолдсон эдийн засгийн томоохон хүндрэлүүдийн дараах хамгийн өндөр сэргэлт болжээ. Харин дэлхий дахинд цар тахлын нөлөөгөөр үүссэн өрийн дарамт, инфляцын өсөлт, мөнгөний хатуу бодлого, ОХУ болон Украйн Улс хоорондын дайны улмаас үүссэн хориг арга хэмжээнүүдээс шалтгаалан 2023 онд дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, 3.1 хувийн өсөлтийг үзүүлээд байна. 2023 оны эдийн засгийн өсөлтийг бүс нутгаар нь авч үзвэл өндөр хөгжилтэй орнуудын эдийн засаг 1.6 хувиар, хөгжиж буй орнуудын эдийн засаг илүү хурдацтай буюу 4.1 хувиар, АНУ-ын эдийн засаг 2.5 хувиар, БНХАУ-ын эдийн засаг 5.2 хувиар тус тус өссөн байна.

**Зураг 11: Дэлхийн эдийн засгийн өсөлт, түүний таамаглал, бүс нутгаар**




*Эх сурвалж: ОУВС, "Дэлхийн эдийн төлөв", 2023 оны 11 дүгээр сар*

"Ковид-19" цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь дэлхийн хэмжээнд бүрэн арилаагүй байхтай зэрэгцэн ОХУ болон Украйн Улсын хооронд үүссэн дайн, үүнээс үүдэлтэй нийлүүлэлтийн хомсдол, түүхий эдийн үнийн өсөлт, худалдааны хориг арга хэмжээ, инфляцын өндөр өсөлт, мөнгөний хатуу бодлого, дэлхийн санхүүгийн тодорхой бус нөхцөл байдал зэрэг хүчин зүйлсийн улмаас цаашид дэлхийн эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөв сул буюу урт хугацааны удаашрал бий болохыг олон улсын санхүүгийн байгууллагууд онцолжээ.

**Хүснэгт 26: Дэлхийн бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал, бүс нутгаар**

| Бүс нутаг | Дэлхийн банк | | | ОУВС | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023F | 2024F | 2025F | 2023F | 2024F | 2025F | 2026F | 2027F | 2028F |
| **Дэлхий** | **2.6%** | **2.4%** | **2.7%** | **3.0%** | **2.9%** | **3.2%** | **3.2%** | **3.1%** | **3.1%** |
| **Өндөр хөгжилтэй орнууд** | **1.5%** | **1.2%** | **1.6%** | **1.5%** | **1.4%** | **1.8%** | **1.9%** | **1.8%** | **1.7%** |
| АНУ | 2.5% | 1.6% | 1.7% | 2.1% | 1.5% | 1.8% | 2.1% | 2.1% | 2.1% |
| Евро бүс | 0.4% | 0.7% | 1.6% | 0.7% | 1.5% | 2.1% | 2.0% | 1.8% | 1.7% |
| Япон | 1.8% | 0.9% | 0.8% | 2.0% | 1.0% | 0.7% | 0.5% | 0.4% | 0.4% |
| **Хөгжиж буй орнууд** | **4.0%** | **3.9%** | **4.0%** | **4.0%** | **4.0%** | **4.1%** | **4.1%** | **4.0%** | **3.9%** |
| БНХАУ | 5.2% | 4.5% | 4.4% | 5.0% | 4.2% | 4.1% | 4.1% | 3.7% | 3.4% |

*Эх сурвалж: ОУВС, "Дэлхийн эдийн засгийн төлөв", 2023 оны 10 дугаар сар*
*Дэлхийн банк, "Дэлхийн эдийн засгийн тойм", 2024 оны 1 дүгээр сар*

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

Цар тахал болон гадаад харилцаанд үүсээд буй тулгамдсан асуудлуудын улмаас үүссэн сөрөг нөлөөллөөс шалтгаалж улс орнууд инфляцын өндөр осолтийн эсрэг мөнгөний хатуу бодлого баримталснаар хүүгийн түвшин нэмэгдэж, гадаад эрэлт буурч, мөн дэлхийн санхүүгийн зах зээлд дарамт үүсэж буй зэргээс шалтгаалан судлаачид дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамаглалаа бууруулж, 2023 онд дэлхийн эдийн засаг 3.1 хувь, 2024 онд 3.2 хувь буюу өнгөрсөн онуудын дундажтай харьцуулахад маш бага хэмжээний өсөлтийг үзүүлэхээр төсөөлөөд байна.

Эдгээр нөхцөл байдлууд нь БНХАУ-аас бусад хөгжиж буй эдийн засагтай орнуудын эдийн засгийн өсөлтийг бууруулж, хөрөнгө оруулалтыг хумьж, санхүүгийн хямралыг эрчимжүүлж байгаа бөгөөд судлаачдын үзэж байгаагаар 2024 оны эцэст хөгжиж буй улс орнуудын гуравны нэгт нь 1 хүнд ногдох орлогын өсөлт цар тахлын өмнөх үеийнхээс бага байхыг дурджээ. Мөн АНУ болон Евро бүсийн улс орнуудын хувьд банкны дампууралтай холбоотой банкны системийн тодорхой бус байдал үүсэхийн зэрэгцээ БНХАУ-д томоохон үл хөдлөхийн компани дампуурч, үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хямрал нүүрлэсэн. Энэхүү үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал дэлхий дахинд ялангуяа түүхий эд экспортлогчдод нөлөөлж байна. Түүнчлэн ОХУ-ын эрчим хүчний импортоос ихээхэн хамааралтай улс орнуудын хувьд эрчим хүчний үнийн огцом өсөлтөөс шалтгаалан эдийн засаг нь удаашралтай байгаа бөгөөд эрчим хүчний үнийн өсөлт нь Евро бүсийн инфляцыг хөөргөхөд ихээхэн нөлөөлсөн аж. Цаашид эдгээр эрсдэлт хүчин зүйл даамжирвал хөгжиж буй орнуудын эдийн засагт сөрөг нөлөөллийг үзүүлж, дэлхийн эдийн засгийн өсөлт таамагласнаас доогуур байх боломжтойг судлаачид онцолжээ.

Дэлхий банкны үзэж байгаагаар эдийн засгийн өсөлтийн удаашралын эсрэг улс орнуудын төв банкнууд мөнгөний бодлогын хэтийн төлөвийг огцом өөрчлөхөөс зайлсхийж, аль эртнээс стратегидаа тохируулан тодорхойлж санхүүгийн эрсдэлийг бууруулах, мөн хөгжиж буй орнуудын хувьд бодлого тодорхойлогчид нь хөрөнгийн гадагшлах урсгал, валютын ханшийн уналт, өндөр инфляцыг бууруулахын тулд бодлогоо чангатгах, хөгжингүй орнуудад тохиолдоод буй банк, санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулахын тулд хөгжиж буй орнуудын банк, санхүүгийн байгууллага нь зохистой хэм хэмжээ, хөрвөх чадвараа сайжруулж, дотоодын эмзэг байдлыг бууруулах шаардлагатайг дурджээ. Мөн судлаачдын зүгээс хөгжиж буй орнууд нь өөрийн дотоод нөөц, боломжоо дайчилж, түүнийгээ үр ашигтай зарцуулах, өрийн удирдлагыг сайжруулахад тэргүүн ач холбогдол өгч, төсвийн тогтвортой байдлыг сэргээх, өрийн дарамтыг бууруулж, дэлхийн санхүүгийн аюулгүй байдлын сүлжээг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авахыг зөвлөөд байгаа юм.

## Инфляц

2020 онд Ковид 19 цар тахлын улмаас үүссэн нийлүүлэлтийн саатал, эрчим хүч болон хүнсний үнийн тогтворгүй байдал зэрэг нь өнөөгийн дэлхий нийтийн өндөр инфляцын түвшинг өдөөх хүчин зүйл болсон бөгөөд үүний эсрэг олон улсын төв банкнууд мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж, инфляцыг бууруулах арга хэмжээ авсаар байна. Үүний үр дүнд 2022 оны 2 дугаар улиралд 11.6 хувь буюу хамгийн оргил үедээ хүрээд байсан дэлхийн инфляцын түвшин нь эрчим хүч болон хүнсний үнийн бууралтаас шалтгаалан 2023 оны 4 дүгээр улиралд 6.4 хувь болж 2 дахин орчим буурсан үзүүлэлттэй байна. Цар тахлын нөлөө хумигдахын хэрээр эдийн засаг сэргэж, дэлхийн инфляцийн түвшинг 2024 онд 5.1 хувь, 2025 онд 4.5 хувь болж буурах төсөөлөлтэй байна.

**Хүснэгт 27: Дэлхийн инфляцын түвшний таамаглал, хугацааны эцэст, бүс нутгаар**

| Бүс нутаг | 2023F | 2024F | 2025F | 2026F | 2027F | 2028F |
|---|---|---|---|---|---|---|
| **Дэлхий** | **6.4%** | **5.1%** | **4.5%** | **4.0%** | **3.9%** | **3.7%** |
| **Өндөр хөгжилтэй орнууд** | **3.3%** | **2.6%** | **2.2%** | **2.0%** | **2.1%** | **1.8%** |
| АНУ | 3.0% | 2.6% | 2.3% | 2.1% | 2.4% | 1.6% |
| Евробүс | 4.0% | 3.0% | 2.4% | 2.1% | 2.0% | 1.9% |
| Япон | 2.7% | 2.6% | 1.8% | 1.6% | 1.6% | 1.6% |
| **Хөгжиж буй орнууд** | **8.6%** | **6.8%** | **6.0%** | **5.4%** | **5.1%** | **4.9%** |

СЭХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| БНХАУ | 0.9% | 1.9% | 2.2% | 2.2% | 2.2% | 2.2% |

*Эх сурвалж: ОУВС, "Дэлхийн эдийн засгийн төлөв", 2023 оны 10 дугаар сар*

2024-06-13
БҮРТГЭВ-02

Олон улсын валютын сан (ОУВС)-ын үзэж байгаагаар дэлхийн инфляцын түвшин 2022 онд 8.9 хувь байсан бол 2023 онд 6.4 хувь, 2024 онд 5.1 хувь болж тогтвортой буурах бөгөөд 2025 онд инфляц зорилтот түвшиндээ хүрнэ гэж таамагласан байна. Түүнчлэн бүс нутгаар нь авч үзвэл инфляцын түвшин өндөр хөгжилтэй орнуудад 3.3 хувь, хөгжиж буй орнуудад 8.6 хувь, Евро бүсийн хувьд 4.0 хувь, АНУ-д 3.0 хувь, Япон улсад 2.7 хувьд хүрнэ хэмээн тус тус таамагласан байна. Судлаачдын үзэж байгаагаар ойрын хугацаанд инфляцын хүлээлт нэмэгдэж, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдалтай холбоотой инфляцын дарамт хэвээр үлдэж, хүлээгдэж байснаас илүүтэйгээр бодлогын хүүг нэмэгдүүлэх шаардлага үүсэж болзошгүй бөгөөд уур амьсгалын өөрчлөлт, геополитикийн цочрол нь хүнс, эрчим хүчний үнийн өсөлтийг үүсгэж болзошгүй гэж үзжээ.

### Бодлогын хүү

"Ковид-19" цар тахал болон геополитикийн асуудлуудын улмаас дэлхий дахинд үүссэн инфляцын дарамт нь дэлхийн улс орнуудыг мөнгөний бодлогоо чангатгах шалтгаан болж байгаа бөгөөд тус байдал нь одоо ч үргэлжилж, хүүгийн түвшин цаашид өсөх хандлагатай байна. Тухайлбал, АНУ-ын инфляцын түвшнийг 2 хувьд хүргэх зорилтын хүрээнд АНУ-ын Холбооны нөөцийн банк удаа дараалан хуралдаж, 2023 оны 12 дугаар сард бодлогын хүүгээ 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж 5.3 хувьд хүргэжээ. АНУ-ын Холбооны нөөцийн банкны үзэж байгаагаар хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал хангалттай сайн буюу ажилгүйдлийн түвшин түүхэн доод хэмжээнд байгаа нь тус улсын инфляцын дарамтыг илүү нэмэгдүүлж байгаа учир тэд АНУ-ын бодлогын хүүгийн медиан төсөөллийг 2024 онд 4.0 хувь, хоёр дахь хагаст 3.8 хувь хүрнэ хэмээн төсөөлжээ. АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн нягт байдлыг харгалзан үзвэл бодлогын хүү цаашид ч тус медиан төсөөллөөс илүү өсөх хандлагатай байна.

**Зураг 12: Улс орнуудын мөнгөний бодлогын хүүгийн хэмжээ, 2023.12.31**




*Эх сурвалж: Bank for International Settlements, Төв банкны бодлогын хүү, 2023.12.31*

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES
ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024 . 07 сар 05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2024 -06- 03
БҮРТГЭВ-02

## 2.4.2. ДЭЛХИЙН БОЛОВСРУУЛСАН ПОЛИЭТИЛЕН ТЕРЕФТАЛАТ МӨХЛӨГИЙН ЗАХ ЗЭЭЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

### Дахин боловсруулсан полиэтилен терефталат мөхлөгийн зах зээл

PET хуванцар нь тунгалаг, хөнгөн, удаан эдэлгээтэй байдаг бөгөөд дахин боловсруулагдах зориулалттайгаар үйлдвэрлэгддэг хуванцрын нэг төрөл юм. Энэхүү хуванцрын хаягдлыг цуглуулж, цэвэрлэн, хайлуулж дахин боловсруулан мөхлөг эсвэл үрэл хэлбэрт оруулан боловсруулсан төрлийг Recycled Polyethylene Therephthalate буюу rPET гэж нэрлэдэг бөгөөд rPET мөхлөгийг ашиглан хүнсний болон бусад хэрэглээний хуванцар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг. Дэлхийн байгаль хамгаалах сангаас 2030 он гэхэд хуванцаргүй байгаль орчныг бүтээх зорилтын дагуу өргөн хэрэглээний хуванцар бүтээгдэхүүний хаягдлыг цуглуулан, дахин боловсруулах, шинээр үйлдвэрлэж буй хуванцар материалыг байгаль орчинд байж болох хамгийн бага хор хөнөөлтэй байлгах үйл явцыг сайжруулахыг эрмэлзэж байна. Шаардлагагүй хуванцрын хэрэглээг зогсоох, хог хаягдлыг багасгах, тойрог эдийн засгийг дэмжихэд энгийн PET хуванцрыг бодвол байгаль орчинд ээлтэй нь бага rPET мөхлөг нь илүү чухал нөлөөтэй байна.

Grand View Research Inc. байгууллагаас гаргасан Дахин боловсруулсан хуванцрын зах зээлийн хэмжээ, хувь болон цаашдын чиг хандлагын судалгаанд дурдснаар 2023 оны байдлаар дэлхийн rPET мөхлөгийн зах зээл 10.8 тэрбум ам.долларын үнэлгээтэй байгаа бөгөөд 2024-2030 он хүртэл жилд дунджаар 8.5 хувиар өсөж, 2030 он гэхэд 17.3 тэрбум ам.долларын үнэлгээнд хүрэх төлөвтэй байна. Мөн салбарын нийт өсөлтөд хоол хүнсний зориулалттай сав, баглаа боодлын компаниуд дахин боловсруулсан хуванцар ашиглах сонирхол ихсэж байгаа нь хамгийн ихээр нөлөөлж байгаа бөгөөд хүнсний бус зориулалтын буюу даавуун материал, гэр ахуйн бүтээгдэхүүн, тавилга, автомашины эд анги, сэлбэг, дулаан тусгаарлагч, машины суудал зэрэг төрөлжсөн хэрэглээ мөн адил өсөж байгаа нь 2030 он хүртэл тус зах зээлийн үнэлгээ нь 8.5 хувиар өсөж, 17.3 тэрбум ам.долларт хүрэхэд голлон нөлөөлөх төлөвтэй байгааг онцолжээ.

rPET мөхлөгийн зах зээлийн өсөлтөд нөлөөлөх голлох хүчин зүйлс болон салбарт үүсэж буй боломжууд нь дараах байдалтай байна. Үүнд:

➔ **rPET зах зээлийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлс**

- Дэлхий даяар дахин боловсруулах үйлдвэрийн тоо нэмэгдэж, үүнийг дагаж технологийн дэвшил, боловсруулалтад зарцуулах хөрөнгийн хэмжээ ихэссэн, илүү хурдан, үр ашигтайгаар хуванцрын хаягдлыг цуглуулж, боловсруулах болсон;
- Хэрэглэгчдийн байгальд ээлтэй хэрэглээг сонгож хэрэглэх хандлага нэмэгдсэн;
- Хоол хүнсний салбарт дахин боловсруулсан хуванцрыг ашиглах эрэлт нэмэгдсэн;
- Хог хаягдлын менежмент болон хяналт сайжирснаар хуванцрын хаягдлыг цуглуулахад илүү зардал багатай болсон.

➔ **Боломж**

- Байгаль орчинд ээлтэй сав, баглаа боодлын хэрэгцээ нэмэгдэж байна;
- Засгийн газраас энэ талаар гаргаж буй зохицуулалтын тогтолцоо сайжирч, тохирох дүрэм журмыг нэвтрүүлж эхэлсэн ба үүнийг даган тус салбарт татварын таатай нөхцөл байдал үүсэх, мөн үйлдвэрлэгчдэд Засгийн газраас хөнгөлт, татаас үзүүлэх боломжтой.

Дахин боловсруулсан хуванцрын тогтмол өсөж байгаа хэрэгцээг хангахын тулд хуванцрын хаягдлыг бохирдолгүй цэвэр хэлбэрээр нь цуглуулах боловсруулах цогц тогтолцоо дэлхий дахинд нэн шаардлагатай байна. Учир нь үйлдвэрлэгчдийн хувьд зөвхөн цөөн нэр төрлийн, цэвэр төрлөөрөө байгаа хог хаягдлыг дахин боловсруулах боломжтой байдаг тул нэг сав баглаа боодолд олон төрлийн материал орсон, мөн материал бохирдсон байх зэрэг үед хуванцар хаягдлыг боловсруулахад хүндрэлтэй байдаг. Иймд хуванцар хог хаягдлыг дахин боловсруулахад цэвэр хуванцар хаягдлын нийлүүлэлт тус зах зээлд хангалтгүй түвшинд байгаа тул хог хаягдлын менежментийг сайжруулах, иргэд хуванцар бүтээгдэхүүний хаягдлыг ангилахад шаардлагатай дэд бүтцийг бий болгох, мөн хогийг

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЭХ
№ 01

2024 -06- 03
БҮРТГЭВ-02

ангилан ялгах талаар мэдлэг, мэдээллийг тогтмол олгох зэргээр цэвэр хуванцар хог хаягдлын нийлүүлэлтийг сайжруулах боломжтой байна

## Тойрог эдийн засагт үзүүлэх нөлөө

Дэлхийн хүн амын тоо нэмэгдэхийн хэрээр түүхий эдийн хэрэгцээ өсөж, дан ганц байгалийн бүтээгдэхүүнээр энэ хэрэгцээг хангах боломжгүй болж эхэлсэн. Хэт их үйлдвэрлэлийн улмаас байгаль орчны тогтвортой байдал алдагдаж, нүүрстөрөгчийн ялгарал байх ёстой хэмжээнээсээ хэт ихэссэнийг тогтворжуулах зорилгоор дэлхий дахинд “тойрог эдийн засаг” буюу хог хаягдалгүй, байгальд орчинд ээлтэй дахин боловсруулалтад тулгуурласан эдийн засгийн тогтолцоог цогцлоох зорилтууд хэрэгжиж эхэлжээ.

2015 онд Европын холбооноос гаргасан тойрог эдийн засагт шилжих зорилтот төлөвлөгөөний хүрээнд 2030 он гэхэд хуванцар үйлдвэрлэлийн компаниудыг дахин боловсруулсан хуванцар ашиглах, шинээр үйлдвэрлэгдэж байгаа хуванцрыг зардал багатайгаар дахин боловсруулах боломжтой байлгахыг үүрэгжүүлсэн байна. Үүнээс гадна 2030 он гэхэд хүн амын бүхий л төрлийн хэрэглээг 32.0 хувиар, 2050 он гэхэд 50.0 хувиар багасгах зорилгыг тавьж, үйлдвэрлэгчдийн хувьд дахин боловсруулах боломжтой PET болон rPET хуванцар нь энэхүү зорилтод хүрэхэд чухал нөлөө үзүүлэх юм.

## Дахин боловсруулсан rPET мөхлөгийн төрөл

Дахин боловсруулсан хуванцрыг тунгалаг болон өнгөтэй хоёр төрлийн бүтээгдэхүүний түүхий эд болгон ашиглах боломжтой ба ихэнх үйлдвэрүүд зардлаа багасгах зорилгоор тунгалаг төрлийг сонгон хэрэглэдэг бол сав баглаа боодлын болон хуванцар савны үйлдвэрүүд брэндийн ялгарал үүсгэх, бүтээгдэхүүний үзэмжийг сайжруулах зорилгоор өнгөтэй хуванцрыг түлхүү ашигладаг.

**Зураг 13: Дэлхийн rPET зах зээлийн орлогын хэмжээ, төрлөөр, 2023 он**




*Зураг 14: Дэлхийн rPET зах зээлийн орлогын бүтэц, эцсийн бүтээгдэхүүний төрлөөр, 2023он*

**Зураг 14: Дэлхийн rPET зах зээлийн орлогын бүтэц, эцсийн бүтээгдэхүүний төрлөөр, 2023он**




*Эх сурвалж : Прэсидэнс Рисэрч судалгааны байгууллагаас бэлтгэсэн тайлан*

Дахин боловсруулсан хуванцрыг тунгалаг болон өнгөтэй хоёр төрлийн материал хийхэд ашигладаг ба ихэнх үйлдвэрүүд зардлаа багасгах зорилгоор тунгалаг төрлийг сонгон хэрэглэдэг бол сав баглаа боодлын болон хуванцар савны үйлдвэрүүд брэндийн ялгарал үүсгэх, бүтээгдэхүүний үзэмжийг сайжруулах зорилгоор өнгөтэй хуванцрыг түлхүү ашигладаг.

2023 оны байдлаар дахин боловсруулсан хуванцрын эдийн засгийн орлогын 76.0 орчим хувийг тунгалаг хуванцар бүрдүүлж байна. Өнгөт хуванцраас үнэ хямд, боловсруулалтын үед шаардагдах энергийн хэмжээ бага, хагарч гэмтэхгүй, хоол хүнстэй урвалд орохгүй зэрэг давуу талууд нь тунгалаг хуванцрын эрэлтийг нэмэгдүүлж байна. Дэлхий даяар ундаа, цэвэр ус зэрэг шингэн бүтээгдэхүүний сав баглаа боодолд дахин боловсруулсан хуванцрыг ашиглах болсон бөгөөд 2008-2017 оны хооронд нийт хуванцар савны үйлдвэрлэлд дахин боловсруулсан хуванцрын эзлэх хувь нь 452.0 хувиар өсөн, 3.3-

18.2 хувь хүржээ. Үүнтэй уялдан өнгөгүй тунгалаг хуванцрын эрэлт нь тайлант хугацаанд буюу 2030 он хүртэл жилд дунджаар 7.2 хувийн өсөлт үзүүлэх төлөвтэй байна.

Өнгөт хуванцар хамгийн их ашигладаг эцсийн бүтээгдэхүүн болох хамгаалалтын сав, баглаа боодол, зөөврийн тавцан, цахилгаан барааны савлагаа, хувцас хэрэглэлийн материал зэргийн хэрэгцээ мөн адил өсөж байгаатай холбогдуулан өнгөт төрлийн хуванцрын үйлдвэрлэл 2024-2030 онд жилд дунджаар 9.5 хувийн өсөлттэй байх магадлалтай байна.[4]

### Дахин боловсруулсан хуванцрын бүтээгдэхүүн

2023 оны байдлаар нийт дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний 40.0 хувийг хувцас, автомашины хэрэгслийн үйлдвэрлэлд ашигласан бол үлдсэн хэсгийг хоол, ундаа усны сав баглаа, боодол, хуванцар хавтас, уяа боолт, хоол хүнсний зориулалтын бус сав, баглаа боодол болон бусад төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигласан байна.

Хоол, хүнсэнд ашиглагдах боломжтой rPET мөхлөгийн борлуулалт нь нийт зах зээлийн борлуулалтын 20.0 орчим хувийг эзэлдэг. Хоол хүнсний сав, баглаа боодолд ашигладаг дахин боловсруулсан хуванцар нь хэрэглэгчийн эрүүл мэндэд шууд нөлөө үзүүлдэг учраас чанарын шаардлагыг өндөр түвшинд хангаж ажиллах шаардлагатай байдаг. Хүнсний өнгө, амтанд нөлөөлөх, урвалд орохоос сэргийлэх, тээвэрлэлтийн явцад баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор бэлтгэсэн шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн rPET мөхлөгийг бэлтгэхийн тулд дахин боловсруулалтын явцад зардал өндөр гардаг. Гэсэн хэдий ч хэрэглэгчдийн эрэлтийг даган хүнсний зориулалттай дахин боловсруулсан хуванцрын үйлдвэрлэл эрчимтэй нэмэгдэж, 2024-2030 онд 9.0 орчим хувийн өсөлт үзүүлэх төлөвтэй байна.

rPET мөхлөгийн нийт зах зээлийн борлуулалтын дийлэнх буюу 80.0 орчим хувийг хүнсний бус зориулалтаар ашиглагдах бүтээгдэхүүн үйлдвэрлэл бүрдүүлж байна. Тэр дундаа харьцангуй хямд үнэ болон засгийн газрын үүсгэсэн таатай бодлогын улмаас хувцас үйлдвэрлэгчид дахин боловсруулсан хуванцрын хэрэглээг ихэсгэх сонирхолтой байна. Дэлхий даяар спортын зах зээлд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хэрээр дахин боловсруулсан хуванцар ашигладаг спортын хувцас хэрэглэлийн эрэлт мөн адил ихсэж байгаа нь өсөлтөд эергээр нөлөөлөх магадлалтай.[5]

### rPET мөхлөгийн үйлдвэрлэлийн өсөлт, бүс нутгаар

- **Ази номхон далайн бүсийн зах зээл**

Ази, Номхон далайн орнуудын хувьд мэргэжлийн ур чадвар бүхий чадварлаг ажилчдыг хямд хөлсөөр ажиллуулах боломж, мөн газар нутгийн өргөн уудам байдал зэргээс шалтгаалан хуванцрын дахин боловсруулалтаараа дэлхийд тэргүүлж, 2023 оны байдлаар тус бүс нь нийт зах зээлийн орлогын 40.6 орчим хувийг эзэлж байна. Энэтхэг, Хятад зэрэг хүн ам ихтэй орнуудын хуванцрын хэрэглээ их байхын хэрээр дахин боловсруулах үйлдвэрлэл хурдацтай хөгжиж байгаа нь тус улсуудын Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, хяналт нь боловсруулсан хуванцрын хэрэглээг нэмэгдүүлэхэд хүчтэй түлхэц болжээ.

Прэсидэнс Рисэрч судалгааны компаниас 2023 онд эрхлэн гаргасан "Дахин боловсруулсан полиэтилен терефталатын зах зээлийн хэмжээ, үнэлгээ болон өсөлтийн судалгаа"-нд Ази номхон далайн орнуудын rPET мөхлөгийн зах зээлийн хэмжээг 2023-2033 онд жилд дунджаар 4.6 хувиар өсөж, 2033 он гэхэд 19.1 тэрбум долларт хүрэх төсөөллийг гаргажээ.



[4] Гранд виюв рисэрч судалгааны байгууллагын 2023 оны судалгаа
[5] Гранд виюв рисэрч судалгааны байгууллагын 2023 оны судалгаа

СЗХ
2024.07.05
БҮРТГЭВ
№ 01
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Зураг 14: Ази номхон далайн бүсийн rPET зах зээлийн үнэлгээний төсөөлөл, тэрбум ам.доллар, 2023-2033 он**




➔ **Европын зах зээл**

PET хуванцрыг rPET хуванцраар орлуулах зорилтын хүрээнд Европын холбооноос гаргасан хуванцар хаягдлыг цуглуулах системийн зохицуулалтын дагуу дахин боловсруулах үйлдвэрүүдийн тоо нэмэгдэж, тус бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжиж байна. 2023 оны байдлаар Европын зах зээл нь дэлхийн rPET-ийн эрэлтийн 25.0 орчим хувийг бүрдүүлж байгаа бөгөөд Герман, Австри, Дани, Нидерланд зэрэг улсууд хуванцрын хог хаягдлыг шууд хаяхыг бүрэн хориглосноор цаашид ч энэ үйлдвэрлэлийн хөгжил хурдсах төлөвтэй байна.

**rPET мөхлөгийн үнэд нөлөөлөх хүчин зүйлс**

**Зураг 15: 1 тонн анхдагч PET хуванцрын дэлхийн дундаж үнэ, доллароор, 2017-2022 он**




*Эх сурвалж :Дахин боловсруулсан хуванцрын бүтээгдэхүүний үнийн судалгаа*

**Дэлхий дахинд rPET мөхлөгийн үнэд нөлөөлөх хүчин зүйлс нь дараах байдалтай байна. Үүнд:**

- Дахин боловсруулсан хуванцрын эрэлт, хэрэгцээ;
- Боловсруулалтын болон тээвэрлэлтийн зардал;
- Эцсийн бүтээгдэхүүний чанарын шаардлага;
- Газрын тосны үнэ;
- Анхдагч PET хуванцрын үнэ;
- Холбоотой хууль журам болон татвар.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



5147204 ХАК0303
ТЖТБ
УЛААНБААТАР ХОТ

2024 .07. 05
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

### 2.4.3. МОНГОЛ УЛСЫН МАКРО ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2024 -06- 03
БҮРТГЭВ-02

### МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

**Хүснэгт 28: Монгол Улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт | Нэгж | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023* |
|---|---|---|---|---|---|---|
| **Үндэсний тооцоо** | | | | | | |
| ДНБ, оны үнээр | Тэрбум төгрөг | 37,839.2 | 37,453.3 | 43,555.5 | 53,851.5 | 68,871.7 |
| ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр | Тэрбум төгрөг | 27,928.3 | 26,655.4 | 27,091.7 | 28,455.1 | 30,453.5 |
| ДНБ, жилийн бодит өсөлт | Хувь | 5.6 | -4.6 | 1.6 | 5.0 | 7.0 |
| Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр | Мянган төгрөг | 11,855.6 | 11,612.9 | 13,267.9 | 16,121.0 | 20,360.0 |
| **Улсын нэгдсэн төсөв** | | | | | | |
| Төсвийн орлого | Тэрбум төгрөг | 10,905.5 | 9,463.8 | 12,711.4 | 17,126.9 | 23,217.9 |
| Төсвийн зарлага | Тэрбум төгрөг | 11,661.7 | 13,904.3 | 15,630.4 | 18,159.7 | 22,454.5 |
| Төсвийн тэнцэл | Тэрбум төгрөг | (756.2) | (4,440.4) | (2,919.0) | (1,032.7) | 763.4 |
| Засгийн газрын нийт өр | Тэрбум төгрөг | 23,915.1 | 27,895.4 | 27,115.8 | 31,945.1 | 30,765.0 |
| **Гадаад худалдаа** | | | | | | |
| Эргэлт | Сая ам.доллар | 13,747.2 | 12,875.2 | 16,086.6 | 21,243.0 | 24,437.0 |
| Экспорт | Сая ам.доллар | 7,619.8 | 7,576.3 | 9,241.1 | 12,538.6 | 15,184.5 |
| Импорт | Сая ам.доллар | 6,127.4 | 5,298.9 | 6,845.5 | 8,704.4 | 9,252.5 |
| Тэнцэл | Сая ам.доллар | 1,492.3 | 2,277.4 | 2,395.7 | 3,834.2 | 5,932.0 |
| **Мөнгөний нийлүүлэлт** | | | | | | |
| Мөнгө М1 | Тэрбум төгрөг | 3,911.4 | 4,212.4 | 6,507.2 | 7,201.3 | 9,853.1 |
| Мөнгө М2 | Тэрбум төгрөг | 21,063.6 | 24,480.7 | 27,863.5 | 29,664.8 | 37,624.1 |
| **Хүүгийн түвшин** | | | | | | |
| Инфляцын түвшин /жилийн/ | Хувь | 5.2% | 2.3% | 13.8% | 13.2% | 7.9% |
| Бодлогын хүү | Хувь | 11.0% | 6.0% | 6.0% | 13.0% | 13.0% |
| Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү | Хувь | 11.0% | 5.6% | 6.2% | 13.0% | 13.1% |
| Хадгаламжийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /төгрөг/ | Хувь | 11.3% | 10.2% | 7.0% | 9.0% | 11.4% |
| Хадгаламжийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /валют/ | Хувь | 4.8% | 3.7% | 2.0% | 2.5% | 3.4% |
| Зээлийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /төгрөг/ | Хувь | 16.8% | 16.6% | 15.5% | 15.9% | 17.0% |
| Зээлийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /валют/ | Хувь | 10.3% | 10.3% | 9.1% | 10.9% | 11.5% |
| Ам.долларын ханш /хугацааны эцэс/ | Төгрөг | 2,734.3 | 2,849.9 | 2,849.3 | 3,444.6 | 3,410.7 |
| **Хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлого** | | | | | | |
| Монгол Улсын нийт хүн ам | Мянган хүн | 3,296.9 | 3,357.5 | 3,409.9 | 3,457.6 | 3,504.7 |
| Хөдөлмөр эрхлэлтийн түвшин | Хувь | 54.4 | 54.6 | 52.3 | 54.7 | 55.4 |
| Дундаж цалингийн хэмжээ /сарын/ | Мянган төгрөг | 1,124.3 | 1,220.6 | 1,279.4 | 1,503.8 | 2,235.4 |
| Өрхийн дундаж орлого /сарын/ | Мянган төгрөг | 1,343.4 | 1,508.8 | 1,621.5 | 1,856.1 | N/A |
| Өрхийн зарлага /сарын/ | Мянган төгрөг | 1,416.6 | 1,519.4 | 1,499.2 | 1,829.7 | N/A |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк*

**2023 оны сараар, өсөн нэмэгдсэн дүнгээр тооцсон тоон үзүүлэлт (2019-2022 оны жилээр тооцсон тоон үзүүлэлт)*

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

**Дотоодын нийт бүтээгдэхүүн**

БНХАУ Тэг Ковид бодлогоо цуцалсантай холбоотой Монгол Улсын нүүрсний гарц сайжирч, 2023 оны 4 дүгаар улирлын байдлаар нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 118.7 хувиар, үнийн дүнгээр 36.8 хувь нэмэгдсэнээр Монгол Улсын эдийн засгийн өсөлт сайжрах гол хүчин зүйл боллоо. Мөн тус хугацаанд нүүрсний экспортын эрчимжилтийг даган тээврийн салбарын өсөлт өмнөх оны мөн үеэс 55.7 хувиар нэмэгдсэн эдийн засгийн өсөлтийг эрэг гарахад багагүй нөлөөг үзүүлэв.

2023 оны 4 дугаар улирлын байдлаар үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон Монгол Улсын ДНБ 68.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 27.9 хувь буюу 15.0 их наяд төгрөгөөр өсжээ. ДНБ-ийг салбаруудын бүтцээр нь авч үзвэл 28.2 хувийг уул уурхай, олборлолтын салбар, 6.9 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 10.2 хувийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар, 9.7 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар, 9.7 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар, 5.7 хувийг тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, үлдсэн 29.5 хувийг бусад үйлдвэрлэл, үйлчилгээний салбар тус тус бүрдүүлж байна. Үнийн өсөлтийг арилгасан буюу 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон Монгол Улсын бодит ДНБ өмнөх оны мөн үеэс 7.0 хувь буюу 2.0 их наяд төгрөгөөр өсөж, 30.5 их наяд төгрөгт хүрчээ. Үнийн өсөлтийг арилгасан ДНБ-ийг салбаруудын бүтцээр авч үзвэл 12.5 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар, 12.7 хувийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар, 12.7 хувийг уул уурхай, олборлолтын салбар, 11.3 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар, 8.1 хувийг боловсруулах үйлдвэрлэл, үлдсэн 42.7 хувийг бусад үйлдвэрлэл, үйлчилгээний салбар тус тус бүрдүүлж байна.

**Зураг 16: ДНБ-ий өсөлтөд салбаруудын оролцооны түвшин, хувиар, 2023 он**




*Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*

Бодит ДНБ-ий өсөлтөд эдийн засгийн салбаруудын оролцооны түвшнийг авч үзвэл тус онд тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 39.3 хувиар өсөж, бодит ДНБ-ий өсөлтийн 1.8 нэгж хувийг, уул уурхайн салбар 23.4 хувиар өсөж, бодит ДНБ-ий өсөлтийн 2.6 нэгж хувийг, бүтээгдэхүүний цэвэр татвар 6.8 хувиар өсөж, бодит ДНБ-ий өсөлтийн 0.9 нэгж хувийг, бөөний болон жижиглэн худалдааны салбар 5.7 хувиар өсөж, бодит ДНБ-ий өсөлтийн 0.7 нэгж хувийг эзэлж байгаа бол хөдөө аж ахуйн салбар 8.9 хувиар буурч, бодит ДНБ-ий өсөлтийн -1.3 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

СЭХ
2024.07 сар 05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Хүснэгт 29: Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал**

| Байгууллага | Эдийн засгийн өсөлтийн таамаглал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2023F | 2024F | 2025F | 2026F | 2027F | 2028F |
| Дэлхийн банк | 5.8% | 6.2% | 6.4% | 6.1% | - | - |
| АХБ | 5.7% | 5.9% | - | - | - | - |
| ОУВС | 5.5% | 4.5% | 3.5% | 3.5% | 3.5% | 4.0% |
| Монголбанк | 6.9% | 6.2% | 5.3% | - | - | - |
| **Дундаж** | **6.0%** | **5.7%** | **5.1%** | **4.8%** | **3.5%** | **4.0%** |

*Эх сурвалж: Дэлхийн банк, "Дэлхийн эдийн засгийн тойм", 2023 оны 6 дугаар сар;*
*ОУВС, "Дэлхийн эдийн засгийн төлөв", 2023 оны 10 дугаар сар;*
*Азийн хөгжлийн банк, "Азийн хөгжлийн тойм", 2023 оны 9 дүгээр сар;*
*Монголбанк, Инфляцын тайлан, 2023 оны 12 дугээр сар.*

БНХАУ-ын эдийн засаг нээгдэж, түүний нөлөөгөөр экспорт сэргэж, урсгал дансны тэнцэл сайжирч, гадаад валютын албан нөөц тогтворжиж, Монгол Улсын 2023 онд төлөх "Гэрэгэ" бондын үлдэгдэл төлбөрийн асуудлыг "Century 2" төслийн хүрээнд 650 сая ам.доллар босгон санхүүжүүлж, улмаар гадаад өрийн эргэн төлөлтийн эрсдэлийг бууруулсан зэргээс шалтгаалж Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал энэ оны эхэн үеэс сайжирсан байна.

Монгол банк, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон Олон улсын валютын сан зэрэг томоохон байгууллагууд нь Монгол Улсын ирэх жилүүд дэх эдийн засгийн өсөлтийн таамаглалыг шинэчлэн гаргаад байна. Азийн Хөгжлийн Банкны үзэж байгаагаар Монгол Улсын эдийн засгийн сэргэлт энэ онд үргэлжилж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт ойрын хугацаанд хадгалагдахаар байгаа бөгөөд Монгол Улсын уул уурхайн салбарын өсөлт, түүнийг дагасан тээвэр ба агуулахын үйл ажиллагаа болон үйлчилгээний бусад үйл ажиллагаанд үзүүлэх эерэг нөлөөлөл зэрэгт үндэслэн 2023 онд Монгол Улсын эдийн засаг 5.7 хувиар, 2024 онд 5.9 хувиар тус тус өснө хэмээн таамаглажээ. Тус төсөөлөлд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг гадаад эрэлт, экспортын сэргэлт, дотоод эрэлт дэмжихээр байгаа хэдий ч, өндөр инфляц, түүний эсрэг мөнгөний хатуу бодлого, дотоод санхүүжилтийн нөхцөл чангарсан зэрэг нь хязгаарлаж байна.

Мөн Монгол Улсын нүүрсний экспортын дэд бүтцийн асуудал болох Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг бүрэн шийдвэрлэсэн, мөн Оюутолгойн гүний уурхай ашиглалтад орсон зэрэг нь цаашдаа нүүрс болон зэсийн экспортыг нэмэгдүүлэх чухал хөшүүрэг болж экспортыг улам нэмэгдүүлэх хүлээлтийг үүсгэж байна. Түүнчлэн ОХУ болон БНХАУ-ыг холбосон хийн хоолойн бүтээн байгуулалт Монгол Улсад 2024 онд эхлэхээр хүлээгдэж байгаа нь Монгол Улсын эдийн засгийн зарим салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, эдийн засгийн өсөлтөд эерэг үр дүнг авчрахаар байна.

### Инфляцын түвшин

2023 оны 2 дугаар улиралд Монгол Улсын хэмжээнд инфляцын түвшин аажмаар буурч, тус хандлага 2023 оны 3 дугаар улиралд үргэлжилсэн бөгөөд Монголбанкны зүгээс инфляцын хүлээлтийг харьцангуй тогтвортой байгаа болохыг мэдэгдлээ. Мөн түүнчлэн Монголбанкны зүгээс инфляцыг 2023-2024 онд жилийн 6 хувь орчимд, +/-2 хувийн интервалд тогтворжуулахыг зорьж байгаа бөгөөд инфляцын төсөөлөл өмнөх тайлантай харьцуулахад ялимгүй нэмэгдэж, зорилтот түвшин рүү буурах хурд нь эдийн засгийн идэвхжил, төсвийн зардал, тэр дундаа төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлсэнтэй холбоотой бага зэрэг удаашраад байгаа юм.

Монгол Улсын инфляцын түвшин 2023 оны сүүлийн байдлаар улсын хэмжээнд зорилтот түвшнээс давсан буюу 7.9 хувьд хүрч, өмнөх сараас 0.7 нэгж хувиар, оны эхэн үеэс 4.4 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн тус хугацаанд хэрэглээний үнийн ерөнхий индекс оны эхэн үеийнхээс 7.4 хувиар буюу 9.6 нэгжээр өсөж 139.5-тэй тэнцэж байгаа бөгөөд 7.4 хувийн өсөлтийн 2.7 нэгж хувийг хүнсний бараа, согтууруулах бус ундааны үнийн өсөлт, үлдсэн 4.7 нэгж хувийг бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл инфляцын түвшин 7.9 хувьд хүрэхэд тус онд хүнсний бараа бүтээгдэхүүний өсөлт ихээхэн нөлөөлсөн байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЭХ 2024.07.05 сар өдөр
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02

- Монгол Улсын инфляцын түвшнийг олон улсын санхүүгийн байгууллагууд болон Монголбанкны зүгээс ирэх жилүүдэд дараах түвшинд хүрнэ хэмээн таамаглажээ.

**Хүснэгт 30: Монгол Улсын инфляцын таамаглал**

| Байгууллага | Инфляцын таамаглал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2023F | 2024F | 2025F | 2026F | 2027F | 2028F |
| Дэлхийн банк | - | - | - | - | - | - |
| АХБ | 10.5% | 8.6% | - | - | - | - |
| ОУВС | 12.3% | 12.2% | 12.0% | 10.5% | 8.9% | 7.0% |
| Монголбанк | 9.2% | 8.7% | 7.7% | - | - | - |
| **Дундаж** | **10.7%** | **9.8%** | **9.9%** | **10.5%** | **8.9%** | **7.0%** |

*Эх сурвалж: ОУВС, "Дэлхийн эдийн засгийн төлөв", 2023 оны 10 дугаар сар; Азийн хөгжлийн банк, "Азийн хөгжлийн тойм", 2023 оны 9 дүгээр сар; Монголбанк, Инфляцын тайлан, 2023 оны 9 дүгээр сар.*

### Бодлогын хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрийн хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж 13.0 хувьд хүргэх шийдвэрийг гаргасан. Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн асуудлаас шалтгаалсан нийлүүлэлтийн хомсдол, үүнийг дагасан инфляцын түвшний өсөлтийг бууруулах зорилгоор Монголбанк мөнгөний хатуу бодлогыг баримталж, бодлогын хүүгийн түвшнийг өсгөсөн хэдий ч инфляцын түвшин буурах хурд төсөөлж буйгаас удаан байсантай холбогдуулан бодлогын хүүгийн түвшнийг 2023 оны турш өөрчлөөгүй байна.

**Зураг 17: Монгол Улсын бодлогын хүүгийн түвшин**




*Эх сурвалж: Монголбанк, "Статистикийн бюллетень", 2024 оны 01 дүгээр сар*

Монгол Улсын мөнгөний бодлогын цаашдын төлөв нь гадаад, дотоод эдийн засгийн орчинд инфляцын төлөв хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарч бодлогын дараагийн алхмуудыг авч хэрэгжүүлэх болохыг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос мэдэгдээд байна.

### Хүүгийн түвшин

2023 оны турш Монголбанкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 13.0 хувьд хэвээр барьсан. Үүнтэй холбогдуулан дийлэнх арилжааны банкнуудын энгийн хугацаатай хадгаламжийн хүүгийн түвшин оны эхэн үеэс хойш өөрчлөгдөөгүй бөгөөд 12 дугаар сарын байдлаар үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкнуудын энгийн хугацаатай хадгаламжийн зарласан хүүгийн түвшин хугацаанаас хамааран 5.8-14.6 хувьтай байна. Мөн 2023 оны турш банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү тогтвортой буюу 13.0 хувь, банкнуудын тухайн сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2023 оны байдлаар 16.0-16.8 хувийн хооронд тогтвортой байсан үзүүлэлттэй байна.

TDB SECURITIES
ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.07.05 он сар өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Зураг 18: Дотоодын зах зээл дэх хүүгийн түвшний харьцуулалт**




*Эх сурвалж: Монголбанк, "Статистикийн бюллетень", 2024 оны 1 дүгээр сар*
*Тухайн сард шинээр татсан харилцах, хадгаламж болон тухайн сард олгосон зээл*

2023 онд биржээр дамжин нээлттэй хүрээнд гарсан компанийн бондуудын хүүгийн түвшин хугацаанаас хамааран дунджаар 18.0-19.2 хувьтай байгаа бол хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн түвшин 14.5%-19.6 хувьтай байгаагаас үзэхэд үнэт цаасны зах зээл дээр гарч буй бүтээгдэхүүнүүдийн хүүгийн түвшин инфляцын түвшнээс өндөр буюу хөрөнгө оруулагчдын мөнгөний үнэ цэнийг хадгалж чадахуйц байна.

### Мөнгөний нийлүүлэлт

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын мөнгөний нийлүүлэлт (М2) 37.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 8.0 их наяд төгрөг буюу 26.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү 26.8 хувийн өсөлтийн 17.9 нэгж хувийг бусад хадгаламж болох валютын харилцах, хадгаламж болон төгрөгийн хадгаламжийн өсөлт бүрдүүлж байгаа бол 8.9 нэгж хувийг бага мөнгө (М1) болох хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцахын өсөлт бүрдүүлж байна. Мөн бүтцийн хувьд М1 мөнгө 9.9 их наяд төгрөгт хүрч, нийт мөнгөний нийлүүлэлтийн 33.3 хувьтай, бусад хадгаламж 27.8 их наяд төгрөгт хүрч, нийт мөнгөний нийлүүлэлтийн 66.7 хувьтай тус тус тэнцэж байна.

**Зураг 19: Монгол Улсын мөнгөний нийлүүлэлт, 2023 он**




*Эх сурвалж: Монголбанк, "Статистикийн бюллетень", 2023 оны 9 дүгээр сар*

Түүнчлэн 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар валютын хадгаламжийн үлдэгдлийн дүн өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар, валютын харилцахын үлдэгдлийн дүн 14.2 хувиар тус тус өссөн байна. Харин төгрөгийн харилцах тус онд өмнөх оны мөн үеэс 40.5 хувиар өссөн бол хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 8.9 хувиар өсөж, М1 мөнгөний хэмжээг 9.9 их наяд хүрэхэд нөлөөлсөн байна.



### Валютын ханш

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
ТЖТБ ХХК
УЛААНБААТАР

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2020 оны 8 дугаар сараас 2022 оны 2 дугаар сар хүртэл 2,848.0-2,850.0 төгрөгийн хооронд тогтвортой байсан бол 2022 оны 3 дугаар сараас 10 дугаар сарын хооронд төгрөгийн ам.доллартой харьцах албан ханш хурдацтай суларч 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 3420.1 төгрөгтэй тэнцсэн үзүүлэлттэй байна. Ийнхүү суларч байсан төгрөгийн ханш 2023 оны 3 дугаар сараас 6 дугаар сарын хооронд чангарч, үүнээс хойш 3,410.7-3,472.8 төгрөгийн хооронд тогтвортой байна.

**Зураг 20: Монгол Улсын гадаад валютын албан нөөц (ГВАН) болон төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн харьцуулалт, 2014-2023 он**




*Эх сурвалж: Монголбанк*

Валютын ханшийг тогтмол барих зорилгоор Төв банкнаас интервенц буюу ам.доллар худалдах, зах зээлд нийлүүлэх замаар ханшийг тогтворжуулах ажиллагаа хийгддэг. 2022 онд Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2019-2022 онд жилд дунджаар 7.9 хувиар буурч, 2022 оны байдлаар тус хугацаан дахь хамгийн доод түвшин буюу 3.4 тэрбум ам.долларт хүрчээ. Харин 2022 оны 9 дүгээр сараас хилийн хязгаарлалт суларч, экспорт нэмэгдэж олон улсын зах зээлээс валют татах боломжууд нэмэгдсэнтэй холбогдон 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар ГВАН өмнөх оны мөн үеэс 48.8 хувиар өссөн байна.

## Төсвийн тэнцэл

2022 оны 4 дүгээр улиралд 1,032.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан Монгол Улсын төсвийн тэнцэл 2023 оны 4 дугаар улирлын байдлаар 763.4 тэрбумын ашигтай байна. Тус хугацаанд Монгол Улсын төсвийн нийт орлого 23.2 их наяд төгрөг, төсвийн нийт зарлага 22.5 их наяд төгрөг тус тус хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан сүүлийн 4 жилд байгаагүй үзүүлэлт юм. Уул уурхайн экспортын таатай нөхцөл байдал, түүнийг дагасан эдийн засгийн идэвхжил Монгол Улсын төсвийн орлогыг нэмэгдүүлж байна. Тухайлбал 2023 оны 4 дүгээр улиралд аж ахуй нэгжийн орлогын албан татвар өмнөх оноос 59.1 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 20.4 хувиар, гадаад худалдааны орлого 16.6 хувиар, бусад татвар, төлбөр, хураамж 82.1 хувиар тус тус өссөн байна. Үүнтэй холбоотойгоор 2022 оны IV улиралтай харьцуулахад татварын орлого 38.8 хувиар өсөж, гадаад худалдааны орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор татварын бус орлого 29.5 хувиар өссөн дүнтэй байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



УЛААНБААТАР ХОТ

**Зураг 21: Монгол Улсын төсвийн орлого, зарлага, их наяд төгрөгөөр, 2013-2023 он**




*Эх сурвалж: Монгол Улсын Сангийн Яам*

**2023 оны сараар тооцсон тоон үзүүлэлт (2013-2022 оны жилээр тооцсон тоон үзүүлэлт)*

Монгол Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оны мөн үеэс 35.6 хувиар өсөж, 23.2 их наяд төгрөгт хүрсэн ба бүтцийн хувьд авч үзвэл 92.4 хувь буюу 21.5 их наяд төгрөгийг татварын орлого, 7.6 хувь буюу 1.8 их наяд төгрөгийг татварын бус орлого тус тус бүрдүүлж байна.

Монгол Улсын төсвийн зарлагын тухайд өмнөх оны мөн үеэс 23.7 хувиар нэмэгдэж, 22.5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд бүтцийн хувьдавч үзвэл урсгал зардлын хэмжээ 75.9 хувь буюу 17.0 их наяд төгрөгийг, хөрөнгийн зардлын хэмжээ 23.0 хувь буюу 5.2 их наяд төгрөгийг, цэвэр зээл 1.0 хувь буюу 0.2 их наяд төгрөгийг тус тус бүрдүүлж байна. Мөн 2023 оны 4 дугаар улирлын байдлаар Засгийн газрын урсгал зардал 19.8 хувиар буюу 2.8 их наяд төгрөгөөр, хөрөнгийн зардал 36.1 хувиар буюу 1.4 их наяд төгрөгөөр, цэвэр зээлийн хэмжээ 83.5 хувиар буюу 0.1 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

## Засгийн газрын өр төлбөр

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын Засгийн газрын нийт өрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.7 хувь буюу 1.2 их наяд төгрөгөөр багасаж, 30.8 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэхүү бууралтад Засгийн газрын дотоод өрийн хэмжээ, үүнээс Засгийн газрын өрийн баталгааны хэмжээний 96.0 хувийн буюу 747.8 тэрбум төгрөгийн бууралт, Засгийн газрын дотоод өрийн хэмжээ 77.4 хувь буюу 801.4 тэрбум төгрөгийн бууралт голлон нөлөөлсөн байна.

Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 3.7 хувь буюу 1.2 тэрбум ам.доллароор өсөж 34.6 тэрбум ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна. Бүтцийн хувьд авч үзвэл нийт гадаад өрийн 42.9 хувь буюу 14.8 тэрбум ам.долларыг компани хоорондын зээллэг, 24.0 хувь буюу 8.3 тэрбум ам.долларыг бусад салбаруудын гадаад өр, 22.9 хувь буюу 7.9 тэрбум ам.долларыг Засгийн газрын гадаад өр, үлдсэн 10.2 хувь буюу 3.5 тэрбум ам.долларыг Төв банк болон хадгаламжийн байгууллагын гадаад өр тус тус бүрдүүлж байна. Монгол Улсын нийт гадаад өрийн 3.7 хувийн өсөлтөд компани хоорондын зээллэг өмнө жилийн мөн үеэс 12.4 хувь буюу 1.6 тэрбум ам.доллароор өссөн нь голлон нөлөөлсөн байна. Түүнчлэн Монгол Улс 2023 оны 1 дүгээр сард "Century-2" бондыг гаргаж 650.0 сая ам.доллар татан төвлөрүүлснээр 2023 оны 5 дугаар сард "Гэрэгэ" бондын үлдэгдлийг төлж дууссан ба 2024 онд "Хуралдай" бондыг эргэн төлөх хуваарьтай байна.

## Гадаад худалдаа

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар гадаад худалдааны эргэлт өмнөх оны мөн үеэс 3.1 тэрбум ам.доллароор өсөж, 24.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Тус хугацаанд Монгол Улсын экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 21.1 хувиар буюу 2.6 тэрбум ам.доллароор өсөж, 15.2 тэрбум ам.долларт хүрсэн бол импортын хэмжээ 6.3 хувиар буюу 0.5 тэрбум ам.доллароор өсөж, 9.3 тэрбум ам.доллартой



СЗХ 2024.07.05 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES

СЗХ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -06- 0 3

тус тус тэнцэж байна. Тайлант хугацаанд худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 2.1 тэрбум ам.доллароор өсөж, 5.9 тэрбум ам долларын ашигтай гарчээ.

**Зураг 22: Монгол Улсын экспорт, импорт ба гадаад худалдааны тэнцэл, их наяд төгрөгөөр, 2014-2023 он**




*Эх сурвалж : Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*

**2023 оны сараар тооцсон тоон үзүүлэлт (2014-2022 оны жилээр тооцсон тоон үзүүлэлт)*

Мөн тус хугацаанд Монгол Улсын экспортын хэмжээ 21.1 хувийн өсөлтийг үзүүлж, 15.2 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд тайлант улирлын нийт экспортын үнийн дүнгийн 86.6 хувь буюу 13.1 тэрбум ам.долларыг эрдэс бүтээгдэхүүний экспорт бүрдүүлж байна. Тоо хэмжээний хувьд их хэмжээгээр экспортолсон голлох нэрийн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл тус улирлын байдлаар адууны махны экспорт өмнөх оны мөн үеэс 375.5 хувиар өсөж 32.9 тонн, малын дайвар бүтээгдэхүүний экспорт 300.4 хувиар өсөж 1,001.1 тонн, жоншны хүдэр ба баяжмалын экспорт нь 180.6 хувиар өсөж 1,087.8 мянган тонн, нүүрсний экспорт 118.7 хувиар өсөж 69.6 сая тонн хүрчээ. Харин хар төмрийн хаягдал 75.0 хувиар буурж 44.0 тонн, боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспорт 40.3 хувиар буурч, тус онд 11.7 тонн экспортолсон байна.

**Зураг 23: Экспорт, импорт бүтээгдэхүүний төрлөөр нийт экспорт, импортод эзлэх хувь, 2023 он**




*Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын дүн 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар буурж, 3.1 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд тус үзүүлэлт нь Монгол Улсын ДНБ-ий 15.3 хувьтай тэнцжээ. Тус хугацаанд бөөний болон жижиглэн худалдаа, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа болон цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын хөрөнгө оруулалт нэмэгдсэн бол удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа ба үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын хөрөнгө оруулалт буурсан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Зураг 24: Монгол Улсын ГШХО-ын орох урсгал, ДНБ-д эзлэх хувь**




*Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*

**Зураг 25: Монгол Улсын ГШХО-ын орох урсгал, салбаруудын бүтцээр**




*Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*

Монгол Улсын уул уурхайн салбар нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хамгийн их татдаг салбар бөгөөд 2019-2022 онуудын хооронд нийт хөрөнгө оруулалтын 66-82 хувийг тус салбарын хөрөнгө оруулалт дангаар бүрдүүлсэн байна. 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар буурсан ч, 2.4 тэрбум ам долларт хүрж, нийт хөрөнгө оруулалтын 79.2 хувийг бүрдүүлсэн байгаагаас үзэхэд уул уурхайн салбарын цаашдын төлөв эерэг байгаа нь Монгол Улсад гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг нэмэгдүүлэх хүлээлттэй байна.

2023 онд Оюу Толгой ХХК-ийн уурхайн нийт баялгийн 80 хувийг бүрдүүлдэг гүний уурхайн олборлолт эхлэх хүлээлттэй холбоотой 2022 оны 4 дүгээр улиралд уул уурхайн салбарын ГШХО 1.6 тэрбум ам.долларт хүрч, тус салбарын 2022 оны нийт ГШХО-ын хэмжээг 2.8 тэрбум ам.долларт хүргэсэн үзүүлэлттэй байна.

Уг үйл ажиллагаанаас үүдэж Copper Mining Analysis байгууллагын үзэж байгаагаар “Оюу Толгой” ХХК-ийн зэсийн олборлолт 2027 онд 416 мянган тонн, 2028 онд 500 мянган тоннд хүрч, 2030 онд дэлхийд дөрөвт эрэмбэлэгдэх зэсийн уурхай болох тооцоололтой байна.

СЭХ 2024.07.05 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

**Зураг 26: Дэлхийн томоохон уул уурхайн компаниудын зэсийн олборлолт, 2022 он, 2027 оны төсөөлөл**




*Эх сурвалж: Copper Mining Analysis*

Иймд Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал нь уул уурхайн салбарт орж буй хөрөнгө оруулалтаас ихээхэн хамаардаг бөгөөд сүүлийн 10 жилийн байдлаар ГШХО-ын дүн ДНБ-ий 18-28 хувийг бүрдүүлж байгаагаас үзэхэд "Оюу Толгой" ХХК-ийн гүний уурхайн олборлолт нь ирээдүйн эдийн засгийн төлөвт эерэг өөрчлөлтийг авчрах төлөвтэй байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES

СЭХ
2024.07.05
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

### 2.4.4. МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

#### Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл

Хог хаягдал боловсруулах үйлдвэрлэлийн зах зээл нь Сангийн сайд болон Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг шинэчлэн батлах тухай" хамтарсан тушаалын дагуу ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарт ордог. Монгол Улсын Статистикийн мэдээллийн сангаас бэлтгэн гаргасан тоон судалгаагаар 2023 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ нь Монгол Улсын нийт ДНБ-ын 0.4 хувийг бүрдүүлжээ. 2019-2023 оны хооронд нийт ДНБ-д эзлэх хувь нь тогтмол 0.4-0.6 хувийн хооронд байсан нь салбарын нэмэгдэл өртөг цэвэр дүнгээрээ буюу 2015 онтой зэрэгцүүлсэн дүнгээр жилд дунджаар 1.9 хувийн өсөлт үзүүлсэн хэдий ч нийт ДНБ цэвэр дүнгээрээ 2.2 хувиар өссөн дүнтэй харьцуулахад бага байгаатай холбоотой.

**Зураг 27: Үнэт цаас гаргагчийн салбарын орлого, тэрбум төгрөг, нийт ДНБ-д эзлэх хувь, 2019-2023 он**




*Эх сурвалж : Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*

#### Монгол Улсад үүсэж буй нийт хог хаягдал

Монгол Улсад үүсэж буй нийт хог хаягдлыг энгийн, аюултай, дахин боловсруулах болон хатуу хог хаягдлын импорт гэсэн 4 төрөлд хуваадаг. 2018-2022 оны хооронд Монгол Улсын нийт хог хаягдлын хэмжээ жилд дунджаар 0.8 хувиар буурч, 2022 онд 2,867.3 мянган тоннд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар өссөн дүн юм. Үүнээс 2,496.5 мянган тонн буюу 87.1 хувийг энгийн хог хаягдал, 285.9 мянган тонн буюу 10.0 хувийг аюултай хог хаягдал, 82.0 мянган тонн буюу 2.9 хувийг дахин боловсруулах, дахин ашиглах, сэргээн ашиглах хог хаягдал үлдсэн 2.9 мянган тонн буюу 0.1 хувийг хатуу хог хаягдлын импорт эзэлж байна. Сүүлийн 5 жилийн дунджаар авч үзвэл нийт хог хаягдлын 82.3 хувийг энгийн хог хаягдал, 10.5 хувийг аюултай хог хаягдал, 7.1 хувийг дахин боловсруулах хог хаягдал, 0.1 хувийг хатуу хог хаягдлын импорт эзэлж байжээ.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
9021110883
5251494
TDB SECURITIES



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
5147204 ХАК0303
УЛААНБААТАР ХОТ

2024.07.05 он сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ

**Зураг 28 : Нийт хог хаягдлын хэмжээ, мянган тонн, төрлөөр, 2018-2022 он**




*Эх сурвалж : Байгаль орчны статистикийн мэдээллийн сан, Үндэсний статистикийн хороо*

Аж ахуйн болон байгууллагын нийт хог хаягдлын хэмжээг эдийн засгийн салбараар эзлэх хувийг 2018-2022 оны дунджаар авч үзвэл цахилгаан, дулаан, усан хангамжийн салбар хамгийн их буюу 22.3 хувь, барилгын салбар 14.4 хувь, боловсруулах үйлдвэрлэл 13.1 хувь, уул уурхайн салбар 11.6 хувь, эрүүл мэндийн салбар 8.1 хувь, үлдсэн 30.6 хувийг бусад салбарууд тус тус бүрдүүлж байна. Эдийн засгийн салбаруудын ялгаруулах хог хаягдлын хэмжээг 2018-2022 оны дундаж үзүүлэлтээр нь авч үзвэл цахилгаан, дулаан, усан хангамжийн салбар 8.3 хувийн өсөлттэй байсан бол бусад салбарууд 0.4-9.0 хувийн бууралттай байгаагаас харвал Монгол Улсын нийт хог хаягдлын хэмжээ буурч байна.

**Зураг 29: Хог хаягдлын хэмжээ, салбараар, мянган тонн, 2018-2022 он**




*Эх сурвалж : Байгаль орчны статистикийн мэдээллийн сан*

## Аюултай хог хаягдал

Базелийн конвенцод тодорхойлсны дагуу хүн, амьтны эрүүл мэнд, үр удамд сөргөөр нөлөөлж, тэдгээрт өвчин эмгэг үүсгэдэг буюу байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулдаг шинж чанар бүхий хог хаягдлыг аюултай хог хаягдал гэж үздэг.

Тэсрэмтгий, шатамхай шингэн буюу хатуу, өөрөө шатдаг, цацраг идэвхт, хорс, агаар, устай харилцан үйлчилснээс хортой, эсвэл галын аюултай хий ялгаруулдаг, исэлдүүлэгч, идэмхий, органик хэт ислийн хаягдлууд нь энэ төрлийн хог хаягдалд хамаарна. 2018-2022 онд нийт аюултай хог хаягдлын хэмжээ жилд дунджаар 0.4 хувийн өсөлттэй байсан бөгөөд улсын нийт хог хаягдлын 7.9-15.4 хувийг бүрдүүлж байжээ.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



ТЖТБ ХХК

2023 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд үүссэн нийт аюултай хог хаягдлын 74.7 хувийг эцсийн боловсруулалтад оруулсан байна. Үүнээс ландфиллд 502.4 мянган тонн буюу 46.1 хувийг булшилж, 22.7 хувийг халдваргүйжүүлэн 5.4 хувийг шатаах болон биологийн аргаар устгасан бол 1.0 хүрэхгүй хувийг химийн болон физикийн аргаар боловсруулжээ.

**Зураг 30: Монгол Улсын нийт аюултай хог, хаягдлын хэмжээ, мянган тонн, 2018-2022 он**




*Эх сурвалж : Үндэсний статистиктийн хороо*

**Зураг 31: Аюултай хог хаягдлыг боловсруулсан байдал, 2023 он**




*Эх сурвалж : Байгаль орчны статистикийн мэдээллийн сан*

Хог хаягдлын эх үүсвэрээр авч үзвэл эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, цахилгаан станц, дулааны үйлдвэрлэл, уул уурхайн салбарууд аюултай хог хаягдлын ихэнх хувийг ялгаруулж байна. 2020 онд дэлхий даяар тохиосон цар тахлын хүрээнд Монгол Улсаас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хүрээнд эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал өмнө жилээс 7.7 дахин буюу 238.7 мянган тонноор өссөн бол мөн цар тахлаас шалтгаалан экспортын хяналт чангарч, уул уурхайн салбарын аюултай хог хаягдал 38.3 хувиар буурчээ.

**Зураг 32: Аюултай хог хаягдлын эх үүсвэрийн төрөл, эзлэх хувиар, 2018-2022 он**




*Эх сурвалж : Үндэсний статистикийн хороо*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02
СЭХ
TDB SECURITIES

СЗХ 2024.07.05 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

## Энгийн хог хаягдал

Энгийн хог хаягдал гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ.

**Зураг 33: Монгол Улсын нийт энгийн хог хаягдлын хэмжээ, эх үүсвэрээр, 2022 он**




**Зураг 34: Хуванцар бүтээгдэхүүний нийт энгийн хог хаягдалд эзлэх хувь, 2018-2022 он**




*Эх сурвалж : Байгаль орчны статистикийн мэдээллийн сан*

2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хэмжээнд цуглуулж тээвэрлэсэн энгийн хатуу хог хаягдлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 94.0 мянган тонн буюу 3.9 хувиар өсөж, 2,496.5 мянган тоннд хүрсэн үзүүлэлттэй байна. Үүний 916.2 мянган тонн буюу 36.7 хувийг аж ахуй нэгж байгууллага болон нийтийн эзэмшлийн зам талбайгаас цуглуулсан хог хаягдал байгаа бол өрхөөс гарах энгийн хог хаягдлын хэмжээ 1580.3 мянган тоннд хүрч, нийт энгийн хог хаягдлын 63.3 хувийг бүрдүүлж байна. 2018-2022 онд нийт энгийн хог хаягдлын хэмжээ нь жилд дунджаар 0.6 хувийн өсөлтийг үзүүлсэн буюу харьцангуй өөрчлөлт багатай байжээ.

Үүнээс өрхийн хог хаягдалд хүнсний бүтээгдэхүүний болон хуванцар бүтээгдэхүүний хог хаягдал давамгайлдаг бол аж ахуйн нэгж байгууллагын хувьд барилгын, цаас, цаасан бүтээгдэхүүний болон автомашины хог хаягдал ихэнх хувийг эзэлдэг. 2020 онд тохиосон цар тахлын улмаас өрхийн хэрэглээ хумигдан, үүнийг дагаад гарах хог хаягдлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 227.5 мянган тонн буюу 14.1 хувиар багассан бөгөөд үүнээс хойш жилд дунджаар 6.8 хувиар өссөн байна.

Нийт цуглуулсан энгийн хог хаягдлыг бүтцийн хувьд авч үзвэл 322.5 мянган тонн буюу 12.3 хувийг хүнсний бүтээгдэхүүний хог хаягдал, 199.1 мянган тонн буюу 8.0 хувийг шил, шилэн бүтээгдэхүүний хог хаягдал бүрдүүлж байсан бол 192.7 мянган тонн буюу нийт энгийн хог хаягдлын 7.7 хувийг хуванцар бүтээгдэхүүний хог хаягдал тус тус бүрдүүлж байна.

**Хүснэгт 31: Нийт энгийн хог хаягдал, төрлөөр, мянган тонн, 2018-2022 он**

| Энгийн хог хаягдлын төрөл | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| Цаасан бүтээгдэхүүний хаягдал | 191.2 | 205.1 | 176.2 | 186.0 | 159.1 |
| Шилэн бүтээгдэхүүний хаягдал | 213.3 | 228.8 | 196.5 | 211.2 | 199.1 |
| Хаягдал төмөр | 45.9 | 49.3 | 42.3 | 44.4 | 60.9 |
| Хуванцар бүтээгдэхүүний хаягдал | 185.3 | 198.7 | 170.7 | 183.4 | 192.7 |
| Барилгын хог хаягдал | 75.9 | 81.4 | 69.9 | 71.7 | 101.2 |
| Хүнсний бүтээгдэхүүний хаягдал | 315.2 | 338.1 | 290.4 | 313.7 | 322.5 |
| Цахилгаан барааны хаягдал | 30.4 | 32.6 | 28.0 | 28.9 | 35.4 |
| Автомашины эд анги | 27.4 | 29.4 | 25.2 | 25.9 | 70.4 |

TDB SECURITIES

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Бусад хог хаягдал | 1,351.3 | 1,449.3 | 1,244.8 | 1,337.2 | 1,355.3 |
| **Нийт энгийн хог хаягдал** | **2,435.8** | **2,612.6** | **2,244.0** | **2,402.5** | **2,496.5** |

*Эх сурвалж : Үндэсний статистикийн хороо*

**Хатуу хог хаягдлын импорт**

**Зураг 35: Монгол улсын хатуу хог хаягдлын импорт, мянган тонн 2018-2022 он**




2018-2022 онд Монгол Улс 1.4-2.9 тонн хог хаягдлыг импортолсон нь нийт хог хаягдлын 0.0-0.1 хувийг бүрдүүлж байна. 2000 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Монгол Улсын нутаг дэвсгэрийг аюултай хог хаягдлаас хамгаалах зорилгоор баталсан "Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох" тухай хуулийн дагуу энэ төрлийн хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор импортлохыг хориглосон.

Иймээс энэ хугацаанд зөвхөн хуванцар бүтээгдэхүүн болон бусад энгийн хог хаягдлыг импортолсон байна. 2022 оны байдлаар өмнөх оноос 54.6 хувиар их буюу 2.9 мянган тонн хог хаягдал импортолсны 0.4 мянган тонн нь хуванцар бүтээгдэхүүний хаягдал байгаа бол үлдсэн 2.5 мянган тонн нь бусад төрлийн хог хаягдал байжээ. Импортын хог хаягдлын хэмжээ нь 2018-2022 онд жилд дунджаар 20.7 хувиар ихсэж байгаа бол үүнээс хуванцар бүтээгдэхүүний импорт нь дунджаар 63.0 хувиар өсөж байгаа дүнтэй байна.

**Дахин боловсруулах, дахин ашиглах, сэргээн ашиглах хог хаягдал**

Хог хаягдлыг дахин боловсруулах гэдэг нь хог хаягдлыг задалж, шинэ бүтээгдэхүүн хийх түүхий эд гаргаж авахыг хэлдэг бол дахин ашиглах гэж хог хаягдлыг анхны зориулалтаар эргэж хэрэглээнд оруулахыг хэлнэ.

Монгол Улсын хувьд 2018-2022 онд нийт хог хаягдлын харьцангуй бага буюу 2.6-9.2 хувийг дахин боловсруулж, дахин болон сэргээн ашиглах боломжтой хог хаягдал эзэлж байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд нийт дахин боловсруулж, ашиглах зорилгоор цуглуулсан хог хаягдлын хэмжээ жилд дунджаар 25.3 хувиар буурж, 2022 онд 73.4 мянган тонн хүрсэн нь нийт хог хаягдлын 2.6 хувийг бүрдүүлж байна. Үүнээс цаас, цаасан бүтээгдэхүүний хэмжээ хамгийн их буюу дунджаар 57.7 хувь, шил, шилэн бүтээгдэхүүн 44.7 хувь, хуванцрын хаягдал 39.7 хувь, хаягдал төмөр 39.0 хувиар буурсан бол харин автомашины эд анги 3.7 хувь, бусад хог хаягдал 1.3 хувиар өссөн дүнтэй байна.

Монгол Улсад хог хаягдлыг цуглуулан ялгах, тээвэрлэх хууль эрхзүйн орчин бүрдсэн ч хэрэгжилт хангалтгүй, ангилсан хогийг авдаг сүлжээ тогтворжоогүйгээс үүдэн нийт хог хаягдлын багахан хэсгийг л дахин боловсруулах боломжтой болж байна. Тухайлбал 2022 онд дахин боловсруулах хуванцрын хэмжээ өмнөх оны мөн үеэс 93.2 хувиар буурсан байгаа нь энэ салбарт онцгой анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

**Зураг 36: Дахин боловсруулж, дахин болон сэргээн ашигласан хог хаягдлын (ДБДБСАХХ) хэмжээ, мянган тонн, 2018-2022 он**




*Эх сурвалж : Үндэсний статистикийн хороо*

**Монгол Улсад үүсэж буй хог хаягдлын дахин боловсруулалт**

Монгол орон даяар 2022 оны байдлаар нийт 3,811.6 га газрыг эзэлсэн 396 хог хаягдлын төвлөрсөн цэг байгаа бөгөөд эдгээр нь хог хаягдлыг устгах, булшлах эсвэл сэргээн болон дахин ашиглах, дахин боловсруулах зорилгоор цуглуулж, төвлөрүүлэн хадгалдаг. Цуглуулсан хог хаягдлыг ангилж ялгасны дараа бүтээгдэхүүний төрөл болон бохирдлоос нь шалтгаалж эцсийн боловсруулалтад оруулах эсвэл дахин боловсруулан шинэ бүтээгдэхүүн хийх, дахин ашиглах, сэргээн ашиглах үйл явц эхэлнэ. Манай улс 2019-2022 оны дүнгээр нийт хог хаягдлын 7.6-8.3 хувийг дахин боловсруулж байгаа нь дэлхий даяар хог хаягдлын менежмент тулгарсан асуудал болоод байгаа өнөө үед хангалтгүй үзүүлэлт юм.

**Зураг 37: Хатуу хог хаягдлын нийт ашиглалт, мянган тонн, ашиглалтын төрлөөр, 2018-2022 он**




*Эх сурвалж : Үндэсний статистикийн хороо*

Хог хаягдлын эцсийн боловсруулалтын аргууд:

- Төвлөрсөн цэгт булшлах - Хог хаягдлыг бүртгэж, хүлээж авсны дараа цаашид тархахаас сэргийлэн хөрсөөр дарж, нягтруулах үйл явц. Төвлөрсөн цэгт аюултай, халдвартай болон шингэн хаягдал, шингэн агуулсан хаягдлыг булшлахыг хориглодог.
- Шатааж устгах – Тусгай зориулалтын байгууламжид хог хаягдлыг тохирох горим, технологийн дагуу шатаан устгах
- Экспортлох – Хог хаягдлыг устгах, боловсруулах техник, тоног төхөөрөмж байхгүй үед хог хаягдал импортлохыг зөвшөөрсөн улсад хог хаягдлыг экспортлох

Монгол Улс 2018-2022 оны дунджаар нийт хог хаягдлын 92.0 орчим хувийг устгаж байжээ. 2022 онд нийт 2,858.7 мянган тонн хог хаягдал гарсны 2,064.8 мянган тонн буюу 72.2 хувийг ландфиллд булшилж, 240.3 мянга буюу 8.4 хувийг шатаан устгаж, 334.6 мянган тонн буюу 11.7 хувийг байгальд хаясан байна. Мөн бусад салбарын завсрын хэрэгцээнд 216.4 мянган тонныг хэрэглэсэн бол үлдсэн 2.7 мянган тонныг экспортод гаргасан нь өмнөх оны мөн үеэс 4.2 дахин нэмэгдсэн дүн юм. Экспортолсон хог хаягдлын ихэнх хэсгийг төмрийн хог хаягдал эзэлж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

### Хуванцар бүтээгдэхүүний хэрэглээ

Монгол Улсад 2022 оны байдлаар үйл ажиллагаагаа явуулж буй хуванцар хаягдал дахин боловсруулах нийт 18 үйлдвэр байдгийн нэг нь PET хуванцрыг дахин боловсруулдаг. Уг үйлдвэрийн гол түүхий эд нь иргэд, айл өрх болон аж ахуйн байгууллагын хэрэглээнээс гарч буй ус, ундааны сав юм. 2021 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд дахин боловсруулах боломжтой материал хүлээн авдаг бүртгэлтэй, бүртгэлгүй нийлсэн 164 төвлөрсөн цэг байсан байна. Үүнээс 44.7 хувь буюу 67 цэг нь хуванцар бүтээгдэхүүн хүлээн авдаг ба нэгээс бусад нь PET хаягдлыг килограмм тутамд нь дунджаар 191 төгрөг худалдаж авдаг байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гаргасан тайлангаар Монгол Улс 2023 онд нийт 408.2 сая литр цэвэр ус, амтат ус, ундаа үйлдвэрлэсэн байна. Үүний 230.6 сая литр буюу 56.5 хувийг амтат ус , ундааны үйлдвэрлэл, 122.5 сая литр буюу 30.0 хувийг цэвэр ус, 55.2 сая литр буюу 13.5 хувийг жүүсний үйлдвэрлэл эзэлж байна. Сүүлийн 5 жилд буюу 2019-2023 онд дотоодод үйлдвэрлэсэн төрөл бүрийн ундааны хэмжээ жилд дунджаар 6.7 хувиар өсөж байгаа бол согтууруулах бус ундааны импорт 9.2 хувиар нэмэгджээ.

**Зураг 38: Монгол Улсын төрөл бүрийн ундааны үйлдвэрлэлийн хэмжээ, төрлөөр, сая литр, 2023 он**




*Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам*

**Зураг 39: Монгол Улсын төрөл бүрийн ундааны үйлдвэрлэлийн хэмжээ, сая литр, жилээр, 2019-2023 он**




*Эх сурвалж : Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам*

### Согтууруулах бус ундааны импорт

Нийт дотоодод байгаа дахин боловсруулах боломжтой PET хуванцар савны хаягдалд дотооддоо үйлдвэрлэсэн согтууруулах бус ундаанаас гадна импортоор орж ирсэн согтууруулах бус ундааны хог хаягдлын мөн хамааруулж тооцдог. 2023 оны байдлаар Монгол Улс өмнөх оны мөн үеэс 6.6 сая литрээр бага буюу 40.8 сая литр согтууруулах бус ундааг импортолсон байна.

TDB SECURITIES

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03

### Согтууруулах бус ундааны экспорт

Монгол Улсын согтууруулах бус ундаа, цэвэр ус, амтат ус, жүүсний экспортын хэмжээ сүүлийн 5 жилд дунджаар 120.7 хувиар өссөн ба 2023 онд 1.8 сая литр согтууруулах бус ундаа, цэвэр ус, амтат ус, жүүс экспортолжээ.

**Зураг 40: Монгол Улсын согтууруулах бус ундааны экспорт, мянган литр, 2019-2023 он**




Бүтцийн хувьд 2019 онд согтууруулах бус ундааны экспортын 56.2 хувь буюу 70.2 мянган литрийг согтууруулах бус ундаа, жүүс, 41.8 хувь буюу 52.2 мянган литрийг ус, рашаан, цас, мөс бүрдүүлж байсан бол рашаан, хийжүүлсэн ус 2.52 мянган литр буюу 2.0 хувийг бүрдүүлж байжээ. 2020 он буюу түүнээс хойшхи жилүүдэд согтууруулах бус ундааны экспортын дийлэнх хувь буюу 99.9 хувиас доошгүй хэсгийг согтууруулах бус ундаа дангаар бүрдүүлсэн байна.

### Монгол Улсад импортлогдсон PET хуванцрын тоо хэмжээ

2018-2023 оны хооронд Монгол Улс БНХАУ, Хонгконг, БНСУ, Нидерланд болон Узбекистан орнуудаас нийт 86.8 мянган тонн полиэтилен терефталат буюу цэвэр PET хуванцрыг импортолжээ. Энэ хугацаанд нийт импортын дийлэнх буюу 74.2 мянган тонн буюу 85.6 хувийг БНХАУ бүрдүүлж байсан бол 12.5 мянган тонн буюу 14.4 хувийг Хонгконг, үлдсэн 79.4 тонн буюу 0.1 хувийг бусад улсуудаас импортлон авсан байна. Нийт импортын хэмжээ сүүлийн 5 жилд дунджаар 6.7 хувиар нэмэгдэж, 2023 онд 17.0 мянган тонн хүрсэн ба үүнд зууралдамтгай чанар нь 78 мл/г буюу түүнээс дээш полиэтелин терефталатын эзлэх хувь 43.9 хувь байгаа нь өмнө жилүүдэд байгаагүй бага үзүүлэлт юм.

**Зураг 41: Монгол Улсын цэвэр полиэтелин терефталатын импортын хэмжээ, илгээгч орноор, мянган тонн, 2018-2023 оны нийт дүн**




*Эх сурвалж : Гаалийн ерөнхий газар*

**Зураг 42: Монгол Улсын цэвэр полиэтелин терефталатын импортын нийт хэмжээ, төрлөөр, мянган тонн, 2018-2023 он**




*Эх сурвалж : Гаалийн ерөнхий газар*

Монгол Улс 2023 онд зөвхөн БНХАУ-аас PET хуванцрыг импортолсон бөгөөд зууралдамтгай чанар 78 мл/г болон түүнээс дээш полиэтелин терефталатын хувьд килограмм нь 1.1 ам.доллар, бусад нь 0.9 ам.долларын үнийн дүнтэй байжээ. Сүүлийн 5 жилийн байдлаар БНХАУ-ын импортын үнэ хамгийн хямд байгаа бол Нидерланд болон ХБНГУ-аас импортолсон бүтээгдэхүүн харьцангуй үнэтэй байна.

**Хүснэгт 32: Полиэтелин терефталатын үнэ, килограмм, илгээгч улсаар, 2019-2023 он**

| Он | Төрөл | Улс | Үнэ, мянган кг/ам.доллар |
|---|---|---|---|
| 2019 | Зууралдамтгай чанар 78 мл/г болон түүнээс дээш | БНХАУ | 1.2 |
| | | Хонгконг | 1.5 |
| | Бусад | Нидерланд | 12.2 |
| | | ХБНГУ | 33.9 |
| 2020 | Зууралдамтгай чанар 78 мл/г болон түүнээс дээш | БНХАУ | 0.9 |
| | | Хонгконг | 1.2 |
| | Бусад | БНХАУ | 0.8 |
| 2021 | Зууралдамтгай чанар 78 мл/г болон түүнээс дээш | БНХАУ | 0.9 |
| | | Хонгконг | 1.1 |
| 2022 | Зууралдамтгай чанар 78 мл/г болон түүнээс дээш | БНХАУ | 1.2 |
| | | Хонгконг | 1.1 |
| | Бусад | БНХАУ | 1.1 |
| | | Узбекистан | 1.2 |
| | | ХБНГУ | 45.5 |
| 2023 | Зууралдамтгай чанар 78 мл/г болон түүнээс дээш | БНХАУ | 1.1 |
| | Бусад | БНХАУ | 0.9 |

*Эх сурвалж : Гаалийн ерөнхий газар*

**Монгол Улсад үүссэн PET хаягдлын хэмжээ, нийт хог хаягдалд эзлэх хувь**

Дотоодын буй цэвэр согтууруулах бус ундааны хэмжээг тухайн жилд дотоодод үйлдвэрлэсэн төрөл бүрийн ундааны үйлдвэрлэлийн хэмжээн дээр согтууруулах бус ундааны импортыг нэмж, экспортод гаргасан нийт согтууруулах бус ундааны хэмжээг хасаж тооцсон.

2018 онд Саудын Арабын Табук их сургууль болон Бангладешийн Ази номхон далайн их сургуулийн судлаачдын хамтарсан судалгаагаар 1 литр согтууруулах бус ундааны хуванцар сав нь ойролцоогоор 30.9 грамм байдаг гэсэн тооцоо гарчээ. Уг дүнг Монгол Улсад байгаа нийт согтууруулах бус ундааны дүнд харьцуулж тооцвол 2023 оны байдлаар манай улсад 18.2 мянган тонн PET хуванцар савны хаягдал үүссэн байна.

**Зураг 43: Нийт дотоодод буй цэвэр согтууруулах бус ундааны хэмжээ, сая литр, 2019-2023 он**




*Эх сурвалж : Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам*

СЗХ
2024.07.05
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02

Дээр дурдсан тооцоолол үндэслэн Монгол Улсын PET хаягдлын хэмжээ 2019-2023 онд дунджаар 6.8 хувиар өссөн байна. PET хаягдлын хэмжээ нь нийт хог хаягдлын 0.5-0.6 хувийг, хуванцар бүтээгдэхүүний энгийн хаягдлын 6.0-9.0 хувийг тус тус бүрдүүлж байна.

2022 оны байдлаар PET хаягдлын хэмжээ нь дахин боловсруулахаар цуглуулсан хуванцрын хаягдлаас 4.8 дахин их байгаа нь хог хаягдлыг цуглуулан, ангилах тогтолцоог сайжруулж чадвал дахин боловсруулах үйлдвэрийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хангалттай боломж байгааг харуулж байна.

**Зураг 44: Монгол Улсад үүсэж буй PET хаягдлын нийт хог хаягдалд эзлэх хувь, 2018-2022 он**




*Эх сурвалж : Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам*

**Монгол Улсын хуванцрын дахин боловсруулалтын цаашдын чиг хандлага**

БОАЖЯ-наас 2022 онд бэлтгэн гаргасан тайлангийн үзүүлэлтээр Монгол Улсын нийт 330 сумын 137 нь хог хаягдлыг тархахаас хамгаалсан хашаагүй, 291 нь хог хаягдал шатаах зуухгүй, 261 нь хог бутлах тоног төхөөрөмжгүй, 76 нь хог тээвэрлэх автомашингүй байна. Улс даяар хог хаягдлыг цуглуулан тээвэрлэх тогтолцоо хангалтгүй, цугларсан хог хаягдлыг ангилан ялгах, боловсруулах төвүүд дутмаг байгаагаас нийт хог хаягдлын 11.7 хувийг байгальд шууд хаяхад хүрж байна.

Дэлхийн нийт хог хаягдлын 56.0 орчим хувийг дахин боловсруулдаг байсан БНХАУ нь 2017 онд түүхий эд, материалаар ашиглагддаг хог хаягдлыг импортоор оруулахыг хориглож, PET хуванцрын импортын хэмжээнд хязгаарлалт тавих шийдвэр гаргаснаар Монгол Улс хуванцрын хог хаягдлаа бие даан боловсруулж эсвэл булшлах, устгах шаардлага гарж иржээ. Хуванцар савны бүрэн задрах хугацаа 450 жил байдаг бөгөөд дэлхий даяар хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, байгаль орчны бохирдлыг бууруулах, ногоон эдийн засгийн эргэлтийг сайжруулах замаар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилготой байгаа энэ үед хуванцар хог хаягдлыг булшилж, устгахаас илүү дахин боловсруулж, ашиглах нь оновчтой шийдвэр болно.

Мөн Монгол Улсын Их хурлаас 2020 онд баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хог хаягдлын цогц менежмент 3R-ийг хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах загвар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилтыг тавьсан.

Дотоодод байгаа нийт PET хуванцрын хэмжээ 2019-2023 онд жилд дунджаар 6.8 хувиар өссөн байх ба тус өсөлтөд тулгуурлан 2028 он гэхэд дотоодын нийт PET хуванцрын хэмжээ 25.4 мянган тонн хүрэх төлөвтэй байна. Монгол Улсад 2022 оны байдлаар PET хуванцрыг дахин боловсруулан үйл ажиллагаагаа явуулж буй цор ганц үйлдвэр байдаг ба энэ нь Үнэт цаас гаргагчийн жилд 27.0 мянган тонн хаягдлыг боловсруулах хүчин чадалтай Ти Эм Эл Пластик үйлдвэр юм. Монгол Улсад хог хаягдлын менежментийг сайжруулан, нийт PET хуванцар савны хаягдлыг бүрэн хэмжээгээр нь цуглуулан ангилах тогтолцоо бүрдэж чадвал Ти Эм Эл Пластик үйлдвэр нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж, Монгол Улсын нийт PET хуванцрын хаягдлыг дахин боловсруулах боломжтой болох юм.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

**Зураг 45: Дотоодод байгаа нийт PET хуванцрын хэмжээний түүхэн үзүүлэлт болон төсөөлөл, мянган тонн, 2019-2029 он**




*Эх сурвалж : Компанийн тооцоолол*


СЗХ 2024.07.05 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-02
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES
ТЖТБ ХХК УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2024.07.05
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

### 2.4.5. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

**Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль тогтоомж**

**Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа нь дараах хуулиудын холбогдох хэсгээр зохицуулагдана. Үүнд:**

***Хог хаягдлын тухай хууль***

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Хог хаягдлын тухай хуулиар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.

**Дагаж мөрдөх бусад хууль тогтоомжууд**

**Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа нь дараах татварын багц хуулиудын холбогдох хэсгээр зохицуулагдана. Үүнд:**

***Татварын ерөнхий хууль***

2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан "Татварын ерөнхий хууль"-ийн шинэчилсэн найруулгаар Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, Монголын Татварын алба, татвар төлөгч болон энэ хуулийн дагуу татварын албаны өмнө үүрэг хүлээсэн бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулдаг болно.

Үнэт цаас гаргагч нь татвар төлөгч болохын хувьд тус хуулиар тогтоосон татварын төрөл, ангиллаар татвар төлөх, татварын эрх зүйн нийтлэг үндэслэл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон татвар төлөгчийн үүрэг, хариуцлага болон холбогдох харилцаанд хуулиар тогтоосон журмыг баримтлах үүрэг хүлээнэ.

***Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль***

2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр ба батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Үнэт цаас гаргагч нь тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон, түүнчлэн гадаад улсаас олсон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасан татвар ногдох орлого олсон бол холбогдох албан татварыг тус хуульд заасан хувь хэмжээгээр төлөх үүргийг хүлээнэ.

***Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль***

2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх эд хөрөнгөнд албан татвар ногдуулах, уг татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг болно.

TDB SECURITIES

УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагч нь Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулиар тогтоосон журмын дагуу татвар төлөх ба аливаа үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч байх үедээ тус хуулийг дагаж мөрдөх үүрэгтэй байна.

***Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль***

1992 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулиар хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг болно.

Үнэт цаас гаргагч нь тээврийн хэрэгслийн эзэмшигч байх тул Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулиар тогтоосон журмын дагуу татвар төлөх, эдгээр хөрөнгийн өмчлөгч байх үедээ тус хуулийг дагаж мөрдөх үүрэгтэй байна.

**Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль тогтоомж, журмууд**

**Үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь дараах хууль тогтоомжийн холбогдох хэсгээр зохицуулагдана. Үүнд:**

***Компанийн тухай хууль***

2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Компанийн тухай хуульд компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Үнэт цаасыг анхдагч зах зээлд нийтэд санал болгох үйл ажиллагаанд Компанийн тухай хуулийн дараах зохицуулалт үйлчилнэ. Үүнд:

- ТУЗ-ийн шийдвэрээр үнэт цаас гаргах.

***Үнэт цаасны зах зээлийн тухай хууль***

2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд холбогдох хуулийн дараах зохицуулалтууд үйлчилнэ. Үүнд:

- Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах эрх зүйн үндэслэл, тус үнэт цаасыг Хороонд бүртгүүлэх, үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрлийг Хорооноос олгох;
- Нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааны журам;
- Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, анхдагч зах зээлд худалдах ажиллагаа, бүрдүүлэх бичиг баримт, үнэлгээ тайлан, тайлагнах үүрэг;
- Үнэт цаасны танилцуулга бүртгүүлэх, танилцуулгын агуулга, түүнд тусгагдсан хууль зүйн болон санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг эрх бүхий хуулийн этгээдээр хянуулах, дүгнэлт гаргуулах;
- Нийтэд санал болгох үнэт цаас гаргах ажиллагаа дахь андеррайтер болон бусад мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа;
- Үнэт цаас гаргагчийн удирдлагад тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо, Биржийн тогтоох эрх зүйн үндэслэл.

Хуульд заасны Компанийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг Хороо үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрлийг олгож, Бирж нь үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

арилжааг зохион байгуулна. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсэгт зааснаар үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг тухайн Үнэт цаасны танилцуулгад зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

***Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль***

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд хувьцаагаа анх удаагаа санал болгож, арилжаалж байгаатай холбоотойгоор хөрөнгө оруулагч хуулийн этгээд нь Компанийн тухай хуулийн дагуу компаниас ногдол ашиг хүртсэн тохиолдолд Аж ахуй нэгжийн орлогын татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад заасны дагуу ногдол ашгийн албан татвар төлөх бөгөөд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад худалдаж орлого олсон тохиолдолд хөрөнгө борлуулсны албан татварыг тус тус төлөх үүргийг хүлээнэ.

Мөн тус хуульд Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод 20 хувиар татвар ногдуулахаар заасан. Харин Давхар татварын гэрээтэй улсуудын хувьд ихэнх тохиолдолд үнэт цаас гаргаж буй компанийн буюу Монгол Улсад ногдол ашгийн татвар төлөхөөр зохицуулсан байдаг боловч гэрээнд заасан хувь хэмжээ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаас бага байдаг.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Монгол Улс дараах 26 улстай байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр” хүчин төгөлдөр үйлчилж байна.

**Хүснэгт 33: Давхар татварын гэрээтэй улс орнуудын жагсаалт**

| № | Улсын нэр | Бүх төрлийн татварын хувь хэмжээ | Гэрээ үйлчилж эхэлсэн огноо |
|---|---|---|---|
| 1 | Бүгд Найрамдах Хятад Ард Улс | 5-10% | 1993.01.01 |
| 2 | Бүгд Найрамдах Солонгос Улс | 5-10% | 1992.01.01 |
| 3 | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс | 5-10% | 1997.01.01 |
| 4 | Бүгд Найрамдах Энэтхэг Улс | 15% | 1994.01.01 |
| 5 | Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс | 10% | 1997.01.01 |
| 6 | Бүгд Найрамдах Турк Улс | 10% | 1997.01.01 |
| 7 | Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс | 5-15% | 1997.01.01 |
| 8 | Бүгд Найрамдах Унгар Улс | 5-15% | 1997.01.01 |
| 9 | Малайз Улс | 10% | 1997.01.01 |
| 10 | Оросын Холбооны Улс | 10% | 1998.01.01 |
| 11 | Бүгд Найрамдах Индонез Улс | 10% | 1998.01.01 |
| 12 | Беларусь улс | 10% | 2002.01.01 |
| 13 | Бүгд Найрамдах Франц Улс | 5-15% | 1999.01.01 |
| 14 | Бүгд Найрамдах Чех Улс | 10% | 1999.01.01 |
| 15 | Бельгийн Вант Улс | 5-15% | 1999.01.01 |
| 16 | Бүгд Найрамдах Казахстан Улс | 10% | 2000.01.01 |
| 17 | Бүгд Найрамдах Киргиз Улс | 10% | 2000.01.01 |

| | | | |
|---|---|---|---|
| 18 | Бүгд Найрамдах Польш Улс | 10% | 2002.01.01 |
| 19 | Бүгд Найрамдах Болгар Улс | 10% | 2002.01.01 |
| 20 | Швейцарын Холбооны Улс | 5-15% | 2002.01.01 |
| 21 | Украин Улс | 10% | 2003.01.01 |
| 22 | Канад Улс | 5-15% | 2003.01.01 |
| 23 | Бүгд Найрамдах Итали Улс | 5-15% | 2004.01.01 |
| 24 | Бүгд Найрамдах Сингапур Улс | 5-15% | 2005.01.01 |
| 25 | Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс | 10% | 2005.01.01 |
| 26 | Бүгд Найрамдах Австри Улс | 5-10% | 2005.01.01 |

*Эх сурвалж: Татварын ерөнхий газар*

***Хувь хүний орлогын албан татварын тухай хууль***

2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг болно.

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд хувьцаагаа анх удаагаа санал болгож, арилжаалж байгаатай холбоотойгоор хөрөнгө оруулагч хувь хүн нь Компанийн тухай хуулийн дагуу компаниас ногдол ашиг хүртсэн тохиолдолд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4 дэх заалтад заасны дагуу ногдол ашгийн албан татвар төлөх бөгөөд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад худалдаж орлого олсон тохиолдолд хөрөнгө борлуулсны албан татварыг Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу тус тус төлөх үүрэг хүлээнэ.

***Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль***

2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Уг хуулийн хүрээнд Үнэт цаас гаргах үйл ажиллагааны хүрээнд Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт болох үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулсныг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэх үүрэгтэй.

Үнэт цаас гаргагч нь тус хуульд заасан компанийн хувьцаа эзэмшигчийн бүтэц, тэдгээрийн хувь эзэмшил болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тусгасан дүрмийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд бүртгүүлэх, компанийн хувийн хэргээс лавлагаа гаргуулах зэргээр улсын бүртгэлийн үйлчилгээ авахад холбогдох эрх зүйн зохицуулалтыг мөрдөж ажилладаг ба олон нийтэд үнэт цаас санал болгон гаргах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн бүтцэд орж ирэх хувьцаа эзэмшигчид, хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний өөрчлөлт, хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг тусгасан дүрмийн шинэчилсэн найруулга, ТУЗ-ийн бүрэлдэхүүн болон эцсийн өмчлөгчийн өөрчлөлтийг бүртгүүлэх үүрэг хүлээж байна.

***Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль***

2009 оны 7 дугаар сарын 09-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбогдсон



СЗХ 2024.07.05 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-08-03 БҮРТГЭВ-02
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES
5147204 ХАК0303 УЛААНБААТАР ХОТ

харилцааг зохицуулна. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно" гэж заасны дагуу Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үнийг ам.доллароор тогтоох, төлбөр тооцоог гүйцэтгэх, сурталчлахад Монголбанкнаас зөвшөөрөл авах үүрэгтэй.

***Зөвшөөрлийн тухай хууль***

Зөвшөөрлийн тухай хууль 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр батлагдаж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр 2001 оны 02 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хүчингүй болсон. Зөвшөөрлийн тухай хуулиар үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналт, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтоохтой холбогдох нийтлэг харилцааг зохицуулдаг болно.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь зүйлд заасны дагуу Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх зохицуулалттай байна. Иймд Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үнийг ам.доллароор тогтоох, төлбөр тооцоог гүйцэтгэхэд Монголбанкнаас зөвшөөрөл авах үүрэгтэй.

**Үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь Санхүүгийн зохицуулах хорооны дараах журмуудын холбогдох хэсгээр зохицуулагдана. Үүнд:**

**Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам**

Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан (2022 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 378 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан) Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмаар нийтэд санал болгон гаргах аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас, компанийн өрийн хэрэгсэл /цаашид "бонд" гэх/-ийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-ны бүртгэлд бүртгэх, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, бондыг анхдагч зах зээлд санал болгох, худалдах, түүний хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх, бонд гаргагч, зохицуулалттай этгээд, Хорооны эрх, үүрэг болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой харилцааг зохицуулдаг болно.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд холбогдох журмын дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- Нийтэд санал болгон бонд гаргагчид тавигдах шаардлага;
- Бондыг бүртгүүлэх хүсэлт гаргах, хүсэлтийг хянах, бүртгэх, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах;
- Бонд гаргах хөтөлбөр;
- Ногоон бонд гаргах;
- Бондыг анхдагч зах зээлд санал болгох, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх;
- Бонд гаргагч, зохицуулалттай этгээд, хорооны эрх, үүрэг;
- Бонд гаргагчийн мэдээллийн ил тод байдал.

***Компанийн засаглалын кодекс***

Хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-оор компанид засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд дэмжлэг үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Компанийн засаглалын кодекст заасан компанийн засаглалын зарчмуудын зүйл тус бүрийг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас гаргагч дагаж мөрдөх үүрэгтэй ба үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- *Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт:* Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.
- *Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг:* Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаагаа тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг өөрөө хүлээнэ.
- *Тайлагнал мэдээллийн ил тод байдал:* Төлөөлөл удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцоотой хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.
- *Аудит, хяналтын тогтолцоо:* Төлөөлөл удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.
- *Эрсдэлийн удирдлага:* Компани эрсдэлийн удирдлагын тогтолцоог зүй зохистой, хараат бус байдлаар зохион байгуулж, уг тогтолцооны үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.
- *Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал:* Төлөөлөл удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.
- *Оролцогч талуудын эрх ашиг:* Компани нь үйл ажиллагаа явуулахдаа бусад оролцогч талуудын эрх ашгийн хүндэтгэнэ.
- *Компанийн соёл:* Төлөөлөл удирдах зөвлөлийн гишүүд компанидаа бизнесийн ёс зүй, хариуцлагын өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтанд мөрдлөг болгон хэвшүүлнэ.
- *Хувьцаа эзэмшигчдийн эрх:* Компани болон төлөөлөл удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, холбогдох мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх боломцоогоор бүрэн хангана.

**Үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь Монголын хөрөнгийн биржийн дараах журмуудын холбогдох хэсгээр зохицуулагдана. Үүнд:**

***Үнэт цаасны бүртгэлийн журам***

Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан (2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 09 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан) Үнэт цаасны бүртгэлийн журмаар Үнэт цаас гаргагчийн хувьцаа, өрийн хэрэгслийг Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, үнэт цаасыг нийтэд танилцуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд холбогдох журмын дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- Үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах /Үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах, үнэт цаас бүртгүүлэх хэлбэр/;
- Үнэт цаас гаргагчийн тогтмол биелүүлэх үүрэг.

Энэхүү журмыг Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан үнэт цаас гаргагч, тэдгээрийн ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

болон андеррайтер, аудитор, хуульч, хөрөнгийн үнэлгээчин, үнэт цаас гаргахтай холбоотой хөндлөнгийн шинжээч зэрэг мэргэжлийн зөвлөхүүд дагаж мөрдөнө.

***Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам***

Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан (2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан) Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмаар Биржид бүртгэлтэй бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн шинээр болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгсэл болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан бусад санхүүгийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх, арилжих үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, шуурхай явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

***Арилжааны журам***

Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан (2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 46 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан) Арилжааны журмаар Биржийн үнэт цаасны арилжааны төрөл, хэлцэл хийгдэх нөхцөл, арилжааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

СЗХ 2024.07.05 БҮРТГЭВ №
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

## 2.5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ, ДАВУУ ТАЛ

### 2.5.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

2021 онд Монгол Улсын хэмжээнд 238.2 мянган тонн хуванцар хог хаягдал үүссэн ба үүний 6.0 хувь буюу 14.4 мянган тонн нь PET хуванцар хог хаягдал бүрдүүлж байна. 2024-2028 онд нийт хуванцар хог хаягдлын хэмжээ жилд дунджаар 3.7 хувиар өсөж, 245.4 мянган тоннд хүрэх[6] ба үүний 10.3 хувь буюу 25.4 мянган тонныг PET хуванцрын хэмжээ эзлэх хандлагатай байна.

Монгол Улсад үүсэж буй цэвэр PET хаягдлын хэмжээ 2019-2023 онд жилд дунджаар 6.8 хувиар өсөж 18.2 мянган тоннд хүрсэн[7] нийт хуванцар хог хаягдлын 8.9 хувийг бүрдүүлж байна. 2024-2028 онд Монгол Улсад үүсэж буй цэвэр PET хаягдлын хэмжээ жилд дунджаар 6.8 хувиар өсөж, 2028 онд 25.4 мянган тоннд хүрэх төсөөлөлтэй байна.

**Зураг 46: Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь**




Үнэт цаас гаргагч нь 2021 онд нийт Монгол Улсын хэмжээнд үүссэн PET хог хаягдлын 26.5 хувийг буюу 3.8 мянган тонн хуванцар хог хаягдал цуглуулсан бол 2022 онд 24.0 хувийг буюу 4.3 мянган тонн, 2023 онд 18.1 хувийг буюу 3.3 мянган тонн PET хуванцар хаягдал цуглуулсан байна. Үнэт цаас гаргагч нь хог хаягдал цуглуулах цэгүүд нэмж барьснаар цуглуулах PET хог хаягдлын хэмжээ 2024-2028 хүртэл жилд дунджаар 17.0 хувиар өсөж, 2028 онд 15.0 мянган тонн PET хаягдал цуглуулах төлөвлөгөөтэй байна.

**Зураг 47: Үнэт цаас гаргагчийн цуглуулсан хог хаягдлын хэмжээ болон үүсэж буй PET хаягдлын хэмжээ, мянган тонн, 2021-2028**




ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИЕС ҮЦК ХХК TDB SECURITIES

[6] 2024-2028 оны нийт хуванцар хог хаягдлын хэмжээний төсөөллийг 2018-2021 оны жилийн дундаж өсөлтийн хувиар өсгөж тооцоолсон болно.
[7] Цэвэр PET хаягдлын хэмжээ = [(Полиэтилен терефталатын импорт+согтууруулах бус ундааны импорт)-согтууруулах бус ундааны экспорт]*30.89 грамм*
*1 литр шингэн хүнсний хуванцар савны дундаж хэмжээ

### 2.5.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН SWOT ШИНЖИЛГЭЭ

**STRENGTHS | ДАВУУ ТАЛУУД**

- Олон улсын чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.
- Компани нь үйлдвэрлэсэн rPET мөхлөгийг БНХАУ руу экспортолдог ба мөн өөрийн нэгдлийн компаниараа дамжуулан Укбекистан улс руу экспортолж байна.
- Компани нь Монгол Улсын байгаль орчны бохирдлыг бууруулах, байгалийн шавхагдах нөөцийн үнэ цэнийг хадгалах зэрэг байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг явуулж байна.
- Компанийн нь дэлхийн тэргүүлэх Сорема болон Эрема брэндийнх тоног төхөөрөмжийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- 27,000 тонн ус, ундааны хуванцар (PET) хаягдлыг дахин боловсруулах хүчин чадалтай Ти Эм Эл Пластик үйлдвэр нь Монгол Улсад үүсэж буй хуванцар (PET) хаягдлыг дангаараа дахин боловсруулах хүчин чадалтай.
- Дэлхий дахинд байгаль орчинд ээлтэй дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг хэрэглэх хандлага нэмэгдэж байгаагийн хэрээр rPET мөхлөгийн хэрэглээ, үүнийг дагасан эрэлт нэмэгдсээр байна. Түүнчлэн rPET мөхлөгийг хувцас, сав баглаа боодол зэрэг өргөн хэрэглэлийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашигладаг. Иймд Компанийн үйлдвэрлэж буй rPET мөхлөг нь дотоодын болоод гадаадын зах зээлд эрэлт өндөртэй байна.
- Компани нь Монгол Улсын хуванцар хаягдлын хамгийн том худалдан авагч, мөн томоохон ханган нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг. Мөн бүтээгдэхүүнээ олон улсад экспортолдгооро давуу талтай.
- Компанийн rPET мөхлөгийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон эцсийн бүтээгдэхүүний чанар нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, шаардлагуудыг хангасан байдаг. Энэ нь Компанийн үйлдвэрлэлийн болон дотоод үйл ажиллагааны олон улсын жишигт нийцсэн туршлага өндөр байгааг харуулж байна.
- Компани нь ус, ундааны хуванцар савыг дахин боловсруулж, хэрэглээний бүтээгдэхүүн болгож байгаа үйл ажиллагаа нь тойргийн эдийн засгийг дэмжиж буй давуу талтай.
- Компани нь мэргэжлийн ур чадвар бүхий чадварлаг хүний нөөцийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Компани нь тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгохын тулд ажилчдадаа чиглэсэн үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлдэг бөгөөд ажилчдын бүтээмж, сэтгэл ханамжийг өндөр байлгахад чиглэсэн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлдэг.

**WEAKNESSES | СУЛ ТАЛУУД**

- Ус, ундааны хуванцар савны хаягдал Монгол Улсын хэмжээнд өндөр байгаа хэдий ч хэрэглэгчдэд хог хаягдлыг ангилах соёл хэвшээгүйн улмаас хангалттай хэмжээний түүхий эдийн цуглуулалт хийж, нөөц бүрдүүлэхэд бэрхшээлтэй байна.
- Компанийн үйлдвэр нь Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо хаягт байршдаг ба тус байршлаас шалтгаалан ажиллах хүчний хомсдол үүсдэг.
- Хуванцар сав цуглуулахтай холбоотой гарах зардал нь бусад дайврын үнийн өсөлттэй шууд хамааралтай.

| OPPORTUNITIES \| БОЛОМЖУУД | THREATS \| АЮУЛ |
|---|---|

**OPPORTUNITIES | БОЛОМЖУУД**

- Компани нь Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар БНХАУ-ын зах зээлд, мөн өөрийн нэгдлийн компаниараа дамжуулан Узбекистан улсын зах зээлд rPET мөхлөгийг экспортолсон байх ба олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг хангасан давуу талынхаа хүрээнд Европын зах зээлд томоохон тэлэлт хийх боломжтой байна.
- Дэлхий даяар ногоон бизнес тренд болж байгаатай уялдуулан Компани нь хуванцар сав төдийгүй хуванцар савны бөглөө, шошго гэх мэт хаягдлыг дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой.
- Компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдах цахилгаан эрчим хүчний хэрэглээг сэргээгдэх эрчим хүч ашиглан бууруулах боломжтой.
- Монгол Улсын хөдөө, орон нутагт үүсэж буй хуванцар хаягдлын цуглуулалт маш бага байгаа нь Компанийн түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийг хөдөө, орон нутагт тэлж, их хэмжээний хуванцар хаягдлыг цуглуулан үйлдвэрлэлийн түүхий эдээр татан төвлөрүүлэх боломжтой байна.
- Ажиллах хүчний бүтээмжийг технологиор дэмжих боломжтой.
- Ногоон бизнес, дахин боловсруулалтыг төрөөс татварын бодлогоор дэмжих боломжтой.
- Олон улсын ногоон трендийг дагасан томоохон санхүүжилт, хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа нь Компанийн санхүүгийн үйл ажиллагааг дэмжих боломжтой.
- ТОС холбоонд гишүүнээр элсэх, нэтворкинг тэлэх

**THREATS | АЮУЛ**

- Бусад дайврын үнийн өсөлтөөс холбоотой хуванцар сав цуглуулах зардал нэмэгдэх аюултай.
- Түүхий эдийн чанар дээр анхаарах буюу ихээхэн хэмжээний бохирдолтой бүтээгдэхүүн татан авч үйлдвэрлэлд оруулах нь гарцын ашигт үйлийн коэффициентын хэмжээг бууруулах аюултай.
- Олон улс, дайны гэх мэт эрсдэл нь төлбөр тооцоо, химийн бодис зэрэг гадаад орчноос хамааралтай түүхий эдийг татахад хүндрэл учруулах боломжтой.
- Хил, гаалийн эрсдэл
- Давагдашгүй хүчин зүйлс
- Эдийн засгийн нөхцөл байдал, үнийн өсөлт, инфляцын дарамт үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх;
- Хуванцар савны хэрэглээ буурах;

СЗХ 2024.07.05 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

## 2.6. НОГООН БОНД

### 2.6.1. НОГООН БОНДЫН ТУХАЙ

Ногоон бонд нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг багасгах, байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилготой тогтмол орлоготой өрийн хэрэгсэл юм. Сүүлийн үед бонд гаргагчид, хөрөнгө оруулагчид болон засгийн газрууд байгаль орчин, тогтвортой эдийн засгийг илүү чухалчилж авч үздэг болсноор хөрөнгийн зах зээлд энэхүү бүтээгдэхүүн нь түгээмэл болж байна.

Олон улсад ногоон бонд нь нийгэм, байгаль орчин, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах үйл ажиллагааг санхүүжүүлдэг тул засгийн газрууд татвараас чөлөөлөх, эрх зүйн таатай орчин бий болгох гэх мэтээр үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлдэг.

Олон улсад НҮБ-ын мянганы сорилтын бодлогын үргэлжлэл болох 17 тогтвортой хөгжлийн зорилт, суурь конвенцын талуудын 28-р бага хурал зэрэг олон улсын санамж бичиг, зорилтуудын хүрээнд улс орнууд тогтвортой санхүүжилтийг нэмэх, таатай орчин бүрдүүлэх, шууд хөрөнгө оруулах зэрэг ногоон бондын зах зээлийг дэмжиж эхэлснээр олон улсад ногоон бонд болон тогтвортой санхүүжилт хурдацтай өсөж байна. Ногоон бондын НҮБ-аас баталсан зорилтод хүрэхэд жилд 5-7 их наяд ам.долларын ногоон хөрөнгө оруулалт хийх шаардлагатай гэсэн судалгаа гарсан ба ногоон бонд нь Ази, номхон далайн бүс нутагт хамгийн өндөр өсөлттэй байх тооцоолол гарчээ.

Монгол Улсын тухайд Парисын хэлэлцээр болон тогтвортой хөгжлийн зорилгод нэгдэн орсноор тус зорилтод хүрэх үүрэг хүлээхийн зэрэгцээ олон улсын туслалцаа авах боломж бүрджээ. Монгол Улс нь тогтвортой хөгжлийн зорилгоо биелүүлэхэд улсын хэмжээнд нийт 43 тэрбум ам.долларын ногоон санхүүжилт шаардлагатай байгаа нь Монгол Улсад ногоон бондын санхүүжилт татах хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд цаашид өсөхийг илтгэж байна.

### 2.6.2. НОГООН БОНДЫН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Дэлхийн банкнаас гаргасан 2022 оны ногоон бондын нөлөөллийн тайланд дэлхийн банкны санхүүжүүлсэн 680 ногоон төсөл нь хүлэмжийн хийн ялгарлыг 8.4 сая тонн нүүрсхүчлийн хийтэй тэнцэхүйц хэмжээгээр бууруулж, жилд 1,492 ГВт/цаг сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг байгуулж 16.7 сая гаруй хүмүүсийг хоол унд, шим тэжээллээр хангасан байна. Мөн олон улсын санхүүгийн корпораци нь өөрийн 2020 онд санхүүжүүлсэн 21 ногоон төсөл нь хүлэмжийн хийн ялгарлыг 8.7 сая тонн нүүрс хүчлийн хийтэй тэнцэхүйц хэмжээгээр бууруулж, 1.6 ГВт.цаг сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх чадвартай үйлдвэр байгуулжээ.

Судлаачид ногоон бонд нь нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах, дахин сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх гэх мэт эерэг нөлөөтэй байдаг боловч энэ нь ногоон бондын зохицуулалт, зохион байгуулалт сайтай орнуудад илүү нөлөөтэй байгааг тогтоосон байна.

Хуванцар савын дахин боловсруулалт нь шинэ хуванцар үйлдвэрлэлээс 79 хувиар бага хүлэмжийн хий ялгаруулахаас гадна хуванцар хог хаягдлыг багасгаснаар усны бохирдол, нөөцийн хомсдол болон дэлхийн дулаарлыг бууруулах эерэг нөлөөтэй байдгийг судлаачид тогтоожээ.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES

ТЖТБ ХХК УЛААНБААТАР

СЗХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

### 2.6.3. ОЛОН УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

НҮБ-аас 2015 онд тогтвортой хөгжил, нийгмийн оролцоог хангахад чиглэсэн тогтвортой хөгжлийн 17 зорилгуудыг баталсан байна.




Эдгээр 17 зорилт нь НҮБ-ын 2012 онд Рио Де Жанейро хотод болсон НҮБ-ын "Тогтвортой хөгжил" бага хурлын үеэр санаачлагдсан ба Мянганы хөгжлийн зорилтуудын үргэлжлэл юм. Тус тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг 2015 оны НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулганаар баталсан бөгөөд 2016 оны 01-р сарын 01-нээс Тогтвортой хөгжлийн зорилго нь дэлхий нийтээр албан ёсоор хэрэгжиж эхэлсэн байна.

Мөн жил бүр уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцын талуудын бага хурал болдог ба 2023 онд Арабын Нэгдсэн Эмират улсын Дубай хотноо суурь конвенцын талуудын ээлжит 28-р бага хурал хуралдаж нүүрс болон бусад чулуулаг түлшний хэрэглээг зогсоох, хүлэмжийг хий ялгаруулалтыг даруй багасгах арга хэмжээг авах, тогтвортой санхүүжилтийг нэмэх шийдвэр гаргасан ба дэлхийн дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх үеэс 1.5 хэмээс ихгүй тогтоох зорилтыг тавьжээ.

**Олон улсын ногоон санхүүжилтийн орчин**

Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооноос тогтвортой, нийгэм, байгаль орчинд ээлтэй төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилготой ногоон санхүүжилт татахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд 2021 оны 6 дугаар сард "Ногоон бондын зарчмууд" баримт бичгийг шинэчилж боловсруулан нийтэлсэн байна.

Ногоон бондын зарчмууд нь ногоон бондын зах зээлийн ил тод болон үнэн шударга байдлыг хангах, аливаа оролцогч талуудад дэмжлэг үзүүлэх зорилготой ба эдгээр нь үндсэн 4 хэсгээс бүрдэнэ:

- Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт;

TDB SECURITIES



ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024 .07 сар 05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -06- 03
БҮРТГЭВ-02

- Төслийг үнэлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагаа;
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага;
- Тайлагнал.

Эдгээрээс гадна ногоон бондын ил тод байдлыг хангахад ногоон бондын тогтолцоо бий болгох болон хөндлөнгийн хяналт шалгалтыг мөн санал болгосон байна.

## 1. Үнэт цаас гаргагчийн Ногоон бондын хүрээнд тусгагдсан татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Ногоон бондын татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт нь ил тод байх бөгөөд үүгээр санхүүжүүлсэн төсөл нь ногоон төслийн шалгуурыг хангаж байхыг бондын гэрээнд тусгана. Ногоон төсөл гэдэг нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, байгалийн нөөцийг хэмнэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах болон агаарын бохирдлыг бууруулах гэх мэт тогтвортой, нийгэм, байгаль орчинд ээлтэй байх шалгуурыг хангасан төсөл байна гэж тодорхойлжээ.

## 2. Үнэт цаас гаргагчийн Ногоон бондын хүрээнд тусгагдсан төслийг үнэлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагаа

Төслийн үнэлгээ, сонгон шалгаруулах үйл ажиллагааны хүрээнд Үнэт цаас гаргагч нь ТУЗ-ийн дэргэдэх Ногоон санхүүжилтийн хороог байгуулсан бөгөөд тус хороо нь Гүйцэтгэх захирал, БОНЗ менежер, ахлах нягтлан бодогч, Эрсдэл, комплайнсын эксперт гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Тус хорооны үйл ажиллагаа, төслийг сонгон шалгаруулах процесстой холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Үнэт цаасны танилцуулгын 2.2.4 дэх хэсгээс уншиж танилцана уу.

## 3. Үнэт цаас гаргагчийн Ногоон бондын хүрээнд тусгагдсан татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага

Үнэт цаас гаргагч нь бондын татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг ил тод байлгахаас гадна татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлсэн төслүүд нь ногоон төслийн шалгуурыг хангасаар байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

## 4. Үнэт цаас гаргагчийн Ногоон бондын хүрээнд тусгагдсан тайлагнал

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгөө төлөвлөгөөний дагуу бүрэн зарцуулах хүртэл жил бүр, мөн гэнэтийн материаллаг нөлөөлөл үүсэх тохиолдол тухай бүрд нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан бэлтгэж, хөрөнгө оруулагчдад тайлагнан, хадгална.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
9021110883 5251495

5147204 ХАК0303
ТЖТБ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024 он 07 сар 05 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

### 2.6.4. МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ОРЧИН

Дэлхий нийтийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө улам бүр нэмэгдэж, байгалийн гамшигт үзэгдлийн тохиолдох давтамж, хамрах хүрээ нэмэгдэх нөхцөл бүрдэж байна. Монгол Улсын хувьд агаарын дундаж температур сүүлийн 80 жилийн хугацаанд 2.25 цельсээр нэмэгдсэн нь дэлхийн дунджаас өндөр үзүүлэлт болсон ба энэ нь байгаль орчин, эдийн засгийн тэнцвэрт байдалд эрсдэл үүсгэж байна.

**Зураг 48: Монгол улсын жилийн нүүрсхүчлийн хийн ялгаруулалт, сая тонн, 1950-2022 он**




**Зураг 49: Нэг хүнд ноогдох нүүрсхүчлийн хийн ялгаруулалт, тонн, 1950-2022 он**




*Эх сурвалж: Our World in Data, Нүүрсхүчлийн хийн мэдээллийн өгөгдлийн сан*

2022 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 39.8 сая тонн нүүрсхүчлийн хий ялгаруулсан нь өмнөх оноос 300 мянган тонноор буюу 0.8 хувиар буурсан үзүүлэлт болж байгаа ба сүүлийн 10 жилийн дундаж өсөлт 1.4 хувь байсан байна. Харин Монгол Улсын нэг хүнд ноогдох нүүрсхүчлийн хийн ялгаруулалт 11.7 тонн байгаа нь дэлхийн дундаж болох 5.2 тонноос 2.3 дахин их байна. Бүтцийн хувьд авч үзвэл Монгол Улсын нийт ялгаруулсан хүлэмжийн хийн дийлэнх нь буюу 50.1 хувь нь эрчим хүч, 48.5 хувь нь хувь нь хөдөө аж ахуйн салбараас ялгарч байгаа бол үлдсэн 0.9 хувь нь аж үйлдвэр, 0.5 хувь нь хог хаягдлын салбараас ялгарч байна.

**“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого**

2020 оны 5-р сарын 13-ны өдөр “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг агуулсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, түүний хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг Монгол Улсын Их Хурлаас баталснаар 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс даган мөрдөгдөж эхэлсэн байна.

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6-р зорилго нь ногоон хөгжил буюу байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж хүний амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн 4 зорилт болон зорилт тус бүрд хэрэгжүүлэх 3 үе шат, үр дүнг тусгасан байна. Эдгээр нь:

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES



5147204
ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 02

**Хүснэгт 34: "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт**

| Чиглэл | Зорилт | Үе шат | Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн |
|---|---|---|---|
| **Эх байгаль анхдагч экосистем** | Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. | I | Монгол орны унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, даацыг тогтоож, үнэлэмжийг нэмэгдүүлж эдийн засгийн үр өгөөжийг үнэлэх. |
| | | II | Экосистемийн үйлчилгээг тэтгэж үр өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлэх. |
| | | III | Үнэлэмж, нөөц, нөхөн сэргэх чадавх, даацад суурилсан байгалийн нөөцийн ашиглалт, хамгааллын бодлого баримталж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах. |
| **Байгалийн баялгийн үр өгөөж** | Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ. | I | Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгох. |
| | | II | Техник, технологийн ололт, инновацыг байгаль хамгаалалд ашиглаж, нөөцийн хомсдол, орчны доройтлоос сэргийлэх. |
| | | III | Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж зохистой ашиглах, шавхагддаг нөөцийг хязгаартай ашиглах. |
| **Үнэт баялаг ус** | Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | I | Усны нөөцийн шаталсан үнэ тарифын тогтолцоог бүрдүүлэн, цэвэр усны үнэлэмжийг нэмэгдүүлж хамгаалах, усны нөөцийг хуримтлуулах. |
| | | II | Усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх, усны хуримтлалыг нэмэгдүүлж, хүртээмж, хангамжийг сайжруулах. |
| | | III | Байгалийн болон зориудаар арвижуулсан нөөцийг хяналттай, зохистой ашиглаж хэвших. |
| **Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил** | Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна. | I | Ногоон санхүүгийн үндэсний тогтолцоог бий болгон хөгжүүлж, байгальд ээлтэй, үр ашигтай цэвэр технологи, хэмнэлттэй хэрэглээг дэмжих. |
| | | II | Ухаалаг хэрэглээ, бүтээмжтэй үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уур амьсгалын ногоон санхүүжилтийн дотоод, гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлэх. |
| | | III | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг тасралтгүй бэхжүүлж, тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төгөлдөржүүлэх. |

*Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5-р сарын 13-ны өдрийн "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52-р тогтоолын 2-р хавсралт*

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

Хог хаягдал болон дахин боловсруулах үйлдвэрлэлийн тухайд тус баримт бичгийн 2.5-р зорилтод хог хаягдлын цогц менежмент 3R-ийг хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах,

ТЖТБ
УЛААНБААТАР ХОТ

6.4-р зорилтод хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажиллагааг хэвшүүлж, дахин боловсруулах, эрчим хүч гаргах байгаль орчинд хор, нөлөөгүй үйлдвэрийг байгуулах, 9.2-р зорилтод хог хаягдлыг ангилан ачих, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж, дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлэх, дахивар түүхий эдийг дахин боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг төрөлжүүлэх, технологийн шинэчлэл хийх, хөгжүүлэх, хаягдалгүй технологи бүхий үйлдвэрлэлийг бий болгохоор тусгагджээ.

**Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт**

Парис хотод болсон Нэгдсэн Үндэсний Байгууллагын суурь конвенцын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас үндэсний хэмжээнд тодорхойлсон зорилт, түүний баримт бичгийг боловсруулан, 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр баталсан.

Тус баримт бичигт Монгол Улсын хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зорилтын хүрээнд үндэсний хэмжээнд хүлэмжийн хийн ялгаралтыг 2010 оны суурь нөхцөлтэй харьцуулахад 2030 он гэхэд 22.7 хүртэлх хувиар бууруулах, үүний хүрээнд тавьж хэрэгжүүлэх эрчим хүч, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, зам тээвэр, барилга, хог хаягдлын салбарууд тус бүрийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтот тооцоо тусгагдсан байна. Тухайлбал хог хаягдлын салбарт хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар төвлөрсөн хогийн цэг дээр дарж булагдах хог хаягдлын хэмжээг багасгаж, хатуу хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хийг бууруулах зорилт тавьжээ.

**Монгол Улсын тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг**

2022 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирлын хамтарсан А-82/157/68/А26 тоот тушаалаар Монгол Улсын тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг батлагдсан байна.

Тус баримт бичиг нь 6 бүлэг, 25 дэд арга хэмжээнээс бүрдсэн байх ба эдгээр нь Монгол Улсын тогтвортой хөгжил, уур амьсгалын зорилтуудтай уялдсан, нэгдмэл, олон талт хамтын ажиллагааг хангасан, тогтвортой санхүүгийн системийг 2030 он хүртэл хөгжүүлэх, бүс нутагтаа тогтвортой санхүүгийн мэдлэг, манлайллын төв болох, үүнд шаардлагатай стратегийн чиглэл, арга хэмжээг тодорхойлох үндсэн зорилготой байна.

**Монгол Улсын ногоон таксономи**

2019 оны 12-р сарын 17-ны өдөр Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан А/302/601/264/62 тоот тушаалаар олон улсад мөрдөгдөж буй Ногоон эдийн засгийн нийтлэг зарчим, шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлэх зорилгын хүрээнд "Ногоон таксономи"-г баталсан байна.

Ногоон таксономийг Монгол Улсын ногоон таксономийн 1.1-т "Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, тодорхойлолт, шалгуур үзүүлэлт" гэж тодорхойлсон байх бөгөөд Ногоон таксономи нь банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид ногоон зээл, ногоон хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлохдоо ашиглах аль нэг салбараар хязгаарлагдахгүй, бизнесийн бүхий л салбарыг хамаарах шалгуур үзүүлэлт гэж тэмдэглэжээ.

Түүнчлэн 1.2-т Ногоон таксономийг тодорхойлж, ашиглах нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөг нөлөөг бууруулах, бохирдлоос хамгаалах, байгалийн нөөцийн зүй зохистой ашиглалтыг дэмжих, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зэрэгт чиглэсэн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ногоон санхүүжилтийн үйл ажиллагааны тодорхойлолт, жагсаалтыг гаргаж, суурь шаардлага тавих зорилготой гэж тэмдэглэжээ. Үүний хүрээнд ногоон таксономи нь дараах зорилтуудтай байна:

СЗХ
2024.07.05
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

- Бодлого боловсруулагч нарт болон санхүүгийн байгууллагууд, бизнес эрхлэгч, бусад гол оролцогчдод ногоон санхүүжилтийн төслүүд, бизнесийн үйл ажиллагааг тодорхойлох болон хөгжүүлэхтэй холбоотой нийтлэг ойлголт, аргачлалыг өгөх;
- Ногоон санхүүжилтийн төслүүдийг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх хүсэлтэй хөрөнгө оруулагчдад итгэл, үнэмшил баталгаа өгөх, "ногоон", "байгаль орчинд ээлтэй" хэмээх тодотголтой хуурамч төслүүд бий болох эрсдэлийг бууруулах;
- Хувийн хэвшил, олон улсын санхүүгийн байгууллагууд, гадаадын хөрөнгө оруулагчид болон бусад эх үүсвэрүүдийг ашиглан ногоон санхүүжилтийн дотогшлох урсгалыг нэмэгдүүлэх;
- Ногоон төслүүдийг санхүүжүүлж буй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүртгэх, Монгол Улсын ногоон хөгжил болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлого, зорилтуудын хэрэгжилтийг үнэлэх;
- Ногоон санхүүжилттэй холбоотой бизнесийн боломжууд, зах зээлийн хөгжлийг хурдасгахад чиглэсэн ногоон санхүүжилтийн үндэсний бодлого, зохицуулалтыг сайжруулах болно.

Ногоон таксономи буюу ногоон төслийн тодорхойлолт, ангиллыг хэрэглээний зээл, байгууллагын санхүүжилт, төслийн санхүүжилт, жижиг дунд бизнесийн санхүүжилт, ногоон бонд, хувьцаа, даатгал, зээлийн баталгаа, тусламж, санхүүгийн зөвлөгөө өгөх болон техникийн туслах үйлчилгээ зэрэг олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэгслүүдэд суурь үзүүлэлт, тавих шаардлага болгон ашиглах боломжтой. Доорх хүснэгтэд ногоон таксономийг ашиглах зах зээлийн оролцогчид болон тэдний ашиглах зориулалтуудыг харуулав.

**Хүснэгт 35: Ногоон таксономи баримт бичгийг ашиглах зах зээлийн оролцогчид болон тэдгээрийн зорилт**

| Чиглэл | Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн |
|---|---|
| **Санхүүгийн байгууллагууд** | • Ногоон санхүүжилтийн стратеги, бодлого боловсруулах,<br>• Ногоон санхүүжилт хийх эсвэл татах боломжит төслүүд, бизнесийн үйл ажиллагааг тодорхойлж, судлах, хөрвүүлэх,<br>• Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүний шалгуурыг боловсруулах,<br>• Зээлийн багц дахь ногоон санхүүжилтийн урсгалыг хэмжих, тайлагнах,<br>• Харилцагч, гол оролцогч талуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сургах зэрэгт ашиглах |
| **Бонд гаргагч байгууллагууд** | • Ногоон бондоор санхүүжүүлэх төсөл, бизнесийн үйл ажиллагааны холбогдох шалгуурыг боловсруулах,<br>• Бонд гарган бүрдүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх төслүүдийг тодорхойлох, үнэлэх,<br>• Бондын үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалтыг хянах,<br>• Хөрөнгийн хуваарилалтыг тайлагнах зэрэгташиглах |
| **Салбарууд** | • Байгууллага, компанийн үйл ажиллагааны стратегид "ногоон" элементийг оруулах,<br>• Ногоон технологитой холбоотой сонголтуудыг үнэлэх, харьцуулах, шийдвэр гаргах,<br>• Ногоон төслүүд, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх,<br>• Ногоон санхүүжилтийн төслүүдийн техникийн болон үр дүнгийн шаардлагуудыг илүү ойлгох, тодорхойлох зэрэгтэй холбоотой үйл ажиллагаанд зааварчилгаа байдлаар ашиглах<br>• Харилцагч, гол оролцогч талуудын мэдлэгойлголтыг нэмэгдүүлэх, сургах зэрэгт ашиглах |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES
5251494



5147204 ХАК0303
ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.07.05 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-05 БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| **Баталгаажуулалтын байгууллагууд** | • Ногоон бонд гаргахын өмнөх болон гаргасны дараах үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх, суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох,<br>• Ногоон төслүүдийг гэрчилгээжүүлэх,<br>• Ногоон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг тодорхойлж патент олгох,<br>• Хөрөнгийн ашиглалтыг хянах зэрэг үйл ажиллагаанд мөн ашиглах |
| **Бодлого боловсруулагчид** | • Ногоон таксономийг холбогдох стандартууд, гэрчилгээ, урамшууллын механизмууд, мөн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн өөрчлөлт зэргийг агуулсан ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын чиглэлийг тодорхойлж, хөгжүүлэхэд ашиглана. |

*Эх сурвалж: Монгол Улсын ногоон таксономи, 2019 оны 12 сар.*

Ногоон таксономийг боловсруулахад 6 үндсэн зарчим баримтласан ба эдгээр нь:

- Зарчим 1: Үндэсний бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах
- Зарчим 2: Байгаль орчинд тулгарч буй бэрхшээл, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх
- Зарчим 3: Байгаль орчинд хог хаягдал, бохирдол ихээр ялгаруулдаг эдийн засгийн гол салбаруудын үйл ажиллагааг хамарсан байх
- Зарчим 4: Олон улсын холбогдох стандартууд болон сайн туршлагуудтай нийцсэн байх
- Зарчим 5: Байгаль орчин, нийгэм болон сайн засаглалын холбогдох стандартуудыг хангасан байх
- Зарчим 6: Байнга хянан сайжруулж байх гэсэн зарчмууд болно.

Дээрх зарчмууд дээр үндэслэн боловсруулсан ногоон таксономийн 8 ангилал болон холбогдох зорилтуудыг дараах хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 36: Монгол Улсын ногоон таксономийн 8 чиглэл**

| № | Ангилал | Холбогдох бодлого, зорилтууд |
|---|---|---|
| 1 | Сэргээгдэх эрчим хүч | ▪ Эрчим хүчний салбар дахь хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2030 он гэхэд 20 хувиар бууруулах; |
| 2 | Бохирдол багатай эрчим хүч | ▪ Нийт эрчим хүч үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 2014 онд 7.62 хувь байсныг 2020 онд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд тус тус хүргэх; |
| 3 | Эрчим хүчний хэмнэлт | ▪ Дулааны цахилгаан станцын үйлдвэрийн дотоодын цахилгааны хэрэглээг (үйлдвэрийн цахилгаан хэмнэлт) 2014 онд 14.4 хувь байсныг 2020 онд 11.2 хувь, 2030 он гэхэд 9.14 хувьд тус тус хүргэх;<br>▪ Цахилгаан дамжуулах шугам сүлжээний цахилгаан алдагдлыг 2014 онд 13.7 хувь байсныг 2020 онд 10.8 хувь, 2030 он гэхэд 7.8 хувьд тус тус хүргэх;<br>▪ Зорилтот аж ахуйн нэгжүүдийн эрчим хүчний хэмнэлтийг 15 хувиар сайжруулах (1-р үе шат) |
| 4 | Ногоон барилга | ▪ Барилгын дулаан алдагдлыг 2014 оны түвшинтэй харьцуулахад 2020 онд 20 хувь, 2030 он гэхэд 40 хувьд хүртэл тус тус бууруулах;<br>▪ Улаанбаатар хотын орон сууцны угсармал 18,184 айл өрхийн байрны дулаалгыг сайжруулах;<br>▪ Хотын нийт барилга байгууламжид ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн эзлэх хувийг 25 хувьд хүргэх. |
| 5 | Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа | ▪ Бохирдол: Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийг 80 хувиар бууруулах, боловсруулаагүй түүхий нүүрсний хэрэглээг цахилгаан станцад хэрэглэхээс бусад зориулалтаар ашиглахыг хориглох, агаарын болон байгаль орчны бохирдлыг 2025 он гэхэд доод тал нь 50 хувиар бууруулах;<br>▪ Хог хаягдал: Газарт булагдаж буй хатуу хог хаягдлын хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 он гэхэд 40 хувьдхүртэл бууруулж, хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагааны менежментийг сайжруулан, |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИЙЗ ҮЦК TDB SECURITIES

| | | |
|---|---|---|
| | | ▪ дахин боловсруулах үйл ажиллагааг нэмэгдүүлэх, мөн нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих. Нийт хог хаягдал дотор дахин боловсруулсан хаягдлын хэмжээг 30 хувь хүртэл өсгөх |
| 6 | Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ | ▪ Хүн амын 90-ээс доошгүй хувьд нь ундны цэвэр ус хэрэглэх боломжийг бий болгох;<br>▪ Гадаргын усны нөөц болон гол мөрний ай сав газруудын байгалийн унаган эко системийг хамгаалах замаар усны нөөцийг хадгалах;<br>▪ Усны нөөц, гол мөрөн болон усны эх үүсвэрүүдийн 50-иас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, Улаанбаатар хот болон аж үйлдвэрүүд, мөн говийн бүсэд усны тогтвортой нийлүүлэлтийг бий болгох шийдлийг боловсруулах. |
| 7 | Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал | ▪ Бэлчээр: Бэлчээрийн даац, хүчин чадалд тохирсон хэмжээнд мал сүргийн тоо толгойг хадгалан, бэлчээрийн тогтвортой менежментийн арга туршлагыг нэвтрүүлэх<br>▪ Малчид, малчдын бүлэг, мөн жижиг дунд фермерүүдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих<br>▪ Хөдөө аж ахуй: Тогтвортой хөдөө аж ахуй, ногоон технологид суурилсан экспортыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх, улмаар арьс шир, ноос ноолуур зэрэг түүхий эд материалын ногоон технологид суурилсан боловсруулалтыг 2020 онд 60 хувь, 2030 он гэхэд 80 хувь хүртэл тус тус нэмэгдүүлэх<br>▪ Газар тариалангаас үүдэлтэй хөрсний доройтлыг бууруулах, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, хөрс арчлах агро техник болон усжуулах дэвшилтэт технологийг ашиглан, ойн бүсийг бий болгох замаар дотоодын буудай, төмс, хүнсний ногооны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх<br>▪ Ой: Ойг устгах үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаралтыг 2020 онд 2 хувь, 2030 он гэхэд 5 хувь хүртэл тус тус бууруулах<br>▪ Бэлчээрийн менежмент: Хөрсний доройтолд орсон газар нутгийн 70 хувийг сэргээхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, нийт газар нутгийн 30 хувийг 2030 он гэхэд төрийн хамгаалалтад авах<br>▪ Эко-аялал жуулчлал: Эко-аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгон хөгжүүлэх, Монголын нүүдэлчин соёл зан заншлыг олон улсад сурталчлах, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэх, жилдээ гадаадын 2.0 сая жуулчин хүлээн авдаг болох |
| 8 | Карбон бага тээвэр | ▪ Хосолсон хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 2014 онд 6.5 хувь байсныг 2030 он гэхэд 13 хувьд хүргэж нэмэгдүүлэх<br>▪ Холбогдох татвар, байгаль орчны төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд зорчих тээврийн хэрэгслийн түлшийг шингэн түлшнээс байгалийн хий рүү шилжүүлэх<br>▪ Байгаль орчинд ээлтэй олон нийтийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх (жишээ нь BRT)<br>▪ Байгаль орчин, хүний эрүүл мэнд, биологийн төрөл зүйлд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй тээврийн сүлжээ болон дэд бүтцийг хөгжүүлэх |

**Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн зарчмууд**

Монгол Улсын банкнуудын үйл ажиллагаа явуулж, бизнесийн шийдвэр гаргахад байгаль орчин, нийгмийн асуудлыг харгалзан авч үзэх удирдамж болох зарчмуудыг боловсруулж, хэрэгжүүлэхээр ОУСК-ын санхүүжилттэйгээр Монголын Банкны Холбооноос 2014 онд Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг баталсан байна.

Тус баримт бичигт Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн 8 зарчмыг тодорхойлсон байх ба зарчим бүрд хэрэгжүүлэх арга зам, сайн туршлагууд болон хэрэгжүүлэхэд холбоотой хийгдэх ажлуудыг нарийвчлан заасан байна.

СЗХ 2024 он 07 сар 05 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES
ТЖТБ ХХК УЛААНБААТАР ХОТ

**Хүснэгт 37: Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн зарчмууд**

| № | Зарчим | Зорилго |
|---|---|---|
| 1 | Байгаль орчноо хамгаалах | Бид хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй, шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана. |
| 2 | Хүний эрх, нийгмийг хамгаалах | Бид хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөнө. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллана. |
| 3 | Соёлын өвийг хамгаалах | Бид Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн соёл, түүх, археологи, палентологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалан ажиллана. |
| 4 | "Ногоон эдийн засаг"–ийн өсөлтийг дэмжих | Бид Монгол Улсын ногоон, цэвэр эдийн засагт хувь нэмэр оруулах төсөл болон бусад үйл ажиллагааг дэмжин ажиллана. |
| 5 | Санхүүгийн хүртээмжийг дэмжих | Бид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, санхүүгийн боловсрол олгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээг авах замаар Монгол Улсад санхүүгийн өргөн хүрээтэй тогтолцоог бий болгохыг дэмжин ажиллана. |
| 6 | Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих | Бид хориглосон жагсаалтад багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, бид ёс суртахуунгүй, гэмт хэргийн шинж чанартай үйлдлийг үл тэвчих бодлого явуулж, ёс зүйтэй байх, компанийн засаглалтай холбоотой сайн туршлагуудыг дэмжих бодлого баримтлан ажиллана. |
| 7 | Ил тод байдал, хариуцлагыг дэмжих | Бид ил тод байдал, хариуцлагыг дэмжин, банкны Тогтвортой санхүүжилт (ToC)-ийн үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах явдлыг дэмжин ажиллана. |
| 8 | Манлайлан үлгэрлэх | Бид харилцагчдадаа тавьж буй шаардлагыг өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, салбарын хувьд Монгол Улсыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд зэрэг хөгжилд чиглүүлэн ажиллана |

## 2.7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.7.1. АУДИТЫН ДҮГНЭЛТ

“Пи Кэй Эф Монголиа Аудит” ХХК нь Үнэт цаас гаргагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн тайлан болон 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон завсар үеийн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогод Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, дүгнэлт гаргасан байна.

Тус хөндлөнгийн аудитын дүгнэлтээр Үнэт цаас гаргагчийн 2023 оны 9-р сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэт зөв, бодитойгоор илэрхийлэгдсэн байна гэж дүгнэжээ.

### 2.7.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОРЛОГЫН ТАЙЛАН

#### 2.7.2.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ТҮҮХЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үнэт цаас гаргагчийн 2020-2022 оны жилийн эцэс болон 2023 оны 3 дугаар улирлаар дуусгавар болгосон аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлан нь дараах байдалтай байна.

**Хүснэгт 38: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн түүхэн үзүүлэлт, сая төгрөг**

| Үзүүлэлт, сая төгрөг | 2020 | 2021 | 2022 | 2023 III |
|---|---|---|---|---|
| Борлуулалтын орлого /цэвэр/ | - | 3,994.6 | 7,396.1 | 6,464.2 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | - | (3,624.9) | (6,615.2) | (5,590.5) |
| **Нийт ашиг** | **-** | **369.7** | **780.9** | **873.7** |
| Хүүгийн орлого | - | - | - | 0.0 |
| Борлуулалт маркетингийн зардал | - | - | (0.1) | - |
| Ерөнхий ба удирдлагын зардал | (30.5) | (165.5) | (726.9) | (1,065.9) |
| Бусад зардал | - | (1.2) | (0.3) | (2.6) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз (гарз) | - | - | (25.1) | (0.0) |
| Бусад ашиг (алдагдал) | - | - | - | (98.0) |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(30.5)** | **203.0** | **28.6** | **(292.8)** |
| Орлогын татварын зардал | - | (20.5) | (2.8) | (0.0) |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **(30.5)** | **182.5** | **25.9** | **(292.8)** |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - | - | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **(30.5)** | **182.5** | **25.9** | **(292.8)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - |
| **Орлогын нийт дүн** | **(30.5)** | **182.5** | **25.9** | **(292.8)** |

СЗХ
2024.07.05
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03

**Борлуулалтын орлого**

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого нь rPET мөхлөг борлуулалт, бөглөөний бэлдцийн борлуулалт, бөглөөний борлуулалт болон хангамжийн материалын борлуулалтын орлогоос тус тус бүрддэг.

2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 4.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан ба үүний 97.8 хувь буюу 3.9 тэрбум төгрөг нь rPET мөхлөг борлуулалтын орлого, үлдсэн 2.2 хувь буюу 0.1 тэрбум төгрөгийн орлого нь бөглөө, бөглөөний бэлдэц болон хангамжийн материалын борлуулалт тус тус бүрдүүлж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 85.2 хувиар өсөж, 7.4 тэрбум төгрөгт хүрчээ. Борлуулалтын орлогыг бүтцийн хувьд авч үзвэл 7.3 тэрбум төгрөг буюу 99.1 хувийг rPET мөхлөгийн борлуулалт бүрдүүлсэн бол бөглөөний бэлдцийн борлуулалт 58.0 сая төгрөг буюу 0.8 хувь, бөглөөний болон хангамжийн материалын борлуулалт 9.4 сая төгрөг буюу 0.1 хувийг тус тус бүрдүүлсэн байна.

**Зураг 50: Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого, түүний бүтэц, тэрбум төгрөг, 2021-2023.III**




Харин 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын хэмжээ 6.5 тэрбум төгрөг хүрсэн бөгөөд үүний 6.4 тэрбум төгрөг буюу 99.5 хувийг rPET мөхлөгийн борлуулалт эзэлж байгаа бол үлдсэн 29.2 сая төгрөг буюу 0.5 хувийг бөглөөний бэлдцийн борлуулалт тус тус бүрдүүлсэн байна.

**Борлуулсан бүтээгдэхүүний өртөг**

Үнэт цаас гаргагчийн борлуулсан бүтээгдэхүүний өртөгт Компанийн борлуулж буй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд гарсан шууд материалын зардал, шууд хөдөлмөрийн зардал, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал болон үйлдвэрлэлд шууд хамаарах зардлыг бүртгэдэг.

2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг 3.6 тэрбум төгрөгтэй тэнцсэн ба үүний 97.8 хувь буюу 3.5 тэрбум төгрөгийн өртөг нь борлуулсан rPET мөхлөгийн өртөг, үлдсэн 2.2 хувь буюу 0.1 тэрбум төгрөгийн өртөг нь борлуулсан бөглөө, бөглөөний бэлдцийн өртөг тус тус бүрдүүлжээ.

2022 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт борлуулсан бүтээгдэхүүний өртөг өмнөх оны мөн үеэс 82.5 хувь буюу 3.0 тэрбум төгрөгөөр өсөж, 6.6 тэрбум төгрөгтэй тэнцсэн байна. Тус онд Компанийн нийт борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 99.3 хувь буюу 6.6 тэрбум төгрөгийг rPET мөхлөг борлуулалтын өртөг, үлдсэн 0.7 хувийг бөглөө, бөглөөний бэлдэц, хангамжийн материалын борлуулалтын өртөг тус тус бүрдүүлж байна.

TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

Зураг 51: Үнэт цаас гаргагчийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг, түүний бүтэц, тэрбум төгрөг, 2021-2023.III




Харин 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг 5.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 99.8 хувийг борлуулсан rPET мөхлөгийн өртөг, үлдсэн 0.2 хувийг борлуулсан бөглөөний бэлдцийн өртөг тус тус бүрдүүлж байна.

### Нийт ашиг

2021 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь 3.6 тэрбум төгрөгийн өртөгтэй бүтээгдэхүүнийг борлуулж, 4.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласнаар Компанийн нийт ашиг 369.7 сая төгрөгт хүрч, нийт ашгийн ахиуц 9.3 хувьтай тэнцсэн үзүүлэлттэй байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь 6.6 тэрбум төгрөгийн өртөгтэй бүтээгдэхүүний борлуулж, 7.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласнаар Компанийн нийт ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өсөж 780.9 сая төгрөгт хүрч, нийт ашгийн ахиуц 10.6 хувьтай тэнцжээ. Тус хугацаанд Компанийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон борлуулалтын орлогын харьцаа нь өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурч, 89.6 хувьтай тэнцэж байгаа нь нэгж бүтээгдэхүүнийг зарах дундаж үнэ нэмэгдсэнээс шалтгаалан борлуулалтын орлогын хэмжээ өссөнтэй холбоотой байна.

Зураг 52: Үнэт цаас гаргагчийн нийт ашиг, тэрбум төгрөг, 2021-2023.III




Үнэт цаас гаргагч нь 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 5.6 тэрбум төгрөгийн өртөгтэй бүтээгдэхүүнийг борлуулж, 6.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласнаар Компанийн нийт ашгийн хэмжээ 873.7 сая төгрөгт хүрч, нийт ашгийн ахиуц 13.5 хувьтай тэнцсэн үзүүлэлттэй байна.

СЭХ
2024 он 07 сар 05 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03

**Бусад орлого болон зардал**

Үнэт цаас гаргагчийн бусад зардалд алданги, хүү торгуулийн зардал болон хандив, тусламжийн зардал багтах бөгөөд 2021 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь 1.2 сая төгрөгийг хандив, тусламжийн зардалд төлсөн бол 2022 онд 0.3 сая төгрөгийг хандив, тусламжийн зардалд тус тус төлжээ.

Харин 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагч нь 1.1 сая төгрөгийг алданги, хүү торгуулийн зардалд, 1.5 сая төгрөгийг хандив, тусламжийн зардалд тус тус төлж, Үнэт цаас гаргагчийн нийт бусад зардал 2.6 сая төгрөгтэй тэнцсэн байна. Мөн 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагч нь 49.0 мянган төгрөгийн хүүгийн орлого олжээ.

**Зураг 53: Үнэт цаас гаргагчийн бусад зардал, түүний бүтэц, сая төгрөг, 2021-2023.III**




**Борлуулалт, маркетингийн зардал**

Үнэт цаас гаргагч нь 2022 онд борлуулалт маркетингийн зардалд 55.0 мянган төгрөгийг төлсөн бол бусад тайлант хугацаанд Компанид борлуулалт, маркетингийн зардал гараагүй байна.

**Ерөнхий ба удирдлагын зардал**

2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн ерөнхий ба удирдлагын зардал 165.5 сая төгрөгтэй тэнцсэн үзүүлэлттэй байна. Тус тайлант хугацаанд ерөнхий ба удирдлагын зардлын 60.4 хувь буюу 99.9 сая төгрөгийг үндсэн ба нэмэгдэл цалингийн зардал, 8.8 хувь буюу 14.5 сая төгрөгийг мэргэжлийн үйлчилгээний зардал, 8.1 хувь буюу 13.3 сая төгрөгийг ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал, үлдсэн 22.8 хувь буюу 37.7 сая төгрөгийн бусад зардал тус тус бүрдүүлж байна.

Харин 2022 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн ерөнхий ба удирдлагын зардал өмнөх оны мөн үеэс 4.4 дахин нэмэгдэж 726.9 сая төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Тус тайлант хугацаанд ерөнхий ба удирдлагын зардлын өсөлтөд үндсэн ба нэмэгдэл цалингийн зардлын 279.1 хувийн өсөлт нь голлон нөлөөлжээ. Зардлын бүтцийн хувьд ерөнхий ба удирдлагын зардлын 77.3 хувь буюу 561.7 сая төгрөгийг үндсэн ба нэмэгдэл цалингийн зардалд, 10.4 хувь буюу 75.3 сая төгрөгийг ААН-ээс төлсөн НДШ-ийн зардалд, 4.5 хувь буюу 33.1 сая төгрөгийг элэгдэл хорогдлын зардалд, 3.8 хувь буюу 27.8 сая төгрөгийг мэргэжлийн үйлчилгээний зардалд, үлдсэн 4.0 хувь буюу 29.0 сая төгрөгийг бусад зардалд тус тус төлсөн байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2024.07.05 он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Зураг 54: Үнэт цаас гаргагчийн ерөнхий ба удирдлагын зардал болон түүний бүтэц, эзлэх хувь, сая төгрөг, 2021-2023.III**




2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагч нь 1.1 тэрбум төгрөгийг ерөнхий удирдлагын зардалд төлсөн байх ба тус зардлын 61.9 хувь буюу 659.7 сая төгрөгийг үндсэн ба нэмэгдэл цалингийн зардалд, 9.2 хувь буюу 98.0 сая төгрөгийг элэгдэл хорогдлын зардалд, 8.3 хувь буюу 88.7 сая төгрөгийг ААН-ээс төлсөн НДШ-ийн зардалд, 5.0 хувь буюу 53.8 сая төгрөгийг мэргэжлийн үйлчилгээний зардалд, үлдсэн 15.5 хувь буюу 165.6 сая төгрөгийг бусад зардалд тус тус төлсөн байна.

**Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз**

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хийсэн гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз 25.1 сая төгрөгтэй тэнцэж байгаа бол 2023 оны 3 дугаар улиралд Компанид 37.6 мянган төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз үүссэн байна.

**Бусад ашиг (алдагдал)**

Үнэт цаас гаргагч нь үндсэн хөрөнгийн бодит үнэ цэний үнэлгээг 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар хийлгэсэн бөгөөд үнэлгээний үр дүнд 2023 оны 3 дугаар улиралд Компанид 98.0 сая төгрөгийг хөрөнгийн үнэ цэний бууралтын гарз үүсэж, бусад ашиг (алдагдал) дансанд бүртгэгдсэн байна.

**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**

2021 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь 203.0 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажилласан бол 2022 оны байдлаар Компанийн татвар төлөхийн өмнөх ашиг өмнөх оны мөн үеэс 85.9 хувиар буурч 28.6 сая төгрөгт хүрсэн нь тус тайлант хугацаанд Компанийн үйл ажиллагааны зардлын 4.4 дахин өсөлт голлон нөлөөлжээ.

2023 оны 3-р улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн татвар төлөхийн өмнөх алдагдал 292.8 сая төгрөгтэй тэнцсэн бөгөөд тус алдагдал нь Компанийн ерөнхий ба удирдлагын зардлын өсөлт болон хөрөнгийн үнэ цэний бууралттай холбоотой байна.

**Орлогын татварын зардал**

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын багц хуулиудыг үйл ажиллагаандаа дагаж мөрддөг бөгөөд 2021 оны тайлант жилд Компани нь 20.5 сая төгрөгийн татварын зардалтай ажиллаж, үр ашигт татварын хувь буюу орлогын албан татварын зардлын татварын өмнөх ашигт эзлэх хувь хэмжээ 10.1 хувьтай тэнцэж байна.

Мөн 2023 оны тайлант жилд Үнэт цаас гаргагч нь 2.8 сая төгрөгийн татварын зардалтай ажиллаж, Компанийн үр ашигт татварын хувь 0.4 хувьтай тэнцсэн үзүүлэлттэй байна.

TDB SECURITIES

СЗХ
2024 .07 сар 05 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2024 -06- 03
БҮРТГЭВ-02

2023 оны 3 дугаар улиралд Үнэт цаас гаргагч нь 4,904.5 төгрөгийг хүүгийн орлогын албан татварын зардалтай ажиллажээ.

**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**

2021 оны тайлант жилд Үнэт цаас гаргагч нь 182.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, цэвэр ашгийн ахиуц 4.6 хувьтай тэнцсэн үзүүлэлттэй байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 85.8 хувиар буурч, 25.9 сая төгрөгт хүрч, цэвэр ашгийн ахиуц 0.3 хувьтай тэнцжээ.

**Зураг 55: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн голлох үзүүлэлтүүд, сая төгрөг, 2021-2023.III**




Харин 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагч нь 292.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Энэ нь тус тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардал өссөн, мөн Үнэт цаас гаргагч нь үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжид хүнсний зориулалттай rPET мөхлөг үйлдвэрлэх нэмэлт тоног төхөөрөмж суурилуулсантай холбоотой Компани сул зогсолт хийсэн нь алдагдалтай ажиллах шалтгаан болсон байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.07.05 өдөр
БҮРТГЭВ №01

## 2.7.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-08-03
БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагчийн 2020-2022 оны жилийн эцэс болон 2023 оны 3 дугаар улирлын байдлаарх аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан дараах байдалтай байна.

**Хүснэгт 39: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлангийн түүхэн үзүүлэлт, сая төгрөг**

| Үзүүлэлт, сая төгрөг | 2020 | 2021 | 2022 | 2023 III |
|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 10.0 | 14.7 | 56.0 | 10.7 |
| Татвар, НДШ -ийн авлага | 0.0 | - | - | 139.5 |
| Бусад авлага | - | 118.7 | 630.9 | 606.8 |
| Бараа материал | - | 745.5 | 1,478.1 | 4,863.6 |
| Урьдчилж төлсөн зардал / тооцоо | 17.2 | 311.8 | 270.9 | 3,287.6 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **27.2** | **1,190.7** | **2,436.0** | **8,908.3** |
| | | | | |
| Үндсэн хөрөнгө | 219.8 | 2,740.1 | 3,579.0 | 50,301.5 |
| Биет бус хөрөнгө | - | 219.8 | 226.9 | 2,006.0 |
| Дуусаагүй барилга | - | 102.0 | - | - |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - | 2.5 | 2.5 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **219.8** | **3,062.0** | **3,808.4** | **52,310.0** |
| | | | | |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **247.0** | **4,252.6** | **6,244.4** | **61,218.3** |
| | | | | |
| Дансны өглөг | 267.6 | 26.5 | 72.9 | 67.8 |
| Цалингийн өглөг | - | - | - | 106.9 |
| Татвар хураамжийн өр төлбөр | - | 81.1 | 196.2 | 41.6 |
| НДШ-ийн өр төлбөр | - | 33.7 | 83.5 | 49.6 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | - | 3,949.3 | 5,703.9 | 43,810.8 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **267.6** | **4,090.6** | **6,056.6** | **44,076.6** |
| | | | | |
| Урт хугацаат өр төлбөр | - | - | - | - |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **-** | **-** | **-** |
| | | | | |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **267.6** | **4,090.6** | **6,056.6** | **44,076.6** |
| | | | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 |
| *Төрийн* | - | - | - | - |
| *Хувийн* | *10.0* | *10.0* | *10.0* | *10.0* |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | - | - | - | 17,246.6 |
| Хуримтлагдсан ашиг | (30.5) | 152.0 | 177.8 | (115.0) |
| **Эздийн өмчийн нийт дүн** | **(20.5)** | **162.0** | **187.8** | **17,141.7** |
| | | | | |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **247.0** | **4,252.6** | **6,244.4** | **61,218.3** |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИЕС ҮЦК ХХК
TDB SECURITIES

СЗХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

### 2.7.3.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ТҮҮХЭН ҮЗҮҮЛЭЛТ

#### НИЙТ ХӨРӨНГӨ

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2020-2022 онд жилд дунджаар 402.8 хувиар өсөж 6.2 тэрбум төгрөгт хүрчээ. Тус тайлант хугацаанд Компанийн нийт хөрөнгийн 39.0 хувь буюу 2.4 тэрбум төгрөгийг эргэлтийн хөрөнгө, үлдсэн 61.0 хувь буюу 3.8 тэрбум төгрөгийг эргэлтийн бус хөрөнгө тус тус бүрдүүлж байна.

**Зураг 56: Нийт хөрөнгө болон түүний бүтэц, тэрбум төгрөг, 2020-2023.III**




2023 оны 3 дугаар улиралд Үнэт цаас гаргагч нь үндсэн хөрөнгийн бодит үнэ цэний үнэлгээг хийлгэж, Компанийн үндсэн болон биет бус хөрөнгийн бодит үнэ цэн 52.3 тэрбум төгрөгтэй тэнцжээ. Ингэснээр Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2023 оны 3 дугаар улирал 61.2 тэрбум төгрөгт хүрсэн ба үүний 14.6 хувь буюу 8.9 тэрбум төгрөгийг эргэлтийн хөрөнгө, үлдсэн 85.4 хувь буюу 52.3 тэрбум төгрөгийг эргэлтийн бус хөрөнгө тус тус бүрдүүлж байна.

#### Эргэлтийн хөрөнгө

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгө 2020-2022 онд жилд дунджаар 846.4 хувиар, өмнөх оны мөн үеэс 104.6 хувиар тус тус өсөж, 2.4 тэрбум төгрөгтэй тэнцсэн үзүүлэлттэй байна. Эргэлтийн хөрөнгийн өсөлтөд бараа материал болон бусад авлагын харгалзан тус бүр 2.0 болон 5.3 дахин өсөлт нь голлон нөлөөлсөн байна. Эргэлтийн хөрөнгийг бүтцийн хувьд авч үзвэл 60.7 хувь буюу 1.5 тэрбум төгрөгийг бараа материал, 25.9 хувь буюу 0.6 тэрбум төгрөгийг бусад авлага, 11.1 хувь буюу 0.3 тэрбум төгрөгийг урьдчилж төлсөн зардал, тооцоо, үлдсэн 1.2 хувь буюу 56.0 сая төгрөгийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө тус тус бүрдүүлж байна.

**Зураг 57: Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгө болон түүний бүтэц, эзлэх хувь, сая төгрөг,2 2021-2023.III**




ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгө 8.9 тэрбум төгрөгт хүрсэн нь 2022 оны жилийн эцсийн үзүүлэлтээс 3.7 дахин өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд бараа материалын 3.3 дахин өсөлт, урьдчилж төлсөн зардал, тооцооны 12.1 дахин өсөлт голлон нөлөөлсөн байна. Тус тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгийн 54.6 хувь буюу 4.9 тэрбум төгрөгийг бараа материал, 36.9 хувь буюу 3.3 тэрбум төгрөгийг урьдчилж төлсөн зардал, тооцоо, 6.8 хувь буюу 0.6 тэрбум төгрөгийг бусад авлага, 1.6 хувь буюу 0.1 тэрбум төгрөгийг татвар, НДШ-ийн авлага, үлдсэн 0.1 хувь буюу 10.7 сая төгрөгийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө тус тус бүрдүүлж байна.

**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Үнэт цаас гаргагчийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 2020-2022 оны байдлаар жилд дунджаар 136.7 хувиар өсөж, 56.0 сая төгрөгт хүрсэн байна. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Компанийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 10.7 сая төгрөгтэй тэнцэж, өмнөх оны жилийн эцсийн үлдэгдлээс 45.3 сая төгрөгөөр буурсан нь үндсэн үйл ажиллагааны мөнгөн зардал ихээхэн гарсантай холбоотой байна.

**Бараа материал**

Үнэт цаас гаргагчийн бараа материал дансанд түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн буюу rPET мөхлөг, хагас боловсруулсан бүтээгдэхүүн буюу хуванцрын хэрчдэс, сав баглаа боодол, хангамжийн материал, хүнсний материал, бичиг хэргийн материал, цэвэрлэгээний материал, сэлбэг, хэрэгсэл, нүүрс, химийн бодис болон барилгын материал тус тус багтана.

2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн бараа материалын эцсийн үлдэгдэл 745.5 сая төгрөг байсан бөгөөд үүний 38.5 хувь буюу 287.0 сая төгрөгийг хагас боловсруулсан бүтээгдэхүүн буюу хуванцрын хэрчдэс, 21.8 хувь буюу 162.6 сая төгрөгийг химийн бодис, 19.6 хувь буюу 145.9 сая төгрөгийг сэлбэг, хэрэгсэл, 13.0 хувь буюу 97.3 сая төгрөгийг rPET мөхлөг, үлдсэн 7.1 хувь буюу 52.6 сая төгрөгийг түүхий эд болон бусад бараа материал тус тус бүрдүүлж байна.

2022 оны тайлант жилд Үнэт цаас гаргагчийн бараа материалын үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.0 дахин өсөж, 1.5 тэрбум төгрөгтэй тэнцсэн үзүүлэлттэй байна. Бүтцийн хувьд бараа материалын эцсийн үлдэгдлийн 35.3 хувь буюу 521.1 сая төгрөгийг химийн бодис, 31.0 хувь буюу 458.5 сая төгрөгийг сэлбэг, хэрэгсэл, 11.6 хувь буюу 171.2 сая төгрөгийг түүхий эд материал, 7.3 хувь буюу 108.4 сая төгрөгийг rPET мөхлөг, үлдсэн 14.8 хувь буюу 218.8 сая төгрөгийг хангамжийн болон бусад бараа материал тус тус бүрдүүлж байна.

**Зураг 58: Үнэт цаас гаргагчийн бараа материал болон түүний бүтэц, эзлэх хувь, сая төгрөг, 2021-2023.III**




2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн бараа материалын эцсийн үлдэгдэл өмнөх оны жилийн эцсээс 3.3 дахин өсөж, 4.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тус тайлант хугацаа дахь бараа

материалын үлдэгдлийн 59.3 хувь буюу 2.9 тэрбум төгрөгийг хагас боловсруулсан бүтээгдэхүүн буюу хуванцрын хэрчдэс, 23.7 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг химийн бодис, 9.5 хувь буюу 460.8 сая төгрөгийг сэлбэг, хэрэгсэл, үлдсэн 7.5 хувь буюу 363.7 сая төгрөгийг бусад төрлийн бараа материал тус тус бүрдүүлж байна.

**Бусад авлага**

Үнэт цаас гаргагчийн бусад авлага дансанд холбоотой талаас авах авлага, ажиллагсдаас авах авлага, дараа тайлангаарх авлага болон барьцааны авлага тус тус багтана.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн бусад авлагын дүн өмнөх оны мөн үеэс 5.3 дахин өсөж, 630.9 сая төгрөгт хүрсэн бөгөөд үүний 99.0 хувь буюу 624.9 сая төгрөгийг холбоотой талаас авах авлага, үлдсэн 1.0 хувийг ажиллагсдаас авах авлага болон барьцааны авлага тус тус бүрдүүлж байна.

2023 оны 3-р улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн бусад авлагын хэмжээ өмнөх оны жилийн эцсээс 3.8 хувиар буурч, 606.8 сая төгрөгт хүрсэн ба үүний 99.7 хувийг холбоотой талаас авах авлага, үлдсэн 0.3 хувийг ажиллагсдаас авах авлага болон барьцааны авлага тус тус бүрдүүлж байна.

**Урьдчилж төлсөн зардал / тооцоо**

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн урьдчилж төлсөн зардлын хэмжээ 2020-2022 онд жилд дунджаар 297.2 хувиар өссөн бол өмнөх оны мөн үеэс 13.1 хувиар буурч 270.9 сая төгрөгт хүрсэн байна. Тус тайлант хугацаанд Компанийн урьдчилж төлсөн зардал, тооцооны 97.8 хувь буюу 264.9 сая төгрөгийг хойшлогдсон нэмэгдсэн өртгийн татварын авлага, үлдсэн 2.2 хувь буюу 6.1 сая төгрөгийг урьдчилж төлсөн тооцоо тус тус бүрдүүлж байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэл өмнөх оны жилийн эцсээс 12.1 дахин өсөж, 3.3 тэрбум төгрөгт хүрсэн байх ба үүний дийлэнх 99.6 хувийг хойшлогдсон нэмэгдсэн өртгийн татварын авлага, үлдсэн 0.4 хувийг урьдчилж төлсөн тооцоо тус тус бүрдүүлж байна.

**Эргэлтийн бус хөрөнгө**

2020 онд Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгө нь 219.8 сая төгрөгтэй тэнцэж байсан бол 2021 онд Компанийн үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө нэмэгдэж, мөн барилга байгууламж барьж эхэлсэнтэй холбоотой дуусаагүй барилга бүртгэгдсэнээр Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгө 3.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 24.4 хувиар өсөж, 3.8 тэрбум төгрөгт хүрсэн ба тус өсөлтөд машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, биет бус хөрөнгө болон бусад эргэлтийн бус хөрөнгийн өсөлт голлон нөлөөлжээ. Бүтцийн хувьд авч үзвэл тус онд эргэлтийн бус хөрөнгийн 94.0 хувь буюу 3.6 тэрбум төгрөгийг үндсэн хөрөнгө, үлдсэн 6.0 хувийг биет бус хөрөнгө болон хойшлогдсон татварын хөрөнгө тус тус бүрдүүлж байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгө өмнөх оны жилийн эцсээс 13.7 дахин өсөж 52.3 тэрбум төгрөгт хүрсэн нь тус тайлант хугацаанд Үнэт цаас гаргагч нь үндсэн хөрөнгийн бодит үнэ цэний үнэлгээг хийлгэсэнтэй холбоотой Компанийн үндсэн хөрөнгийн үнэлгээ өссөн байна. Бүтцийн хувьд авч үзвэл Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгийн 96.2 хувь буюу 50.3 тэрбум төгрөгийг үндсэн хөрөнгө бүрдүүлж байгаа бол үлдсэн 3.8 хувь буюу 2.0 тэрбум төгрөгийг биет бус хөрөнгө болон хойшлогдсон татварын хөрөнгө тус тус бүрдүүлж байна.

**Зураг 59: Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгө болон түүний бүтэц, эзлэх хувь, тэрбум төгрөг, 2020-2023.III**




**Үндсэн хөрөнгө**

Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгө дансанд барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер бусад хэрэгсэл болон бусад үндсэн хөрөнгө багтдаг байна.

2020 онд Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгө 219.8 сая төгрөгтэй тэнцэж байсан бол 2021 онд үндсэн хөрөнгийн худалдан авалттай холбоотой Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгийн цэвэр дансны үнэ 2.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. 2021 оны байдлаарх Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгийг цэвэр дүнгээр, бүтцийн хувьд авч үзвэл 99.0 хувийг машин, тоног төхөөрөмж, үлдсэн 1.0 хувийг тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер, бусад хэрэгсэл тус тус бүрдүүлж байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгийн цэвэр дүн өмнөх оны мөн үеэс 30.6 хувиар өсөж 3.6 тэрбум төгрөгт хүрсэн ба үүний 85.7 хувь буюу 3.1 тэрбум төгрөгийг машин тоног, төхөөрөмж, 12.2 хувь буюу 0.4 тэрбум төгрөгийг барилга байгууламж, үлдсэн 2.1 хувь буюу 74.0 сая төгрөгийг тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил болон компьютер бусад хэрэгсэл тус тус бүрдүүлж байна.

2023 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь өөрийн нэгдлийн компани болох "Ти Эм Эл" ГХОХХК-аас 38.3 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий тоног төхөөрөмжийг шилжүүлэн авч, 2023 оны 9-р сарын 30-ны өдрийн байдлаарх үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг "Гэрэгэ-Эстимэйт Үнэлгээ" ХХК-аар үнэлүүлж, хөрөнгийн дахин үнэлгээгээр Компанийн нийт хөрөнгө үндсэн 15.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, цэвэр дүнгээр 50.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. "Ти Эм Эл" ГХОХХК-аас шилжүүлэн авсан үндсэн хөрөнгөтэй холбоотой гэрээ, хэлцлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Үнэт цаасны танилцуулгын хавсралт дахь Хуулийн дүгнэлт хэсгээс уншиж танилцана уу.

**Зураг 60: Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгө, цэвэр дүнгээр, тэрбум төгрөг, 2020-2023.III**



СЗХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ

**Биет бус хөрөнгө**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагчийн биет бус хөрөнгөд компьютерын программ хангамж болон газар эзэмших эрх тус тус багтдаг.

2021 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн биет бус хөрөнгө дансанд 219.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий газар эзэмших эрх бүртгэгдсэн байх ба 2022 оны байдлаар Компани нь 7.6 сая төгрөгийн үнийн дүн бүхий компьютер программ хангамж нэмж авснаар Үнэт цаас гаргагчийн биет бус хөрөнгө тус онд цэвэр дүнгээр 226.9 сая төгрөгтэй тэнцжээ.

Үнэт цаас гаргагч нь Сонгинохайрхан дүүрэгт байрлах үйлдвэрлэлийн зориулалттай 19,985 м.кв нэгж талбайг эзэмшдэг ба 2023 оны 9-р сарын 30-ны өдрөөр хөрөнгийн дахин үнэлгээгээр тус эзэмших эрхтэй газар нь 1.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тус тайлант хугацаанд Компанийн нийт биет бус хөрөнгийн цэвэр дүн 2.0 тэрбум төгрөгтэй тэнцсэн байна.

**Хойшлогдсон татварын хөрөнгө**

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн хойшлогдсон татварын хөрөнгө нь гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарзаас шалтгаалан 2.5 сая төгрөгтэй тэнцсэн байна. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар тус үзүүлэлт нь мөн адил 2.5 сая төгрөгтэй тэнцсэн үзүүлэлттэй байна.

**НИЙТ ӨР ТӨЛБӨР**

2020 онд Компани нь өр төлбөргүй ажилласан байгаа бол 2021 оноос 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөрийн 100.0 хувийг богино хугацаат өр төлбөр эзэлж байгаа буюу Компани нь аливаа урт хугацаат өр төлбөргүй байна.

2021 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөр 4.1 тэрбум төгрөгтэй тэнцсэн байх ба үүний 96.5 хувь буюу 3.9 тэрбум төгрөгийг бусад богино хугацаат өр төлбөр, 2.0 хувь буюу 81.1 сая төгрөгийг татвар хураамжийн өр төлбөр, үлдсэн 1.5 хувь буюу 60.2 сая дансны өглөг болон НДШ-ийн өр төлбөр тус тус бүрдүүлж байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөр өмнөх оны мөн үеэс 48.1 хувиар нэмэгдэж 6.1 тэрбум төгрөгт хүрсэн байх ба үүний 94.2 хувь буюу 5.7 тэрбум төгрөгийг бусад богино хугацаат өр төлбөр, 3.2 хувь буюу 196.2 сая төгрөгийг татвар, хураамжийн өр төлбөр, үлдсэн 2.6 хувь буюу 156.4 сая төгрөгийг дансны өглөг болон НДШ-ийн өр төлбөр тус тус бүрдүүлж байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөр өмнөх оны мөн үеэс 7.3 дахин өсөж, 44.1 тэрбум төгрөгт хүрсэн байх ба үүний 99.4 хувь буюу 43.8 тэрбум төгрөгийг бусад богино хугацаат өр төлбөр, үлдсэн 0.6 хувийг дансны өглөг, цалингийн өглөг болон татвар хураамжийн өр төлбөр тус тус бүрдүүлж байна. Тус тайлант хугацаанд өр төлбөрийн 7.3 дахин өсөлтөд холбоотой талын өглөгийн 7.7 дахин өсөлт голлон нөлөөлсөн байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



УЛААНБААТАР ХОТ

**Зураг 61: Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөр, тэрбум төгрөг, 2021-2023.III**




### Дансны өглөг

2020-2021 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн дансны өглөг жилд дунджаар 47.8 хувиар буурч 72.9 сая төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн дансны өглөг өмнөх оны жилийн эцсээс 7.0 хувиар буурч 67.8 сая төгрөгтэй тэнцэж байгаа нь Компанийн нийт өр төлбөрийн 0.2 хувийг бүрдүүлж байна.

### Цалингийн өглөг

2020-2022 онуудад Үнэт цаас гаргагч нь өр төлбөрт цалингийн өглөг бүртгэгдээгүй байх ба 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Компанийн цалингийн өглөг 106.9 сая төгрөгт хүрсэн нь нийт өр төлбөрийн 0.2 хувийг бүрдүүлж байна.

### Татвар хураамжийн өр төлбөр

Үнэт цаас гаргагчийн татвар хураамжийн өр төлбөрт ААНОАТ-ын өглөг, НӨАТ-ын өглөг болон цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын өглөг тус тус бүрдүүлдэг.

Үнэт цаас гаргагч нь 2021 онд 81.1 сая төгрөгийн татвар хураамжийн өглөгтэй ажилласан байх ба 2022 онд тус өглөг нь өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өсөж 196.2 сая төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Тус тайлант хугацаат Компанийн татвар хураамжийн өглөгийн 57.3 хувь буюу 112.4 сая төгрөгийг НӨАТ-ын өглөг, 29.6 хувь буюу 58.1 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварын өглөг, үлдсэн 13.1 хувь буюу 25.7 сая төгрөгийг ААНОАТ-ын өглөг тус тус бүрдүүлж байна.

**Зураг 62: Үнэт цаас гаргагчийн татвар хураамжийн өр төлбөр, сая төгрөг, 2021-2023.III**




2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн татвар хураамжийн өр төлбөрийн дүн өмнөх оны жилийн эцсээс 78.8 хувиар буурч 41.6 сая төгрөгт хүрсэн байх ба энэ нь 100 хувь цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татварын өглөгөөс бүрдсэн байна.

**НДШ-ийн өр төлбөр**

2021 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь 33.7 сая төгрөгийн НДШ-ийн өр төлбөртэй ажилласан байна. 2022 оны байдлаар тус өглөг нь өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өсөн 83.5 сая төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагч нь 49.6 сая төгрөгийн НДШ-ийн өр төлбөртэй ажилласан нь Компанийн нийт өр төлбөрийн 0.1 хувийг бүрдүүлж байна.

**Бусад богино хугацаат өр төлбөр**

Үнэт цаас гаргагчийн бусад богино хугацаат өр төлбөрийг хувь хүнд өгөх бусад богино хугацаат өр төлбөр, холбоотой талд өгөх өглөг, дараа тайлангаарх өглөг болон ажиллагсад өгөх өглөг тус тус бүрдүүлнэ.

2021 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн бусад богино хугацаат өр төлбөрийн дүн 3.9 тэрбум төгрөгтэй тэнцсэн үзүүлэлттэй байх бөгөөд үүний 99.2 хувь буюу 3.9 тэрбум төгрөгийг холбоотой талд өгөх өглөг, үлдсэн 0.8 хувь буюу 31.9 сая төгрөгийг хувь хүнд өгөх бусад богино хугацаат өр төлбөр, дараа тайлангаарх өглөг болон ажиллагсад өгөх өглөг тус тус бүрдүүлж байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн бусад богино хугацаат өр төлбөр өмнөх оны мөн үеэс 44.4 хувиар өсөж 5.7 тэрбум төгрөгт хүрсэн байх ба үүний 99.7 хувь буюу 5.7 тэрбум төгрөгийг холбоотой талд өгөх өглөг, үлдсэн 0.3 хувь буюу 17.3 сая төгрөгийг хувь хүнд өгөх бусад богино хугацаат өр төлбөр, дараа тайлангаарх өглөг болон ажиллагсад өгөх өглөг тус тус бүрдүүлж байна.

Зураг 63: Үнэт цаас гаргагчийн бусад богино хугацаат өр төлбөр, тэрбум төгрөг, 2021-2023.III




2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн бусад богино хугацаат өр төлбөр 43.8 тэрбум төгрөгтэй тэнцсэн байх ба үүний дийлэнх хувийг холбоотой талд өгөх өглөг бүрдүүлж байна. Үнэт цаас гаргагч нь өөрийн нэгдлийн компани болох "Ти Эм Эл" ГХОХХК-тай байгуулсан 2018 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн ХАГ-2018 тоот "Хөрөнгө оруулж, хамтран ажиллах гэрээ", 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн НГ/210201 тоот "Хөрөнгө оруулж, хамтран ажиллах гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ", 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн "Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний дагалдах баримт бичиг", 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн "Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний дагалдах баримт бичгийн нэмэлт, өөрчлөлт"-ийн хүрээнд "Ти Эм Эл" ГХОХХК-тай 38.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, төлбөрийг гэрээний хүрээнд 2024 оны 9 дүгээр сарын 30-ны дотор хэсэгчлэн төлөх нөхцөлтэйгээр Компанийн балансаст бүртгэснээр Компанийн холбоотой талын өглөгийн дүн нэмэгдсэн байна.

## ЭЗДИЙН ӨМЧ

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2020 оноос 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 10.0 сая төгрөг байх ба Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш хувь нийлүүлсэн хөрөнгөдөө аливаа өөрчлөлт оруулж байгаагүй болно.

2020 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн дүн 20.5 сая төгрөгийн алдагдалтай байсан нь тус онд Компани нь үйл ажиллагаагаа явуулж эхлэхтэй холбоотой 30.5 сая төгрөгийн цалингийн зардал гаргаж, Компанийн цэвэр ашиг тус хэмжээгээр алдагдалтай гарсантай холбоотой байна.

2021 онд байдлаар Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн дүн 162.0 сая төгрөгтэй тэнцсэн байх ба үүний 93.8 хувь буюу 152.0 сая төгрөгийг хуримтлагдсан ашиг, үлдсэн 6.2 хувь буюу 10.0 сая төгрөгийг хувь нийлүүлсэн хөрөнгө тус тус бүрдүүлж байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн дүн өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар өсөж, 187.8 сая төгрөгт хүрсэн байх ба тус тайлант хугацаанд Компани нь 152.0 сая төгрөгийн ашигтай ажиллаж, Үнэт цаас гаргагчийн хуримтлагдсан ашгийн хэмжээ 177.8 сая төгрөгт хүрсэн нь нийт эздийн өмчийн 94.7 хувийг бүрдүүлж байна.

**Зураг 64: Үнэт цаас гаргагчийн эздийн өмч, түүний бүтэц, тэрбум төгрөг, 2020-2023.III**




2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагч нь 292.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласнаар Компанийн хуримтлагдсан алдагдал 115.0 сая төгрөгтэй тэнцсэн үзүүлэлттэй байна. Мөн тус тайлант хугацаанд Компани нь үндсэн хөрөнгийн бодит үнэ цэний үнэлгээ хийлгэсэнтэй холбоотой хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 17.2 тэрбум төгрөгт хүрснээр Компанийн нийт эздийн өмчийн дүн 17.1 тэрбум төгрөгтэй тэнцсэн байна.

### 2.7.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ШИНЖИЛГЭЭ

Үнэт цаас гаргагчийн 2021-2022 оны жилийн эцэс болон 2023 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн байдлын тайлан болон орлогын дэлгэрэнгүй тайланд хийсэн санхүүгийн харьцаа үзүүлэлтийн шинжилгээ нь дараах байдалтай байна.

**Хүснэгт 40: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт, сая төгрөг | 2021 | 2022 | 2023 III |
|---|---|---|---|
| **Хөрвөх чадварын харьцаа** | | | |
| Эргэлтийн харьцаа | 0.29 | 0.40 | 0.20 |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 0.03 | 0.11 | 0.02 |
| Бэлэн мөнгөний харьцаа | 0.00 | 0.01 | 0.00 |
| **Төлбөрийн чадварын харьцаа** | | | |
| Санхүүгийн хөшүүрэг | 31.81 | 30.01 | 3.89 |
| **Үйл ажиллагааны харьцаа** | | | |
| Бараа материалын эргэц (удаа) | 9.73 | 5.95 | 1.76 |
| Бараа материалын эргэц (өдөр) | 37.53 | 61.34 | 207.03 |
| Авлагын эргэц (удаа) | 67.28 | 19.73 | 10.44 |
| Авлагын эргэц (өдөр) | 5.43 | 18.50 | 34.95 |
| Өглөгийн эргэц (удаа) | 29.72 | 147.78 | 127.58 |
| Өглөгийн эргэц (өдөр) | 12.28 | 2.47 | 2.86 |
| **Ашигт ажиллагааны харьцаа** | | | |
| Нийт ашгийн ахиуц | 9.3% | 10.6% | 13.5% |
| Цэвэр ашгийн ахиуц | 4.6% | 0.3% | -4.5% |
| Хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх ашгийн ахиуц (EBITDA margin) | 11.8% | 5.5% | 5.7% |
| Татварын өмнөх ашгийн ахиуц (EBT margin) | 5.1% | 0.4% | -4.5% |
| Нийт хөрөнгийн өгөөж (ROA) | 8.1% | 0.5% | -0.9% |
| Нийт эздийн өмчийн өгөөж (ROE) | 258.1% | 14.8% | -3.4% |

**Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд**

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд болох эргэлтийн харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа болон бэлэн мөнгөний харьцаа үзүүлэлтүүд нь 2022 оны жилийн эцсийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад буурсан байна. Тухайлбал 2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварын харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа болон бэлэн мөнгөний харьцаа үзүүлэлтүүд харгалзан тус бүр 0.40, 0.11, 0.01 байсан бол 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 0.20, 0.02, 0.00 болж тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ

Зураг 65: Үнэт цаас гаргагчийн нийт болон цэвэр ахиуц ашиг, 2021-2023.III




2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт авлагын хэмжээ өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 18.3 хувиар өсөж, мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 80.8 хувиар буурсан боловч Үнэт цаас гаргагчийн нийт эргэлтийн хөрөнгө нь бараа материал болон урьдчилж төлсөн зардлын өсөлттэй холбоотойгоор 3.7 дахин өсжээ. Үүний зэрэгцээ Үнэт цаас гаргагчийн холбоотой талд өгөх өглөгийн өсөлттэй холбоотойгоор Компанийн богино хугацаат өр төлбөрийн хэмжээ 7.3 дахин өссөнөөр Үнэт цаас гаргагчийн хөрвөх эргэлтийн харьцаа үзүүлэлтүүд буурсан байна.

### Төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтүүд

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн санхүүгийн хөшүүрэг буюу дундаж нийт хөрөнгийг дундаж нийт эздийн өмчид харьцуулсан харьцаа үзүүлэлт нь өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 26.1 нэгжээр буурч 3.89 хүрсэн үзүүлэлттэй байна. Энэхүү өсөлтөд Компани нь үндсэн хөрөнгийн бодит үнэ цэний үнэлгээ хийсэнтэй холбоотой эздийн өмчийн хэмжээ 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 91.3 дахин өссөн нь нөлөөлсөн байна.

Зураг 66: Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтүүд, 2021-2023.III




### Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн бараа материалын эргэц өмнөх оны жилийн эцсийн байдлаарх үзүүлэлтээс буурч Компанийн нийт бараа материал жилд 1.76 удаа буюу 207.03 өдөрт нэг эргэж байна. Тус тайлант хугацаанд Компанийн бараа материалын эргэц удааширсан нь бараа материалын үлдэгдэл их, үүнд хагас боловсруулсан бүтээгдэхүүн буюу хуванцрын хэрчдэс болон химийн бодисын үлдэгдэл их байгаатай холбоотой байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн авлагын эргэц 10.44, өдрөөр тооцсон эргэж 35 байгаа нь Компани нь авлагаа жилд 10.44 удаа буюу 34.95 өдөрт цуглуулж байна. Тус тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн авлага цуглуулах хугацаа нь өмнөх оны жилийн эцсээс удааширсан буюу 9.3 удаа, 16.45 өдрийн илүү хугацаагаар авлагаа цуглуулж байна.

Мөн тус тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн өглөгийн эргэц 127.58 удаа, өдрөөр тооцсон эргэц 2.86 байгаа нь өмнөх оны жилийн эцсийн үзүүлэлтээс бага зэрэг удааширсан үзүүлэлттэй байна. Тухайлбал Үнэт цаас гаргагч нь 2022 онд өр төлбөрийг жилд 147.78 удаа буюу 2.47 өдөрт барагдуулдаг байсан бол 2023 оны 3 дугаар улирлын байдлаар жилд 127.58 удаа буюу 2.86 өдөрт барагдуулж байгаа хэдий ч Үнэт цаас гаргагчийн өглөгийн эргэцийн үзүүлэлт сайн байна.

**Зураг 67: Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, 2021-2023.III**




### Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд

2021 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь 9.3 хувийн нийт ашгийн ахиуцтай, 4.6 хувийн цэвэр ашгийн ахиуцтай ажилласан бол 2022 оны байдлаар тус үзүүлэлт Компанийн үйл ажиллагааны зардлын өсөлтөөс шалтгаалсан цэвэр ашгийн ахиуц 4.3 нэгж хувиар буурч, 0.3 хувьтай тэнцсэн бол нийт ашгийн өсөлтөөс шалтгаалан нийт ашгийн ахиуц 1.3 нэгж хувиар нэмэгдэн 10.6 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Үнэт цаас гаргагчийн нийт ашгийн ахиуц 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 13.5 хувьтай тэнцсэн үзүүлэлттэй байх ба энэ нь өмнөх оны жилийн эцсийн үзүүлэлтээс 2.9 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Харин Үнэт цаас гаргагчийн ерөнхий ба удирдлагын зардлын өсөлт болон хөрөнгийн үнэ цэний бууралтын гарзаас шалтгаалан Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн ахиуц 2021 он болон 2022 оны жилийн эцсийн үзүүлэлтээс тус тус буурсан үзүүлэлттэй байна.

СЗХ 2024.07.05 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

**Зураг 68: Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, 2021-2023.III**




2021 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж 8.1 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 258.1 хувьтай тэнцсэн Компани нь тус тайлант хугацаанд 182.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж, эздийн өмчийн дундаж хэмжээ буурсантай холбоотой өндөр гарчээ. 2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 7.6 нэгж хувиар буурч 0.5 хувьд, өөрийн хөрөнгийн өгөөж 243.3 нэгж хувиар буурч 14.8 хувьтай тэнцсэн үзүүлэлттэй байна. Тус тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн хэмжээ буурч, дундаж эздийн өмчийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлт буурсан байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цас гаргагч нь үйл ажиллагааны зардлын өсөлт болон хөрөнгийн үнэ цэний гарзаас шалтгаалан 292.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан тус тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлт буурчээ. Мөн тус тайлант хугацаанд Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжид нэмэлт тоног төхөөрөмж суурилуулсантай холбоотой 3 дугаар улиралд сул зогсолт хийсэн нь ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлт буурахад нөлөөлсөн байна.

Үнэт цаас гаргагчийн хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх ашгийн ахиуцын хэмжээ 2021 оны байдлаар 11.8 хувьтай тэнцэж байсан бол 2022 оны байдлаар тус үзүүлэлт нь 6.3 нэгж хувиар буурч 5.5 хувьтай тэнцсэн үзүүлэлттэй байна. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн тус харьцаа үзүүлэлт нь өмнөх оны жилийн эцсийн үзүүлэлтээс 0.2 нэгж хувиар нэмэгдэж 5.7 хувьд хүрсэн нь тус тайлант хугацаанд Компанийн үйл ажиллагааны орлого өмнөх жилийн эцсийн үзүүлэлтээс өссөнтэй холбоотой байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2024.07.05
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

## 2.8. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

### 2.8.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УРТ ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ЧИГЛЭЛ

"ТЖТБ" ХХК нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх, түүхий эдийн татан авалтыг сайжруулах, Монгол Улсын тэргүүлэгч боловсруулах үйлдвэрийн нэр хүндийг хадгалахын тулд урт хугацаанд дараах стратеги чиглэлтэйгээр ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

**Зураг 69: Үнэт цаас гаргагчийн урт хугацааны стратеги чиглэл**




Үнэт цаас гаргагч нь "**Байгаль орчинд үзүүлж буй хувь нэмрээ нэмэгдүүлэх**" урт хугацааны стратеги чиглэлийнхээ хүрээнд 27,000 тонн хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийнхээ хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлж, 2028 он хүртэл үйлдвэрийн нийт хүчин чадлын 67 орчим хувийг ашиглахаар төлөвлөж, орон нутагт хог ангилан ялгах, цуглуулах цэгийн байгууламжуудыг байгуулж, Монгол Улсад үүсэж буй нийт ус, ундааны хуванцар хаягдлыг дийлэнх буюу 41-59 хувийг цуглуулан дахин боловсруулж, байгаль орчны бохирдлыг бууруулахад томоохон хувь нэмрийг оруулна.

Үнэт цаас гаргагч нь "**Бүс нутагтаа тэргүүлэх дахин боловсруулах үйлдвэр болох**" урт хугацааны стратеги чиглэлийнхээ хүрээнд Монгол Улсад үүсэж буй нийт ус, ундааны хуванцар хаягдлын дийлэнх хэсгийг дахин боловсруулж, дотоодын шингэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн гол түүхий эд болох хуванцар савны импортын хэрэглээг орлож, дотоодоосоо хангах боломжийг олгосон бүс нутагтаа тэргүүлэх дахин боловсруулах үйлдвэр болохыг зорьж байна.

Үнэт цаас гаргагч нь "**Тойрог эдийн засгийг дэмжигч үйлдвэр болох**" урт хугацааны стратеги чиглэлийнхээ хүрээнд дэлхий дахинд ихээхэн эрэлттэй байгаа дахин боловсруулсан бүтээгдэхүүнээр савнаас савыг үйлдвэрлэх системээр хуванцар савны хаягдлыг дахин боловсруулж эргэлтэд оруулахаар зорьж байна.

**Урт хугацааны тогтвортой хөгжлийн стратеги**

Үнэт цаас гаргагч нь байгальд ээлтэй, хаягдал багатай, үр ашигтай дахин боловсруулах үйлдвэрлэлээрээ дамжуулан хөгжлийн өнөөгийн хандлагыг өөрчилж, байгалийн шавхагдах нөөц баялаг, экосистемын үнэ цэнийг хадгалан хог хаягдлын менежментийг сайжруулан эдийн засгийн эргэлтэд оруулахын зэрэгцээ ажилгүйдэл ядуурлыг бууруулах, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг хангах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгаж орчны бохирдлыг бууруулах замаар ээлтэй хот, иргэдийн оролцоо, хариуцлагатай хэрэглээг дэмжин урт хугацаанд тогтвортой ногоон хөгжлийн дараах стратеги чиглэлийг баримтлан хэрэгжүүлнэ. Үүнд:

TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024 07 05 он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Хүснэгт 41: Үнэт цаас гаргагчийн урт хугацааны тогтвортой хөгжлийн стратеги**

| | |
|---|---|
| **Үйлдвэрийн санхүүгийн тогтвортой, бие даасан байдлыг хангах** | • Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр ашигт байдлыг өндөр хэмжээнд байлгах механизмыг бүрдүүлэх;<br>• Бүтээгдэхүүний чанарт тогтмол хяналт тавьж, шинэ технологийг цаг алдалгүй нэвтрүүлэх. |
| **Байгалийн нөөцийг хэмнэх, үр ашгийг нэмэгдүүлэх** | • Дахин боловсруулах үйл ажиллагаагаараа нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах;<br>• Цэвэр усны хэрэглээнд тогтмол хяналт тавьж, дахин боловсруулж зарцуулалтыг бууруулах;<br>• Үйлдвэрийн эрчим хүчний хэрэглээг багасгаж, хэрэглээнд тохирсон сэргээгдэх эрчим хүчний шинэ технологийг судлан үе шаттайгаар нэвтрүүлэх;<br>• Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх;<br>• Органик хог хаягдлыг дахин боловсруулах технологийг нэвтрүүлэх. |
| **Тогтвортой хүний нөөцийг бүрдүүлэх** | • Хүний нөөцийн уян хатан, оновчтой стратеги бодлогыг хэрэгжүүлэн, ажилтанд суурилсан хөгжлийг бий болгож тасралтгүй суралцах соёлыг төлөвшүүлж, хувь хүн болон байгууллагын шилдэг туршлагыг бий болгох. |
| **Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээг үүсгэх** | • Хуванцрын хаягдлыг бүрэн цуглуулах сүлжээг бий болгож хүртээмжийг нэмэгдүүлэх;<br>• Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, ханган нийлүүлэгчийн найдвартай түншлэлээ хадгалан тэлэх. |
| **Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан үйлдвэр** | • ХАБЭА хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг чандлан мөрдөх;<br>• Үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг олон улсын стандарт жишгийн дагуу хханган ажиллах;<br>• Аюул, осолгүй, таатай ажиллах орчныг бүрдүүлэх. |
| **Нийгэмд үзүүлэх эерэг нөлөө** | • Бүхий л оролцогч талуудыг хамруулан байгаль орчны бохирдлыг бууруулах талаар мэдлэг, мэдээллийг хүргэж, ангилан ялгалтыг хэвшүүлэх нийгэмд чиглэсэн ажлыг тогтмол хэрэгжүүлэх. |

TDB SECURITIES
ТЖТБ ХХК

Үнэт цаас гаргагч нь дээрх урт хугацааны тогтвортой хөгжлийн стратегийг хэрэгжүүлснээр урт хугацаанд байгаль орчинд дараах үнэ цэнийг бий болгохоор төлөвлөж байна. Үүнд:

**Хүснэгт 42: Урт хугацаанд Үнэт цаас гаргагчийн байгаль орчинд үзүүлэх нөлөө, үнэ цэн**

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт цуглуулах хаягдал** | **16,144 тонн** 2023 он* | **121,198 тонн** 2024-2029 он | **276,480 тонн** 2030-2039 он |
| **Хөрсний бохирдол үүсэхээс хамгаалсан** | **46,522 м.куб** 2023 он* | **242,396 м.куб** 2024-2029 он | **552,960 м.куб** 2030-2039 он |
| **Нүүрсхүчлийн хий ялгарахаас сэргийлсэн** | **63,171 тонн** 2023 он* | **474,252 тонн** 2024-2029 он | **1,081,878 тонн** 2030-2039 он |
| **Ус хэмнэлт** | **8,791,903 тонн** 2023 он* | **65,929,224 тонн** 2024-2029 он | **151,918,811 тонн** 2030-2039 он |
| **Эрчим хүчний хэмнэлт** | **139,912,888 квц** 2023 он* | **1,050,381,419 квц** 2024-2029 он | **2,396,160,000 квц** 2030-2039 он |
| **Нефтийн хэмнэлт** | **9,751 тонн** 2023 он* | **73,204 тонн** 2024-2029 он | **166,994 тонн** 2030-2039 он |

**Үнэт цаас гаргагчийн 2023 оны урьдчилсан санхүүгийн гүйцэтгэл*

### 2.8.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ, ЧИГЛЭЛ, БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагч нь урт хугацааны стратегийн зорилтдоо хүрэхийн тулд дунд хугацаанд дараах стратеги чиглэлийг баримтлан ажиллахаар төлөвлөсөн байна.

**Зураг 70: Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги чиглэл**

**Үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх**

2029 он хүртэл үйлдвэрийн нийт хүчин чадлын ашиглалтыг **70%** орчимд хүргэж, 2030 оноос хойш 75 гаруй хувийн хүчин чадлаар ажиллахаар төлөвлөж байна.

**Бүтээгдэхүүний төрөлжилт**

Хуванцар савны шошго, бөглөөг дахин боловсруулж, дотоодын ариун цэврийн хоолой, хамгаалалтын дуулга гэх мэт бүтээгдэхүүний үндсэн түүхий эдийн импортын хэрэглээг орлох.

**Түүхий эд татах дэд бүтцийн хөгжүүлэлт**

2029 он хүртэл Монгол Улсын 4 бүсэд үндсэн 5 цуглуулах, ангилах, багцлах байгууламжийг шинээр байгуулж, хог цуглуулах төслүүдийг хэрэгжүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.

СЗХ
2024.07.05
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Дотоод зах зээлийн тэлэлт**

Жилд 16,450 тонн rPET үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд үүнийг 2028 он хүртэл 50 орчим хувийг нь дотоод зах зээлд шингэн хүсний түүхий эдийн хэрэглээнд, 50 орчим хувийг нь экспортод гаргах.

**Гадаад зах зээлийн тэлэлт**

Дэлхийн зах зээл дэх томоохон үйлдвэрүүдэд **шаардлага, стандарт** бүрийнх нь дагуу бүтээгдэхүүнээ тогтмол нийлүүлэх.

1. **Үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх**

Үнэт цаас гаргагчийн нь сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 16,144 тонн хог хаягдлыг дахин боловсруулж, 9,821 тонн rPET мөхлөгийг үйлдвэрлэсэн нь нийт түүхий эд боловсруулах хүчин чадлын 13.9-31.1 хувиар, бүтээгдэхүүний нийт гарцын хүчин чадлын 12.2-28.7 хувиар тус тус ажилласан байна.

Цаашид Компани нь 2024-2028 онуудад нийт түүхий эд боловсруулах хүчин чадлын ашиглалтын хувийг 41-59 хувьд, бүтээгдэхүүний нийт гарцын хүчин чадлын ашиглалтын хувийг 50-67 хувьд хүргэхээр зорин ажиллаж байна. Үүний хүрээнд Үнэт цаас гаргагч нь өөрийн охин компани болох "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК-аар дамжуулан түүхий эдийн татан авалтын системийг сайжруулахад чиглэсэн Монгол Улсын 4 бүсэд хог цуглуулах цэгүүдийг дараах байршлуудад байгуулахаар төлөвлөөд байна. Үүнд:

**Зураг 71: Түүхий эд бэлтгэн нийлүүлэх цэгүүдийн байршлын төлөвлөгөө**




2. **Бүтээгдэхүүний төрөлжилт**

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES

УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч хүнсний болон хувцас үйлдвэрлэлийн түүхий эдийн гол шалгуур үзүүлэлт (IV) буюу Intrinsic viscosity /зуурамтгай чанар/ олон улсын стандартад бүрэн нийцэж байгаа нь дэлхийн аль ч улсын үйлдвэрлэлийн түүхий эдэд бүрэн нийцэх суурь нөхцөлийг бүрдүүлээд байна. Цаашид Үнэт цаас гаргагч хүнсний үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийн олон улсын томоохон ханган нийлүүлэгч болохоор зорьж байгаа бөгөөд илүү нарийн стандартууд болоод олон улсын аль ч үйлдвэрлэлийн шалгуур, шаардлагад нийцэх олон төрлийн сонголт, чанар бүхий бүтээгдэхүүний төрөлжилтийг хийн ажиллахаар зорьж байна.

Мөн хуванцар хог хаягдлын бөглөө, шошгоос бусад буюу үндсэн хуванцар сав (PET)-ыг дахин боловсруулж байгаа ба цаашид шошго, бөглөө зэргийг боловсруулж дотоодын ариун цэврийн хоолой, хамгаалалтын дуулга гэх мэт бүтээгдэхүүний үндсэн түүхий эдийн импортын хэрэглээг орлохоор зорьж байна.

### 3. Түүхий эд татах дэд бүтцийн хөгжүүлэлт

Үнэт цаас гаргагчийн үйлдвэрийн үндсэн түүхий эдийг бэлтгэн нийлүүлдэг "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК нь хуванцар хог хаягдлыг нийслэлийн 3 цэг, Дархан-Уул аймгийн 1 цэг болон гэрээт харилцагчдаас цуглуулан авч байна. Иймд түүхий эд татан авах дэд бүтцийг хөгжүүлэх стратеги зорилтын хүрээнд цаашид охин компанийн үндсэн татан авалтын сувгийн томоохон хэсгийг орон нутаг болгохоор зорьж, сувагт тус бүрд тохирсон системийг хөгжүүлэн доорх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр зорьж байна. Үүнд:

**Нийслэл:**

1. Харилцагчийн үйлчилгээг боловсронгуй болгож дуудлага мэдээлэлд түргэн шуурхай хариу өгч, дуудлагын дагуу түүхий эдийг цуглуулахад шаардагдах машин, техник хэрэгслийн хүртээмжийг тогтмол нэмэгдүүлэх;
2. Иргэдийг соён гэгээрүүлэх, хог ангилах дадалд суулгахад чиглэсэн мэдлэг, мэдээллийг идэвхтэй олгох,
3. Түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдэд зориулж нийлүүлэлтийн хэмжээнээс хамаарсан үнийн бодлогыг хэрэгжүүлэх;
4. Харилцагчдын бааз суурийг оновчтой тогтоож, технологийн дэвшлийг ашиглан ухаалаг хяналт удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх;
5. Хуванцар худалдан авагч тусгай зориулалтын автомат машинуудын хүрэлцээг нэмж, иргэн бүрд хүрэх боломжийг нээх.

**Цэгүүд:**

1. Хувиараа дахивар цуглуулагч бизнес эрхлэгч нартай уян хатан, бүтээмж дээр суурилсан үнийн бодлогыг нэвтрүүлж, цаг үетэй зэрэгцүүлэн тогтмол боловсронгуй болгох;
2. Тус бизнес эрхлэгчдийг компанийн зүгээс үндсэн ажилтны хэмжээнд урамшуулал, нийгмийн хангамжаар хангаж дэмжих;
3. Татан авалтын цэгээс пресслэх буюу багцалсан байдлаар татах дэд бүтцийг байгуулах;
4. Хөдөлмөрийн аюулгүй орчныг бүрдүүлэхэд оролцогч талуудтай хамтран ажиллах.

**Орон нутаг:**

1. Ангилан цуглуулах дэд бүтцийг Монгол Улсын 4 үндсэн бүсэд байгуулан зах зээлээ тэлэх;
2. Орон нутгийн үйлдвэрлэл, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллаж хаягдал хуванцрыг татан авах;
3. Орон нутгуудад байгальд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажиллах;
4. Хөдөлмөрийн аюулгүй орчныг бүрдүүлэх тал дээр оролцогч талуудтай хамтран ажиллах.

### 4. Дотоод зах зээлийн тэлэлт

Монгол Улсын согтууруулах бус шингэн хүнсний зах зээл буюу цэвэр ус, ундаа, амтат жүүсний үйлдвэрлэл 2018-2023 оны байдлаар жилд дунджаар 6.1 хувиар өсөж, 122.4 сая л цэвэр ус, 230.6 амтат ус ундаа, 55.2 сая литр шүүс, нийт 408.2 сая литр согтууруулах бус шингэн хүнсийг үйлдвэрлэжээ. Эдгээр үйлдвэрлэгчид нь бүтээгдэхүүний сав баглаа боодлын түүхий эдээ бүрэн импортоор авч байгаа ба Гаалийн ерөнхий газрын статистик мэдээгээр 2023 онд 16.9 сая долларын үнийн дүн бүхий 17 мянган тонн хэмжээтэйгээр Полиэтилен Терефталат буюу үндсэн түүхий эд импортоор орж ирсэн байна.

Харин согтууруулах бус ундааны импортын тухайд 2018-2023 онд жилд дунджаар 11.4 хувиар өсөж, 40.8 сая литр согтууруулах бус ундааг импортолсон байгаа бол тус хугацаанд согтууруулах бус ундааны экспорт жилд дунджаар 120.7 хувиар өсөж, 1.8 сая литрт тус тус хүрсэн үзүүлэлттэй байна.

Иймд Монгол Улсын хэмжээнд үүссэн цэвэр хуванцар (PET) хог хаягдлын[8] хэмжээг тооцон үзвэл 2019-2023 онд жилд дунджаар 6.8 хувиар өсөж, 18.2 мянган тонн ус, ундааны хуванцар хаягдал (PET) хаягдал үүссэн байх ба 2024-2028 онд дунджаар 19.5-25.4 мянган тонн PET хаягдал үүсэх төлөвтэй байна. Дэлгэрэнгүйг Үнэт цаасны танилцуулгын 2 дугаар бүлгийн 2.4.2 дахь хэсгээс уншиж танилцана уу.

Энэ нь Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэлийн гол түүхий эд болох хуванцар хаягдлын нөөц их байгааг харуулж байгаа бөгөөд шингэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хуванцар савны түүхий эдийг дотоодоосоо хангах томоохон боломж байгааг харуулж байна. Иймд Үнэт цаас гаргагч нь 2024-2028 онд үйлдвэрлэсэн rPET мөхлөгийнхөө 20-50 хувийг дотоодын зах зээлд хангаж нийлүүлж, импортын хэрэгцээг хангахаар төлөвлөөд байна.

### 5. Гадаад зах зээлийн тэлэлт

Үнэт цаас гаргагч нь гадаад зах зээлийн тэлэлт стратеги чиглэлийнхээ хүрээнд 2024 онд нийт үйлдвэрлэсэн rPET мөхлөгийнхөө 80 хувийг гадаадын зах зээлд экспортлохоор төлөвлөсөн бөгөөд 2028 он хүртэл тус хэмжээг аажмаар бууруулан 50 хувьд хүргэхээр төлөвлөөд байна.

Дэлхий дахинд байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийн бодлого бүхий хуванцар сав баглаа боодлын хэрэглээ эрчимжиж байгаагийн хэрээр хэрэглэгчид ч мөн адил байгаль орчинд ээлтэйг хэрэглээг ухамсарласан дахин боловсруулах боломжтой, дахин боловсруулагдсан материалаар хийсэн бараа, бүтээгдэхүүнийг сонгохыг илүүд үзэх болжээ. Мөн олон улсад тойрог эдийн засгийг дэмжих бодлогууд ихээр гарч байгаа бөгөөд тухайлбал сав баглаа боодолдоо дахин боловсруулсан түүхий ашиглах, мөн PET мөхлөгийн агууламжийг хамгийн бага төвшинд хүргэх зорилтуудыг тавьсаар байна. Эдгээр зохицуулалтыг даган шингэн хүнсний зах зээлд томоохон бизнес эрхлэгчдийн нэг болох Кока Кола 2030 он гэхэд үйлдвэрлэлийн сав баглаа боодолд 50 хувь rPET мөхлөгийг ашиглахыг зорьж байгаа бол Европын холбооны зүгээс 2030 он гэхэд хуванцар сав баглаа боодлын түүхий эдийн 30 хувийг rPET мөхлөгөөр хангахаар төлөвлөөд байна[9].

Иймд Үнэт цаас гаргагч нь БНХАУ-ын зах зээлд нэвтрэн rPET бүтээгдэхүүнийг экспортлоод байгаа бол гадаад зах зээлийн тэлэлт стратеги чиглэлийн хүрээнд дэлхийн бусад орнуудын томоохон үйлдвэрүүдэд тавигддаг тусгай, шаардлага стандартынх нь дагуу бүтээгдэхүүнээ тогтмол нийлүүлэхээр төлөвлөж байна.

[8] Цэвэр PET хаягдлын хэмжээ = [(Полиэтилен терефталатын импорт+согтууруулах бус ундааны импорт)-согтууруулах бус ундааны экспорт]*30.89 грамм*
*1 литр шингэн хүнсний хуванцар савны дундаж хэмжээ

[9] Дахин боловсруулсан Полиэтилен терефталат (rPET) мөхлөгийн зах зээлийн төлөв байдал 2023-2033, https://www.factmr.com/report/r-pet-market

СЭХ
2024.07.05
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

### 2.8.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

#### 2.8.3.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын хог хаягдал дахин боловсруулах салбарын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, Олон улсын ногоон хөгжлийг дэмжих бодлого зэрэгт үндэслэн 2024-2028 оны Дунд хугацааны санхүүгийн төлөвлөл болон санхүүгийн тайлангийн төсөөллийг боловсруулсан байна.

#### 2.8.3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Дунд хугацааны бизнес төлөвлөлтийн дагуу Үнэт цаас гаргагчийн 2024-2028 оны орлогын тайлангийн төсөөлөл дараах байдалтай байна.

**Хүснэгт 43: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөг, 2024-2028 он**

| Үзүүлэлт, сая төгрөг | 2024 | 2025 | 2026 | 2027 | 2028 |
|---|---|---|---|---|---|
| Борлуулалтын орлого /цэвэр/ | 34,768.1 | 40,236.5 | 47,559.0 | 54,347.9 | 61,234.0 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | (19,240.6) | (21,116.1) | (23,175.8) | (25,557.3) | (27,488.8) |
| **Нийт ашиг** | **15,527.5** | **19,120.4** | **24,383.2** | **28,790.6** | **33,745.2** |
| Хүүгийн орлого | 12.0 | 2,134.7 | 4,711.5 | 1,591.8 | 676.5 |
| Хүүгийн зардал | (2,228.7) | (4,974.7) | (5,649.7) | (3,316.9) | (402.4) |
| Борлуулалт маркетингийн зардал | (200.0) | (212.0) | (224.7) | (238.2) | (252.5) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | (4,232.3) | (3,331.5) | (3,910.5) | (4,217.6) | (4,527.7) |
| Бусад зардал | (5.0) | (5.3) | (5.6) | (6.0) | (6.3) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз (гарз) | (1,002.2) | (3,066.2) | (3,751.7) | (1,043.8) | (91.1) |
| Бусад ашиг (алдагдал) | (9.9) | (10.7) | (11.5) | (12.4) | (13.4) |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **7,861.4** | **9,654.7** | **15,540.9** | **21,547.4** | **29,128.3** |
| Орлогын татварын зардал | (1,321.6) | (1,770.6) | (3,242.1) | (4,744.3) | (6,639.1) |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **6,539.8** | **7,884.1** | **12,298.8** | **16,803.1** | **22,489.2** |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - | - | | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **6,539.8** | **7,884.1** | **12,298.8** | **16,803.1** | **22,489.2** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | | - |
| **Орлогын нийт дүн** | **6,539.8** | **7,884.1** | **12,298.8** | **16,803.1** | **22,489.2** |
| *Ам.долларын төгрөгтэй харьцах ханшийн төсөөлөл* | *3,462* | *3,652* | *3,864* | *4,011* | *4,111* |

TDB SECURITIES



УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
2024 07 05
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -06- 03
БҮРТГЭВ-02

**Борлуулалтын орлого**

Үнэт цаас гаргагчийн 2024-2028 оны борлуулалтын орлого нь rPET мөхлөг болон бөглөөний бэлдцийн борлуулалтаас бүрдэхээр төлөвлөсөн байна.

**Зураг 64: Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын төсөөлөл болон түүний бүтэц, тэрбум төгрөгөөр, 2024-2028 он**




2024-2028 онд Үнэт цаас гаргагч нь түүхий эд цуглуулалтыг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын түвшинг сайжруулж, нэгж бүтээгдэхүүнийг борлуулах үнийг дэлхийн rPET мөхлөгийн дундаж үнэтэй харьцуулан өмнөх жилд борлуулж байсан дундаж үнийн дүнгээс дунджаар 68 хувь орчим өсгөсөн доллараар борлуулахаар төлөвлөснөөр тус хугацаанд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын хэмжээ нэмэгдэх төлөвлөгөөтэй байна. Үнэт цаас гаргагч нь ам.долларын төгрөгтэй харьцах ханшийг 2024-2028 онд жилд дунджаар 4.4 хувь өсөхөөр төлөөлсөн аж.

2024 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь түүхий эд цуглуулалтыг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын түвшинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.2 нэгж хувиар өсгөж 49.9 хувь хүргэж, мөн нэгж бүтээгдэхүүнийг борлуулах үнийг дэлхийн rPET мөхлөгийн дундаж үнэтэй харьцуулан өмнөх жилд борлуулж байсан дундаж үнийн дүнгээс 55 орчим хувиар нэмэгдүүлсэн үнээр бүтээгдэхүүний борлуулахаар төлөвлөсөн. Ингэснээр Үнэт цаас гаргагч нь тус онд нийт 34.8 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллах төлөвлөгөөтэй байгаа ба үүний 18.2 хувь буюу 6.3 тэрбум төгрөг нь дотооддоо борлуулах rPET мөхлөгийн борлуулалтын орлого, 80.2 хувь буюу 27.9 тэрбум төгрөг нь экспортоор борлуулах rPET мөхлөгийн борлуулалтын орлого, үлдсэн 1.5 хувь буюу 0.6 тэрбум төгрөг нь бөглөөний бэлдцийн борлуулалтын орлого тус тус бүрдүүлэхээр төлөвлөжээ.

2025 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт орлогын хэмжээ 40.2 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Борлуулалтын орлогыг бүтцээр нь авч үзвэл 11.1 тэрбум төгрөгийг дотооддоо борлуулах rPET мөхлөг, 28.5 тэрбум төгрөгийг экспортоор борлуулах rPET мөхлөг, үлдсэн 0.6 тэрбум төгрөгийг бөглөөний бэлдэц бүрдүүлэх нь ба энэ нь харилцан нийт борлуулалтын орлогын 27.6, 70.9 болон 1.5 хувийг тус тус бүрдүүлэхээр төлөвлөжээ. Тус тайлант жилд дотоодын rPET мөхлөгийн борлуулалтын орлогын хэмжээ 2024 оны мөн үеэс 4.8 тэрбум төгрөгөөр өсөж байгаа бол гадаадад борлуулах rPET мөхлөгийн борлуулалтын орлого 0.6 тэрбум төгрөгийн өсөлтийг үзүүлэхээр байна.

Үнэт цаас гаргагч нь 2026 онд өөрийн борлуулалтын орлогоо өмнөх оны мөн үеэс 18.2 хувиар өсгөж 47.6 тэрбум төгрөгт хүргэх төлөвлөгөөтэй байна. Тус өсөлтийн 69.0 хувийг дотоодын rPET борлуулалтын орлогын өсөлт бүрдүүлж байгаа бол экспортын rPET мөглөгийн борлуулалт 30.0 хувийг, бөглөөний бэлдцийн борлуулалтын орлогын өсөлт 1.0 хувийг бүрдүүлэхээр байна. Ингэснээр нийт борлуулалтын орлогод эзлэх дотоодын rPET мөглөгийн борлуулалт 34.0 хувь буюу 16.2 тэрбум төгрөг, экспортын rPET мөглөгийн борлуулалт 64.6 хувь буюу 30.7 тэрбум төгрөг, бөглөөний бэлдцийн борлуулалт 1.4 хувь буюу 0.7 тэрбум төгрөгийг тус тус бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

2027 болон 2028 онд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад харилцан 14.3 болон 12.7 хувиар өсөх ба 54.3 болон 61.2 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. Дотооддоо борлуулсан rPET мөхлөгийн борлуулалт 2027 онд 20.8 тэрбум төгрөг буюу нийт борлуулалтын орлогын 38.3 хувийг бүрдүүлэх бол 2028 онд 2027 оны мөн үеэс 38.2 хувиар өсөж 28.8 тэрбум төгрөг буюу нийт борлуулалтын орлогын 47.0 хувийг бүрдүүлнэ. Харин экспортоор гаргах rPET мөхлөгийн борлуулалтын орлого 2027 онд 32.8 тэрбум төгрөг байх ба 2028 онд энэ нь 3.5 хувиар буурч 31.6 тэрбум төгрөгт хүрч, нийт борлуулалтын орлогын 51.7 хувийг бүрдүүлэх төсөөлөлтэй байна.

**Зураг 72: Үнэт цаас гаргагчийн rPET мөхлөгийн борлуулалтын орлогын төсөөлөл, 2024-2028 он**




2024-2028 онд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын жилийн дундаж өсөлтийн түвшин 15.2 хувь байх бол дотоодын rPET мөхлөгийн борлуулалтын орлого 45.9 хувь, экспортоор гаргасан rPET мөглөгийн борлуулалтын орлого 3.2 хувь, бөглөөний бэлдцийн борлуулалтын орлого 12.3 хувийн жилийн дундаж өсөлт үзүүлэх төсөөлөлтэй байна. Тус борлуулалтын орлогын өсөлт нь үнэт цаас гаргагчийн түүхий эд хаягдал цуглуулах дэд бүтцийн хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын түвшний өсөлтөөс бий болжээ.

**Борлуулсан бүтээгдэхүүний өртөг**

2024-2028 онд Үнэт цаас гаргагчийн нийт борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ жилд дунджаар 7.7 хувь, нэгж бүтээгдэхүүнд ноогдох өртөг 8.9 хувиар өссөнөөр Үнэт цаас гаргагчийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг жилд дунджаар 9.3 хувиар өсөх төсөөлөлтэй байна. Тухайлбал, 2024 онд үнэт цаас гаргагчийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг 19.2 тэрбум төгрөг байх бол энэ нь 2028 онд 27.5 тэрбум төгрөгт хүрэх тооцоололтой байна.

**Нийт ашиг**

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 2024-2028 онд жилд дунджаар 15.2 хувиар өсөх бол борлуулсан бүтээгдэхүүний өртөг түүнээс бага буюу 9.3 хувиар өссөнөөр Үнэт цаас гаргагчийн нийт ашиг жилд дунджаар 21.4 хувиар өсөх төсөөлөлтэй байна.

2024 онд Үнэт цаас гаргагч нь 34.8 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ба 19.2 тэрбум төгрөгийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэй ажилласнаар 15.5 тэрбум төгрөгийн нийт ашигтай ажиллах ба Үнэт цаас гаргагч нь тус онд 44.7 хувийн нийт ашгийн ахиуцтай ажиллах төсөөлөл болж байна.

**Зураг 73: Үнэт цаас гаргагчийн нийт ашгийн төсөөлөл, 2024-2028 он**




Харин 2028 онд Үнэт цаас гаргагчийн нийт борлуулалтын орлого 61.2 тэрбум төгрөгт хүрч, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 27.5 тэрбум төгрөгт хүрснээр Үнэт цаас гаргагч нь 33.7 тэрбум төгрөгийн нийт ашигтай ажиллах нь өмнөх оны мөн үеэс 17.2 хувь, 2024 оноос 2.2 дахин өссөн үзүүлэлт болох төсөөлөлтэй байна.

### Хүүгийн орлого

Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын үйл ажиллагаанаас олсон мөнгөө хөрөнгө оруулалт хийх замаар инфляцаас хамгаалж, хүүгийн орлого олох төлөвлөгөөтэй байна.

2024 онд Үнэт цаас гаргагч нь 12.0 сая төгрөгийн хүүгийн орлоготой ажиллах төсөөлөлтэй байгаа ба 2025 онд тус үзүүлэлт нь Компанийн борлуулалтын орлого болон мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дансны өсөлтийн нөлөөгөөр 2.1 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. Цаашлаад 2026 онд мөн адил Үнэт цаас гаргагчийн хүүгийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 дахин өсөж, 4.7 тэрбум төгрөгт хүрэх нь тус оны борлуулалтын орлогын 9.9 хувьтай тэнцэж байна.

Харин 2027 онд бондын үндсэн төлөлттэй холбоотойгоор мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө буурснаар Үнэт цаас гаргагчийн хүүгийн орлого мөн адил 66.2 хувиар буурч 1.6 тэрбум, 2028 онд өмнөх оны мөн үеэс 57.5 хувиар буурч 0.7 тэрбум төгрөгийн хүүгийн орлоготой ажиллах төсөөлөлтэй байна.

### Борлуулалт маркетингийн зардал

Үнэт цаас гаргагч нь 2024 онд 200 сая төгрөгийн борлуулалт, маркетингийн зардал гаргахаар төлөвлөсөн ба 2028 хүртэл өөрийн борлуулалт, маркетингийн зардлаа тогтмол 6 хувиар өсгөж, 2028 онд 252.5 сая төгрөгийн борлуулалт маркетингийн зардал гаргахаар төсөөлжээ.

### Ерөнхий ба удирдлагын зардал

Үнэт цаас гаргагч нь 2024 онд ерөнхий ба удирдлагын зардал 4.2 тэрбум төгрөг байхаар төсөөлсөн ба үүний 32.7 хувийг буюу 1.4 тэрбум төгрөгийг үндсэн ба нэмэгдэл цалин, шууд бус хөдөлмөр болон НДШ-ийн зардал, 32.6 хувь буюу 1.4 тэрбум төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал, 20.9 буюу 0.9 тэрбум төгрөгийг тээврийн зардал бүрдүүлсэн бол үлдсэн 13.8 хувь буюу 0.6 тэрбум төгрөгийг бусад ерөнхий ба удирдлагын зардал бүрдүүлэх төсөөлөлтэй байна.

СЭХ 2024.07 сар 05 өдөр БҮРТГЭВ
2024-06-03 БҮРТГЭВ-02
TDB SECURITIES

СЭХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ

2024-06-03
БҮРТГЭВ-02

**Зураг 67: Үнэт цаас гаргагчийн ерөнхий ба удирдлагын зардлын төсөөлөл болон түүний бүтэц, тэрбум төгрөг, 2024-2028 он**




2025 онд Үнэт цаас гаргагчийн ерөнхий ба удирдлагын зардал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 тэрбум төгрөг буюу 21.3 хувиар буурах төсөөлөлтэй байгаа ба үүнд Үнэт цаас гаргагчийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 1.2 тэрбум төгрөг буюу 85.3 хувиар буурах төсөөлөлтэй байгаа нь голчлон нөлөөлжээ.

2025-2028 онд Үнэт цаас гаргагчийн ерөнхий ба удирдлагын зардал жилд дунджаар 10.8 хувиар өсөх төсөөлөлтэй байна. Үүнийг бүтцээр нь задалбал тус хугацаанд үндсэн ба нэмэгдэл цалин, шууд бус хөдөлмөр болон НДШ-ийн зардал жилд дунжаар 15.2 хувиар өсөх ба 2028 онд 2.3 тэрбум төгрөгт хүрч ерөнхий ба удирдлагын зардлын талаас их буюу 50.2 хувийг бүрдүүлж байна. Харин Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги чиглэл болох экспортын тэлэлттэй холбоотой тээврийн зардал тус хугацаанд дунджаар 8.2 хувиар өсөж 2028 онд 1.3 тэрбум, бусад ерөнхий ба удирдлагын зардал 5.2 хувиар өсөж 2028 онд 0.7 тэрбум төгрөгт хүрсэн нь ерөнхий ба удирдлагын зардлын 27.9, 16.6 хувийг тус тус бүрдүүлэхээр байна.

**Гадаад валютын ханшийн зөрүүний бодит гарз**

Үнэт цаас гаргагч нь өрийн бичгийн купон болон үндсэн төлбөрийн төлөлтөөс гадаад валютын ханшийн зөрүүний гарзыг хүлээн зөвшөөрөх төсөөлөлтэй байна. Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь 2024-2028 онд ам.долларын төгрөгтэй харьцах ханшийг жилд дунджаар 4.4 хувиар өсөхөөр төсөөлсөн байна.

Үнэт цаас гаргагчийн гадаад валютын ханшийн зөрүүний бодит гарз 2025 онд өмнөх оны мөн үеэс 3.1 дахин өсөж 3.1 тэрбум төгрөг, 2026 онд 22.4 хувиар өсөж 3.8 тэрбум төгрөг хүрэхээр байгаа ба энэ нь тухайн жилийн борлуулалтын орлогын 7.9 хувьтай тэнцэх алдагдал болж байна.

2027 онд Үнэт цаас гаргагчийн гадаад валютын ханшийн зөрүүний бодит гарз өмнөх оны мөн үеэс 72.2 хувиар буюу 2.7 тэрбум төгрөгөөр буурч 1.0 тэрбум төгрөг болох бол 2028 онд 91.3 хувиар буюу 952.8 сая төгрөгөөр буурч 91.1 сая төгрөгийн алдагдал хүлээх төсөөлөлтэй байна.

**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**

Үнэт цаас гаргагч нь үйлдвэрийн хүчин чадлаа илүү ашиглах, хүнсний зориулалттай дахин боловсруулсан Полиэтилин Терефталат (rPET) мөхлөг үйлдвэрлэн борлуулах зэргээр 2024-2028 онд татварын цэвэр ашгийн жилийн дундаж өсөлтийн түвшин 36.2 хувь буюу 2028 онд 22.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, нийт 17.7 тэрбум төгрөгийн татварыг төлөхөөр төсөөлсөн байна.

TDB SECURITIES

## 2.8.3.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

**Хүснэгт 44: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлангийн төсөөлөл, сая төгрөг, 2024-2028 он**

| Үзүүлэлт, сая төгрөг | 2024 | 2025 | 2026 | 2027 | 2028 |
|---|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 9,816.1 | 16,347.5 | 25,104.4 | 149.1 | 8,346.1 |
| Татвар, НДШ -ийн авлага | 3,900.9 | 4,007.6 | 3,698.7 | 2,979.2 | 1,520.3 |
| Дансны авлага | 5,719.3 | 7,816.2 | 9,676.1 | 8,431.4 | 10,719.6 |
| Бараа материал | 5,974.3 | 7,251.3 | 7,872.7 | 10,411.2 | 13,026.3 |
| Урьдчилж төлсөн зардал / тооцоо | 653.5 | 3,295.3 | 6,586.1 | 8,654.5 | 8,667.9 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **26,064.2** | **38,717.9** | **52,937.8** | **30,625.3** | **42,280.1** |
| | | | | | |
| Үндсэн хөрөнгө | 45,055.0 | 44,083.5 | 42,218.3 | 39,826.1 | 38,347.4 |
| Биет бус хөрөнгө | 2,004.3 | 2,004.2 | 2,004.0 | 2,003.8 | 2,003.7 |
| Хөрөнгө оруулалт | 3,461.9 | 7,304.5 | 7,728.2 | 0.0 | 4,111.2 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 97.5 | 309.3 | 627.0 | 107.5 | 0.0 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **50,618.7** | **53,701.5** | **52,577.5** | **41,937.4** | **44,462.3** |
| | | | | | |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **76,682.9** | **92,419.4** | **105,515.3** | **72,562.7** | **86,742.4** |
| | | | | | |
| Дансны өглөг | 71.6 | 75.9 | 80.4 | 85.3 | 90.4 |
| Цалингийн өглөг | 101.8 | 110.0 | 145.9 | 189.0 | 170.1 |
| Хүүгийн өглөг | 750.1 | 243.5 | 257.6 | 267.4 | 0.0 |
| НӨАТ өглөг | 0.0 | 0.0 | 38.7 | 379.1 | 221.7 |
| Татвар, НДШ-ийн өр төлбөр | 674.6 | 900.1 | 1,640.7 | 2,397.7 | 3,342.5 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 8,205.9 | 5,572.0 | 2,358.0 | 1,386.5 | 592.5 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **9,803.9** | **6,901.5** | **4,521.3** | **4,704.9** | **4,417.2** |
| | | | | | |
| Урт хугацаат өр төлбөр | 44,029.0 | 54,783.8 | 57,961.2 | 8,021.8 | 0.0 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **44,029.0** | **54,783.8** | **57,961.2** | **8,021.8** | **0.0** |
| | | | | | |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **53,832.9** | **61,685.3** | **62,482.5** | **12,726.8** | **4,417.2** |
| | | | | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 |
| Төрийн | - | - | - | - | - |
| Хувийн | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 17,246.6 | 17,246.6 | 17,246.6 | 17,246.6 | 17,246.6 |
| Хуримтлагдсан ашиг | 5,593.3 | 13,477.4 | 25,776.2 | 42,579.3 | 65,068.5 |
| | | | | | |
| **Эздийн өмчийн нийт дүн** | **22,849.9** | **30,734.1** | **43,032.8** | **59,836.0** | **82,325.2** |
| | | | | | |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **76,682.9** | **92,419.4** | **105,515.3** | **72,562.7** | **86,742.4** |

### НИЙТ ХӨРӨНГӨ

Үнэт цаас гаргагчийн Дунд хугацааны бизнес төлөвлөлтөд тусгагдсаны дагуу нийт хөрөнгө нь 2024 оноос 2026 онд жилд дунджаар 17.2 хувиар өсөж 105.5 тэрбум төгрөгт хүрэх боловч 2026 оноос 2028 онд үндсэн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын бууралтаас үүдэн жилд дунджаар 9.3 хувиар буурч 86.7 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна.

СЭХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Зураг 74: Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн бүтэц, 2024-2028 он**




**Эргэлтийн хөрөнгө**

Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнесийн төлөвлөлтөд тусгагдсаны дагуу эргэлтийн хөрөнгө нь 2024-2028 онд жилд дунджаар 12.6 хувиар өсөж, 2028 оны байдлаар нийт хөрөнгийн 48.7 хувийг бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 2024-2026 онд жилд дунджаар 59.9 хувиар өссөнөөр 25.1 тэрбум төгрөг хүрэх боловч өрийн бичгийн үндсэн төлбөрийг төлснөөр бууран 2028 онд 8.2 тэрбум мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөтэй байх төсөөлөлтэй байна.

**Зураг 75: Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгийн бүтэц, 2024-2028 он**




Эргэлтийн хөрөнгийн дансны авлага, бараа материал болон урьдчилж төлсөн зардлын данс нь тогтмол өсөлттэй байна. Тодруулбал дансны авлагын 2024-2028 оны жилийн дундаж өсөлт 17.0 хувь байсан ба 2028 онд 10.7 тэрбум төгрөг буюу нийт эргэлтийн хөрөнгийн 25.4 хувийг бүрдүүлж байсан бол бараа материалын жилийн дундаж өсөлт 21.5 хувь байсан ба 2028 онд 13.0 тэрбум төгрөг буюу эргэлтийн хөрөнгийн 30.8 хувийг бүрдүүлэх төсөөлөлтэй байна. Урьдчилж төлсөн зардлын данс харьцангуй өндөр өсөлттэй буюу жилийн дундаж өсөлтийн түвшин 90.8 хувь байсан ба 2028 онд 8.7 тэрбум хүрэх нь нийт эргэлтийн хөрөнгийн 20.5 хувийг бүрдүүлэх төсөөлөлтэй байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES

СЗХ 2024.07.05 бүртгэв № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03

### Эргэлтийн бус хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгө 2024-2028 онд жилд дунджаар 3.2 хувиар буурах төсөөлөлтэй байна. 2028 онд Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгийн дийлэнх хэсгийг буюу эргэлтийн бус хөрөнгийн 86.2 хувийг үндсэн хөрөнгө бүрдүүлэх бол биет бус хөрөнгө 4.5 хувь, хөрөнгө оруулалт 9.2 хувийг бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгө нь элэгдлийн зардалтай холбоотойгоор 2024-2028 онд жилд дунджаар 3.9 хувиар буурч 2028 онд 38.3 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт эргэлтийн бус хөрөнгийн бууралтад нөлөөлсөн бол Үнэт цаас гаргагчийн биет бус хөрөнгө болох эзэмших эрхтэй газрын дүн тогтвортой буюу 2.0 тэрбум байх төсөөлөлтэй байна.

**Зураг 76: Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгийн бүтэц, 2024-2028 он**




Үнэт цаас гаргагч нь өөрийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлээ дэмжих зорилгоор дэд бүтэц, логистик, түүхий эдийн татан авалтыг сайжруулах төлөвлөгөөний хүрээнд өөрийн охин компани болох Эс И Эс Эл Смарт Солюшн ХХК-д хөрөнгө оруулснаар хөрөнгө оруулалтын хэмжээ 2024-2026 онд жилд дунджаар 49.4 хувиар өсөж 7.7 тэрбум төгрөгт хүрэх боловч цаашид жилд дунджаар 27.1 хувиар бууруулан 2028 онд 4.1 тэрбум төгрөгт хүрэх төлөвлөгөөтэй байна.

### НИЙТ ӨР ТӨЛБӨР

Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөлтөд тусгагдсаны дагуу богино хугацаат өр төлбөр нь 2024-2028 онд жилд дунджаар 18.1 хувиар буурах бол урт хугацааны хөрөнгө оруулалтад зөвхөн Үнэт цаас гаргагчийн гаргах өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд гаргасан бондын өр төлбөр байх төсөөлөлтэй байна.

**Зураг 77: Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн бүтэц, 2024-2028**






TDB SECURITIES
ТЖТБ ХХК

СЗХ 2024.07.05 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03

Бусад богино хугацаат өр төлбөр буюу Үнэт цаас гаргагчийн дансны өглөг, цалингийн өглөг болон татвар, НДШ-ийн өглөг 2024-2028 он хүртэл жилд дунджаар харгалзан 6.0, 13.7, 49.2 хувиар өсөж байгаа ба тус хугацаанд Үнэт цаас гаргагчийн холбоотой талд өгөх өглөгийн жилийн дундаж бууралт 52.2 хувь байснаар богино хугацаат өр төлбөр нь жилд дунджаар 48.2 хувиар буурч, 2028 онд 0.6 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Үнэт цаас гаргагч нь өөрийн нэгдлийн компани болох "Ти Эм Эл" ГХОХХК-аас 38.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үндсэн хөрөнгийг төлбөрийг дараа шилжүүлэх нөхцөлтэйгээр шилжүүлэн авсан ба тус тоног төхөөрөмжийн худалдан авалтын төлбөрийг 2024 онд төлөхөөр төлөвлөснөөр холбоотой талд өгөх өглөгийн хэмжээ буурах төсөөлөлтэй байна.

Үнэт цаас гаргагчийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд гаргах 15.0 сая ам.доллар хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичгийн хөтөлбөрөөр урт хугацаанд санхүүжилт татахаар төлөвлөсөн ба тус урт хугацаат бонд нь 2028 онд бүрэн төлөгдөж дуусах төлөвлөгөөтэй байна.

## ЭЗДИЙН ӨМЧ

Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны санхүүгийн төлөвлөлтөд эздийн өмчийн дүн 2024-2028 онд 37.8 хувиар өсөж, 2028 онд 82.3 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөж байна.

**Зураг 78: Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн бүтэц, 2024-2028 он**




Хуримтлагдсан ашиг нь 2024-2028 он хүртэл жилд дунджаар 84.7 хувийн өсөлттэй байх ба 2028 онд 65.1 тэрбум төгрөг болж өсөх төсөөлөлтэй байгаа нь Компанийн эздийн өмчийн хэмжээг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

### 2.8.3.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ШИНЖИЛГЭЭ

**Хүснэгт 45: Үнэт цаас гаргагчийн харьцаа үзүүлэлтүүдийн төсөөлөл**

| Үзүүлэлт, сая төгрөг | 2024F | 2025F | 2026F | 2027F | 2028F |
|---|---|---|---|---|---|
| **Хөрвөх чадварын харьцаа** | | | | | |
| Эргэлтийн харьцаа | 2.66 | 5.61 | 11.71 | 6.51 | 9.57 |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 1.98 | 4.08 | 8.51 | 2.46 | 4.66 |
| Бэлэн мөнгөний харьцаа | 1.00 | 2.37 | 5.55 | 0.03 | 1.89 |
| **Төлбөрийн чадварын харьцаа** | | | | | |
| Өрийн харьцаа* | 57.4% | 59.3% | 54.9% | 11.1% | 0.0% |
| Өр эздийн өмчийн харьцаа** | 1.93 | 1.78 | 1.35 | 0.13 | 0.00 |
| Санхүүгийн хөшүүрэг | 3.55 | 3.16 | 2.68 | 1.73 | 1.12 |
| Хүү төлөх чадварын харьцаа | 4.53 | 2.94 | 3.75 | 7.50 | 73.38 |
| **Үйл ажиллагааны харьцаа** | | | | | |
| Бараа материалын эргэц (удаа) | 4.06 | 3.19 | 3.06 | 2.80 | 2.35 |
| Бараа материалын эргэц (өдөр) | 89.86 | 114.30 | 119.09 | 130.56 | 155.60 |
| Авлагын эргэц (удаа) | 7.60 | 5.95 | 5.44 | 6.00 | 6.39 |
| Авлагын эргэц (өдөр) | 48.03 | 61.39 | 67.12 | 60.80 | 57.08 |
| Өглөгийн эргэц (удаа) | 470.7 | 303.7 | 304.4 | 339.1 | 342.8 |
| Өглөгийн эргэц (өдөр) | 0.78 | 1.20 | 1.20 | 1.08 | 1.06 |
| **Ашигт ажиллагааны харьцаа** | | | | | |
| Нийт ашгийн ахиуц | 44.7% | 47.5% | 51.3% | 53.0% | 55.1% |
| Цэвэр ашгийн ахиуц | 18.8% | 19.6% | 25.9% | 30.9% | 36.7% |
| Хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх ашгийн ахиуц (EBITDA margin) | 44.5% | 50.6% | 53.3% | 54.4% | 56.1% |
| Үйл ажиллагааны ахиуц | 31.9% | 38.7% | 42.6% | 44.8% | 47.3% |
| Нийт хөрөнгийн өгөөж (ROA) | 9.4% | 9.3% | 12.4% | 18.9% | 28.2% |
| Нийт эздийн өмчийн өгөөж (ROE) | 33.5% | 29.4% | 33.3% | 32.7% | 31.6% |

**Хүү төлөгдөх өр төлбөрийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа*
*** Хүү төлөгдөх өр төлбөрийг эздийн өмчид харьцуулсан харьцаа*

**Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд**

2024-2028 онд Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд болох эргэлтийн харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа болон бэлэн мөнгөний харьцаа үзүүлэлтүүд тогтмол өсөх боловч 2027 онд бондын эргэлт төлөлттэй холбоотойгоор эргэлтийн хөрөнгө, тэр дундаа мөнгө, түүнтэй түүнтэй адилтгах хөрөнгийн эрс бууралтаас үүдэн буурах боловч 2028 оноос буцаж өсөх төсөөлөлтэй байна.

Тухайлбал, 2024 Үнэт цаас гаргагчийн эргэлтийн харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа болон бэлэн мөнгөний харьцаа үзүүлэлтүүд харгалзан 2.66, 1.98, 1.00 байсан бол 2028 онд эдгээр харьцаа үзүүлэлтүүд нь 9.57, 4.66 болон 1.89 болж өсөх төсөөлөлтэй байна.

СЗХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Зураг 79: Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд, 2024-2028 он**




2027 онд Үнэт цаас гаргагчийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 25.0 тэрбум төгрөг буюу 99.4 хувь, дансны авлага 1.2 тэрбум төгрөг буюу 12.9 хувь, татвар, НДШ-ийн авлага 0.7 тэрбум төгрөг буюу 19.5 хувиар буурснаар эргэлтийн хөрөнгийн дүн 22.4 тэрбум төгрөгөөр буюу 42.1 хувиар буурах тооцоололтой байгаа нь Үнэт цаас гаргагчийн 2027 оны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн төсөөллийг бууруулахад голчлон нөлөөлжээ.

**Төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтүүд**

Үнэт цаас гаргагчийн өрийн харьцаа, өр эздийн өмчийн харьцаа, санхүүгийн хөшүүргийн харьцаа үзүүлэлтүүд 2026 он хүртэл харьцангуй тогтмол байх бол 2027 оноос бондын үндсэн төлбөр төлөгдсөнөөр буурч эхлэх төсөөлөлтэй байна.

**Зураг 80: Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтүүд, 2024-2028 он**




Тухайлбал 2024-2026 онд Үнэт цаас гаргагчийн өрийн харьцаа 57.4 хувиас 54.9 хувь болж 2.5 нэгж хувиар, өр эздийн өмчийн харьцаа 1.93-аас 1.35 болж 0.58 нэгжээр, санхүүгийн хөшүүргийн хэмжээ 3.45-аас 2.68 болж 0.77 нэгжээр буурах төсөөлөлтэй байна. Харин 2027 оны хувьд тухайн үзүүлэлтүүд нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад огцом буурах буюу өрийн харьцаа 11.1 хувь болж 43.8 нэгж хувиар, өр эздийн өмчийн харьцаа 0.13 болж 1.22 нэгжээр, санхүүгийн хөшүүргийн харьцаа 1.73 болж 0.95 нэгжээр тус тус буурах тооцоололтой байна.

Харин Үнэт цаас гаргагчийн хүү төлөх чадварын харьцаа мөн адил 2024-2026 онд харьцангуй тогтмол буюу 2026 онд 1.58 байсан нь 2024 оны мөн үетэй харьцуулахад 0.02 нэгжээр буурсан үзүүлэлттэй байх бол 2027 онд тус үзүүлэлт 0.86 нэгжээр, 2028 онд 15.12 нэгжээр өсөж, 17.55 болох төсөөлөлтэй байна.

TDB SECURITIES

СЗХ
2024.07.05
БҮРТГЭВ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

### Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд

2024 онд Үнэт цаас гаргагчийн бараа материал жилд 3.55 удаа буюу 102.8 хоногт нэг эргэх бол тус үзүүлэлт нь бараа материалын жилийн 21.5 хувийн дундаж өсөлтийн нөлөөгөөр буурч, 2028 онд жилд 2.35 удаа буюу 155.6 хоногт нэг удаа эргэх төсөөлөлтэй байна.

**Зураг 81: Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, 2024-2028 он**




Үнэт цаас гаргагчийн дундаж авлагын хэмжээ 2025 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 тэрбум төгрөгөөр буюу 95.7 хувиар өсөх ба энэ нь үнэт цаас гаргагчийн авлагын эргэц 2024 онд 7.60 байснаас 2025 онд 5.95 болж 1.65 нэгжээр буурахад голчлон нөлөөлнө. Үнэт цаас гаргагчийн авлагын эргэц 2026 онд мөн 0.51 нэгжээр буурч жилд 5.44 удаа эргэх боловч борлуулалтын орлогын өсөлтөөс шалтгаалан 2026 оноос хойш өсөн, 2028 онд 6.39 эргэц буюу 57.08 хоногт нэг эргэх үзүүлэлттэй байх төсөөлөлтэй байна.

**Зураг 82: Үнэт цаас гаргагчийн өглөгийн эргэц, 2024-2028 он**




Үнэт цаас гаргагчийн өглөгийн эргэц 2024 онд жилд 470.7 удаа буюу 0.78 өдөрт нэг удаа эргэх төсөөлөлтэй байна. Тус үзүүлэлт нь 2025 онд дансны өглөгийн өсөлтийн нөлөөгөөр 167.0 нэгжээр буурч 303.7 буюу 1.20 өдөрт нэг эргэнэ. Цаашид 2025-2028 онд жилд дунджаар 13.0 нэгжээр өсөх ба 2023 онд өглөгийн эргэц 342.8 нэгжид хүрэх нь 1.06 өдөр нэг удаа эргэх үзүүлэлт юм. Үүнд Үнэт цаас гаргагчийн бараа материалийн жилийн дундаж 21.5 хувийн өсөлт болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 9.2 хувийн өсөлт голчлон нөлөөлнө.

### Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд

2024-2028 онд Үнэт цаас гаргагчийн ахиуц ашгийн харьцаа үзүүлэлтүүд болох нийт ашгийн ахиуц, цэвэр ашгийн ахиуц, Хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх ашгийн ахиуц болон үйл ажиллагааны ахиуц үзүүлэлтүүд тогтмол өссөн байхаар төсөөлөгдсөн ба энэ нь Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны

санхүүгийн төлөвлөгөөнд тусгагджээ. Тухайлбал, 2024 оноос 2028 оны хооронд Үнэт цаас гаргагчийн нийт ашгийн ахиуц 44.7 хувиас 55.1 хувь болж 10.4 нэгж хувиар, Цэвэр ашгийн ахиуц 18.8 хувиас 36.7 хувь болж 17.9 нэгж хувиар, Үйл ажиллагааны ахиуц 31.9 хувиас 47.3 хувь болж 15.4 хувиар, Хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх ашгийн ахиуц 44.3 хувиас 56.0 хувь болж 11.7 хувиар тус тус өсөх төсөөлөлтэй байна. Үүнд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 2024-2028 онд жилд дунджаар 15.2 хувиар өсөх бол Үнэт цаас гаргагчийн зардлууд жилд дунджаар 8.2 хувиар өсөх нь голчлон нөлөөлнө.

**Зураг 83: Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, 2024-2028 он**




Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж 2024 онд 9.5 хувь байх бол 2028 онд 28.2 хувьд хүрж 18.7 нэгж хувиар өсөх төсөөлөлтэй байгаа бол нийт эздийн өмчийн өгөөж харьцангуй тогтмол байх төсөөлөлтэй байна. Тухайлбал, 2024 онд Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн өгөөж 32.7 байх бол 2028 онд үүнээс 1.1 нэгж хувиар буурч 31.6 хувьд хүрэхээр байна. Үүнд Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг 2024-2028 онд жилд дунджаар 36.2 хувиар өсөх тооцоололтой байгаа ба эздийн өмч мөн адил тус хугацаанд 37.8 хувиар өсөх нь голчлон нөлөөлсөн байна.

**Зураг 84: Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөж, 2024-2028 он**



ДуПонт шинжилгээ

Үнэт цаас гаргагчийн ДуПонт шинжилгээ дараах байдалтай байна.

**Хүснэгт 46: Үнэт цаас гаргагчийн ДуПонт шинжилгээ**

| ДуПонт шинжилгээ | 2024 | 2025 | 2026 | 2027 | 2028 |
|---|---|---|---|---|---|
| **Эдийн өмчийн өгөөж (ROE)** | 33.5% | 29.4% | 33.3% | 32.7% | 31.6% |
| Цэвэр ашгийн ахиуц | 18.8% | 19.6% | 25.9% | 30.9% | 36.7% |
| Нийт хөрөнгийн эргэц | 0.50 | 0.48 | 0.48 | 0.61 | 0.77 |
| Санхүүгийн хөшүүрэг / Эздийн өмчийн үржүүлэгч | 3.55 | 3.16 | 2.68 | 1.73 | 1.12 |

Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн ахиуц өсөж байгаа боловч өр төлбөрийн бууралтаас үүдсэн санхүүгийн хөшүүрэг буюу эздийн өмчийн үржүүлэгчийн бууралтын нөлөөгөөр эздийн өмчийн өгөөж харьцангуй тогтмол байх төлөвтэй байна.

СЗХ 2024.07.05 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES

СЗХ
2024 он .07 сар .05 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

## 2.9. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ БА ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

### 2.9.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагын гурван давхар хамгаалалтын шугамыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд өөрийн удирдлагын тогтолцоо, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороогоор дамжуулан үйл ажиллагаандаа учирч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох, сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах талаар Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, журам болон холбогдох бусад заавар, журмын хүрээнд тодорхойлогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавин ажилладаг.

**Зураг 85: Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо**




Компанийн Эрсдэлийн удирдлагын журмын хүрээнд Эрсдэлийн удирдлагын баг нь тогтоосон хугацаанд эрсдэлийн үнэлгээг хийж компанийн удирдлагын багт танилцуулдаг бөгөөд эрсдэлийн удирдлагын гурван шугамын хамгаалалтыг дараах албан тушаалтан хариуцаж ажилладаг байна.

**Хүснэгт 47: Эрсдэлийн удирдлагын гурван шугамын хамгаалалт, хариуцах албан тушаалтан**

| | |
|---|---|
| I хамгаалах шугам | Компанийн цуглуулах алба, БОНЗ менежер, үйлдвэр, чанарын албаны дарга, тухайн учирсан эрсдэл харьяалагдах алба нэгж |
| II хамгаалах шугам | Гүйцэтгэх захирал, Санхүүгийн шинжээч, хуулийн зөвлөх |
| III хамгаалах шугам | Компанийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо |

Компани нь өөрийн Эрсдэлийн удирдлагын журмын хүрээнд учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэж, хүлээн зөвшөөрөх, эрсдэлийг бууруулах, эрсдэлээс зайлсхийх гэсэн арга гурван шугамын хамгаалалтын дагуу хэрэгжүүлдэг бөгөөд тус журмын дагуу дараах байдлаар эрсдэлийн зэрэглэлийг тогтоодог байна. Үүнд:

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

**Хүснэгт 48: Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн зэрэглэл**

| Зэрэглэлийн түвшин | 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|---|
| **Нөлөөллийн цар хэмжээ** | Ач холбогдолгүй | Бага | Дунд | Өндөр | Аюултай |
| **Санхүүгийн төсвийн хэмжээ, бодит эрсдэлийн төсөвт эзлэх хувь** | 10 сая төгрөг дотор | 10-100 сая төгрөгийн хооронд төсөвтэй | 100-500 сая төгрөгийн төсөвтэй | 500 сая-1 тэрбум төгрөгийн хооронд төсөвтэй эсвэл төсвийн 1-5% хооронд дүнтэй эрсдэл тооцох боломжтой, хөрөнгийн дутагдал гарсан | 1 тэрбумаас төгрөгөөс дээш төсөвтэй эсвэл төсвийн 5%-аас дээш эрсдэл тооцох боломжтой эсвэл хөрөнгийн бодит дутагдал, шамшигдуулалт гарсан |
| **Үйл ажиллагааны эрсдэлийн түвшин** | Бодит хор нөлөө нь анзаарагддаггүй | Бодит хор нөлөө нь бага илэрдэг | Бодит хор нөлөө нь үе үе мэдрэгдэж, үйл ажиллагаанд заримдаа бодит саад учруулдаг | Бодит хор нөлөө нь үргэлжлэн илэрч, үйл ажиллагаанд байнга саад учруулдаг | Бодит хор нөлөө нь нэмэгдэж, үйл ажиллагаанд ноцтой саад учруулдаг |
| **Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэлийн түвшин** | Ашиглагдах хууль, журам цөөн зохицуулалтын шаардлага бага | Ашиглагдах хууль, журам цөөн зохицуулалтын шаардлага өөрчлөгддөггүй | Ашиглагдах хууль, журам цөөн боловч заримдаа өөрчлөлт, зохицуулалтын шаардлага гардаг | Үйл ажиллагаанд ашиглагдах хуулиуд байнга өөрчлөгдөж байдаг, зохицуулалтын шаардлага байнга гардаг | Ашиглагдах хууль, журам байнга өөрчлөгдөж зохицуулалтыг үндсээр нь өөрчилж шинэчлэх шаардлагатай |
| **Гадаад хүчин зүйлсийн эрсдэлийн түвшин** | Бодит хор нөлөө нь анзаарагддаггүй | Бодит хор нөлөө нь бага илэрдэг | Бодит хор нөлөө нь үе үе мэдрэгдэж, үйл ажиллагаанд заримдаа бодит саад учруулдаг | Бодит хор нөлөө нь үргэлжлэн илэрч, үйл ажиллагаанд байнга саад учруулдаг | Бодит хор нөлөө нь нэмэгдэж, үйл ажиллагаанд ноцтой саад учруулдаг |

СЭХ
2024 он 07 сар 05 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2024 он 07. 05 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

## 2.9.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ

Компани нь Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох журам, заавар болон зөвлөмжийн хүрээнд дотоод үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, эрсдэлийн зохистой засаглал, хяналтын тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай бодлогыг нарийвчлан тодорхойлох хүрээнд Компанийн эрсдэлийн удирдлагын журмыг батлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг байна. Тус эрсдэлийн удирдлагын журмын хүрээнд Компанийн эрсдэлийн удирдлагын баг нь дараах зурагт тусгасан дарааллын дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг байна.

**Схем 3: Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх дараалал**




**Хүснэгт 49: Компанийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хийж гүйцэтгэх алхмууд**

| | |
|---|---|
| **Эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох** | • Өнгөрсөн жил тохиолдсон эрсдэл болон тухайн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө хэрэгжсэн эсэх, түүний хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт хийх;<br>• Алба хэлтсүүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлд хамаарах эрсдэл, түүний хүчин зүйлсийг тодорхойлох;<br>• Эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлж, эрсдэлийн талаар дүгнэлт гаргах. |
| **Эрсдэлийг үнэлэх** | • Тодорхойлсон эрсдэлүүдийг ангилалд хуваарилах замаар санхүүгийн болон эрсдэлийн шинжилгээг гүйцэтгэж, үнэлгээ өгөх;<br>• Мэдээллийн сангийн санал дүгнэлтэд үндэслэж эрсдэл үүсэх магадлалыг шинжилж үнэлгээ өгөх, тодорхой төрлийн эрсдэл үүссэний улмаас гарч болзошгүй алдагдлын хэмжээг тооцож эрсдэлийн матриц байгуулах. |
| **Эрсдэлийг удирдах стратегийг тодорхойлох** | • Эрсдэл үүсэх магадлалыг бууруулах, үүссэн эрсдэлийн улмаас хүлээх алдагдлын хэмжээг хамгийн бага түвшинд байлгах төлөвлөгөөг боловсруулах;<br>• Боловсруулсан төлөвлөгөөг салбар нэгжийн ажилтнуудад танилцуулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлэх заавarчилгааг өгөх. |
| **Эрсдэлийг хянах, тайлагнах** | • Тохиолдсон болон тодорхойлсон эрсдэл, түүний хүчин зүйлсэд хяналт тавьж, эргэн хяналтын тайланг бэлтгэх, тайлагнах ажлыг хамааруулна. |

Түүнчлэн Компанийн эрсдэлийн удирдлагын баг нь улирал бүр алба, нэгжээс ирүүлсэн эрсдэлийн бүртгэлийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж харьцангуй арга хэмжээ авах, дундаас дээш түвшний

TDB SECURITIES

шийдвэрлэгдээгүй эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан хяналт тавьж ажилладаг ба Компанийн эрсдэлийн удирдлагын баг нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

**Хүснэгт 50: Компанийн эрсдэлийн удирдлагын баг, түүний бүрэлдэхүүн**

| | |
|---|---|
| **Эрсдэлийн удирдлагын багийн дарга** | ♦ Санхүүгийн шинжээч. |
| **Эрсдэлийн удирдлагын багийн гишүүд** | ♦ Үйлдвэрийн дарга;<br>♦ Санхүүгийн шинжээч;<br>♦ БОНЗ менежер;<br>♦ Цуглуулалтын албаны дарга;<br>♦ ХАБЭА;<br>♦ Чанар, хяналтын албаны менежер;<br>♦ Эрсдэл гарсан алба, нэгжийн ажилтан. |
| **Эрсдэлийн удирдлагын багийн нарийн бичиг** | ♦ Хуулийн зөвлөх. |

Эрсдэлийн удирдлагын журмын хүрээнд эрсдэлийн удирдлагын баг нь болзошгүй эрсдэлийн судалгаа, төлөвлөгөөг тогтоосон хугацаанд үр дүнтэй гүйцэтгэх, батлагдсан эрсдэлийн төлөвлөгөөг холбогдох ажилтнуудад танилцуулах, мэдээлэх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, Компанийн удирдлагад үр дүнг танилцуулах үүрэгтэй. Харин Компанийн удирдлагын баг нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхийн хүрээнд эрсдэл болон боломжид чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцөөр хангах; үүрэг хариуцлагыг ажилтан, алба нэгжид хуваарилж, шийдвэр гаргах үүрэгтэй байна.

2024.07.05 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

2024 он 07 сар 05 ... өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

### 2.9.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компани нь эрсдэлийн удирдлагын журмын хүрээнд компанид учирч болзошгүй гадаад болон дотоод эрсдэлүүдийг болон тухайн эрсдэл учрахад хэрэгжүүлэх арга хэмжээг Эрсдэлийн удирдлагын журмын дагуу тодорхойлсон байдаг бөгөөд дараах байдалтай эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг байна.

Компанид учирч болзошгүй гадаад хүчин зүйлсийн эрсдэл болон түүний удирдлага дараах байдалтай байна. Үүнд:

**Хүснэгт 51: Үнэт цаас гаргагчийн гадаад эрсдэлийн хүчин зүйлс, түүний удирдлага**

| Эрсдэлийн хүчин зүйл | Эрсдэлийн удирдлага |
|---|---|
| **Хууль, эрхзүйн орчин, хяналт зохицуулалттай холбоотой эрсдэл** | Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан тушаал, шийдвэр, заавар, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.<br>Компани нь үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журмын анхдагч болон шинэчилсэн найруулга, түүний нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр судалж, холбогдох үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээ хариуцаж буй газар, нэгжид хүргүүлэн, Компанийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэх ажлыг гүйцэтгэснээр хууль эрх зүйн хувьд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах боломжтой байна. |
| **Макро эдийн засгийн нөхцөл байдал болон зах зээлийн эрсдэл** | Эдийн засгийн өсөлт бууралт, бодлогын хүү болон инфляцын өөрчлөлт зэрэг макро эдийн засгийн чиг хандлага, зах зээлийн тогтворгүй байдал нь Компанийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Эрсдэл болон боломжуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний маягтын дагуу Компани нь эдийн засгийн эрсдэлийг бууруулахаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:<br>♦ Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан ногоон төслийн хүрээнд өртөг бага шинэ санхүүгийн эх үүсвэрүүд хайх;<br>♦ Худалдан авагч талуудтай борлуулалтын сувгийн идэвхийг хамгаалах хэлэлцээрүүдийг тогтмол байгуулах;<br>♦ Үнийн тогтвортой бодлого явуулах, үүний хүрээнд түүхий эдийн зохист хэмжээг үргэлж хангаж ажиллахаар төлөвлөж байна.<br>Мөн Монгол Улсын хэрэгжүүлж буй "Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хог хаягдлын менежментийг зөв зохистой хэвшүүлэхээр төлөвлөж байгаа нь Компанийн цаашдын үйл ажиллагаа, салбарын хөгжилд бодлогын түвшинд дэмжлэг үзүүлэх боломжтой байна. |
| **Ханшийн эрсдэл** | Үнэт цаас гаргагч нь хог хаягдлыг дахин боловсруулах голлох түүхий эд болох химийн бодисыг Герман болон Орос улсаас худалдаж авдаг бөгөөд бараа бүтээгдэхүүнээ дотоодын төгрөг болон гадаад валютаар борлуулдаг байна. Иймд экспорт, импорт болон Монголбанкны ам.долларын нөөцийн өөрчлөлт зэргээс шалтгаалан ханшийн эрсдэл үүсэх нь Компанийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Үйл ажиллагаа болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд Компани нь импортын түүхий эд болох химийн бодисыг олон төрлийн сувгаас сонгох байдлаар арга хэмжээ авч эрсдэлийг бууруулах боломжтой байна.<br>Түүнчлэн, Компани нь 2024 онд нээлттэй хэлбэрээр ам.долларын бонд гаргаж санхүүжилт татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна. Дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу 2024-2028 онд бондын үндсэн болон хүүгийн эргэн төлөлттэй холбоотой Үнэт цаас гаргагчид нийт 9.0 тэрбум төгрөгийн ханшийн зөрүүний гарз үүсэж байгаа хэдий ч цаашид Компани нь 1 килограмм бүтээгдэхүүнийг 1,252-1,423 ам.доллароор борлуулахаар буюу бүтээгдэхүүн үйлчилгээний орлогыг доллароор хүлээж авахаар төлөвлөж байгаа нь учирч болзошгүй ханшийн эрсдэлээс сэргийлж байна. Ингэснээр 2024-2028 оны ханшийн зөрүүний гарз нь компанийн борлуулалтын орлогын 7.9-0.1 хувийг бүрдүүлж байна. |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES

2024.07.05
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

| | |
|---|---|
| **Давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл** | Байгалийн гамшигт үзэгдэл, жагсаал цуглаан, үймээн, хэл хорио, олон нийтийг хамарсан өвчлөл зэрэг давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн Үнэт цаас гаргагчийн хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсэх, үйл ажиллагаа түр хугацаагаар зогсох улмаар алдагдал хүлээх зэрэг эрсдэл үүсэх боломжтой ба тус эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Компани нь нөөцийн үр ашигт байдлыг эхний зорилт болгож ажилладаг бөгөөд давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл учирсан тохиолдолд нөхцөл байдалд тохируулан түргэн шуурхай, уян хатан шийдвэр гаргах бодлого баримтлан ажиллаж байна. |

Компани нь үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой байдлыг хангах, цаашлаад ашигт ажиллагааг тогтвортой нэмэгдүүлэхэд учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэн оновчтой эрсдэлийн бодлогыг баримталж ажиллахыг чухалчлан үздэг тул үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлж, эрсдэлийн удирдлагын хүрээнд хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлон ажиллаж байна. Компанийн үйл ажиллагааны эрсдэлд үйлдвэрлэлийн, дотоод процессын, худалдан авагч, нийлүүлэгчийн болон хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлүүдийг хамруулан авч үздэг бөгөөд дараах байдлаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна.

**Хүснэгт 52: Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, түүний удирдлага**

| Эрсдэлийн хүчин зүйл | Эрсдэлийн удирдлага |
|---|---|
| **Үйл ажиллагааны эрсдэл** | Үнэт цаас гаргагч нь нь Европын Хүнсний Аюулгүй Байдлын Газар (EFSA) болон АНУ-д Хүнс, Эмийн Захиргаа (FDA) –ны стандартуудыг 2023 онд үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд сертификатын хугацаа дуусгавар болох буюу хугацааг сунгах үед Компани стандартын шаардлагыг бүрэн хангаагүй, үйл ажиллагаанд мөрдөгддөг зарчмууд өөрчлөгдсөн зэргээс шалтгаалж Олон улсын стандартын гэрчилгээ сунгагдахгүй байх эрсдэл үүсэх боломжтой байна.<br><br>Иймд, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулахын тулд Компани нь үйл ажиллагаандаа стандартын зарчмуудыг мөрдөж ажилладаг бөгөөд үүний хүрээнд дахин боловсруулсан бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартыг дагуу үйлдвэрлэж, 24 цагийн давтамжтайгаар тухайлсан нэг цагт тогтмол дээж авч шалгах зэргээр чанарын хяналтын системийг сайжруулан ажиллаж байна. |
| **Үйлдвэрлэлийн эрсдэл** | Тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтэл болон цахилгааны хязгаарлалтаас шалтгаалан Компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тасалдах, сул зогсолт болж, үр ашигт ажиллагаа багасах, төлөвлөгдсөн хугацаанд төлөвлөгдсөн тоо хэмжээний бүтээгдэхүүнийг нийлүүлж чадаагүйгээс болж Компанийн үйл ажиллагаа тасалдах, гэрээт хэрэглэгч нарт бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж чадахгүй байх зэрэг эрсдэл үүсэж болзошгүй юм.<br><br>Үнэт цаас гаргагч нь 24 цагийн турш үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавидаг ба тоног төхөөрөмжийн ажиллах цагийн ачааллыг тохируулан тооцоолж, цахилгаан эрчим хүчний хэрэглээ, нөөцийг хянах, долоо хоног бүр тоног төхөөрөмжид тогтмол үзлэг шалгалт хийж үйлдвэрлэлтэй холбоотой эрсдэлийг бууруулж байна. Мөн, Итали улсын Erema болон Австри улсын Sorema гэх үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрлэгч компаниудаас холбогдох мэргэжилтнүүд тогтмол хугацаанд ирж тоног төхөөрөмжүүдийг бүрэн үзлэгт хамруулан, шаардлагатай засвар үйлчилгээг үзүүлдэг байна. |
| **Дотоод процессын эрсдэл** | Компанийн дотоод харилцаа, холбоо болон процессын уялдаагүй байдал, бүртгэл, тайлан, мэдээллийн алдаатай байдал, үйл ажиллагааны үр дүн, чанар муудалт, дотоод мэдээлэл алдагдах зэрэг Компанийн дотоод зохион байгуулалт, процессоос шалтгаалж үйл ажиллагаа доголдох, улмаар хэрэглэгч нарын итгэлийг алдах эрсдэл үүсэж болзошгүй байна.<br><br>Үнэт цаас гаргагч нь Эрсдэлийн удирдлагын журмын хүрээнд дотоод процессын эрсдэлийг бууруулахын тулд дунд түвшний менежерүүдийг дотоод үйл ажиллагааны журмуудыг зайлшгүй сахин мөрдөх шаардлагыг тавьж ажилладаг бөгөөд сар бүр ажилтны |

TDB SECURITIES

дотоод процесстой холбоотой KPI-г удирдлагын зүгээс ТУЗ-д танилцуулж, шаардлагатай арга хэмжээг гүйцэтгэх замаар эрсдэлийг бууруулж ажилладаг байна.

**Нийлүүлэгчийн эрсдэл**

Бэлтгэн нийлүүлэгчээс захиалсан түүхий эд материал товолсон цагт ирэхгүй байх үүнээс улбаалан Компанийн үр ашигт ажиллагаа буурах, үйл ажиллагаа тасалдах, бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгч нарт тогтоосон хугацаанд нийлүүлж чадахгүй байх эрсдэл үүсэх боломжтой.

Компани нь олон тооны нийлүүлэгчтэй стандартын шаардлагыг хангасан бараа бүтээгдэхүүнийг тогтоосон хугацаанд хүлээж авахаар гэрээ байгуулж, үндсэн болон дайвар түүхий эд материалыг хямд үнээр худалдаж авах боломжийг тасралтгүй эрэлхийлэх замаар нийлүүлэгчийн эрсдэлийг бууруулж ажиллаж байна.

**Төлбөрийн болон хөрвөх чадварын эрсдэл**

Компани нь аливаа гуравдагч этгээдийн өмнө гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох, мөн мөнгөн хөрөнгийн дутагдалд орох эрсдэл үүсэх боломжтой.

Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд гарах үнэт цаасыг зах зээлд транч хэлбэрээр хэсэгчлэн гаргаж, транч дахь бонд тус бүрийн нарийвчилсан нөхцөл буюу хүүгийн хэмжээ зэргийг тухай бүр Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж гаргахаар байгаа нь эх үүсвэрийн өртгийг удирдах боломжийг бүрдүүлж байна. Мөн, Компани нь Эрсдэлийн удирдлагын журмын хүрээнд авлагын эргэцийг 60 хоногийн хугацаан дотор барих замаар хөрвөх чадварын эрсдэлийг бууруулж ажилладаг ба 2023 оны жилийн эцсийн байдлаар хүү төлдөг өр төлбөргүй байна.

**Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл**

Ажилтан, албан хаагч ажлын байранд хөдөлмөрлөх явцад, эрүүл мэндэд нь сөрөг нөлөөлөл бий болж болохуйц химийн, физикийн, биологийн, сэтгэл зүйн болон физиологийн эрсдэлүүдийг хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлд авч үзэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь ХАБЭА-н ерөнхий дүрэм, ХАБЭА-н дотоод журам, ХАБЭА-н дотоод хяналтын журмын дагуу дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлдэг бөгөөд үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

СЭХ
2024.07 сар 05 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2024-06-03
БҮРТГЭВ-02

Компани нь Дунд хугацааны бизнес төлөвлөгооны дагуу 2024 онд нээлттэй хэлбэрээр ам.долларын бондыг гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд барьцаа хөрөнгийн үнэ цэнэ буурах, төлбөрийн тасалдал, төлбөрийн чадваргүй болох зэрэг Үнэт цаас гаргахтай холбоотой эрсдэл, түүний удирдлагын хүрээнд хэрэгжүүлэх алхмууд дараах байдалтай байна. Үүнд:

**Хүснэгт 53: Үнэт цаастай холбоотой эрсдэл**

| Эрсдэлийн хүчин зүйлс | Эрсдэлийн удирдлага |
|---|---|
| **Барьцаа хөрөнгийн үнэ цэнэ буурах эрсдэл** | Үнэт цаасны үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор барьцаалсан барьцаа хөрөнгийн үнэ цэнэ буурах эрсдэл үүсэх боломжтой.<br><br>Барьцааны гэрээний дагуу үнэт цаасны үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор барьцаалсан барьцаа хөрөнгийн үнэ цэн буурах тохиолдолд Барьцаалуулагч нь барьцаа хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, барьцаа хөрөнгийг нэмэгдүүлэх, өөр боломжит хөрөнгөөр солих үүрэгтэй байна. Мөн, Үнэт цаас гаргагчийн барьцаа хөрөнгө давхар барьцаалагдаагүй бөгөөд барьцааны мэдэгдэл бүртгэх цахим мэдээллийн санд бүртгэгдэнэ. |
| **Төлбөрийн тасалдлын эрсдэл** | Компани нь үнэт цаасны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг хугацаандаа төлж чадахгүй байх, хугацаа хоцроож төлөх эрсдэл үүсэх боломжтой.<br><br>Үнэт цаас гаргагч нь санхүүгийн мөнгөн урсгалаа тогтмол төлөвлөж, гүйцэтгэлд хяналт тавих замаар төлбөрийн тасалдлын эрсдэлээс сэргийлэн ажилладаг бөгөөд Үнэт цаас гаргагчийн аливаа үйлдэл нь Компанийн бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу эргэн төлөхөд хүндрэл учруулахгүй байх зорилгоор хязгаарлах нөхцөлүүдийг үүрэгжүүлсэн. Үүнд:<br>• Гэрээг байгуулах үед эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулахгүй байх;<br>• Аливаа этгээдтэй нэгдэж, нийлэхгүй, бусад хэлбэрээр өөрчлөн байгуулагдахгүй байх;<br>• Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэх үүргээ бусдад шилжүүлэхгүй байх;<br>• Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэх үүргийн гүйцэтгэлтэй байх нөхцөлд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байх;<br>• Үнэт цаас гаргагчийн ашиг эсхүл орлогыг бусад этгээдтэй хуваалцах нөхцөлтэй гэрээ байгуулахгүй байх;<br>• Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэхэд саад учруулах хэмжээний гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн аливаа өр төлбөрийг хугацаанаас өмнө эргэн төлөхгүй байх;<br>• Аливаа үүргийн гүйцэтгэл, баталгаа, батлан даалт нь Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтийг хийх хуваарьтай давхцах тохиолдолд Ногоон бондын төлбөрийг эхэлж төлөх;<br>• Үнэт цаас гаргагчийн Ногоон бонд гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа нь Үнэт цаасны танилцуулгад тусгасан зориулалтын дагуу зарцуулах;<br>• Үнэт цаас гаргагчийн аливаа бүх үйлдэл (банк, санхүүгийн байгууллагаас зээл авах, бонд гаргах, бусад этгээдийн санхүүгийн өглөгт баталгаа, батлан даалт гаргах, аливаа гуравдагч этгээд, аж ахуйн нэгжид хөрөнгө оруулалт хийх, өөрийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн худалдах, шилжүүлэх, эсвэл өөр бусад аргаар захиран зарцуулах зэрэг) нь Үнэт цаас гаргагчийг мөнгөн хөрөнгийн дутагдалд оруулах буюу Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу эргэн төлөхөд хүндрэл учруулахгүй байх.<br><br>Мөн Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаа, үнэт цаасны хязгаарлах нөхцөлүүдийг хангаж буй байдалд хяналт тавин, хөрөнгө оруулагчийн эрх ашигт нөлөөлөх аливаа мэдээ мэдээллийг хөрөнгө оруулагчдад тогтмол мэдээлэн ажиллана. |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



5147204 ХАК0303
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.07.05
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Төлбөрийн чадваргүй болох эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадвараа алдаж, бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг төлж барагдуулж чадахгүй болох тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу барьцаа хөрөнгөөр хангуулах эрх үүснэ.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

5147204 ХАК0303
УЛААНБААТАР ХОТ




# 03 ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES



ГҮТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024 .07. 05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -06- 03
БҮРТГЭВ-02

## 3.1. НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ НОГООН БОНДЫН ТАНИЛЦУУЛГА

### ҮНЭТ ЦААСНЫ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | "ТЖТБ" ХХК |
| Үнэт цаасны төрөл | Компанийн купонтой ногоон бонд |
| Өрийн хэрэгслийн төрөл | Ногоон бондын хөтөлбөр |
| Үнэт цаасны бүртгэл | Монголын хөрөнгийн бирж |
| Үнэт цаасны нэр | "Green Recycle" бонд |
| Үнэт цаас гаргах валют | Ам.доллар |
| Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ | 100.0 ам.доллар |
| Үнэт цаасны нийт тоо ширхэг | 150,000 ширхэг хүртэл |
| Үнэт цаасны нийт үнийн дүн | 15,000,000.0 ам.доллар хүртэл |
| Үнэт цаасны хугацаа | Үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдсанаас хойш 36 сар |
| Үнэт цаасыг анхдагч зах зээлд бүхэлд нь эсхүл хэсэгчлэн гаргаж арилжаалах хуваарь | Нээлттэй хүрээнд бүхэлд нь эсхүл хэсэгчлэн гаргах бондын хүү, хэмжээг тухай бүр Компанийн Гүйцэтгэх захирал тогтооно. |
| Үнэт цаасны хүүгийн төрөл | Тогтмол |
| Үнэт цаасны хүү тооцох суурь хоног | 365 хоног |
| Үнэт цаасны хүү /жилийн/ | Жилийн 10.0% хувь |
| Үнэт цаасны хүү төлөгдөх давтамж | Хагас жил тутам |
| Үнэт цаасны эргэн төлөлтийн хэлбэр | Хугацааны эцэст |
| Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| Үнэт цаасны барьцаа, баталгаа | • "ТЖТБ" ХХК-ийн үндсэн хөрөнгө*, тоног төхөөрөмжүүд*, арилжааны банкнууд дахь данснууд;<br>• Үнэт цаас гаргагчийн нэгдлийн компани болох "Ти Эм Эл" ГХОХХК-ийн өмчлөлийн оффисын зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө*;<br>• Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани болох "Ти Эм Эл Констракшн" ХХК-ийн өмчлөлийн худалдаа, үйлчилгээний зориулалттай газар*;<br>• Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч болох Х.Тэгшээгийн баталгаа. |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES

| | |
|---|---|
| Барьцааны зүйлийн хэмжээ | 64.3 тэрбум төгрөг |
| Үнэт цаасны үүргийн гүйцэтгэл хангах арга | Үнэт цаасны үүргийн гүйцэтгэл хангахтай холбоотой харилцааг холбогдох этгээдүүдтэй байгуулсан дараах гэрээнүүдийн хүрээнд зохицуулсан байна. Үүнд:<br>• Үнэт цаасны компани болон Үнэт цаас гаргагч нарын хооронд байгуулсан "Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээ" болон "Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ";<br>• Үнэт цаасны компани болон "Ти Эм Эл" ГХОХХК нарын хооронд байгуулсан "Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой барьцааны гэрээ";<br>• Үнэт цаасны компани болон "Ти Эм Эл Констракшн" ХХК нарын хооронд байгуулсан "Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой барьцааны гэрээ";<br>• Үнэт цаас гаргагч, Үнэт цаасны компани болох Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч Х.Тэгшээ нарын хооронд байгуулсан "Баталгааны гэрээ";<br>• Үнэт цаас гаргагч, Үнэт цаасны компани болон арилжааны банкнуудтай байгуулах гурван талт "Төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээ". |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт | • Тоног төхөөрөмжийн худалдан авалт буюу "Ти Эм Эл" ГХОХХК-аас шилжүүлэн авсан тоног төхөөрөмжийн төлбөрийг гүйцэтгэх;<br>• Хуванцар хаягдал цуглуулах, ангилах, бэлтгэн нийлүүлэх цэг байгуулах хөрөнгө оруулалт;<br>• Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт буюу түүхий эдийн худалдан авалт. |
| Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр | Компанийн үйл ажиллагааны орлого |
| Хүүгийн орлогод ногдох албан татвар | 5%** |
| Үнэт цаасны хязгаарлах нөхцөлүүд | • Эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулахгүй байх;<br>• Аливаа этгээдтэй нэгдэж, нийлэхгүй, бусад хэлбэрээр өөрчлөн байгуулагдахгүй байх;<br>• Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэх үүргээ бусдад шилжүүлэхгүй байх;<br>• Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэх үүргийн гүйцэтгэлтэй байх нөхцөлд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байх;<br>• Үнэт цаас гаргагчийн ашиг эсхүл орлогыг бусад этгээдтэй хуваалцах нөхцөлтэй гэрээ байгуулахгүй байх;<br>• Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэхэд саад учруулах хэмжээний гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн аливаа өр төлбөрийг хугацаанаас өмнө эргэн төлөхгүй байх;<br>• Өрийн бичгийн хөтөлбөрийн гэрээ байгуулагдсанаас хойш төлөх аливаа үүргийн гүйцэтгэл, баталгаа, батлан даалт нь Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтийг хийх хуваарьтай давхцах тохиолдолд Ногоон бондын төлбөрийг эхэлж төлөх; |

СЗХ
2024.07 сар 05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2024-06-03
БҮРТГЭВ 02

- Ногоон бонд гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа нь Үнэт цаасны танилцуулгад тусгасан зориулалтын дагуу зарцуулах;
- Үнэт цаас гаргагчийн аливаа бүх үйлдэл (банк, санхүүгийн байгууллагаас зээл авах, бонд гаргах, бусад этгээдийн санхүүгийн өглөгт баталгаа, батлан даалт гаргах, аливаа гуравдагч этгээд, аж ахуйн нэгжид хөрөнгө оруулалт хийх, өөрийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн худалдах, шилжүүлэх, эсвэл өөр бусад аргаар захиран зарцуулах зэрэг) нь Үнэт цаас гаргагчийг мөнгөн хөрөнгийн дутагдалд оруулах буюу Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу эргэн төлөхөд хүндрэл учруулахгүй байх.

| Андеррайтер | "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК |
|---|---|

** Эдгээр хөрөнгүүд нь арилжааны банкнуудын барьцаанд байгаа бөгөөд Ул хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээнд заасны дагуу Үнэт цаас гаргагч нь Барьцааны зүйлийг Үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг өөрийн дансанд хүлээн авсан өдрөөс хойш 1 сарын дотор гуравдагч этгээдийн барьцаанаас бүрэн чөлөөлөх үүрэгтэй байна.*

*** Монгол Улсад байрладаггүй гадаадын аж ахуйн нэгжийн хувьд 20% (Давхар татварын гэрээний хүрээнд албан татвар ногдуулж, суутгал хийнэ). Хүүгийн орлогод ногдох албан татвартай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Үнэт цаасны танилцуулгын 2.4.5-д заасан хэсгээс харна уу.*

Үнэт цаасыг Хороонд бүртгүүлснээс хойш 6 (зургаа) сарын хугацаанд Өрийн бичгийн хөтөлбөрийн эхний транч бондын арилжааг зохион байгуулах ба хөтөлбөрийн хүрээнд хэсэгчлэн гарах бусад транч бондуудыг Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор баталсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3.1 дэх заалтад заасны дагуу үнэт цаасыг Хороонд бүртгүүлснээс хойш 24 (хорин дөрөв) сарын дотор санал болгоно.

## 3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Үнэт цаас гаргагч нь Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан ногоонд бондыг нээлттэй хүрээнд санал болгох нь дараах зорилго, ач холбогдолтой байна. Үүнд:

1. **Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлж, тогтвортой хөгжлийг хамтдаа бүтээх:** Үнэт цаас гаргагч нь үндсэн хөрөнгийн худалдан авалт, түүхий эдийн татан авалт болон түүхий эд цуглуулах дэд бүтцийн сайжруулалтыг хийх санхүүжилтийг өрийн хэрэгслийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд ингэснээр Компани болон хөрөнгө оруулагчид 2029 он хүртэл байгаль орчин, нийгэмд дараах үнэ цэнийг бүтээх боломжтой болно. Үүнд:

| **82.6 мянган тонн** | **1,050.4 сая кВт.цаг** | **242,396 м.куб** |
|---|---|---|
| хуванцар хаягдлын дахин боловсруулна. | цахилгаан эрчим хүч хэмнэнэ. | хөрсний бохирдол үүсэхээс сэргийлнэ. |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

5147204 ХАК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**474.3 мянган тонн**
нүүрсхүчлийн хийн ялгарал үүсэхээс сэргийлнэ.

**17.1 тэрбум төгрөг**
татварыг Улсын төсөвт бүрдүүлнэ.

**5,200 ширхэг**
шинэ ажлын байр бий болгоно.

2. **Хөрөнгө оруулагчид мөнгөн урсгалын тохиромжтой цаг хугацааг сонгон Монгол Улсын анхны "ОНЦ" үнэлгээтэй, тогтмол орлоготой ам.долларын ногоон бондод хөрөнгө оруулах боломжийг олгох:** Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн зах зээлд тогтмол орлоготой, хөрвөх чадвар бүхий бүтээгдэхүүнийг бий болгох замаар хөрөнгийн зах зээлийг дэмжих, Монгол Улсад Sustainable Fitch байгууллагаас анх удаа **"ОНЦ"** үнэлгээ авсан нээлттэй ногоон бондод хөрөнгө оруулах сонирхолтой хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл бүхий үнэт цаасыг санал болгож байна. Мөн Үнэт цаас гаргагч нь Ногоон бондыг Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд 24 сарын хугацаанд зах зээлд хэсэгчлэн гаргах ба ингэснээр хөрөнгө оруулагчид өөрийн мөнгөн урсгалын тохиромжтой цаг хугацааг сонгон, хөрөнгө оруулалтаа хийх, дахин хөрөнгө оруулах боломжийг олгох давуу талтай юм.

### 3.3. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ШИЙДВЭР

**Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол**

Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.5 дахь хэсэг, 87 болон 88 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам" болон Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын холбогдох зүйл, хэсэг, заалтууд, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 9.10.6 дахь заалтыг тус тус үндэслэн, Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 24/12 тоот тогтоол болон 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 24/16 тоот тогтоолоор Компани нь Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд 15,000,000 (арван таван сая) хүртэлх ам.доллароор илэрхийлэгдэх үнийн дүн бүхий үнэт цаас буюу Ногоон бондыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон нээлттэй хүрээнд бүхэлд нь эсхүл хэсэгчлэн гаргахаар шийдвэрлэсэн байна.

Тус шийдвэрийн дагуу Ногоон бондыг Хороонд бүртгүүлснээс хойш 24 (хорин дөрөв) сарын дотор санал болгох талаар заасан байх бөгөөд тус тогтоолын хавсралтаар Үнэт цаасны ерөнхий нөхцөлийг баталсан байна.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
9021110883
5251494
TDB SECURITIES



5147204
ХАН-УУЛ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.07.05
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

### 3.4. ҮНЭТ ЦААСНЫ БАРЬЦАА ХӨРӨНГӨ

**Барьцааны зүйл, барьцаа хөрөнгийн үнэлгээ**

Үнэт цаас гаргагч нь Өрийн бичгийн хөтөлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон дараах хөдлөх болон үл хөдлөх хөрөнгүүдийг барьцаалсан болно. Үүнд:

**Хүснэгт 54: Барьцаа хөрөнгийн мэдээлэл**

| **Барьцаа 1: Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэлийн зориулалттай эзэмших эрхтэй газар[10], үйлдвэрийн зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө[10], түүний бүрдэл** | |
|---|---|
| Өмчлөгч/эзэмшигч | "ТЖТБ" ХХК |
| Үндсэн хөрөнгийн төрөл | Ү-2201060245 гэрчилгээний дугаартай, 6,000 м.кв талбай бүхий үйлдвэрийн зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө болон түүний бүрдэл;<br>Э-2201008629 гэрчилгээний дугаартай, 19,985 м.кв талбайтай үйлдвэрлэлийн зориулалттай эзэмших эрхтэй газар. |
| Хаяг | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо, хотын шинэ төв /18270/ гудамж, 91 тоот |
| Үндсэн хөрөнгийн тоо ширхэг | 9 ширхэг |
| **Барьцаалагдах хөрөнгийн үнэлгээ** | **12.6 тэрбум төгрөг** |

| **Барьцаа 2: "Ти Эм Эл" ГХОХХК-ийн контор үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө[10]** | |
|---|---|
| Өмчлөгч/эзэмшигч | "Ти Эм Эл" ГХОХХК |
| Үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл | Ү-2204027873 гэрчилгээний дугаартай, 2,790 м.кв талбайтай үйлдвэрийн зориулалттай контор үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө; |
| Хаяг | Нийслэлийн Баянзүрх дүүргийн 1-р хороо, 12 хороолол /13380/, токио гудамж, 2 байр, 0 тоот; |
| Үл хөдлөх хөрөнгийн тоо ширхэг | 1 ширхэг |
| **Барьцаалагдах хөрөнгийн үнэлгээ** | **12.1 тэрбум төгрөг** |

| **Барьцаа 3: "Ти Эм Эл Констракшн" ХХК-ийн худалдаа үйлчилгээний зориулалттай эзэмших эрхтэй газар[10]** | |
|---|---|
| Өмчлөгч/эзэмшигч | "Ти Эм Эл Констракшн" ХХК |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИЕС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494

5147204 ХАК0343

[10] Эдгээр хөрөнгүүд нь арилжааны банкны барьцаанд байгаа бөгөөд Үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийн барьцааны гэрээнд заасны дагуу Үнэт цаас гаргагч нь Барьцааны зүйлийг Үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг өөрийн дансанд хүлээн авсан өдрөөс хойш 1 сарын дотор гуравдагч этгээдийн барьцаанаас бүрэн чөлөөлөх үүрэгтэй байна.

СЗХ 2024.07.05 он сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| Газрын мэдээлэл | Э-2204037431 гэрчилгээний дугаартай, 672 м.кв талбайтай худалдаа үйлчилгээний зориулалттай эзэмших эрхтэй газар. |
| Хаяг | Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 1-р хороо, 12 хороолол /13380/, токио гудамж, 2 байр |
| Газрын тоо ширхэг | 1 ширхэг |
| **Барьцаалагдах хөрөнгийн үнэлгээ** | ▪ - |

| Барьцаа 4: Үнэт цаас гаргагчийн хөдлөх эд хөрөнгө хөрөнгө болон эдийн бус хөрөнгө[10] | |
|---|---|
| Өмчлөгч/эзэмшигч | "ТЖТБ" ХХК |
| Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн мэдээлэл | Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй үндсэн хөрөнгөөс 78 ширхэг хөдлөх хөрөнгө;<br>Одоогийн 7 данс болон ирээдүйд нээгдэх дансны орлого. |
| **Барьцаалагдах хөрөнгийн үнэлгээ** | **39.6 тэрбум төгрөг** |

| | |
|---|---|
| **Нийт барьцаа хөрөнгөөр хангагдах үүргийн хэмжээ** | ▪ **64.3 тэрбум төгрөг** |

Үнэт цаас гаргагч нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 24/15 тоот "Хөрөнгө барьцаалах зөвшөөрөл олгох тухай" шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 24/12 тоот "Үнэт цаас нээлттэй гаргах тухай" тогтоол болон 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 24/16 тоот "Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор Өрийн бичгийн хөтөлбөрийн барьцаа болгон Компанийн эзэмшил, өмчлөл дэх үл хөдлөх болон хөдлөх хөрөнгүүдийг барьцаалах зөвшөөрлийг олгож, барьцаа хөрөнгийн үнэлгээг тогтоосон бөгөөд түүнтэй холбогдох гэрээ хэлцэл болон холбогдох баримт бичигт гарын үсэг зурах эрхийг тус компанийн Гүйцэтгэх захиралд олгосон байна.

Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани болох "Ти Эм Эл" ГХОХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 24/04 тоот "Хөрөнгө барьцаалах зөвшөөрөл олгох тухай" шийдвэрээр Өрийн бичгийн хөтөлбөрийн барьцаа болгон "Ти Эм Эл" ГХОХХК-ийн эзэмшил, өмчлөл дэх үл хөдлөх хөрөнгийг барьцаалах зөвшөөрлийг олгож, барьцаа хөрөнгийн хэмжээг тогтоосон бөгөөд түүнтэй холбогдох гэрээ хэлцэл болон холбогдох баримт бичигт гарын үсэг зурах эрхийг тус компанийн Хувьцаа эзэмшигчид олгосон байна.

"Ти Эм Эл" ГХОХХК-ийн 2022-2023 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлт нь дараах байдалтай байна. Үүнд:

**Хүснэгт 55: "Ти Эм Эл" ГХОХХК-ийн санхүүгийн үзүүлэлт, сая төгрөг, 2022-2023 он**

| Санхүүгийн байдлын тайлан | 2022 | 2023 |
|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 125.9 | 3,850.6 |
| Дансны авлага | 13,412.6 | 52,923.5 |
| Бусад авлага | 27,458.9 | 42,970.7 |
| Бараа материал | 41,318.9 | 7,017.2 |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИЗ ҮЦК ХХК TDB SECURITIES

ТЖТБ ХХК УЛААНБААТАР ХОТ

| | | |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал | 54,490.6 | 47,778.5 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **136,807.0** | **154,540.5** |
| Үндсэн хөрөнгө | 14,292.6 | 14,835.9 |
| Биет бус хөрөнгө | 8.1 | 6.5 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 5,030.0 | 5,030.0 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **19,330.7** | **19,872.4** |
| **Нийт хөрөнгийн дүн** | **156,137.7** | **174,412.9** |
| Дансны өглөг | 20,018.7 | 14,530.2 |
| Татвар, НДШ-ийн өглөг | 1,089.3 | 4,582.4 |
| Богино хугацаат зээл | 47,365.7 | 53,380.2 |
| Хүүний өглөг | 4,506.3 | 2,815.6 |
| Урьдчилж орсон орлого болон бусад богино хугацаат өр төлбөр | 33,548.4 | 44,428.6 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **106,528.4** | **119,737.0** |
| Урт хугацаат зээл | 30,000.0 | 30,000.0 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | - | 268.6 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **30,000.0** | **30,000.0** |
| **Нийт өр төлбөр** | **136,528.4** | **150,005.7** |
| Хувьцаат капитал | 999.6 | 999.6 |
| Хуримтлагдсан ашиг | 18,609.8 | 23,407.7 |
| **Эздийн өмч** | **19,609.4** | **24,407.2** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **156,137.7** | **174,412.9** |

| **Орлогын тайлан** | **2022** | **2023** |
|---|---|---|
| Борлуулалтын орлого | 43,009.1 | 75,100.7 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | (26,447.8) | (62,072.6) |
| **Нийт ашиг** | **16,561.3** | **13,028.0** |
| Бусад орлого | 2,833.0 | 5,667.8 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | (5,000.0) | (4,480.4) |
| Санхүүгийн зардал болон бусад зардал | (9,934.3) | (9,545.9) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 695.5 | 314.4 |
| Бусад олз (гарз) | - | 588.3 |
| **Татварын өмнөх ашиг** | **5,155.5** | **5,572.2** |
| Орлогын албан татварын зардал | (489.5) | (635.2) |
| **Тайлант үеийн цэвэр ашиг** | **4666.0** | **4,936.9** |

Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани болох "Ти Эм Эл Констракшн" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 24/02 тоот "Хөрөнгө барьцаалах зөвшөөрөл олгох тухай" шийдвэрээр Өрийн бичгийн хөтөлбөрийн барьцаа болгон "Ти Эм Эл Констракшн" ХХК-ийн эзэмшил,

өмчлөл дэх үл хөдлөх хөрөнгийг барьцаалах зөвшөөрлийг олгож, барьцаа хөрөнгийн хэмжээг тогтоосон бөгөөд түүнтэй холбогдох гэрээ хэлцэл болон холбогдох баримт бичигт гарын үсэг зурах эрхийг тус компанийн Гүйцэтгэх захиралд олгосон байна.

"Ти Эм Эл Констракшн" ХХК-ийн 2022-2023 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлт нь дараах байдалтай байна. Үүнд:

**Хүснэгт 56: "Ти Эм Эл Констракшн" ХХК-ийн санхүүгийн үзүүлэлт, сая төгрөг, 2022-2023 он**

| Санхүүгийн байдлын тайлан | 2022 | 2023 |
|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 0.2 | 0.2 |
| Дансны авлага | 467.5 | 467.5 |
| Татвар, НДШ-ийн авлага | 0.0 | 0.0 |
| Бусад авлага | 179.9 | 179.9 |
| Урьдчилж төлсөн зардал | - | 0.3 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **647.6** | **647.9** |
| Эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **-** | **-** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **647.6** | **647.9** |
| Дансны өглөг | 1,105.4 | 1,105.8 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **1,105.4** | **1,105.8** |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | - | - |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **-** |
| **Нийт өр төлбөр** | **1,105.4** | **1,105.8** |
| Хувьцаат капитал | 151.0 | 151.0 |
| Хуримтлагдсан ашиг | (608.8) | (608.9) |
| **Эздийн өмч** | **(457.8)** | **(457.9)** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **647.6** | **647.9** |
| **Орлогын тайлан** | **2022** | **2023** |
| Борлуулалтын орлого | - | - |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | - | - |
| **Нийт ашиг** | - | - |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 0.2 | 0.1 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 0.0 | - |
| **Татварын өмнөх ашиг** | **(0.2)** | **(0.1)** |
| Орлогын албан татварын зардал | - | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг** | - | - |

Үнэт цаас гаргагчийн Ногоон бондын хүрээнд барьцаалах барьцаа хөрөнгийн үнэлгээг "Гэрэгэ-Эстимэйт Үнэлгээ" ХХК гүйцэтгэсэн бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Үйлдвэр, тоног төхөөрөмж, бусад хөрөнгийн үнэлгээний тайлан болон 2024 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн Барилга, газрын үнэлгээний тайлангаар үнэлгээг хүргүүлсэн байна.

СЗХ 2024.07.05 он сар өдөр №51

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

**Үнэт цаасны баталгаа**

Үнэт цаас гаргагчийн биржээр дамжуулан нээлттэй хүрээнд олон нийтэд санал болгох Ногоон бондын үүргийн гүйцэтгэх хангах баталгаа болгон Компанийн эцсийн өмчлөгч болох Х.Тэгшээ (РД:УЗ80071013) нь баталгаа гаргаж, Андеррайтер болон Үнэт цаас гаргагчтай 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр TDBS-619/2024 тоот "Баталгааны гэрээ"-г байгуулсан. Тус гэрээгээр Х.Тэгшээ нь Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр тохиролцсон хугацаанд бүрэн төлөгдөнө гэсэн баталгааг гаргасан бөгөөд Үнэт цаас гаргагч нь Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг тохиролцсон хугацаанд гүйцэтгээгүй, төлбөрийн тасалдал үүсэх бодит нөхцөл байдал бий болсон эсхүл Үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд Х.Тэгшээ нь уг төлбөрийг өөрийн хөрөнгөөр үл маргах журмаар төлөх үүрэгтэй байна.

**Хүснэгт 57: Баталгаа гаргагчийн мэдээлэл**



**Х.Тэгшээ**
ТУЗ-ийн ердийн гишүүн,
эцсийн өмчлөгч
**20+** жилийн туршлага

**Боловсрол**

- БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль, Химич.

**Туршлага**

- 2006 оноос одоог хүртэл Ти Эм Эл ГХОХХК, Ерөнхий захирал;
- 2014 оноос одоог хүртэл Ти Эм Эл Трейд ХХК, Ерөнхий захирал;
- 2014 оноос одоог хүртэл Эм Жи Эл Акуа ХХК, Ерөнхий захирал;
- 2017 оноос одоог хүртэл Ньюгор ХХК, Ерөнхий захирал;
- 2017 оноос одоог хүртэл Эм Пластик ХХК, Ерөнхий захирал;
- 2018 оноос одоог хүртэл Ньюшилэн Интернэшнл ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2021 оноос одоог хүртэл Шидэт Чандмань Эрдэнэ ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2021 оноос одоог хүртэл Ти Эм Эл Констракшн ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2021-2023 онд ТЖТБ ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2022 оноос одоог хүртэл Эс И Жи Вай Вай ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2023 оноос одоог хүртэл Эс И Эс Эл Смарт Солюшн ХХК, Ерөнхий захирал;
- 2024 оноос одоог хүртэл ТЖТБ ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны дарга, Аудитын хорооны гишүүн.

Баталгаа гаргагч Х.Тэгшээ нь баталгаа гаргах өдрийн байдлаар "Эм Пластик" ХХК, "Ньюгор" ХХК, "Нью Шилэн Интернэшнл" ХХК болон "Ти Эм Эл Трейд" ХХК-ийн хувьцааны 100 хувийг, "Ти Эм Эл" ГХОХХК-ийн хувьцааны 50 хувийг тус тус шууд эзэмшдэг. Мөн "Ти Эм эл Трейд" ХХК-ийн охин компаниуд болох "Эм Жи Эл Акуа" ХХК, "МТЗҮК" ХХК, "Сээмета" ХХК, "Эс И Жи Вай Вай" ХХК, "Шидэтчандмань эрдэнэ" ХХК, "Скай Ти Ти Эс Эс" ХХК, "Ти Эм Эл констракшн" ХХК болон "Эс И Эс Эл Смарт Солюшн" ХХК-ийн хувьцааны 100 хувийг шууд бусаар эзэмшдэг. Тус компаниудын мэдээллийг Үнэт цаасны танилцуулгын 2.1.6 дахь хэсгээс уншиж танилцана уу.

Үнэт цаасны үүргийн гүйцэтгэл хангах баталгаа гаргаж буйтай холбоотой Баталгаа гаргагч Х.Тэгшээ нь "Эм Пластик" ХХК, "Ньюгор" ХХК, "Нью Шилэн Интернэшнл" ХХК, "Ти Эм Эл Трейд" ХХК, "Ти Эм Эл" ГХОХХК, болон "Скай Ти Ти Эс Эс" ХХК дахь өөрийн шууд болон шууд бус эзэмшлийн хувьцаанд харгалзах эздийн өмчийн хэмжээ буюу өөрийн эзэмшлийн хувьцааг дансны үнээр нь үнэлэн баталгаа гаргасан ба тус компаниудын 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгө, эздийн өмчийн хэмжээ болон баталгаа гаргах хэмжээ нь дараах байдалтай байна. Үүнд:

**Хүснэгт 58: Баталгаа гаргагчийн хувь эзэмшиж буй компаниудын мэдээлэл, 2023 он**

| № | Компанийн нэр | Хувьцааны too ширхэг | Баталгаа гаргагчийн шууд болон шууд бус эзэмшлийн хувь | Нийт хөрөнгө, сая төгрөг | Эздийн өмч, сая төгрөг | Баталгаа гаргагчийн эзэмшиж буй хувьцааны нийт үнэлгээ /дансны үнэ/, сая төгрөг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Эм Пластик" ХХК | 10,000 | 100% | 21,383.8 | 13,127.3 | 13,127.3 |
| 2 | "Скай Ти Ти Эс Эс" ХХК | 1,000 | 100% | 3,718.0 | 793.6 | 793.6 |
| 3 | "Ньюгор" ХХК | 1,000 | 100% | 21,763.9 | 8,087.4 | 8,087.4 |
| 4 | "Нью шилэн интернэшнл" ХХК | 572,396 | 100% | 7,270.5 | 3,827.2 | 3,827.2 |
| 5 | "Ти Эм Эл" ГХОХХК | 1,000 | 50% | 174,412.9 | 24,407.2 | 12,203.6 |
| 6 | "Ти Эм Эл Трейд" ХХК | 1,000 | 100% | 11,549.9 | 5,207.0 | 5,207.0 |
| | Нийт | | | | | **43,246.1** |

TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

## 3.5. ҮНЭТ ЦААСНЫ ХЯЗГААРЛАХ НӨХЦӨЛ

Үнэт цаас гаргагч болон Андеррайтерийн хооронд байгуулагдсан TDBS-608/2024 "Өрийн бичгийн хөтөлбөрийн гэрээ" (цаашид "**Өрийн бичгийн хөтөлбөрийн гэрээ**" гэх)-ний дагуу Үнэт цаас гаргагч нь Ногоон бондын Өрийн бичгийн хөтөлбөрийн нийт хугацаанд Хөрөнгө оруулагчдын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараах үйл ажиллагаанд хамаарах шийдвэр гаргахгүй байх хязгаарлалтын нөхцөлүүдийг бүрэн ойлгож, хүлээн зөвшөөрсөн болно. Үүнд:

- Эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулахгүй байх;
- Аливаа этгээдтэй нэгдэж, нийлэхгүй, бусад хэлбэрээр өөрчлөн байгуулагдахгүй байх;
- Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэх үүргээ бусдад шилжүүлэхгүй байх;
- Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэх үүргийн гүйцэтгэлтэй байх нөхцөлд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байх;
- Үнэт цаас гаргагчийн ашиг эсхүл орлогыг бусад этгээдтэй хуваалцах нөхцөлтэй гэрээ байгуулахгүй байх;
- Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэхэд саад учруулах хэмжээний гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн аливаа өр төлбөрийг хугацаанаас өмнө эргэн төлөхгүй байх;
- Өрийн бичгийн хөтөлбөрийн гэрээ байгуулагдсанаас хойш төлөх аливаа үүргийн гүйцэтгэл, баталгаа, батлан даалт нь Компанийн Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтийг хийх хуваарьтай давхцах тохиолдолд Ногоон бондын төлбөрийг эхэлж төлөх;
- Ногоон бонд гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа нь Үнэт цаасны танилцуулгад тусгасан зориулалтын дагуу зарцуулах;
- Үнэт цаас гаргагчийн аливаа бүх үйлдэл (банк, санхүүгийн байгууллагаас зээл авах, бонд гаргах, бусад этгээдийн санхүүгийн өглөгт баталгаа, батлан даалт гаргах, аливаа гуравдагч этгээд, аж ахуйн нэгжид хөрөнгө оруулалт хийх, өөрийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн худалдах, шилжүүлэх, эсвэл өөр бусад аргаар захиран зарцуулах зэрэг) нь Үнэт цаас гаргагчийг мөнгөн хөрөнгийн дутагдалд оруулах буюу Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу эргэн төлөхөд хүндрэл учруулахгүй байх.

## 3.6. ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагчийн Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд хүлээсэн төлбөрийн үүргийг Барьцааны зүйлээр хангахтай холбоотой бүхий л харилцааг Өрийн бичгийн хөтөлбөрийн гэрээ, Барьцааны гэрээ болон Баталгааны гэрээгээр тус тус зохицуулсан байна.

**Төлбөрийн тасалдал болсонд болон төлбөрийн чадваргүйд тооцох нөхцөл**

**Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд төлбөрийн тасалдал болсонд тооцно. Үүнд:**

- Үнэт цаас гаргагч нь Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг тохиролцсон хугацаанд гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй (Зохих ёсоор гүйцэтгээгүй гэдэгт Ногоон бондын үндсэн төлбөр, Ногоон бондын хүү, алданги болон Андеррайтерийн гэрээтэй холбоотой бий болсон бусад төлбөр, барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй зэргийг багтааж ойлгоно);
- Ногоон бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн тасалдал үүсэх бодит нөхцөл байдал бий болсон;
- Үнэт цаас гаргагч нь Төлбөрийн тасалдал үүсэхээс сэргийлэх арга хэмжээнд заасан мэдэгдлүүдийг холбогдох баримт материалын хамт ирүүлээгүй;
- Андеррайтер нь Төлбөрийн тасалдал үүсэхээс сэргийлэх арга хэмжээнд заасан төлөвлөгөө нь шаардлага хангахааргүй байна гэж үзсэн;
- Барьцааны зүйлийн бүрэн бүтэн байдал алдагдах, үнэ цэнэ ихээхэн буурах нөхцөл байдал үүссэн бөгөөд энэ талаар нэн даруй Андеррайтерт мэдэгдэж, барьцааны зүйлийг өөр боломжит

эд хөрөнгөөр солих буюу Андеррайтерийн бичгээр өгсөн мэдэгдэлд заасан дүнгээр нэмэгдүүлээгүй.

**Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно. Үүнд:**

- Үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийн үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй байх.

## Төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээ

Барьцааны гэрээгээр Үнэт цаас гаргагч нь бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу эргэн төлөхгүй байх бодит нөхцөл байдал бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг талууд авч хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан. Энэ нь үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, төлбөрийн тасалдал үүсэх аливаа эрсдэлт хүчин зүйлээс сэргийлж буй арга хэмжээ юм.

**Зураг 86: Төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ**



СЗХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ

### 3.7. ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮГИЙН ТҮВШИН ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад санал болгох Компанийн бондын өгөөж, хүүгийн түвшинг зах зээлийн хүүгийн түвшин болон Компанийн үзүүлэлттэй уялдуулан тогтоосон.

2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Монголбанкны бодлогын хүүг 12.0 хувь болгож тогтоосон бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын байдлаар арилжааны банкнуудын шинээр татсан 36 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 13.8 хувь, гадаад валютын төгрөгийн жигнэсэн дундаж хүү 3.2 хувьтай тус тус тэнцсэн үзүүлэлттэй байна.

2023 оноос 2024 оны 02 дугаар сарын 29 хүртэл өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгосон төгрөгийн бондын дундаж хүү 18.0 хувьтай тэнцүү байгаа бөгөөд үүнд МХБ ХК дээр 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдөр Монголын хөрөнгийн бирж ХК дээр нээлттэй хүрээнд арилжаа нь явагдсан Хаан банк ХК-ийн 24 сарын хугацаатай төгрөгийн Ногоон бондын хүү 16.0 хувьтай тэнцүү байна.

**Зураг 87: Хүүгийн түвшний харьцуулалт, төгрөг**

**Зах зээл дэх хүүгийн түвшний харьцуулалт, 2024.02.29-ний өдрийн байдлаар**




2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкнуудын 24 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн зарласан дундаж хүү 13.3 хувь, 36 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн зарласан дундаж хүү 13.4 хувьтай тус тус тэнцэж байна.

**Зураг 88: Хүүгийн түвшний харьцуулалт, ам.доллар**

**Зах зээл дэх хүүгийн түвшний харьцуулалт, 2024.02.29-ний өдрийн байдлаар**




ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК
TDB SECURITIES

Түүнчлэн 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкнуудын 24 сарын хугацаатай ам.долларын хадгаламжийн зарласан дундаж хүү 3.1 хувь, 36 сарын хугацаатай ам.долларын хадгаламжийн зарласан дундаж хүү 4.7 хувьтай тус тус тэнцэж байна.

"ТЖТБ" ХХК-ийн санал болгож буй бондын хүүгийн хэмжээг арилжааны банкнуудын энгийн хугацаатай төгрөгийн хадгаламжийн зарласан дундаж хүүтэй харьцуулахад ойролцоогоор 3 нэгж хувиар,

СЗХ 2024.07.05 он сар өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

ам.долларын хадгаламжийн зарласан дундаж хүүтэй харьцуулахад ойролцоогоор 6-7 нэгж хувиар өндөр байна.

### 3.8. ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагч нь Андеррайтертай Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор баталсан “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэгт заасны дагуу 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдөр TDBS-608/2024 тоот “Өрийн бичгийн хөтөлбөрийн гэрээ”-г байгуулсан ба тус гэрээгээр Үнэт цаас эзэмшигч болон Үнэт цаас гаргагчийн эрх, үүргийг зохицуулсан.

#### 3.8.1. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

**Үнэт цаас эзэмшигч буюу хөрөнгө оруулагч нь Үнэт цаас, түүгээр гэрчлэгдэх дараах нийтлэг эрхийг эдэлнэ. Үүнд:**

- Үнэт цаасны үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой шимтгэл, хураамжийн үүргийг гүйцэтгэснээр Үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэхийг Үнэт цаас гаргагчаас шаардах;
- Хорооны шийдвэрийг үндэслэн Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн төлбөрийн үүргийн мэдээллийг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд тухай бүрд нийлүүлж, шинэчлэх;
- Үнэт цаасны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу Өрийн бичгийн хөтөлбөрийн гэрээгээр тохиролцсон хугацаанд бүрэн төлөхийг шаардах;
- Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагааны талаар шаардлагатай мэдээ, мэдээлэлтэй Биржийн болон Үнэт цаас гаргагчийн цахим хуудсаар дамжуулан танилцах;
- Үнэт цаас гаргагч нь төлбөр гүйцэтгэх үүргийн гүйцэтгэлийг бүрэн хангах боломжгүй тохиолдолд Компанийн бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг төлөхийг шаардах, үүргийн гүйцэтгэлийг Барьцааны зүйлээр хангуулах;
- Үнэт цаас гаргагч Өрийн бичгийн хөтөлбөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах;
- Үнэт цаасыг гуравдагч этгээдэд худалдах замаар эзэмших эрхээ шилжүүлэх буюу арилжаалах;
- Төлбөрийн тасалдал үүсэх бодит нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Барьцааны гэрээний дагуу хангуулах;
- Үнэт цаас гаргагч төлбөрийн чадваргүй болж, хүүгийн болон үндсэн төлбөрөө төлөөгүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
- Холбогдох хууль тогтоомж, журам, гэрээгээр тодорхойлогдох бусад эрх.

#### 3.8.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

**Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчийн өмнө дараах үүргийг хүлээнэ. Үүнд:**

- Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон тохиолдолд ажлын 5 (тав) өдрийн дотор үнэт цаасны үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх;
- Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцсон тохиолдолд ажлын 5 (тав) өдрийн дотор Хөрөнгө оруулагчийн эзэмшилд Үнэт цаас эзэмших эрхийг шилжүүлэх;
- Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөх хугацааг уг Үнэт цаасны эзэмших эрхийг Компанийн Ногоон бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс тооцох;
- Үнэт цаасыг борлуулах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг тусгай дансанд байршуулж, зөвхөн Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зориулалтын дагуу зарцуулах;
- Үнэт цаасны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг тохиролцсон хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах;

TDB SECURITIES

- Холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангаж, Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар хөрөнгө оруулагчдад мэдээлж, хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;
- Хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон холбогдох бусад хууль, журамд заасан мэдээллийг үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс Үнэт цаасыг Хорооны бүртгэлээс хасах хүртэлх хугацааны туршид тогтоосон хэлбэр, давтамжаар Хороо, Бирж болон олон нийтэд Монгол хэлээр, шаардлагатай бол гадаад хэлээр давхар мэдээлэх;
- Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага, зарцуулалт, хөрөнгө хуваарилалт болон санхүүгийн тайланд жил бүр аудит хийлгэх ба хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулагч байгууллагаар дүгнэлт гаргуулсан бол тухайн татан төвлөрүүлсэн хөрөнгө бүрэн хуваарилагдаж дуусах хүртэлх хугацаанд жил бүр тухайн байгууллагаар ногоон үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт гаргуулах;
- Хөндлөнгийн баталгаажуулагч байгууллагын гаргасан тайланг Ногоон бондын тайланд тусгаж, компанийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх;
- Өрийн бичгийн хөтөлбөрийн гэрээний 4 дүгээр зүйлд гаргасан баталгаа, хязгаарлах нөхцөлүүдийг чанад мөрдөх;
- Өрийн бичгийн хөтөлбөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Хөрөнгө оруулагчид учруулсан аливаа хохирол, алдангийг үл маргах журмаар төлж, барагдуулах;
- Бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг тогтоосон хуваарийн дагуу төлөөгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээр хангуулах арга хэмжээ авах;
- Өрийн бичгийн хөтөлбөрийн хугацаанд барьцааны зүйлийн бүрэн бүтэн байдал алдагдах, үнэ цэнэ ихээхэн буурах нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэн даруй мэдэгдэж, барьцааны зүйлийг өөр боломжит эд хөрөнгөөр солих буюу нэмэгдүүлэх;
- Бусдын эд хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр барьцаалсан, барьцааны зүйлийн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлснээс үүдэн гарах хохирлыг бүрэн хариуцах;
- Барьцааны зүйлд ногдох татвар, хураамж, зардлыг хариуцах;
- Хөтөлбөрийн хүрээнд бүртгүүлсэн Үнэт цаасны танилцуулгыг Хороонд бүртгүүлснээс хойш 6 (зургаа) сар тутамд шинэчлэн Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, олон нийтэд мэдээлэх;
- Өрийн бичгийн хөтөлбөрийн гэрээний 8.4.16-д заасан Үнэт цаасны шинэчилсэн танилцуулга нь бонд гаргагчийн бизнесийн орчин, санхүүгийн байдалд орсон өөрчлөлтүүд болон үүсэж болзошгүй нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын шийдвэрт материаллаг нөлөө үзүүлэхүйц үйл явдал болсон, эсхүл болох нь тодорхой байгаа асуудлууд зэрэг Үнэт цаас гаргагчийн шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл бүхий анх бүртгүүлсэн Үнэт цаасны танилцуулгын нэмэлт хавсралт хэлбэртэй байх;
- Холбогдох хууль тогтоомж, журам, Гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

СЗХ 2024 07 05 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ-02
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

## 3.9. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэхийн хүрээнд ногоон бонд гаргаж, татан төвлөрүүлсэн хөрөнгийг "Ногоон бондын хүрээ"-д тусгасны дагуу Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ICMA)-ны Ногоон бондын зарчимд нийцсэн дараах төслүүдийг хэсэгчлэн эсхүл бүрэн санхүүжүүлэх/дахин санхүүжүүлэхэд зарцуулна. Үүнд:

**Хүснэгт 59: Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт**

| Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх төслүүд | Шалгуур | Санхүүжилтийн хуваарилалт | ICMA-н ногоон бондын зарчимд нийцтэй байдал | Европын Холбооны таксономитой нийцсэн байдал | Монгол Улсын Ногоон таксономитой нийцсэн байдал |
|---|---|---|---|---|---|
| Хуванцар хог хаягдал ангилах, дахин боловсруулах үйлдвэр:<br>• Тоног төхөөрөмж;<br>• Дэд бүтэц;<br>• Газар;<br>• Шаардлагатай капиталын зардал (CAPEX);<br>• Үйл ажиллагааны зардлууд. | Жилд дахин боловсруулах хуванцар хог хаягдлын хэмжээ 5,000 тонноос багагүй байх ба үүнээс боловсруулагдан гарч буй эцсийн бүтээгдэхүүн нь нийт боловсруулж буй түүхий эдийн дор хаяж 50 хувиас доошгүй жинтэй байх | 73% | • Бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах<br>• Бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, технологи, үйл явц нь тойрог эдийн засгийг баримтлах | • Тойрог эдийн засагт шилжих<br>• Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах | • Эрчим хүчний хэмнэлт<br>• Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа<br>• Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ |
| Хог хаягдал цуглуулах, ангилах дэд бүтцийн хөгжүүлэлт:<br>• Тоног төхөөрөмж;<br>• Дэд бүтэц;<br>• Газар;<br>• Шаардлагатай капиталын зардал (CAPEX);<br>• Үйл ажиллагааны зардлууд<br>• Түүхий эд материалын худалдан авал (PET хаягдал). | Жилд цуглуулах хуванцар хог хаягдлын хэмжээ 1,000 тонноос багагүй байх ба хог хаягдлыг цуглуулахдаа хаягдал цуглуулах цэгүүдээс шууд цуглуулах эсвэл хяналттай хог цуглуулах цэг байгуулах | 27% | • Бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах<br>• Бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, технологи, үйл явц нь тойрог эдийн засгийг баримтлах | • Тойрог эдийн засагт шилжих<br>• Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах | • Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа<br>• Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ |

Үнэт цаас гаргагч нь дээрх дурдсан татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөөд байна.

2024.07.05 он сар өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ 03

**Хүснэгт 60: Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын нарийвчилсан төлөвлөгөө**

| № | Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт | Зарцуулах дүн, сая доллар хүртэл | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Тоног төхөөрөмжийн худалдан авалт буюу "Ти Эм Эл" ГХОХХК-аас шилжүүлэн авсан тоног төхөөрөмжийн төлбөрийг гүйцэтгэх | 11,000,000.0 | 73.3% |
| 2 | Хуванцар хаягдал цуглуулах, ангилах, бэлтгэн нийлүүлэх цэг байгуулах хөрөнгө оруулалт | 2,000,000.0 | 13.3% |
| 3 | Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт | 2,000,000.0 | 13.3% |
| | **Нийт** | **15,000,000.0** | **100.0%** |

Үнэт цаас гаргагчийн ногоон бонд гаргаж татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт нь НҮБ-ын "Тогтвортой хөгжлийн зорилт", Европын Холбооны таксономи болон Монгол Улсын Ногоон таксономитой нийцсэн байдлын талаарх дэлгэрэнгүйг Үнэт цаасны танилцуулгын 3.4 дэх хэсгээс уншиж танилцана уу.

## 3.10. ХӨНДЛӨНГИЙН БАТАЛГААЖУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ

"ТЖТБ" ХХК нь Sustainable Fitch байгууллагатай 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 00158705.0 дугаартай "ТЖТБ" ХХК-ийн байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан. Sustainable Fitch байгууллагын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр гаргасан хөндлөнгийн үнэлгээд дараах үзүүлэлтүүдийг онцлон тусгасан байна. Үүнд:

**Хүснэгт 61: Үнэт цаас гаргагчийн БОНЗ-ын хөндлөнгийн үнэлгээ**

| Үзүүлэлт | Үнэлгээ | Гол үзүүлэлтүүд |
|---|---|---|
| **Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт** | **Онц** | • "ТЖТБ" ХХК-ийн ногоон бондын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах төлөвлөгөөнд багтаж буй хоёр зорилт нь уур амьсгалын өөрчлөлтийг багасгах, хуванцар хог хаягдлын бохирдлоос урьдчилан сэргийлэх, тойрог эдийн засагт шилжихэд бодит нөлөө үзүүлнэ гэж Sustainable Fitch-с дүгнэсэн байна.<br>• Түүнчлэн, татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт нь Европын Холбооны Ногоон таксономийн хоёр зорилтын техникийн шалгуурыг хангасан бөгөөд мөн Монгол Улсын Ногоон таксономи болон урт хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байна. |
| **Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт – Бусад мэдээлэл** | **Сайн** | • Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 27%-ийг шинэ төсөлд хөрөнгө оруулах амлалт өгөөд байна. Sustainable Fitch нь татан төвлөрүүлсэн хөрөнгөд шинэ төсөл санхүүжүүлэх хувь өндөр байхыг илүүд үздэг нь шинэ төслийн интервенцээр үзүүлэх нэмэлт нөлөө нь илүү байдагтай холбоотой юм.<br>• 36 сарын эргэн харах хугацаатай байгаа нь зах зээлийн практиктай нийцэж байна |
| **Төслийн үнэлгээ, сонгон шалгаруулах үйл явц** | **Онц** | • Шаардлага хангасан төслүүдийг үнэлэх, сонгох чиг үүрэг бүхий Ногоон санхүүжилтийн хороо нь чиглэл бүрийн мэргэжилтнээс бүрдэж байна. Эдгээр нь БОНЗ менежер, |

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

ТЖТБ
УЛААНБААТАР ХОТ

2024 .07 сар 05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ 02

| | | |
|---|---|---|
| | | ахлах нягтлан бодогч, эрсдэл комплайнсын эксперт, Гүйцэтгэх захирал /хорооны дарга/-аас бүрдэнэ. |
| **Татан төвлөрүүлсэн хөрөнгийн менежмент** | **Онц** | • Ногоон бонд гаргаснаар татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгай дансанд байршуулна. Ногоон санхүүжилтийн хороо нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн хуваарилалтыг хянах ба шалгуур хангаагүй төслүүдийг ногоон төслүүдийн жагсаалтаас хасах эрхтэй. |
| **Тайлагнал ба ил тод байдал** | **Онц** | • Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл бүрийн хуваарилалтын болон нөлөөллийн тайланг жил бүр тайлагнахаар байна.<br>• Мөн Үнэт цаас гаргагч нь дээрх тайлангуудыг хараат бус гуравдагч этгээдээр баталгаажуулахаар байна. |

**НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын холбогдох зорилт:**







**Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт:**

| | |
|---|---|
| **Ногоон** | • Бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах<br>• Тойрог эдийн засагт нийцсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн технологи ба үйл явц. |

**Үнэт цаас гаргагчийн Ногоон Бондын Хүрээний онцлох зүйлс**

Sustainable Fitch нь Үнэт цаас гаргагчийн Ногоон Бондын Хүрээ (НБХ)-д хийгдэх хэлцлүүдийг Олон Улсын Хөрөнгийн Зах Зээлийн Холбоо (ОУХЗЗХ)-оос нийтэлсэн Ногоон Бондын Зарчимууд (НБЗ)-тай нийцнэ гэж дүгнэж байгаа бөгөөд түүнд НБЗ-ын дөрвөн гол тулгуур багтаж байна. Үүнд:

- татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт;
- үнэлгээ ба сонгон шалгаруулалт;
- татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага;
- тайлагнал ба ил тод байдал.

Мэргэжлийн баталгаажуулалтын байгууллага нь Үнэт цаас гаргагчийн Ногоон Бондын Хүрээг "Онц" үнэлгээтэйгээр ОУХЗЗХ-ны НБЗ-тай нийцэж байгаа гэж дүгнэжээ.

**Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт (ТТХЗ) – Нийцлийн үнэлгээ: ОНЦ**

***Хуванцар хог хаягдал ялгах ба дахин боловсруулах үйлдвэр***

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг хуванцар хог хаягдал ялгах ба дахин боловсруулах үйлдвэрт зарцуулахаар төлөвлөж байгаа нь ОУХЗЗХ-ны НБЗ-ын "хог хаягдлын бохирдлоос урьдчилан сэргийлэх ба түүнийг хянах" болон "тойрог эдийн засагт нийцсэн бүтээгдэхүүн, үйлдвэрийн технологи ба үйл явц" гэх ногоон төслийн ангиллуудтай нийцэж байна.

Ти Эм Эл Пластик үйлдвэр нь Европын Холбооны таксономийн дараах шалгууруудыг хангасан байна. Үүнд:

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5147204 ХАК
ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2024.07.05 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

**Хүснэгт 62: Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт нь Европын Холбооны таксономийн шалгууруудыг хангасан байдал**

| № | Нэр | Шалгуур давсан үндэслэл |
|---|---|---|
| 1 | Уур амьсгалын өөрчлөлт багасгах зорилт | - цуглуулсан хуванцар хог хаягдлын тавиас дээш хувийг хоёрдогч түүхий эд болгож боловсруулдаг;<br>- хуванцар хог хаягдлыг дахин боловсруулдаг. |
| 4 | Тойрог эдийн засагт шилжих зорилт | - боловсруулж буй бүтээгдэхүүнээ тусад нь цуглуулж тээвэрлэдэг;<br>- үйлдвэрийн дахин боловсруулалтын харьцаа нь эрх бүхий байгууллагын тавьсан шаардлагаас өндөр ба Үнэт цаас гаргагч тус харьцааг хянах зорилгоор KPI үүсгэсэн байна;<br>- хөндлөнгийн этгээд Үнэт цаас гаргагчийн боловсруулж буй хоёрдогч түүхий эдийг үндсэн түүхий эдийн орлуулагч болох баталгааг олгосон. |

Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн нь олон улсын стандарт хангаснаар Монгол Улсын ногоон таксономийн дараах ангилалтай нийцэж байна:

**Хүснэгт 63: Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт нь Монгол Улсын Ногоон таксономийн ангилалтай нийцэж буй байдал**

| № | Нэр |
|---|---|
| **6.2.2** | Хаягдал цуглуулах, ангилах болон нөхөн сэргээх, дахин боловсруулах байгууламжууд |
| **6.3.1** | Түүхий эд материал ашиглалтыг багасгах, ногоон болгох |

Жилд 27,000 тонн хуванцар дахин боловсруулах хүчин чадалтай Ти Эм Эл Пластик үйлдвэр нь Монгол Улсын PET хог хаягдлыг багасгахад томоохон нөлөө үзүүлэхээр байна. Sustainable Fitch нь уг татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын шаардлага хангасан төслүүд Монгол Улсын 2030 онд ландфилллд булшлах хог хаягдлын хэмжээг 40%-иар бууруулах зорилтод ихээхэн хувь нэмэр оруулна гэж дүгнэжээ.

***Хуванцар хог хаягдлыг цуглуулах ба ялгах дэд бүтэц***

Үнэт цаас гаргагч татан төвлөрүүлсэн хөрөнгийг хуванцар хог хаягдал цуглуулах болон ялгах дэд бүтэц байгуулахад зарцуулах нь ОУХЗЗХ-ны НБЗ-ын "хог хаягдлын бохирдлоос урьдчилан сэргийлэх ба түүнийг хянах" ангилалтай нийцэж байна. Уг төсөл нь дахин боловсруулагдах хог хаягдлыг үйлдвэрт очихоос өмнө өмнө шаардлагатай цэвэрлэгээ болон ялгах ажиллааг биелүүлж байгаа бөгөөд энэ нь Монгол Улсын тойрог эдийн засагт дэмжлэг үзүүлэх нэг хэлбэр юм.

**Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, бусад мэдээлэл – Нийцлийн үнэлгээ: САЙН**

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн 73 хувийг хуванцар ялгах ба дахин боловсруулах үйлдвэрт зарцуулж байгаа нь дахин санхүүжилт гэж Sustainable Fitch үзэж байна. Харин үлдсэн 27 хувийг шинэ төсөл санхүүжүүлэхэд зарцуулж байгаа нь мэргэжлийг баталгаажуулалтын байгууллагын хувьд нэмэлт байгаль орчны эерэг нөлөө бий болгож байгаа юм.

**Үнэлгээ ба сонгон шалгаруулалт – Нийцлийн үнэлгээ: ОНЦ**

ОУХЗЗХ-ны НБЗ-д үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц ил тод байхыг шаарддаг ба Үнэт цаас гаргагчийн төсөл тодорхойлох, үнэлэх, сонгох үйл явц үүнтэй нийцэж байна. Түүнчлэн Ногоон Санхүүжилтийн Хороод өөр нэгж, газруудын төлөөлөл оролцож олон өнцгөөс санал бодол авах нь сайн практик юм.

TDB SECURITIES

**Татан төвлөрүүлсэн хөрөнгийн менежмент – Нийцлийн үнэлгээ: ОНЦ**

Үнэт цаас гаргагчийн НБХ нь зарцуулагдаагүй татан төвлөрүүлсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй байгаа нь ОУХЗЗХ-ны НБЗ-тэй нийцэж байна. Зарцуулагдаагүй татан төвлөрүүлсэн хөрөнгийг НБХ-ний байгаль орчны зорилтод нийцэх хөрөнгө оруулалтад байршуулах нь бондын байгаль орчины нөлөөнд нэмэр оруулах юм.

Зарцуулагдаагүй татан төвлөрүүлсэн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөр үлдээх нь зах зээлийн практиктай ижил байна. Түүнчлэн татан төвлөрүүлсэн хөрөнгийг тусгай дансаар удирдаж ногоон төсөлд зарцуулах нь аливаа ногоон бус төсөл санхүүжүүлэх эрсдэлээс хамгаалж байна.

**Тайлагнал ба ил тод байдал – Нийцлийн үнэлгээ: ОНЦ**

Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг бүрэн зарцуулагдах хүртэл жил бүр тайлан тавихаар байгаа нь ОУХЗЗХ-ны НБЗ-тай нийцэж байна. Түүнчлэн ногоон бондын хугацаа дуусах хүртэл санхүүжүүлсэн төслүүдийн байгаль орчны нөлөөг тайлагнахаар байгаа нь зах зээлийн сайн жишигтэй нийцэж байгаа бөгөөд уг тайланд төсөл бүрийг тусад нь оруулахаар байна. Төслүүдийн байгаль орчны нөлөөг хэмжих аргачлал нь олон улсын стандартаар баталгаажсан судалгаа шинжилгээ дээр суурилсан юм.

СЗХ 2024.07.05 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03 БҮРТГЭВ-02

## 3.11. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ

### 3.11.1. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАХ АРГА ХЭЛБЭР

Үнэт цаас гаргагч нь Ногоон бондын анхдагч зах зээлийн арилжааг Биржийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор баталж, 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 9 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталж, 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам", Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор баталсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-д заасны дагуу явуулна.

Үнэт цаас гаргагч нь биржээр дамжуулан нээлттэй хүрээнд санал болгож буй Ногоон бондыг Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор баталсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон үнийн аргаар Монголын хөрөнгийн биржээр дамжуулан зохион байгуулна.

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох тодорхой үнийн дүн бүхий Үнэт цаасыг бүхэлд (нийтэд) нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаа хэсэгчлэн санал болгох Өрийн хэрэгслийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### 3.11.2. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагч нь дараах хуваарийн дагуу үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна.

**Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах хуваарь**




### 3.11.3. ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасаа нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг Бирж болон Хороонд гаргах бөгөөд уг арилжаа эрхлэх болон зохицуулагч байгууллагууд Үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд санал болгох Үнэт цаасны анхны нийлүүлэлтийг Хороонд бүртгүүлснээс хойш 6 (зургаа) сарын дотор гүйцэтгэх ба Үнэт цаасыг Хороонд бүртгүүлснээс хойш 24 (хорин дөрөв) сарын хугацаанд хөтөлбөрийг хэрэгжүүлж бүрэн дуусгана.

Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгох нийт бондуудын тоо, татан төвлөрүүлэхээр зорьж байгаа хөрөнгийн хэмжээ, үндсэн болон хүүгийн төлбөр төлөх нөхцөл, үнэ, хүү нь харилцан адилгүй байж болно.

Андеррайтер нь Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд Үнэт цаасыг анхдагч зах зээлд нийлүүлэх тухай бүрд холбогдох мэдэгдлийг баримт бичгийн хамт уг ажиллагааг эхлүүлэхээс 5 (тав)-аас доошгүй доошгүй өдрийн өмнө Хороо болон Биржид хүргүүлэх бөгөөд тус мэдэгдлийг хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авахад бэлэн болно.

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авч, арилжааг зохион байгуулан, санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын 3 (гурав) өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг Биржийн дүгнэлтийн хамт Хороонд хүргүүлнэ. Хороо нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын 3 (гурав) өдөрт багтаан холбогдох талуудад хүргүүлнэ.

### 3.11.4. ҮНЭТ ЦААСЫГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ

Бирж болон Хороо нь үнэт цаасыг бүртгэж, үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдахыг зөвшөөрсний дараа Андеррайтер нь тухайн үнэт цаасны танилцуулах аяныг эхлүүлэх талаар мэдэгдлийг ажлын 5 (тав)-аас доошгүй хоногийн өмнө Хороонд хүргүүлж, үнэт цаасыг нийтэд мэдээлэх, танилцуулах аяныг зохион байгуулна.

Үнэт цаасыг бүртгүүлэхээс өмнөх бэлтгэл үе шатанд үнэт цаас гаргагч болон андеррайтер нь стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдтэй хөрөнгө оруулалт татах талаар урьдчилан яриа, хэлэлцээр хийж болох бөгөөд үүнийг үнэт цаасыг нийтэд санал болгосонд тооцохгүй.

### 3.11.5. АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛ

Үнэт цаасыг нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай Хорооноос шийдвэр гаргасны дараа Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд Үнэт цаасыг анхдагч зах зээлд нийлүүлэх тухай бүрд дараах мэдэгдлийг баримт бичгийн хамт уг ажиллагааг эхлүүлэхээс 5 (тав)-аас доошгүй доошгүй өдрийн өмнө Хороо болон Биржид хүргүүлэх бөгөөд бөгөөд тус мэдэгдлийг хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авахад бэлэн болно. Үүнд:

- Захиалга авч эхлэх огноо, үргэлжлэх хугацаа;
- Санал болгох үнэт цаасны хэмжээ, үнэ;
- Санал болгох арга, хэлбэр;
- Өмнөх улирлын санхүүгийн ерөнхий үзүүлэлт;
- Үнэт цаасны танилцуулгад заасан үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан.

Андеррайтер нь арилжаа зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, анхдагч зах зээлийн арилжааг эхлэх, дуусгах өдрийг товлон Биржид мэдэгдэж, Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх бөгөөд үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 (тав) хоногт хүлээн авна.

Үнэт цаасны захиалгын бүртгэлийг Биржийн анхдагч зах зээлийн арилжааны программ болон Андеррайтерийн арилжааны системээр дамжуулан тус тус зохион байгуулна.

СЭХ 2024.07.05 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2024-06-03

### 3.11.6. ҮНЭТ ЦААСНЫ ХУВААРИЛАЛТ

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай зөвшилцөн, олон нийтээс хүлээн авсан бондын захиалгын хуваарилалтыг Биржийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 10 дугаар бүлгийг баримтлан хэрэгжүүлэх ба анхдагч зах зээлийн арилжааны хэлцэл биелүүлэх ажиллагааг Үнэт цаасны танилцуулга болон Андеррайтераас ирүүлсэн хүсэлтэд тусгасан хуваарилалтын нөхцөлийн дагуу Биржээр дамжуулан гүйцэтгэнэ.

### 3.11.7. ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ, ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

Хөрөнгө оруулагч нь Биржид бүртгэлтэй үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэж, өөрийн үнэт цаасны дансанд дараах зааврын дагуу үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгөө байршуулах ба үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалгаа өгнө.

**Үнэт цаас худалдан авах захиалга өгөх заавар**




- ➔ Үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэнэ.
- ➔ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК дээрх өөрийн нэр дээрх дансанд үнэт цаас худалдан авах мөнгөө байршуулна.
- ➔ Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа үнэт цаас худалдан авах захиалга өгнө.
- ➔ Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдаж, эрх бүхий байгууллага зөвшөөрснөөр хөрөнгө оруулагчийн нэр дээр үнэт цаас шилжинэ.

**Мөнгөн хөрөнгө байршуулах**

Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн банкаар дамжуулан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх өөрийн нэрийн дансандаа мөнгөн хөрөнгөө байршуулна.

**Хүснэгт 64: Үнэт цаасны мөнгө байршуулах заавар**

| | |
|---|---|
| Хүлээн авагчийн банк | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| Хүлээн авагчийн нэр | Овог, нэр |
| Дансны дугаар | **** **** **** 12 орон бүхий үнэт цаасны дансны дугаар (үйлчлүүлдэг ҮЦК-аас лавлах) |
| Үнийн дүн | Бондын үнэ + Шимтгэл |
| Гүйлгээний утга | Бондын мөнгө, [Овог нэр, регистрийн дугаар] |

**Арилжааны шимтгэл**

Үнэт цаас худалдан авагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон болон захиалга өгсөн Үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд эрх бүхий байгууллагууд болон арилжаа эрхлэх байгууллагын шимтгэл багтсан байна.*

**Биржийн гишүүн Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.*

**Албан татвар**

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2024 он 07 сар 05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024 -06- 03
БҮРТГЭВ-02

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт "Энэ хуулийн 21.2.4, 21.2.5-д заасныг үл харгалзан Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл, хувьцаа, нэгж эрх эзэмшигч албан татвар төлөгчийн тухайн хувьцаа, нэгж эрх, өрийн бичигтэй холбоотойгоор олсон хүүгийн орлого, ногдол ашгийн орлогод 5 хувиар албан татвар ногдуулна." гэж заасны дагуу Үнэт цаас гаргагчийн нээлттэй хүрээнд биржийн зах зээлд гаргаж буй энэхүү Ногоон бондыг эзэмшиж буй Монгол Улсын иргэн, хуулийн этгээд болон гадаад улсын иргэний хүүгийн орлогод 5 хувийн татвар ногдоно*. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн хувьд Монгол Улсын Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтын дагуу бондын хүүгийн орлогоос 20 хувийн татвар төлөхөөр зохицуулагдсан байна.

** Давхар татварын гэрээний хүрээнд албан татвар ногдуулж, суутгал хийнэ*

**Валютын ханш**

Монголбанкны 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А-1/89 тоот албан бичгийн хүрээнд Үнэт цаас гаргагч нь орон нутагт хог ангилах үйлдвэр, цэгүүдэд шаардлагатай машин, тоног төхөөрөмж худалдаг авах зорилгоор 15.0 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг биржийн зах зээлд ам.доллароор гаргах, үүнтэй холбоотой төлбөр тооцоог ам.доллароор гүйцэтгэх зөвшөөрлийг авсан байна.

Үүний хүрээнд 15.0 сая доллар хүртэлх үнийн дүн бүхий үнэт цаасны арилжаа нь ам.доллароор хийгдэнэ.

### 3.11.8. АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО, ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын 3 (гурав) өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг Биржийн дүгнэлтийн хамт Хороонд хүргүүлнэ. Хороо нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд Үнэт цаас гаргагчийн Ногоон бондын өмчлөх эрхийн бүртгэлийг хийх ба Биржид үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох ба энэ тухай албан бичгийг ажлын 3 (гурав) өдөрт багтаан хүргүүлнэ.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь Хорооны албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 (тав) өдрийн дотор үнэт цаас гаргагчийн Ногоон бондын эрхийн бүртгэлийг хийх ба энэ талаар Хороо, Биржид мэдэгдэнэ. Бирж нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн Ногоон бондын бүртгэлийг хийсэн тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 2 (хоёр) өдрийн дотор үнэт цаас гаргагчийн бондын хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES



ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ



# 04 ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

## 4.1. АНДЕРРАЙТЕР

### 4.1.1. АНДЕРРАЙТЕРЫН ТАНИЛЦУУЛГА

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК**

| | |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9011165033 |
| **Регистрийн дугаар:** | 5251494 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Брокер, андеррайтер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа, номинал данс эзэмших, уур уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагаа |
| **Хаяг:** | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа, хөгжлийн банкны байр, 1401 тоот |
| **Утас:** | (976) 70100261, (976) 11 311914 |
| **Э-шуудан:** | info@tdbsecurities.mn |
| **Вэб хуудас:** | www.tdbsecurities.mn |

"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК нь анх 2011 онд "Ти Ди Би Капитал" ХХК нэрээр үүсгэн байгуулагдаж, дотоодын болон олон улсын зах зээл, эдийн засгийн салбаруудын бие даасан онцлог болон тэдгээрийн хоорондын харилцан хамаарлын талаар мэдлэг, мэдээллийг хослуулан хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаагаа явуулж буй Монгол Улсын тэргүүлэх үнэт цаасны компани юм.

Тус компани харилцагчдын хэрэгцээ шаардлага, хүсэл зорилгыг эрхэмлэсэн, дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээ, шийдлийг мэргэжлийн өндөр түвшинд түргэн шуурхай хүргэн үндэсний баялаг бүтээгчдийг дэмжиж, харилцагчдын найдвартай зөвлөх байхыг зорин ажиллаж байна. Тус компани нь харилцагчдадаа хөрөнгө оруулалтын банкны болон үнэт цаасны зуучлалын үйлчилгээг үзүүлж, хувьцаа, бонд зэрэг үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслүүд, бүтэцжүүлсэн санхүүгийн хэрэгслийг нээлттэй болон хаалттай зах зээлд гаргах замаар санхүүжилт татах, үнэт цаас гаргах бэлтгэл ажилд зөвлөх, үнэт цаас гаргасны дараа нэмэлт үйлчилгээ үзүүлэх, компанийн хэлбэрийг өөрчлөх, компанийг өөрчлөн байгуулах, тухайн байгууллагын онцлогт тохирсон санхүүжилтийн хамгийн үр ашигтай хувилбарыг санал болгох, компанийн стратеги төлөвлөлтөд зөвлөх, бизнесийн үнэлгээ гаргах, гадаад дотоодын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцоход зуучлах, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх зэргээр харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг бүрэн хангах, мэргэжлийн зөвлөгөө, туслалцааг үзүүлдэг.

Андеррайтер нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн гадаад болон дотоодын зах зээлд нээлттэй болон хаалтай хүрээнд үнэт цаас гаргах нийт 3.8 тэрбум ам.долларын үнийн дүн бүхий төслүүд дээр ажилласан туршлагатай бөгөөд зах зээлийн дэд бүтцийн хөгжилд томоохон хувь нэмрийг оруулж буй үнэт цаасны компани юм.

Андеррайтер нь Санхүүгийн зохицуулах хорооноос брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, номинал данс эзэмших, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авсан байх бөгөөд эдгээр үйл ажиллагаагаа мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллаж байна.

### 4.1.2. АНДЕРРАЙТЕРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийн компани болох "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК-тай 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр TDBS-575/2023 тоот "Андеррайтер-зөвлөх үйлчилгээний гэрээ", 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр TDBS-618/2024 тоот "Андеррайтер-зөвлөх үйлчилгээний нэмэлт гэрээ"-г тус тус байгуулсан ба Гэрээгээр Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн биржийн зах зээлд нээлттэй хүрээнд санал болгож буй Ногоон бонд гаргах үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай бусад хууль тогтоомж, Эрх бүхий байгууллагуудын холбогдох дүрэм, журамд нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулахаар тусгасан байна.

Гэрээний хүрээнд Туслах андеррайтер нь үнэт цаас гаргах ажлын төлөвлөгөө боловсруулах, Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн мэдээлэл зэрэгт урьдчилсан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр бэлтгэх шаардлагатай баримт бичгүүд, төсөв төлөвлөгөө, мэдээ мэдээллийн талаар зөвлөгөө өгөх, үнэт цаас гаргахтай холбоотой бэлтгэл ажлыг хангуулах, дунд хугацааны бизнес төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө боловсруулахад зөвлөмжөөр хангах, үнэт цаас гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр гаргах, Компанийн сайн засаглалыг хөгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журам, заавар, бодлого боловсруулахад зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах, үнэт цаасны танилцуулга бэлтгэх, эрх бүхий этгээдэд үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлт гаргах, танилцуулах аяныг зохион байгуулах, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах, үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор холбогдох хууль тогтоомж, эрх бүхий зохицуулах байгууллага, арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журмын шаардлага болон түүнийг хангах талаар шаардлагатай зөвлөмжөөр хангах зэрэг ажлуудыг мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэх талаар тусгажээ.

Гэрээнд тусгагдсан гол нөхцөлүүд:

1. Андеррайтерийн үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3 дахь заалтад заасны дагуу хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр зохион байгуулах;
2. Үнэт цаас гаргагчийн гаргаж буй үнэт цаасыг стратегийн хөрөнгө оруулагч болон олон нийтэд санал болгох бөгөөд үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахдаа тогтоосон үнээр санал болгох арилжааны аргыг ашиглах;
3. Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд хэсэгчлэн гаргасан үнэт цаасны эргэн төлөлт Үнэт цаас гаргагчаас шалтгаалан саатсан, Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасны үндсэн төлбөрийн нийлбэр дүн нь эрх бүхий зохицуулах байгууллагаас баталсан журамд заасан харьцаа үзүүлэлтээс хэтэрсэн буюу хэтрэх нөхцөл байдалд байх, зээл баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөртэй, төрийн эрх бүхий байгууллагаас, эсхүл хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын бйагууллагаас Үнэт цаас гаргагч нь "ногоон", "байгаль орчинд ээлтэй" гэх ойлголтыг буруу ашигласан болохыг тогтоосон тухай, эсхүл уг шаардлагад нийцээгүй болсон зэрэг тохиолдолд Андеррайтер нь Өрийн бичгийн хөтөлбөрийн хүрээнд нэмж үнэт цаас гаргахгүй байх эрхтэй байна.

Түүнчлэн, гэрээгээр дотоод мэдээлэл эзэмшигчийн асуудлыг зохицуулсан байх бөгөөд дотоод мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд дамжуулах, худалдах, шилжүүлэх; санхүүжилт татах, үнэт цаас гаргахтай холбоотой бүх төрлийн дотоод мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах, Андеррайтерийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлэх, үнэт цаасыг биржээр арилжаалж эхэлсэн тохиолдолд дотоод мэдээллийг ашиглан ашиг олох, зах зээлийг урвуулан ашиглах болон эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу дотоод мэдээлэл эзэмшигчийн хийхийг хориглосон бусад үйл ажиллагааг дотоод мэдээлэл эзэмшигчдэд хориглосон байна.

Үнэт цаас гаргагч нь Андеррайтерт ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн тогтоол, шийдвэр, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг Андеррайтераас санал болгосон хугацаанд түргэн

шуурхай, бүрэн гүйцэд, шаардлага хангахуйц байдлаар гаргаж өгөх, Андеррайтерийг үнэн зөв мэдээллээр хангах үүрэг хүлээсэн байна.

Нөгөө талаас, Андеррайтер нь Үнэт цаас гаргагчаас бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчийн нууц мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд ямар нэгэн хэлбэрээр задруулахгүй байх, Үйлчилгээг ямар нэг байдлаар доголдолтой үзүүлсэн тохиолдолд тухайн доголдлыг өөрийн зардлаар арилгах үүрэгтэй байна.

СЗХ
2024 .07. 05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

## 4.2. АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

### 4.2.1. АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

PKF

**"Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК**

| | |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9018001031 |
| **Регистрийн дугаар:** | 2565617 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Аудитын үйл ажиллагаа эрхлэх, үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх |
| **Хаяг:** | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъяан гүний гудамж 18, Даун таун оффис, 602 тоот |
| **Утас:** | (976) 11 325446 |
| **Э-шуудан:** | info@pkf.mn |
| **Вэб хуудас:** | www.pkf-ifs.mn |

"Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК нь анх "Координат аудит" ХХК нэртэйгээр 1998 онд үүсгэн байгуулагдаж, мэргэжлийн ёс зүйг чанад баримталж, нийтийн ашиг сонирхлыг хангаж, аудит, санхүүгийн салбарт 25 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Пи Кэй Эф Монголиа нь 2020 оны 6-р сард аудит ба баталгаажуулалт, татвар, бизнесийн зөвлөх үйлчилгээгээр дэлхийд тэргүүлэгч олон улсын сүлжээ фирмүүдийн нэг "PKF International" сүлжээ фирмийн Монгол Улс дахь албан ёсны төлөөллийг хэрэгжүүлж эхэлсэн ба харилцагчдад олон улсын стандартад нийцсэн, чанартай мэргэжлийн ажил үйлчилгээг үзүүлж байна. Үйл ажиллагааны хувьд аудит, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ, эрсдэлийн удирдлага, санхүүгийн шинжилгээний гэх мэт зөвлөх үйлчилгээ, татварын зөвлөх үйлчилгээ, цалин хөлсний талаарх зөвлөгөө зэргээр үйлчлүүлэгч компаниудаа ханган ажилладаг.

Тус аудитын байгууллага нь үйл ажиллагаа явуулж буй хугацаандаа эдийн засгийн салбар бүрийн хувийн болон төрийн өмчийн байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын төсөл хөтөлбөрүүд гэх мэт 200 гаруй байгууллага, аж ахуйн нэгжүүдэд аудитын болон зөвлөх үйлчилгээний үйлчилгээ болон санхүүгийн шинжээчийн ажлыг гүйцэтгэсэн арвин туршлагатай. Мөн Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг нэр хүндтэй олон улсын байгууллагын санхүүжилт, зээл тусламжаар хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдэд зөвлөхөөр, үндэстэн дамнасан корпорацуудад ажил, үйлчилгээг үзүүлэн хамтран ажиллаж байжээ.

### 4.2.2. АУДИТЫН БАЙГУУЛЛАГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Үнэт цаас гаргагч нь Аудитын байгууллага болох "Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК-тай 2023 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр №18 дугаар бүхий "Аудитын үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ"-г байгуулсан бөгөөд тус гэрээнд Үнэт цаас гаргагчийн 2022 оны 12 дугаар сарын 31 болон 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тус тус тасалбар болгосон санхүүгийн тайлан, анхан шатны баримт, бусад санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой баримт мэдээ, үйл ажиллагаанд Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хөндлөнгийн хяналт шалгалт хийж, дүгнэлт өгөхөөр тусгасан байна.

Гэрээнд тусгагдсан гол нөхцөлүүд:

1. Аудитын компани нь аудитын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай баримт мэдээллийг бүрэн хүлээн авсан өдрөөс хойш календарийн 45 өдөрт багтаан ажил үүргийг гүйцэтгэх;

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

ТЖТБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

2. Үнэт цаас гаргагч нь Аудитын компанийн шалгалтанд шаардлагатай баримт, мэдээллийг гэрээт ажил эхлэхээс өмнө болон тухайн шаардагдсан цаг тухайд нь шуурхай гаргаж өгөх;
3. Үнэт цаас гаргагч нь аудитын үйл ажиллагааг явуулах нөхцөл боломжоор хангах, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцохгүй, саад учруулахгүй байх;
4. Үнэт цаас гаргагч нь шалгалтын явцад илэрсэн бүртгэл хөтлөлтийн болон санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчлийг залруулах;
5. Аудитын компани нь Үнэт цаас гаргагчийн 2022 оны 12 дугаар сарын 31 болон 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тус тус тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийхдээ Монгол Улсын Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын багц хууль болон бусад хуулийг чандлан сахиж, АОУС-д заасан арга хэлбэрээр аудитын үйл ажиллагааг явуулах;
6. Аудитын компани нь аудитын ажлыг Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны цар хүрээ, хийгдэх ажлын хэмжээтэй уялдуулан аудитын багийг томилж, мэргэжл ийн өндөр түвшинд, хууль тогтоомж, батлагдсан стандартын дагуу шударгаар гүйцэтгэх;
7. Аудитын үйл ажиллагааг Үнэт цаас гаргагчийн эсвэл өөрийн байранд явуулах бөгөөд аудит хийх явцад олж авсан Үнэт аас гаргагчийн аливаа мэдлээллийг хувийн зорилгоор ашиглах, хуулинд үаснаас өөр тохиолдолд бусдад мэдээлэхээс татгалзах ба Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой баримтууд болон аудитын бусад ажлын баримт, материалыг өөрийн ажлын байранд тусгайлан хадгалж, нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

СЗХ
2024.07.05 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

## 4.3. ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА

### 4.3.1. ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

**"Гэрэгэ-Эстимэйт Үнэлгээ" ХХК**

| | |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9011215085 |
| **Регистрийн дугаар:** | 5342961 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа, бизнесийн зөвлөгөө өгөх, хөрөнгийн үнэлгээ хийх |
| **Хаяг:** | Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сүхбаатарын талбай, 20/6 Эрдмийн ордон, 1004 тоот |
| **Утас:** | (976) 7000 5000 |
| **Э-шуудан:** | info@geregepartners.mn |

"Гэрэгэ-Эстимэйт үнэлгээ" ХХК нь хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний чиглэлээр ажилладаг үнэлгээний мэргэжлийн компани юм. Үнэлгээний баг нь үнэлгээчин, актуарч, нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч зэрэг олон чиглэлийн нарийн мэргэжлийг гадаад дотоодын их дээд сургуулиудад эзэмшиж, мэргэжлээрээ ажилласан туршлагатай чадварлаг мэргэжилтнүүдээс бүрддэг.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь Монгол Улсын Сангийн яамны хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй бөгөөд Монголын хөрөнгийн бирж дээр үнэт цаас арилжаалах компаниудын бизнесийн үнэлгээ хийх эрхтэй Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй компани юм.

Үнэт цаас гаргагчийн барьцаа хөрөнгийн үнэлгээний багийн ахлагчаар Доноровын Ганбаатар ажилласан. Д.Ганбаатар нь хугацаагүй хөрөнгийн үнэлгээчин бөгөөд 2010 оноос хойш тасралтгүй хөрөнгийн үнэлгээний чиглэлээр ажиллаж байна.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээчид өнгөрсөн хугацаанд нийт 20 орчим бизнесийн үнэлгээний ажил хийж гүйцэтгэсэн байдаг бөгөөд эдгээр дурдвал дараах байдалтай байна. Үүнд:

- 2017 онд Монгол Улсын анхны финтек компани болох ЛендМН ББСБ ХК;
- 2018 онд Инвескор ББСБ ХК;
- 2019 онд Бодь Даатгал ХК
- 2021 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК;
- 2022 онд Сэндли ББСБ ХК;
- Монголын хөрөнгийн бирж ХК;
- 2023 онд Монложистикс холдинг ХК
- Инновейшн инвестмент ХК зэрэг компаниудын бизнесийн үнэлгээг тус компаниудын хувьцааг хөрөнгийн бирж дээр олон нийтэд анх удаа санал болгон гаргах зориулалтаар хийж гүйцэтгэсэн туршлагатай бөгөөд эдгээр компаниудын хувьцаа нь Монголын хөрөнгийн бирж дээр амжилттай арилжаалагдаж байна.

### 4.3.2. ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Үнэт цаас гаргагч нь үнэлгээний байгууллага болох "Гэрэгэ-Эстимэйт Үнэлгээ" ХХК-тай 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр GB-230901 тоот "Хөрөнгийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулсан ба тус гэрээнд Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгийн үнэлгээг 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар санхүүгийн тайлагналын зориулалтаар Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад хууль тогтоомж, шаардлагын хүрээнд Үнэлгээний Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэх талаар тусгажээ.

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

Мөн Үнэт цаас гаргагчийн нэгдлийн компани болох "Ти Эм Эл" ГХОХХК нь "Гэрэгэ-Эстимэйт Үнэлгээ" ХХК-тай 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн TML 24/02/06 тоот "Хөрөнгийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулж, үнэт цаасны үүргийн гүйцэтгэл хангах барьцаа хөрөнгө болох "Ти Эм Эл" ГХОХХК-ийн өмчлөл дэх оффисын зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар барьцаа хөрөнгийн зориулалтаар Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шаардлагын хүрээнд Үнэлгээний Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэх талаар тусгажээ.

Үнэлгээний компани нь үнэлгээ хийх мэргэжлийн үйл ажиллагаандаа хараат бус байх, нууцыг хадгалах, шударга байх, бодитой байх, хууль тогтоомж, стандартад нийцсэн байх зарчмуудыг тус тус баримтлан заасан хугацаанд үнэлгээний тайланг аливаа эрхийн зөрчилгүй, доголдолгүй байдлаар, үнэлгээчний ёс зүйн дүрмийг баримталж, аливаа эрхийн зөрчилгүй, доголдолгүй, хууль, тогтоомж, аргачлалд нийцсэн үнэн зөв тайлан гаргах үүрэгтэй.

Гэрээнүүдэд тусгагдсан гол нөхцөлүүд:

1. Үнэт цаас гаргагч нь үнэлгээний компанид ил болгох, шилжүүлэх шаардлагатай гэж талууд үзсэн аливаа мэдээлэл, баримт, тайланг үнэлгээний компанийн санал, хүсэлтийн дагуу аль болох хурдан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.
2. Үнэлгээний компани нь аливаа эрхийн зөрчилгүй, доголдолгүй, хууль, тогтоомж, аргачлалд нийцсэн үнэн зөв тайлан гаргах үүрэгтэй.
3. Үнэлгээний компани нь тайланд үнэлгээ хийсэн аргачлал, үнэлгээнд нөлөөлсөн хүчин зүйлсийн үндэслэлийг нарийн тусгасан байх бөгөөд үнэт цаас гаргагчийн хүсэлтээр гуравдагч этгээдэд үнэлгээ хийхэд өөрийн хийсэн аргачлал болон үндэслэлийг аливаа нэмэлт үнэ төлбөргүйгээр батлан харуулах, тайлбарлах үүрэгтэй.
4. Үнэлгээний компани нь ажил гүйцэтгэх явцад олж мэдсэн үнэт цаас гаргагчийн эд хөрөнгийн өмчлөлийн талаарх бүхий л мэдээлэл, баримт бичиг, зураг төсөл, программ хангамж, дижитал мэдээлэл, түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр дамжуулахгүй, задруулахгүй байх үүргийг гэрээ дуусгавар болсноос хойш 5 жилийн хугацаанд хүлээнэ.
5. Үнэлгээний компани нь үнэт цаас гаргагч болон гуравдагч этгээдээс ажил гүйцэтгэхэд зориулан шилжүүлсэн бичиг баримт, эл хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллаж, ажил гүйцэтгэж дууссаны дараа үнэт цаас гаргагчид аливаа доголдолгүйгээр эргүүлэн шилжүүлэх үүрэгтэй.
6. Үнэт цаас гаргагч нь гэрээт ажлын хүрээнд багтсан аливаа ажлын нэмэлт дүгнэлт, тодорхойлолтыг үнэ төлбөргүйгээр гаргуулах, шаардлагатай тохиолдолд нэмэлт тооцоо судалгаа хийлгүүлэх эрхтэй.
7. Үнэт цаас гаргагч нь үнэлгээний компанийн ажлын гүйцэтгэл чанарын шаардлага хангаагүй тохиолдолд үнэлгээний тайланг хүлээн авахаас татгалзаж, дахин үнэ төлбөргүйгээр ажлын 10 хоногт багтаан гүйцэтгэхийг шаардах, шаардлагыг хүлээж аваагүй тохиолдолд гэрээг цуцалж, шилжүүлсэн аливаа төлбөрийг буцаан шаардах эрхтэй.
8. Үнэт цаас гаргагчийн "Гэрэгэ-Эстимэйт Үнэлгээ" ХХК-тай 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр GB-230901 тоот "Хөрөнгийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ"-нд Үнэлгээний байгууллага нь үнэлгээнд шаардагдах материалыг үнэт цаас гаргагчаас гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 3 хоногийн дотор, нэмэлт мэдээллийг хүсэлт гаргаснаас хойш нэн дариу хүлээн авч үнэлгээний ажлын төлөвлөгөөг мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын 2 хоногт багтаан үнэт цаас гаргагчид танилцуулах, үнэлгээний урьдчилсан үр дүнг шаардлагатай мэдээллийг авснаас хойш ажлын 10 хоногт багтааж гаргах, урьдчилсан үр дүнг танилцуулан ажлын 10 хоногт багтаан талууд ойлголцох, талууд харилцан ойлголцсоноос хойш ажлын 5 хоногт багтаан үнэлгээний ажлын эцсийн тайланг хүлээлгэн өгөх үүрэгтэй.
9. Үнэт цаас гаргагчийн нэгдлийн компани болох "Ти Эм Эл" ГХОХХК нь "Гэрэгэ-Эстимэйт Үнэлгээ" ХХК-тай 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн TML 24/02/06 тоот "Хөрөнгийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ"-нд Үнэлгээний байгууллага нь үнэлгээнд шаардагдах материалыг үнэт цаас гаргагчаас гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 1 хоногийн дотор, нэмэлт мэдээллийг хүсэлт

гаргаснаас хойш нэн дариу хүлээн авч үнэлгээний ажлын төлөвлөгөөг мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын 1 хоногт багтаан үнэт цаас гаргагчид танилцуулах, үнэлгээний урьдчилсан үр дүнг шаардлагатай мэдээллийг авснаас хойш ажлын 3 хоногт багтааж гаргах, урьдчилсан үр дүнг танилцуулан ажлын 2 хоногт багтаан талууд ойлголцох, талууд харилцан ойлголцсоноос хойш ажлын 1 хоногт багтаан үнэлгээний ажлын эцсийн тайланг хүлээлгэн өгөх үүрэгтэй.

СЗХ
2024.07.05
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

## 4.4. ХӨНДЛӨНГИЙН ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

### 4.4.1. ХУУЛИЙН ЗӨВЛӨХИЙН ТАНИЛЦУУЛГА

SNOW HILL CONSULTANCY

**Өмгөөллийн "Сноу Хилл Консалтанси" ХХН**

| | |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9022003117 |
| **Регистрийн дугаар:** | 6593879 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх, үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх |
| **Хаяг:** | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж 16, Ардчиллын өргөө, 6 давхар |
| **Утас:** | (976) 7711 8193, 976) 7711 8194 |
| **Э-шуудан:** | info@snowhill.mn |
| **Вэб хуудас:** | www.snowhill.mn |

Өмгөөллийн "Сноу Хилл Консалтанси" ХХН нь 2020 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Улсын дээд шүүхэд бүртгэлтэй өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх 19 хуульч, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх эрх бүхий 12 хуульч, Татварын итгэмжлэгдсэн болон Мэргэшсэн нягтлан бодогч, санхүү бүртгэлийн зөвлөх 3, хятад, англи, орос, герман, солонгос болон япон хэлээр мэргэжлийн түвшинд ажиллах чадвартай 30 гаруй хуульч, эрх зүйчдээс бүрдсэн томоохон хуулийн фирмүүдийн нэг юм. Дан ганц бизнесийн зөвлөх үйлчилгээ төдийгүй хуулийн төсөл боловсруулах, гадны санхүүжүүлэгч байгууллагуудаас хэрэгжүүлдэг, нийгмийн хөгжилд чиглэсэн төслүүдэд зөвлөхөөр ажиллаж, дотоодын болон олон улсын шүүхийн болон арбитрын хэргүүдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байна. Тус нөхөрлөл нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 1 сарын 27-ны өдөр 24 тоот тогтоолын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэн ажиллаж байна.

### 4.4.2. ХУУЛИЙН ЗӨВЛӨХТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Үнэт цаас гаргагч нь хуулийн байгууллага болох "Сноу Хилл Консалтанси" ХХН-тай 2023 оны 8 дугаар сарын 07-ны өдөр S-50/23 тоот "Хууль зүйн үйлчилгээний гэрээ"-г байгуулсан ба тус гэрээнд Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон ногоон бонд гаргахтай холбоотой хууль зүйн дүгнэлт болон бусад хууль зүйн үйлчилгээг эрх бүхий байгууллагаас гаргасан журмын агуулгын хүрээнд гаргах талаар тусгажээ.

Хуульч нь гэрээний дагуу гүйцэтгэх ажлын үр дүн болгож Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон Монголын хөрөнгийн биржийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 2018/01 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 226 дугаарын тогтоолын хавсралтаар баталсан "Өрийн хэрэгслийн журам"-д тус тус нийцүүлэн боловсруулсан хууль зүйн дүгнэлтийг үнэт цаас гаргагчид монгол хэл дээр хүргүүлнэ.

Гэрээнд тусгагдсан гол нөхцөлүүд :

1. Хуульч нь гэрээ байгуулахаас өмнө Үнэт цаас гаргагчтай ямар нэг ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхийг нягтална.
2. Хуульч нь гэрээний дагуу гүйцэтгэх ажлын үр дүн болгож Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон Монголын хөрөнгийн биржийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 2018/01 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Санхүүгийн зохицуулах хорооны 2021

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

оны 226 дугаарын тогтоолын хавсралтаар баталсан "Өрийн хэрэгслийн журам"-д тус тус нийцүүлэн боловсруулсан хууль зүйн дүгнэлтийг үнэт цаас гаргагчид монгол хэл дээр хүргүүлнэ.

3. Хуульч нь баримт бичгийг бүрэн хүлээж авснаас хойш хуанлийн 30 хоногт багтаан хуулийн дүгнэлтийн эхний төслийг гаргана. Шаардлагатай бол эхний төслийг танилцуулах уулзалтыг хийх бөгөөд нэмэлт тодруулга, нэмэлт баримт, мэдээлэл, зайлшгүй хийх шаардлагатай нийцлийн ажлуудын хүрээнд хуанлийн 14-21 хоногт багтаан хоёр дахь төслийг илгээнэ. Үнэт цаасны танилцуулга эцсийн хувилбарыг хуульчид илгээснээс ажлын 3 хоногийн дараа хууль зүйн дүгнэлтийн эцсийн хувилбарыг баталгаажуулж, хэвлээд үнэт цаас гаргагчид илгээнэ.
4. Талууд гэрээний хугацаанд олж мэдсэн аливаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, гэрээний нөхцөл заалттай холбоотой бүх нууцыг хадгалах үүрэг хүлээнэ.
5. Хуульч нь зөвхөн үнэт цаас гаргагчийн амаар болон бичгээр өгсөн зааварчилгааны дагуу үйлчилгээ үзүүлэх бөгөөд урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр аливаа ажиллагааг бие даан гүйцэтгэхгүй.
6. Хуульч нь Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх магадлалтай сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагаа тогтоогдсон тохиолдолд мэдээлэх үүрэгтэй бөгөөд уг шаардлагын дагуу мэдээлэл өгсөн нь гэрээгээр хүлээсэн үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах үүргээ зөрчсөн гэж үзэхгүй.

## 4.5. МЭРЭГЖЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

### 4.5.1. МЭРЭГЖЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

| Sustainable Fitch | **Sustainable Fitch Limited** |
|---|---|
| **Хаяг:** | ИБУИНХУ, E14 5GN, Лондон хот, Канэри-Уорф, Умард Колнэйдын гудамж, 30 |
| **Утас:** | +44 (0) 20 3530 1000 |
| **Вэб хуудас:** | www.sustainablefitch.com |

Sustainable Fitch Limited нь Fitch Group-ийн хамаарал бүхий байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээний байгууллага ба дэлхийн улс орнууд болон компаниуд, тэдний санхүүжилтийн тогтолцооны байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээ, зах зээлийн судалгаа шинжилгээ, дүгнэлт гаргах үйл ажиллагаа эрхэлдэг. 2008 онд консалтингийн үйл ажиллагаа явуулах зорилгоор байгуулагдсанаас хойш байгаль орчны тогтвортой байдлын менежментийн салбарт олон улсад танигдсан байгууллага болжээ. Тус компани нь үйлчлүүлэгч компаниудын бизнесийн стратегид тогтвортой байдлын зорилтуудад нийцсэн төлөвлөгөөг тусган, урт хугацааны үнэ цэнийг бүтээх зорилготой ажилладаг.

### 4.5.2. МЭРЭГЖЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Үнэт цаас гаргагч нь Sustainable Fitch Limited мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагатай 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 00158705.0 дугаартай Үнэт цаас гаргагчийн биржийн хүрээнд нээлттэй гаргах Ногоон бонд болон тус бондоор санхүүжих төсөл, үйл ажиллагаа нь ICMA буюу Олон Улсын Хөрөнгийн Зах Зээлийн холбооноос гаргасан ногоон бондын зарчмуудтай нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргах гэрээг байгуулжээ.

Мөн тус гэрээнд зааснаар Sustainable Fitch Limited нь Хөндлөнгийн баталгаажуулалтын дүгнэлтийг захиалагч талаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн гаргах бөгөөд мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг захиалагч тал хариуцна. Тус хөндлөнгийн дүгнэлтийг гаргаснаас хойш Sustainable Fitch Limited нь захиалагч талын хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихгүй бөгөөд цаашид үнэт цаас гаргагчийн хөрөнгийн зарцуулалт болон ногоон бондын зарчмуудтай нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргахгүй байхаар тусгасан байна.

Тус гэрээний хүрээнд Sustainable Fitch Limited-ээс Second Party Opinion буюу хөндлөнгийн баталгаажуулалтын дүгнэлт гаргасан ба үүнд Үнэт цаас гаргагчийн ногоон бондын зарцуулалт нь ногоон бондын зарчмуудтай нийцэж байгаа ба **"Онц"** үнэлгээ өгчээ.

СЗХ
2024.07.05
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2024-06-03
БҮРТГЭВ-02

**Үнэт цаас гаргагч**

**"ТЖТБ" ХХК**

Монгол Улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо, Хотын шинэ төв /18720/ гудамж, 91 тоот

**ТУЗ-ийн дарга**
Овог, нэр: Х.Сэргэлэн

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

**Гүйцэтгэх захирал**
Овог, нэр: Ч.Агиймаа

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

**Ерөнхий нягтлан бодогч**
Овог, нэр: Н.Жавхланчимэг

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

**Андеррайтер**

**"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК**

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, 14210, Худалдаа, хөгжлийн банкны төв байр

**Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч,**
**Дэд захирал**
Овог, нэр: Г. Энхбат

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)